



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

МОНИТОРИНГИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Төрийн үйлчилгээний мониторинг

*Төрийн бус байгууллагуудын
2005 оны төслийн тайлангийн
ЭМХТГЭЛ*



*Улаанбаатар хот
2006*

DDC
354.68
Т-594

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,
Монгол Улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-314857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@soros.org.mn

Уг тайланд бичигдсэн дүгнэлт, саналууд нь
мониторинг гүйцэтгэсэн багийн үзэл бодлыг
илэрхийлнэ.

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл
ННФ-ын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна.

ISBN 99929-0-102-0

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

ГАРЧИГ

| | |
|---|-----|
| Өмнөх үг | 5 |
| Өмнөтгөл | 6 |
| Замын-Үүд, Алтанбулаг боомт хотын гаалийн албад болон Улаанбаатар хотын Толгойтын гүнийн Гаалийн албаны үйл ажиллагаанд хийсэн мониторинг | 7 |
| Төрөөс өрх, иргэнд газар өмчлүүлэх /эзэмшүүлэх/ үйлчилгээнд хийсэн мониторинг | 27 |
| Барилга байгууламж барих зорилгоор иргэн, хуулийн этгээдэд газар олгох төрийн үйлчилгээнд хийсэн мониторинг | 49 |
| Газрын харилцаа ба иргэд | 65 |
| Нийтийн орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайн газар олголт, эзэмшилтийн мониторинг | 77 |
| Эрүүл Мэндийн Яам эмийн лицензийг мэргэжлийн бус хүмүүст олгож байгаа явдалд хяналт тавих | 93 |
| Тусгай зөвшөөрлийн мониторинг | 103 |
| Цэргийн дүрэмт хувцасны хангалтад хийсэн мониторинг | 123 |
| Нийгмийн халамжийн үйл ажиллагааны “Тусгал” төсөл | 137 |
| Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэгүй олгох эд зүйлийн хүртээмж, олголтын байдалд хийсэн мониторингийн “Халамж үйлчилгээ” төсөл | 157 |
| Орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд мониторинг хийх нь | 167 |

Ардчилсан нийгмийн оршин тогтнох үндэс суурь нь ардчиллын зарчмуудад тулгуурлан үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод явуулдаг, хариуцлагатай төр байдаг. Ийм төр бодитой бүрэлдэхэд саад болж байгаа болон, цаашид оршин тогтноход нь учирч болох саад тотгор, алдаа дутагдлыг соргогоор хянан шүүмжилж, засч залруулах талаар хүч чармайлт гаргах нь иргэний нийгмийн байгууллагуудын хүлээх ёстой чухал үүрэг юм.

Нээлттэй Нийгэм Форумас төрийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжих зорилгоор 2005 оноос эхлэн төрийн үйлчилгээний болон бодлогын Мониторингийн Тэтгэлэгт Хөтөлбөр зохион байгуулах болсон билээ. Тэтгэлэгт хөтөлбөрийн эхлэлийг тавин 2005 онд 15 төрийн бус байгууллага төрийн хэд хэдэн чиглэлийн үйлчилгээнд мониторинг хийсэн бөгөөд тэдний гүйцэтгэсэн ажлын тайланг эмхтгэл болгон та бүхэнд хүргэж байгаадаа баяртай байна.

Энэхүү эмхтгэлд газар олголт, халамжийн үйлчилгээ, шүүх, гааль, лиценз олголтод хийсэн мониторингийн төслүүдийн тайланг хураангуйлан оруулсан бөгөөд эдгээр үйлчилгээнд гарч байгаа алдаа дутагдлыг дэлгэн, учир шалтгааныг оновчтой тайлбарласны дээр хэрхэн засч залруулах талаар үнэтэй зөвлөмж боловсруулсныг нийтэллээ.

Төрийн бус байгууллагын мониторинг буюу хөндлөнгийн хяналт-үнэлгээ нь манай нийгмийн хувьд харьцангуй шинэ ойлголт ба үүнийг анх санаачлан хийсэн байгууллагууд чамгүй бэрхшээлтэй тулгарсан. Гэвч бэрхшээлийг зориг шантралгүй даван туулж, тавьсан зорилгодоо хүрсэн төрийн бус байгууллагууддаа талархал дэвшүүлье.

Нээлттэй Нийгэм Форумын захирал

П.Эрдэнэжаргал

УДИРТГАЛ

Монгол Улсад иргэний нийгмийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болсон төрийн бус байгууллагууд /ТББ/-ын тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, үйл ажиллагааных нь өргөжин тэлсээр байна. Энэ нь сайшаалтай хэрэг мөн боловч ТББ-уудын үйл ажиллагаа ихэвчлэн иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаанд чиглэх хандлага түлхүү ажиглагдах боллоо. Үүний нөлөөгөөр иргэний нийгмийн гүйцэтгэвэл зохих өөр нэгэн үндсэн үүрэг болох төр, засгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих талаар үйл явдал харьцангуй бага хэрэгжиж байна. Үүний гол шалтгаан нь ТББ-уудын мониторинг хийх чадавхи, нөөц бололцоо хязгаардлагдмал байгаатай холбоотой юм. Энэ байдлаас гарах арга замыг бий болгох зорилгоор Нээлттэй Нийгэм Форум /ННФ/ 2005 оноос эхлэн төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний ил тод байдлыг хангахад ТББ-ын хөндлөнгийн хяналт тавих чадавхийг бэхжүүлэх үүднээс төрийн үйлчилгээний мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийг ТББ-уудын дунд зарлан явуулах болсон юм.

Мониторинг нь төрийн үйлчилгээний тогтолцоо болоод бодлогын хэрэгжилтийн явцад гарч байгаа аливаа гажуудлыг засч залруулахад нэн чухал ач холбогдолтой бөгөөд хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн оролцооны нэн чухал хэлбэр болно. Мониторингийн тухай ойлголтыг тодруулан тайлбарлавал:

- Төрийн үйлчилгээний мониторинг нь төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний ил тод байдал, иргэдийн эрх зөрчигдөж буй талаархи мэдээлэл цуглуулах, цаашлаад тухайн чиглэлээр мөрдөгдөж буй хууль тогтоомж нь үйлчилгээний ил тод байдлыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт өгч, тэдгээрийн хэрэгжилт, дутагдалтай талуудын талаар баримт цуглуулан, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлбэл санал зөвлөмж боловсруулах, нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх цогц үйл ажиллагаа юм.
- Бодлогын мониторинг нь хуулийн заалтууд олон улсын тогтсон хэм хэмжээтэй хэрхэн нийцэж байгаад дүгнэлт хийн, хууль хэрэгжих явцад гарч буй зөрчлийн талаар баримт, мэдээлэл цуглуулан баталгаажуулж, түүнд тулгуурлан дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх санал зөвлөмж гарган түүнийг хэрэгжүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.

ННФ нь цаашид мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийг жил бүр зарлан явуулах бөгөөд 2006 оноос уг хөтөлбөрийн хамрах чиглэл, хүрээг улам өргөжүүлэн, бодлогын мониторингийн шинэ чиглэлийг нэмээд байна. Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд ТББ-ын мониторингийн талаар мэдлэг хийгээд, түүнийг хийж гүйцэтгэх чадавхи, санаачилга улам бүр нэмэгдэнэ гэж бид найдаж байна.

Замын-Үүд, Алтанбулаг боомт хотын гаалийн албад болон Улаанбаатар хотын Толгойтын гүнийн Гаалийн албаны үйл ажиллагаанд хийсэн мониторинг

Төслийн зорилго:

Төслийн зорилго нь Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Алтанбулагийн боомтын гаалийн албад болон Улаанбаатар хот дахь Толгойтын Гүнийн гаалийн албаны үйл ажиллагаанд мониторинг хийх замаар Гаалийн албаны үйл ажиллагааны ил тод байдал болон иргэдэд үйлчлэх төрийн тусгай албаны үүргээ хэрхэн биелүүлж байгаа, үйл ажиллагаа нь эрхэм зорилготойгоо хэрхэн нийцэж буй, төрийн үйлчилгээг ямар төвшинд үзүүлж байгааг бодит байдлаар тодорхойлох явдал юм.

Төслийн зорилт:

- Төрийн албан хаагчдын албан тушаалаа урвуулан ашиглаж буй хэлбэрүүдийг тогтоох,
- Гаалийн ажилчид болон бизнес эрхлэгчидтэй уулзан авилгал авч өгч буй үзэгдлийн үндсэн шалтгааныг тодорхойлох,
- Гаалийн албаны үйл ажиллагаанаас эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох,
- Төслийн үр дүнд гаалийн албыг хувийн эрх ашгийн төлөө урвуулан ашиглахыг зогсооход чиглэсэн шинэчлэл хийх талаар санал зөвлөмж боловсруулан гаргах.

Мониторингийн үндэслэл

Гааль нь улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй төрийн тусгай алба төдийгүй чухамдаа гадаад худалдааг дэмжих, гадаадын хөрөнгө оруулагчдыг татахад хувь нэмрээ оруулж хөрөнгө оруулагчдад анхны сэтгэгдэл төрүүлж, ойлголтыг нь төлөвшүүлэх эхлэлийг тавьж өгдөг байгууллага билээ.

Гэтэл гаалийн байгууллагын өнөөгийн үйл ажиллагаатай холбоотой төрөл бүрийн гэмт хэргийн шинжтэй дуулиант мэдээлэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр байнга шахуу гарч байдгаас нийгмийн сэтгэхүй гаальчдын талаар сөрөг төсөөлөлтэй болоод байгаа. 2004 онд Авилгалтай Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторингийн судалгаа хийх явцад авилгалын төвшинг байгууллагуудаар нь гаргахад Гаалийн байгууллага 78.5 - 79.6%-аар нэгдүгээр байрт явж байв.

Мониторингийн хугацаа, хамарсан хүрээ, байршил

Дорноговь аймгийн Замын-Үүдийн боомт, БНХАУ-ын Эрээн хот, Сэлэнгэ аймгийн Гаалийн газар, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт, Улаанбаатар хотын гааль, Улаанбаатар хотынТолгойтын гүнийн гааль, Чингис хаан нисэх буудлын нисэхийн гааль, Гаалийн ерөнхий газар /ГЕГ/, ГЕГ-ын харьяа Гааль, эдийн засгийн дээд сургууль, Бизнесийн байгууллагууд, Бизнес эрхлэгчид, Иргэд

Судалгааг 2006 оны 1 дүгээр сарын 1-нээс 2006 оны 6 дугаар сарын 30-ны хооронд нийт 6 сарын хугацаанд хийж гүйцэтгэв.

Мониторингийн аргачлал

Мониторингийн аргачлал нь холбогдох хүмүүстэй ярилцах, санал солилцох, анкетийн судалгаа авах, газар дээр нь очиж байдалтай танилцах байдлаар явагдсан. Төслийн багийн гишүүд төсөл хэрэгжүүлэх явцдаа гаалийн байгууллагын талаар гарсан материал, ном товхимол, судалгаа шинжилгээ, эрх зүйн орчныг судлахаас гадна дараах арга хэлбэрүүдийг ашигласан болно.

Ярилцлага, санал солилцох:

Гаалийн байгууллагад ажиллаж байгаа болон ажиллаж байсан хүмүүс, бизнес эрхлэгчид, судлаачид, үйлчлүүлэгч иргэд, Монголд үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын төлөөлөгчид гэх мэт нийт 100 гаруй хүнтэй уулзаж ярилцлага хийн, санал солилцож, зөвлөгөө авсан болно.

Газар дээр нь байдалтай танилцах:

Дээр дурьдсан газар, байгууллагуудаар явж бодит байдалтай танилцан Гаалийн ажилтнууд болон Гаалийн улсын байцаагч /ГУБ/ нартай уулзсан. Үүнд хилийн боомт хотуудын гаалийн албад, гүнийн гаалийн газар, терминалууд хамрагдсан болно. Мөн Замын-Үүдийн хилээр гаальтай машинаар үйлчлүүлж хилийн орох, гарах урсгалд ажиглалт хийж энгийн иргэдтэй ярилцаж, байдлыг тандсан болно.

Анкетийн судалгаа авах:

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд, бизнес эрхлэгчид, гаалийн ажилтнууд зэрэг нийт 1017 хүнийг хамарсан анкетийн түүвэр судалгааг Улаанбаатар хот, Сэлэнгэ аймаг, Алтанбулаг боомт хот, Улаанбаатар хотын Гүнийн гааль гэх мэт газруудыг хамруулан хийв.

Мониторинг хийхэд баримтлал болгосон холбогдох хуулийн заалтууд:

Олон Улсын гаалийн эрх зүй нь үндэсний гаалийн эрх зүйн хамааралд, гаалийн хууль зүйн хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Гаалийн хууль, Гаалийн тарифийн хууль, олон улсын гааль худалдааны хэлэлцээр, конвенцэд тусгалаа олдог. Гаалийн байгууллага нь олон улсын гааль, худалдаа, үйлчилгээний конвенцүүд, Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ/-ын гишүүн орны хувьд хүлээх үүргийн хүрээнд бараа тээвэрлэлт, дамжин өнгөрүүлэхтэй холбогдолтой олон улсын гэрээ конвенц, хоёр улсын хамтын ажиллагааны бичиг баримт, гэрээний үндсэн дээр гадаад үйл ажиллагаагаа явуулж байна.

Одоогийн байдлаар гаалийн байгууллагад хамааралтай 30 гаруй хууль, үүнээс гаалийн татвараас чөлөөлөх хууль 10 гаруй гарсан, Улсын Их Хурал /УИХ/-ын 10 гаруй тогтоолыг УИХ-аас гарган Засгийн газар, яам, байгууллагын даргын болон сайдын хамтарсан тушаал шийдвэртэй 100 гаруй дүрэм, журам, заавар үйлчилж байна. Олон улсын эрх зүйн хувьд цөөн тооны гэрээ конвенцийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн гаалийн байгууллага /ДГБ/-ын эрх зүйн эх сурвалж болдог зарим олон улсын конвенцууд :

- Дэлхийн худалдааны байгууллага (Монгол Улс 1996 оны 12 дугаар сард элссэн) Тариф ба худалдааны тухай ерөнхий хэлэлцээр туссан
- Гаалийн холбоо
- Олон улсын (ОУ) хооронд бараа худалдах-худалдан авах тухай НҮБ-ын конвенц
- Барааг тодорхойлох, кодлох уялдуулан зохицуулсан системийн тухай олон улсын конвенц
- Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц
- Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай ОУ-ын конвенц
- Киотогийн конвенц (ОУ-ын гаалийн горимын зөрөөг багасгах гол санаа)

Хуулийн заалтууд:

Бид монгол Улсын Үндсэн хууль, гаалийн тухай хууль, Гаалийн тарицын тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Татварын хуулиуд (нэмэгдсэн өртөгийн болон Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай, Онцгой албан татварын хууль, Татварын ерөнхий хууль, гаалийн албан татвараас чөлөөлөх тухай зэрэг,) төрийн албаны тухай хууль бусад Засгийн газар, яам, гаалийн байгууллагын дарга нарын дүрэм журмыг үндэс болгов.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Мониторинг хийхдээ нийт 100 гаруй хүнтэй уулзаж ярилцан 1017 хүнийг хамарсан Гаалийн байгууллагын өнөөгийн үйл ажиллагааны талаарх судалгааг хийлээ. Судалгаанд 455 бизнес эрхлэгчид, 485 иргэд, 77 гаалийн ажилтан, албан хаагч тус тус оролцлоо. Нийт оролцогчдын 87.7 хувийг Улаанбаатар хотоос, 12.3 хувийг орон нутгаас авсан.

Төрийн Албан хаагчдын албан тушаалаа урвуулан ашиглаж буй хэлбэрүүдэд мониторинг хийхэд

Гаалийн албан хаагчдын албан тушаалаа урвуулан ашиглаж буй үзэгдлүүдэд: ГУБ нар бизнес эрхлэгчидтэй жишиг үнэн дээр ярьж тохиролцох, гаальтай ачааны болон суудлын машины үйлчилгээг өөгшүүлсэн байдал мөн экспортын бараа бүтээгдэхүүний нэр, төрлийг өөрчлөх, импортын бүтээгдэхүүний тоо, үнийг өөрчлөх, мөн зарим бизнес эрхлэгчид танил талтайгаа хамтран барааг транзит нэрээр оруулж ирэн гарсан гэсэн бичиг үйлдэн монголын нутагт ямар нэгэн татваргүйгээр оруулах гэх мэт хууль бус үйл ажиллагаа явуулдаг талаар бизнес эрхлэгчидтэй уулзаж байхдаа олж тогтоосон. Мөн гаальд ажилд ороход эхлээд 5-7 сая төгрөг төлдөг гэх мэт баримтуудыг ГУБ нар дурьдаж байв.

1017 хүнийг хамарсан судалгааны бизнес эрхлэгчдийн асуулгаас харахад ГУБ нар хяналт шалгалт хийхдээ хүнд суртал гаргаж, чирэгдүүлдэг (72.3 хувь), харьцааны соёл олон улсын жишигт хүрээгүй (88.6 хувь) гэж ихэнх хувь нь хариулжээ. Мөн гаалийн алба зүй ёсоор үйлчилгээ үзүүлж чаддаггүй гэж 60.9 хувь нь, холбогдох хууль, дүрэм журам, мэдээллээр хангаж чаддаггүй гэж 82.9 хувь нь хариулжээ. Харин шаардлагатай хууль тогтоомж, дүрэм журмыг 60-аад хувь нь мэдээллийн хэрэгслээс, 20-иод хувь нь гаалийн байгууллага, байцаагчаас, үлдсэн хувь нь бусад мэдээллээс олж авдаг байна.

Иргэдийн санал асуулгаас гаалийн байгууллагаар үйлчлүүлсэн эсэхийг харахад судалгаанд оролцсон иргэдийн тал хувь нь (53.0 хувь) гаалийн

байгууллагаар үйлчлүүлсэн боловч ихэнх хувь нь (73.2 хувь) хурдан шуурхай, соёлтой үйлчилгээ авч чадаагүй байна. Гаалийн байгууллагад авилгал байдаг гэж бизнес эрхлэгчдийн 94.3 хувь, иргэдийн 95.1 хувь нь үздэг байна. Гаалийн бүрдүүлэлт хийхэд ямар нэгэн хүндрэл учирдаг гэж 55.2 хувь нь, мөн гаалийн байцаагч үнэлгээг бодиттой тогтоодоггүй гэж 70 хувь нь хариулжээ.

Харин Гаальд ажиллаж буй албан хаагчдын өөрийн байгууллага дахь авилгалын талаарх дүгнэлтээс хувийн жингээр харахад, Гаалийн байгууллагад авилгал байдаг гэж гаалийн байцаагчдын 68.8 хувь нь хариулснаас авилгалд зөвхөн цөөн хэсэг нь л автагдсан гэж 50-аад хувь нь гол төлөв дээд албан тушаалтнууд авилгалд автсан гэж 20 гаруй хувь нь, гол төлөв доод албан тушалтнууд автагдсан гэж хамгийн бага хувь буюу 2 хувь нь хариулжээ. Харин авилгал байдаггүй гэж хариулагсад бүгд авилгал авч, өгч байсан тохиолдлыг мэддэггүй гэсэн байна. Гаалийн ажилтан, албан хаагчдын санал асуулгаас харахад ГУБ-ыг ажлаа хийхэд нь удирдлагын арга барил сөргөөр хамгийн их (46.8 хувь) нөлөөлдөг байна.

Гаалийн ажилчид болон бизнес эрхлэгчидтэй уулзан авилгал авч, өгч буй үзэгдлийн үндсэн шалтгааныг тодорхойлоход

Зөвхөн ГЕГ-ын дарга нь биечлэн шийдэж Гаалийн Улсын бүх байцаагчийг томилж тогтолцоотой. Энэ эрхийг урвуулан ашиглаж ирснээс харьяалдаг намын санхүүжилтийг хууль бусаар хийх, УИХ, Засгийн газрын гишүүд, холбоо сүлбээтэй томоохон бизнесмэнүүд, намын нөхдийн болон өөрийн танил тал, ах дүү хамаатан саданг гаалийн албанд олноор авч ажиллуулах болсноос гаалийн албыг мэргэшлийн байгууллага бус, албан тушаалаа хувийн эрх ашгийн төлөө ашигладаг хэсэг бүлэг хүмүүсийн цугларалт болгожээ.

Хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн хангалтгүй байдал, ГУБ-ын хүнд суртал, мэргэшил чадварын доголдолтой болон албан тушаалаа урвуулан ашиглах хувийн сонирхолд хөтлөгдсөн байдал нь хориглосон болон хязгаарласан барааг хууль бусаар оруулах боломж олгон, хүн амын эрүүл мэндэд шууд заналхийлж ядуурал доройтолд хүргэх нэгэн хүчин зүйл болж байна.

Судалгаанд оролцогчдын хувь, гаалийн албаны үйл ажиллагааг сайжруулахад хийгдэх шаардлагатай ажлуудад судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 48.4 хувь нь удирдлагын томилгооны тогтолцоог өөрчлөх гэж хариулсан байна. Харин иргэдийн 60 хувь, бизнес эрхлэгчдийн 51.9 хувь нь хариуцлагын тогтолцоог чангалах, гаалийн ажилтнуудын 84.4 хувь нь цалин нэмэх, ажилчдын нийгмийн халамжийг сайжруулах гэж хариулсан байна. Бусад хийгдэх шаардлагатай ажлуудад гаалийн албан хаагчид танил тал, ах дүү харгалзан ажилд авах явдлыг зогсоох, эрүүгийн хэрэгт удаа дараа холбогдсон, хэрэг үйлдсэн тодорхой байцаагчдыг төрийн албанаас шууд халдаг байх, гаалийн улсын байцаагч бусдаас харилцан хамааралгүй

байх нөхцөлийг бүрдүүлэх гэсэн бол бизнес эрхлэгчид гаалийн ажилчидтай хариуцлага тооцох, ард түмнийхээ санал хүсэлтийг зохих журмын дагуу хүлээн авдаг байх, боомтын үйл ажиллагааг бүхэлд нь өөрчлөх, хүнд суртал татварын дарамтыг багасгах, гаалийн ажилчдын чадавхийг сайжруулах, харьцааны соёлыг сайжруулах хэрэгтэй гэжээ. Харин иргэд хүнд суртал, хээл хахууль, авилгалыг арилгах, түргэн шуурхай үйлчилдэг болох, хяналтын тогтолцоог сайжруулах, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах гэх мэт ажлуудыг хийх шаардлагатай гэж үзсэн байна.

Гаалийн албаны үйл ажиллагаанаас эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Гаалийн байгууллага нь улсын төсвийн 40 гаруй хувийг гааль, НӨАТ, зарим нэрийн барааны онцгой албан татвараар бүрдүүлж байгаа нь өнгөцхөн харахад их тоон үзүүлэлт мэт боловч хураах ёстой татварынхаа дөнгөж 50-60%-ийг хурааж бусдыг нь худалдааны луйвар, татварын булхай, авилгал хээл хахуулийн замаар алддаг байна. Гаалийн байгууллага дахь боловсон хүчний алдаа завхрал, хүнд сурталыг арилгаж, авилгал дагуулсан элдэв хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгаж чадвал улсын төсөвт орох мөнгийг наад зах нь 2-3 дахин нэмэгдүүлэх боломжтой нь харагдаж байна.

Статистик мэдээнээс дүн шинжилгээ хийж үзвэл:

| | 2003 он тэрбум төг | 2004 он тэрбум төг | 2005 он тэрбум төг |
|--|-----------------------|-----------------------|-----------------------|
| Улсын төсөв | 553,889.3 | 713,113.6 | 837,858.3 |
| Татварын орлого (гааль дээр хурааж буй татвар) | 224,342.8 | 298,965.7 | 343,616.2 |
| Хувь | 40.5% | 41.9% | 41% |

Гаалийн байгууллагын үндсэн үүрэг, үйл ажиллагааны талаарх санал асуулгаас харахад:

Гаалийн байгууллагын үндсэн үүрэг, үйл ажилгааны талаар нийт судалгаанд оролцогчдын эрэмбэлснээр харвал “Улсын төсөв бүрдүүлэх”-ийг 55 хувь нь 1-р үндсэн үүрэг, “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах”-ыг 47.1 хувь нь 2-р үндсэн үүрэг, “Үндэсний аюулгүй байдлыг хангах”-ыг 49.9 хувь нь 3-р үндсэн үүрэг, “Бусад”-ыг 26.8 хувь нь 4-р үндсэн үүрэг, харин 69.6 хувь нь эрэмбэлээгүй байна.

Гааль дээр хурааж буй татварыг ямар байдлаар хураавал зохимжтой вэ гэсэн асуултад бизнес эрхлэгчдийн хамгийн их хувь буюу 20 гаруй хувь нь шууд нээлттэйгээр, мөнгөн хэлбэрээр, хахуульгүйгээр хураах, 10 хувь нь шууд бусаар шууд дансанд хийх, электрон карт, чекээр хураах гэх мэтээр саналаа өгсөн байна. Гааль дээр хурааж буй татварын хэмжээг бизнес эрхлэгчдийн ихэнх хувь нь (69.7 хувь) өндөр байна гэж боддог байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Уг нь Гаалийн алба бол хилээр орох урсгалд манай хүн ардад хор хөнөөлтэй хар тамхи, мансууруулах бодис, зэр зэвсгээс эхлээд спиртийн хууль бус наймаа хүртэлх хориглосон, хязгаарласан бүхий л бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, гарах чиглэлд ард түмний түүх соёлын үнэт зүйлс, байгалийн баялаг, алт мөнгөнөөс авахуулаад чухал түүхий эд хүртэлх манай эх орон, төрийн тусгаар тогтнолын баталгаа болсон үндэсний үнэт өв санг хамгаалах, гаалийн болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гаалийн хэрэг зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үндсэн үүрэг бүхий хууль сахиулах ёстой байгууллага юм.

Гаалийн алба нь хэн бүхэнд тэгш үйлчлэх ёстой байдаг. Гаалийн байгууллага 20 гаруй үндсэн үүргийг биелүүлж ажиллах ёстойгоос зөвхөн нэг үүрэг нь гаалийн татвар, тэрчлэн зарим хууль тогтоомжид заасны дагуу бараанд нэмсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулж барагдуулж ажилладаг. Гаалийн байгууллагын энэ үүргийг төсвийн алдагдал ихтэй зарим улс оронд хэт дөвийлгөн тавьдагаас тэдгээр нь гаалийн субъектуудын татвар дагалдсан булхай, худалдааны луйвар, мөнгө угаах, авилгал өгөх, авах зэрэг янз бүрийн сөрөг үр дагавар бий болгож эцэс сүүлдээ гаалийн концепцийн алдаа гардаг ба энэ нь Монгол Улсын гаалийн байгууллагад тохиолдоод байна. Ингэж гааль нь хээл хахуульд идэгдэн, төр нь түүнээсээ болж ганхдаг жишээ олон оронд тохиолдож байсан байна.

Бид Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн мониторингийн дүн шинжилгээн дээрээ үндэслэн дараах гол дүгнэлтүүдийг хийж байна.

Гаалийн байгууллагын боловсон хүчний бодлого бүрэн алдагдсан

Төрийн алба бизнесийн томоохон бүлэглэл болон улс төрчдийн эрх мэдэлд шилжсэний улмаас гаалийн байгууллага нь төрийн эрхийг барьж буй улс төр бизнесийн бүлэглэлийн эрх ашгийг хэрэгжүүлэгч байгууллага болж хувирсан байна. Засаг солигдох бүрийд гаалийн удирдлага, газар хэлтсийн дарга, орлогч, ахлах байцаагч солигдох болсон тул гаалийн байгууллага дахь төрийн бодлого, боловсон хүчний чадавхи алдагдаж эрхэм зорилгоосоо ихээхэн гажсан зөвхөн татвар бүрдүүлэх төдий үүрэгтэй байгууллага болж хувирчээ.

ГЕГ-ын дарга нарыг улс төрийн нам хүчин, фракцаар хуваан авч томилдог болжээ. Энэ байдал нь дарга нар, зохих чухал албан тушаалууд нам хүчнээс шууд хараат байх нөхцөл байдлыг бүрдүүлж өгдөг. ГЕГ-ын дарга нь өөрөө Гаалийн Улсын бүх байцаагчдыг томилдог тогтолцоотой байна. Ингэснээр өөрийн намын санхүүжилтийг хууль бусаар хийх, УИХ, Засгийн газрын гишүүд, томоохон бизнесменүүд, намын нөхдийн болон өөрийн танил тал, ах дүү хамаатан саданг гаалийн албанд авч ажиллуулдаг, гаалийн албыг

мэргэшлийн бус байгууллага болгосон, албан тушаалаа хувийн эрх ашгийн төлөө ашигладаг хэсэг бүлэг хүмүүсийн цугларалт болгожээ.

Боловсон хүчний бодлого бүрэн алдагдсанаар, мэргэжлийн бус боловсон хүчин нь ёс суртахуунгүй, харьцааны наад захын соёлгүй, хүнд суртал гаргадаг, гаалиар оруулж, гаргаж байгаа бараа бүтээгдэхүүн нь шаардлага хангаж байгаа эсэхийг үл тоодог, хууль дүрэм журмаа мэддэггүй, хээл хахуульд ихээр автагдах гэх мэт алдаа дутагдал нь наад захын үзэгдэл болсон бөгөөд өөрийн ажлын үндсэн үүргээ бараг ойлгоогүй энэ ажлыг хэн ч хийж болно гэсэн хандлагатай болжээ.¹

ГУБ болохын тулд болон хэрэгцээтэй газраа томилогдохын тулд гаалийн удирдлага, зуучлагчид эхлээд 5-7 сая төгрөгийн хахууль төлдөг.² Хахуулийн хэмжээ хаана, ямар албан тушаалд очихоос хамаарч янз янз байдаг. Иймэрхүү байдлаар ажилд орсон хүмүүс нь ГУБ-ын мэргэжлийн шаардлага хангадаггүй, тухайн гаалийн газар хороодын удирдлагын шийдвэр тушаалыг ч үл тоомсорлодог. Ийм ГУБ нар хувийн эрх ашгийг нэгдүгээрт тавьдаг учраас Монгол Улсын үндэсний аюулгүй байдал түүн дотроо эдийн засгийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдлаа хамгаалан хяналт шалгалт хийх үндсэн үүргээ умартан зөвхөн улсын төсөв бүрдүүлэх дээр голчлон ажилладаг ба бусад чухал үүргийг орхигдуулан ажилд орохдоо өгсөн хахуулийн мөнгөө мөн л хууль бус аргаар нөхөн олж авахыг урьтал болгож эсвэл танил тал хамаатан садантайгаа хамтран төрийн албыг хувийн эрх ашиг, хувийн бизнесийн төлөө ашиглаж байна.

Нийгмийн халамж Төсвийн байгууллага дотроо хамгийн өндөр цалинтай нь гаалийн байгууллага байдаг. Орон сууцаа үнэгүй өгдөг. Төсвийн орлого бүрдүүлсний шагнал болох 300 сая төгрөгийг Сангийн Яам /СЯ/-аас ГЕГ-т өгсөн ч хувиарлалт шударга явагддаггүй, очих ёстой эзэндээ очдоггүй, 800 гаруй ГУБ-аас 200 ГУБ-д байр хуваарилахдаа шударга бусаар олгосон, ажиллагсдын эрүүл мэнд гэх мэт асуудлыг удирдлагын зүгээс хайхардаггүй байна.

Дээд тал нь 500 сая төгрөгийн татвар цуглуулсан хүнд 30 000 төгрөг шагналд өгч татвар хасаад гар дээр нь 27 000 төгрөг л очдог байна. Зэрэг дэвийн нэмэгдэл гэхэд л 1997 оны тогтоолын дагуу гарсан тушаал 2005 оны 5 дугаар сард хэрэгжиж байжээ /тэр үед мөнгөний ханш их байсан учир энэ нь одоогийн нөхцөл байдалд тохиромжгүй/.

Гаалийн ажилчдын гэр бүлийг ажлын байраар хангах ёстой байдаг боловч энэ байдал ер хэрэгждэггүй бөгөөд бүх дарамтыг шилжин ажиллаж байгаа гаалийн ажилчид үүрдэг байна. Мөн гэр бүл, үр хүүхдээсээ олон жилээр хол амьдрах болдог. Тэр хэрээр гэр бүл, үр хүүхдийн боловсрол, эрүүл мэнд,

¹ Гаалийн байгууллагын үндсэн үүрэг, үйл ажилгааны талаар гаалийн ажилчдаас авсан судалгаанаас харахад 57.1 хувь нь «Улсын төсөв бүрдүүлэх»-ийг үндсэн үүрэг, 26 хувь нь «Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах»-ыг үндсэн үүрэг, 16.9 хувь нь «Үндэсний аюулгүй байдлыг хангах»-ыг үндсэн үүрэг гэж үзэж, «Бусад»-ыг нь эрэмблээгүй байна.

² Нэлээд олон ГУБ-тай ярилцаж байхад энэ ханшийг хэлж байлаа.

ёс суртахуун гэх мэт олон зүйл орхигддог байна. Эмэгтэй ГУБ-ын нийгмийн асуудал эрэгтэй ГУБ-ынхаас илүү хүнд байдаг.

Төсөв бүрдүүлэх үүрэг болон татвар цуглуулалт

Гаалийн байгууллага нь улсын төсвийн 40 гаруй хувийг гааль, нэмүү өртгийн албан татвар /НӨАТ/, зарим нэрийн барааны онцгой албан татвараар бүрдүүлж байгаа нь өнгөцхөн харахад их тоон үзүүлэлт мэт боловч хураах ёстой татварынхаа дөнгөж 50-60%-ийг хурааж бусдыг нь худалдааны луйвар, татварын булхай, авилгал хээл хахуулийн замаар алддаг байна. Нөгөөтэйгүүр импортын жолоодлогогүй өсөлт 10 гаруй жил үргэлжилж, гадаад худалдааны алдагдал буюу экспорт импортын зөрүү зарим жил 190 сая ам долларын алдагдалд хүрч,³ Монгол Улс үндсэндээ импортын маш олон төрлийн барааны эрхшээлд автагдсан “импорт улс” болчихоод байхад төрийн бодлогын шинжтэй тодорхой арга хэмжээ авалгүй энэ чухал асуудлыг зөнд нь орхисон нь “Монгол Улсад гаалийн алба байна уу” гэж асуухад хүргэж байна. Гаалийн байгууллагын авилгал, боловсон хүчний алдаа завхрал, хүнд сурталыг арилгаж, авилгал тойрсон элдэв хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах бодлого хэрэгжүүлж чадвал улсын төсөвт орох мөнгийг наад зах нь 2-3 дахин нэмэгдэх боломжтой байна.

Мөн төрийн өндөр албан тушаалтнууд болон томоохон бизнесменүүд нь гаальд ажиллаж буй өөрсдийн хамаатан садан, танил талаараа дамжуулан гаалиар оруулж, гаргаж байгаа бараа бүтээгдэхүүнээ татваргүй оруулах эсвэл их хэмжээний татварын хөнгөлөлт авах, НӨАТ болон Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар /ААНБОАТ/-аас зайлсхийх, бараа бүтээгдэхүүний нэр тоог өөрчлөн засварлах, бараа бүтээгдэхүүнээ дамжин өнгөрүүлэх нэрээр оруулан хилээр гарсан тухай хуурамч бичиг баримт үйлдэн ямар ч татваргүй оруулах эсвэл экспортоор гарч байгаа татвартай гол нэрийн бүтээгдэхүүний нэрийг хуурамчаар үйлдэх гэх мэт үйл ажиллагаа явуулан хууль бусаар хөрөнгөжин баяжиж байгаа бөгөөд энэ нь дээрээс доош хэрсэн маш том гэмт хэргийн сүлжээ болон хувирчээ. Эндээс харахад энгийн ард иргэд татварын ачааллыг үүрч харин зарим эрх мэдэлтэй нь хууль бусаар баяжиж байна. Энэ байдлыг дээгүүрээ мэдэхгүй биш мэдэж байдаг хэдий ч үүнд өөрсдөө орооцолдсон учраас нэгнийгээ илчлэх сонирхолгүй байдаг ба зөвхөн гарцаагүй тохиолдолд улс төрийн нам хүчний харьяалал болон үзэл бодол нийлэхгүй учраас өөрсдийн замаас зайлуулахын тулд л хэргийг гарган тавьж золиос болгодог байна.

Засгийн газрын хөнгөлөлт чөлөөлөлт

Төр, засгаас алсыг харсан хууль зүйн тодорхой бодлого зохицуулалтгүйгээр гадаадын хөрөнгө оруулагчдад хууль, гэрээгээр гаалийн болон бусад

³ Гадаад Худалдааны гаалийн статистик мэдээлэл

татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэн улсын төсвийн орлогыг тодорхой хэмжээгээр бууруулж мөн үндэсний үйлдвэрлэгчдийг ялгаварлан гадуурхаж буй үзэгдлийг засаж залруулах хэрэгтэй байна. Гаалийн байгууллага жилд 250-300 гаруй тэрбум төгрөгийн татвар цуглуулахын хажуугаар тэргүүлэх ач холбогдол бүхий эдийн засгийн салбар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгсэл, экспортын бараа үйлдвэрлэх гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоног төхөөрөмж гэх зориулалтаар 300 орчим тэрбум төгрөгийн барааг Гааль болон НӨАТ-аас чөлөөлдөг. Харамсалтай нь хууль эрх зүйн тогтолцоо сул дорой, хууль хэрэгжүүлэн гүйцэтгэх тогтолцоо боловсронгуй бус байгаагийн улмаас татвараас чөлөөлөх асуудал нь улс төрчдийн эрх мэдлийн асуудал болж хувиран хээль хахуулийг улам бүр гааруулж байна.

Техник технологи

Хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн хангалтгүй байдал, ГУБ-ын авилгал, хүнд суртал, мэргэшил чадварын доголдолтой байдал нь хориотой болон хязгаарласан барааг хууль бусаар оруулах боломжийг олгон, хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдал, ядуурал доройтолд шууд нөлөөлж байна.

Одоогийн байдлаар бүх боомтод цахилгаан жин байдаг боловч бараг ажиллуулдаггүй, ачаа барааг ачиж буулгах механикжсан тоног төхөөрөмж хангалттай бус учраас бага оврын рентген болон метал хайгч тоног төхөөрөмж суурилуулах шаардлагатай байна.

Их хэмжээний төсвийн хөрөнгө мөнгө зарж ашиглалтад оруулаад удаагүй байгаа “электрон гааль” буюу ГАМАС-ийн талаар хийсэн судалгаанаас харахад түүнд хамрагдсан ГУБ нарын 60 гаруй хувьд нь гологдож, уг программ хангамж гаалийн үнийг мэдүүлэх, шалгаж тогтоох чадваргүйгээс гадна ГАМАС-т тарифын хувь хэмжээг суулгаагүйгээс тооцоолон бодох системд байдаг хяналтын хэрэгсэл нь алдагдчихаад байна.⁴

ГУБ болон гаалиар үйлчүүлэгч хоёрын хооронд хүнд суртал, авилгал, үл ойлголцол үүсгэхгүй байх боломж нь интернэтээр гаальд мэдүүлэх систем боловч төдийлөн сайн ашиглагдахгүй байна. Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт нь ядууд нь дээрэлхэж хийдэг, чадалтайгаас нь авилгал авах цоорхой үүсгэдэг шалгалтын хэлбэр болжээ.

Гаалийн лаборатори

Гаалийн лаборатори нь мэргэжлийн чиг үүргээ алдаж худалдааны луйвар, татварын булхай хийх нэг арга зам болж ГЕГ-ын удирдлага нь контрабандынхаа үйл ажиллагаанд ашигладаг тухай олон баримт байдаг ба лабораторийн дарга, шинжээчдэд эрүү үүсгэн шалгаж байжээ. Тэд төмрийг тугалга, модыг Монголынх биш болгож татвараас зайлсхийлгэх нь наад захын үзэгдэл болжээ.

⁴ «Монгол Гааль»сэтгүүл, 2005 он, УБ, 38-р хуудас

Гаальтай машин

Одоогоор хил хооронд хүн тээвэрлэх эрхтэй (гаальтай машин) 400 орчим машин байдаг. Үүнээс улс хооронд тогтмол тээвэр хийж байгаа 100 гаруй Уаз-69 маркийн, 40 гаруй ачааны машин байна. Гаальтай машины жолооч нар ГУБ-ын хамаатан садан, танил тал, нутгийн иргэд байдаг. Гаальтай машин нь тээвэрлэж байгаа ачааны овор хэмжээнээс хамаарч гаальтай карго гэх мэтээр хүрээгээ тэлэх хандлагатай байна.

Гаальтай том, жижиг машинаар үйлчлүүлэхэд хурдан шуурхайгаас гадна, татвар болон НӨАТ бага төлдөг аль эсвэл бараг төлдөггүй, барааг шалгадаг ч үгүй байна. Тиймээс хил гаалиар хэдэн төгрөгийн үнэтэй ямар бараа бүтээгдэхүүн орж гарч байгаа нь тодорхой бус учраас энд мөн л улс үндэстний эрх ашиг, аюулгүй байдал алдагдахад хүрч байна. Зарим бизнесменүүдийн ярьж байгаагаар хилээр галт зэвсэг, хар тамхи, бусад аюултай химийн бодис гэх мэтийг оруулж ирэх нь нэг их хүндрэлтэй асуудал биш бололтой. Эдгээр машины эзэд нь гол төлөв хил, гаалийн хүмүүс байдаг.

Бусад албаныхан

Мэргэжлийн хяналтын албаныхан хориотой барааг газар дээр нь устгаж байх ёстой боловч зохих ёсоор ажилладаггүй мөн хилийн цэргийн албаныхан, стандарт, эрүүл ахуй, мал эмнэлэг, ургамал хорио цээрт ажилладаг албан хаагчдын ёс суртахуун маш дорд түвшинд орсон, хүнд сурталтай, хариуцлагаас зайлсхийдэг, авилгал авдаг, танил талдаа үйлчилдэг, ялгаварлан гадуурхах үзэл их гаргадаг байна.

Бид илтгэлдээ гаалийн байгууллагын одоогийн явуулж буй үйл ажиллагаа, төр засгийн бодлогын бодит байдлыг тоо баримттайгаар харуулж өгсөн ба сэдэв бүрээр цаашид ямар арга хэмжээ авч болох талаарх зөвлөмжүүдийг оруулж өглөө.

Эдгээр асуудлыг олон нийтэд гаргаж тавьснаараа гаалийн байгууллагын үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгааг, удирдлага болон гаалийн ажилчид нь тодорхой нам хүчин, фракц бүлэглэл, бизнес эрхлэгчдийн нөлөөнд орж тэдний ашиг сонирхлын төлөө үйлчилдэг хэсэг болж хувирсныг гарган тавьж иргэд бидний төлөө зарцуулагдах ёстой төсвийн хөрөнгө мөнгө ямар замаар, хэрхэн хэний халаасанд хууль бусаар орж, хэр хэмжээний татварыг нуун дарагдуулж байгааг мэдэх боломжийг олгож байгаа юм.

Иргэний нийгэм, ард иргэд, төр засгийн зүгээс гаалийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүнд тавих хяналт шалгалтыг нэмэгдүүлж, улс орны үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах хамгийн гол үүргээ гүйцэтгэхэд нь анхаарал хандуулах цаг болжээ.

Түүнчлэн бидний илрүүлэн нээж чадаагүй олон зүйл байгааг ч үгүйсгэхгүй бөгөөд илүү нарийн судалж дүгнэлт гаргах ёстой асуудлууд байсныг ч хүлээн

зөвшөөрч байна. Үүнд жишиг үнийн, валютын хяналтын гэх мэт Монгол Улсад дөнгөж яригдаж эхэлж байгаа илүү мэргэжлийн төвшинд, олон хүрээг хамарч яригдаж, судлагдах ёстой ээдрээтэй орхигдсон асуудлууд ч байлаа.

Гаалийн байгууллага нь төрийн тусгай алба болохын хувьд төр, засгийн зүгээс түүнд хандсан зөв бодлого баримтлах болон мэргэшсэн байгууллагын хувьд өөрөө өөрийнхөө үндсэн концепцоос хазайхгүй байхад байнга анхаарах ёстой болжээ.

ЗӨВЛӨМЖ

I. Удирдлага, боловсон хүчин:

- Гааль нь Төрийн тусгай алба учир удирдлага болон ажилчид нь заавал мэргэжлийн байх бөгөөд намын харъяаллаас ангид байх
- Гаалийн удирдлагаар чадвартай хүнийг нээлттэй ил тод, байдлаар шударга өрсөлдөөн дээр тулгуурлаж олон нийтийн өмнө сонгож томилох ёстой. Хуулиндаа ямар тохиолдолд тухайн албан тушаалтныг эргүүлэн татаж, чөлөөлж болох талаар тодорхой тусгах хэрэгтэй. Гаалийн дарга нь төвөөс алслагдсан мянга гаруй км-ийн цаана ажиллаж буй байцаагчийг Гаалийн ерөнхий газраас удирдаж, захирах гэж оролдолгүй харин харьяа газар дарга нарын бүрэлдэхүүнийг зохион байгуулалтын болоод функциональ удирдлагаар дамжуулан удирдаж, бусад эрх үүргийг нэгж хэсэгт шилжүүлэн тэдэнтэй дүрэм журам хууль, тогтоомж, хариуцлагын биелэлт тооцдог тогтолцоо чухал
- Гаалийн байгууллагыг төрийн тусгай албаны ангилалд оруулсан нь чухамдаа төрийн тусгай чиг үүргийг гүйцэтгэх нарийн мэргэшсэн мэргэжлийн алба гэдгийг нь тодорхойлж буй явдал юм. Өөрөөр хэлбэл гаалийн мэргэшсэн албыг улс төрийн дарангуйлал, бизнесийн түрэлт дайралт, нутаг нуга ах дүүсэг бүлэглэлүүдийн явцуу эрх ашиг, аливаа бохир үйл ажиллагаанд аль болох хутгалдуулахгүй байж, мэргэжлийнх нь чиг шугамыг ямагт тэргүүн зэрэгт тавих бодлогыг хатуу баримтлах нь гаальчдын ёс зүйг дээшлүүлэхэд чиглэгдсэн чухал хамгаалалт болно.
- Хүний үнэлэмж өндөр байх тусмаа байгууллага сайн явна. Гаалийн байгууллагад ажиллах хүмүүсийг сонгохдоо эдгээр хүмүүсийн мэдлэг чадварыг харахаас гадна хэрэгцээг нь тодорхойлж өндөр суртахуунтай хүмүүсийг авч ажиллуулах шаардлагатай юм
- Мэргэшсэн ГУБ-ыг бэлтгэн гаргахын тулд ГУБ-ыг тогтвор суурьшилтай ажиллуулж, томилгооны буюу сонгон шалгаруулах үйл ажиллагааг нээлттэй явуулж цомхон чадварлаг бүтцийг бий болгох, ГУБ-д тавих шалгуурыг өндөрсгөж сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн

ТББ оролцуулах хэрэгтэй. Эдгээр мэргэжилтэн нь хууль сахиулах үүрэгтэйн хувьд худалдаа, бараа, хуулийн гэх мэт мэргэжлийг эзэмшсэн байх ёстой

- Гаалийн байгууллага болон энд ажиллаж байгаа ажилчид нь юун түрүүнд Үндсэн хууль болон, Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл баримтлалаа барьж, дагаж мөрдөж ажиллах ёстой
- Гаальд шударга ёсыг бий болгох ёстой ба бүх хүнд тэгш зарчмаар үйлчлэх ёстой. Байцаагч нарт зориулсан мэргэжлийн болон ёс суртахууны сургалтыг байнга хийдэг байх, ГУБ нар хэрэгт холбогдох үед томилсон газар нь зохих ёсны хариуцлагыг тэр дор нь тооцдог системийг бий болгох
- Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах хэрэгтэй. Олон нийтийн ба ард иргэдийн хяналтын болон мэдээллийн тогтолцоо байдаггүй. Үүнийг яаралтай бүрдүүлэх
- Гаалийн удирдах ажилтныг бэлтгэх, давтан сургах хэрэгтэй бөгөөд энэ талаар шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Үлгэр дууриал болохуйц ёс зүйтэй удирдлагын бүтцийг бүрдүүлэх

Хүнд суртал:

- Гаалийн үйл ажиллагааг автоматжуулах буюу компьютержүүлснээр ажлын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлж, авилгал үйлдэх олон боломжийг хаах ба иргэд шаардлагатай мэдээллээ ГУБ-аас үл шалтгаалан олж авах боломжтой
- Иргэд, бизнесменүүдэд холбоотой бүх мэдээлэл буюу хууль дүрэм, журам, үнийн бааз, үнэлгээний аргыг интэрнэтэд тавих болон үзэхэд хялбар нээлттэй байлгах

Гаалийн хэрэг бүртгэл:

- Гаалийн албыг контрабанд болон бусад гэмт хэрэг, гаалийн зөрчилд хэрэг бүртгэлт хийх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах, эрүүгийн хэрэг үүсгэх, эрэн сурвалжлах шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх ажлын эрхээр хангах зайлшгүй шаардлагатай байна. Гааль дээр гарсан гэмт хэрэг авилгалыг шүүх, цагдаа руу шилжүүлэх биш өөрсдөө дотроо хэрэг бүртгэл явуулдаг байх хэрэгтэй. Шүүх, цагдаа руу явуулсан тохиолдолд гаалийн хэрэг бүртгэх алба нь өөрөө нэхэмжлэгч болдог.
- Гаалийн эрх зүйн үндсэн субъект болсон гаалийн байгууллагад дээр дурьдсан эрхүүдийг холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан олгох үндсэн дээр нэг талаас уг асуудлыг хяналтдаа байлгах, нөгөө талаас түүний өмнөөс үүрэг хариуцлага хүлээх хууль зүйн үндэслэл бий болно

- Энэхүү олон улсын практик үйл ажиллагааг зохистой хэлбэрээр сэргээн шийдвэрлэхгүйгээр улам бүр хүрээгээ тэлж хэдэн зуун сая, тэрбум ам.доллараар яригдаж эхэлсэн худалдааны луйвар, хар тамхи, мансууруулах бодис, төрөл бүрийн аюултай хог хаягдлын контрабанд, валютын “Хайч” зэрэг орчин үеийн хамгийн эмзэг бөгөөд түрэмгийн асуудлуудыг төр, засаг гаалийн байгууллага хяналтандаа авч чадахгүйд хүрнэ гэдгийг гадаад орны туршлага, манай өнөөгийн байдал харуулж байна. Тэгээд ч дэлхий даяараа нэгдсэн сүлжээ бүхий мэргэжлийн гаалийн байгууллага гүйцэтгэж заншсан зүйлийг Монголын нөхцөлд цагдаа, тагнуулд даалгасан нь угаасаа мэргэжлийн бус хандлага болжээ
- Өнөөдрийн байдлаар 2002 оны Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалтыг өөрчлөн амьдралд нийцүүлэх талаар ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Гаалийн байгууллага шинэчлэгдэн батлагдах дээрх хуулиудын үзэл баримтлалд нийцүүлэн Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хойшлуулашгүй ажиллагааны эрх авах мөн эрүүгийн хуулинд гаалийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбогдох тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллах хэрэгтэй гэж үзэж байна
- Гаалийн ажилтан, түншүүд болон энгийн иргэд авилгал, ёс зүйгүй буюу хууль бус ажиллагааны талаар мэдээлэл өгөх явдлыг хөхиүлэн дэмжиж, хэрэв тийм мэдээлэл өгсөн бол шуурхай, нарийвчилсан мөрдлөг явуулж, мэдээллийн эх сурвалжийг нууцлан хамгаалах.

Нийгмийн халамж:

- Олон сая төгрөгийн зөрчил илрүүлсэн ГУБ-ыг шагнаж урамшуулах системийг боловсронгуй болгох
- Төсөвт оруулсан мөнгөний тодорхой хувийг гаальчдад шагнал болгож өгөх
- Сайн ажилласан хүнд шагнал, одон тэмдэг бий болгох
- Цалин хөлсийг нэмэгдүүлэх
- ГУБ-ын шилжих хөдөлгөөнийг журмаар зохицуулах. Жишээ нь, Увсын гаалийн газар гэх мэт ГУБ очих дургүй газар ГУБ-ыг томилохдоо байр, гадаад суралцуулах гэх мэт зүйлээр урамшуулах талаар ч мөн ГЕГ-аас дурьдаж байсан
- Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ санаачлагатай ажиллах, шилжиж ирсэн ажилтнуудын гэр бүлийг ажлын байраар хангаж байх
- Гаалийн ажилчдыг байр орон сууцаар хангахын тулд мөнгөний тодорхой хувийг олгох мөн хөнгөлттэй зээл өгөх гэх мэт арга хэмжээг авах
- Үр дүнгийн гэрээний урамшууллыг өөрчлөх
- ГУБ-ын ажлын хувиарлалтыг сайжруулах

II. Төсөв бүрдүүлэх үүрэг болон татвар цуглуулалт

Бизнес эрхлэгчид барааны тоо хэмжээг дутуу мэдүүлж зөрүүгээр нь ГУБ-д авилгал өгч ганзагын наймаачид улсын төсөвт татвар төлөхгүй, бараа бүтээгдэхүүнийг хууль бусаар хил давуулан оруулж ирэх явдал газар авсан болох нь илт харагдаж байв.

Гаалийн татварын хөнгөлөлт чөлөөлөлтүүд нь зарим талаар татварын адил тэгш, шударга байх зарчмыг алдагдуулах, татвараас зайлсхийх, бууруулах, бага татвар төлөх арга бололцоо олгож байна. НӨАТ нь хэрэглээний татвар тул эцсийн хэрэглэгч л энэ татварыг төлөгч болохоос биш импортлогч, үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгчид татварын нэмэгдэл дарамт болохгүй, харин бараа үйлчилгээний үнэ тодорхой хэмжээгээр нэмэгдэж, зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлөх талтай.

- Төсвийн орлого алдагдах, төсвийн орлогоос луйвардахын эсрэг хяналт шалгалтыг сайжруулах тоног төхөөрөмж, техник технологийг сайжруулах хөрөнгө оруулалтыг хийх
- Контрабандын үйлдэлтэй тэмцэх, зах зээлийн шударга өрсөлдөөн, гадаад худалдааг хөнгөвчилж хөрөнгө оруулалтыг татахын тулд Засгийн газрын хөнгөлөлт чөлөөлөлтийг хязгаарлах
- Тарифын болон тарифын бус бодлогыг оновчтой тодорхойлох
- Татварын хувь хэмжээг бууруулахад татвар төлөх хэмжээ нэмэгддэг. Мөн нуугдмал байсан далд орлого ил болох тал байдаг.
- Гаалийн 5%-аас НӨТ-ын 15%-ийг давхардуулан авч байгааг болих. Энэ нь 0,75% бөгөөд гааль жилд улсын төсөвт 300 тэрбум төгрөг бүрдүүлдэг гэж бодвол 2 тэрбум 250 сая давхар авч байгаа юм.
- Гаалийн татвар 10% НӨТ 10% болсноор импортлогчид гааль дээр 21% татвар төлөхөөр харагдаж байна.
- Жишиг үнийг зөвхөн Хятадаас импортлож буй бараанд хэрэглэх
- Гаалийн татварыг ялгавартай тогтоохдоо дотооддоо үйлдвэрлэж болох барааг судлан хамруулах
- Гааль дээр хурааж буй гаалийн татвар болон НӨАТ-ыг тусад нь авдаг тогтолцоог бий болгох
- Эсвэл гааль дээр татвар хураах тогтолцоог боловсронгуй болгож дотоод хяналтын программууд, дотоодын болон хөндлөнгийн /гаднын байгууллагын/ аудитын хяналт, мөрдөн шалгалт, байцаалт зэрэг хяналт, шалгалтын аль тохиромжтой механизмыг нэвтрүүлбэл тэр нь гаалийн байгууллагад авилгал гарахаас урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих ажилд тус дөхөм болно

- Гаалийн үйл ажиллагаанд квот, демпинг, ялгавартай татвар тарифын хэрэглүүрийг ашигтай нөхцөлөөр хэрэглэх, чадваргүй байгаа мэргэжлийн агентлагуудыг чадваржуулж, гадаад худалдаа зохицуулалтын дээрх арга хэрэгслүүдийг өргөн ашиглаж болохуйц эрх зүйн механизм тогтоох

Гаалийн байгууллагаас татвар ногдуулах, барагдуулах үйл ажиллагааг боловсронгуй болгож гааль татвар, банкны байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулах шаардлагатай. Үнэлгээний луйвар, контрабанд нарийсч байгаа учраас гаалийн хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалтыг дэлхийн бусад орны жишигт хүргэх зорилтыг тавих шаардлагатай. Саяхан Гэнэтийн ашгийн татварын хууль батлагдсанаар алт, зэс гэх мэт барааг гаалиар хууль бусаар гаргаж эхэлж байна.

III. Засгийн газрын зүгээс

Гадаад худалдааг либералчлахад өнөөгийн нөхцөлд татварын уян хатан бодлого үгүйлэгдэж байгаа ба экспортыг хөхиүлэн дэмжиж, үндэсний үйлдвэрлэгчдийг гадаадын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх, эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэхэд гаалийн тарифын зохистой тогтолцоог бүрдүүлэх явдал нэн тэргүүнд тавигдаж байна.

IV. Техник технологи зөвлөмж

Гаалийн бүрдүүлэлт болон хяналт шалгалтын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хялбарчлах, сайжруулахад хөрөнгө оруулалтын бодлогыг чиглүүлж өндөр, нарийн технологитой хяналт шалгалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр гаалийн байгууллагыг хангах. Үүнд:

- хилийн ба гүнийн гааль дээр явуулын болон суурин лаборатори байгуулж төв лабораторитой сүлжээгээр холбох
- барааг гаальд мэдүүлэх журмыг боловсронгуй болгож алсаас болон урьдчилан мэдүүлэх замаар бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хялбарчлах
- хил дээр байрлах ачааны болон зорчигчийн терминалыг салгаж, шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулж үйл ажиллагааг хялбарчлах
- алслагдсан боомтуудыг гаалийн мэдээллийн нэгдсэн онлайн сүлжээнд холбох
- гаалийн хяналт шалгалт хийх, бараа ачиж буулгах ажлыг механикжуулах
- байнгын болон түр ажиллагаатай боомтуудад хяналт шалгалт хийх орчинг бүрдүүлэх
- гаалийн холбогдолтой мэдээллүүд, хууль тогтоомж, дүрэм журмыг ил тод байлгаж, ойлгомжтой байдлаар интернетэд байрлуулах

V. Гаальтай машин:

- “Авто тээврийн тухай хууль”-ийн 3.1.7-д “Улс хоорондын тээвэрлэлт гэж Монгол Улсын хилийг нэвтрэн хийх тээвэрлэлтийг” хэлнэ гэж заасан байдаг тул Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас БНХАУ-ын Эрээн хотын хооронд болон Алтанбулаг боомт хотоос ОХУ-ын Наушка хүртэл хийх зорчигч тээвэрлэлт нь улс хоорондын тээвэрлэлт болно. Гаальтай машиныг арилгахын тулд тээвэрлэлтийн нэгдсэн бодлого шаардлагатай.
- “Авто тээврийн тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 8.1-т “Олон улсын тээврийг тухайн улсын хууль ёсоор зөвшөөрөгдсөн авто тээврийн байгууллага хариуцан гүйцэтгэнэ” гэж заасан билээ. Иймд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тээвэрлэлт хийх зөвшөөрлийг цаашид Монгол Улсын эрх бүхий байгууллага /Зам тээвэр, аялал, жуучлалын яам/-аас улс хоорондын тээвэрлэлтийн шаардлага хангасан авто тээврийн байгууллага, аж ахуйн нэгжид олгох бодлого баримтлах хэрэгтэй
- Хэдийгээр өнөөдөр Замын-Үүдэд явж буй УАЗ-469 автомашины хөдөлгөөнийг зогсоогоогүй байгаа боловч цаашид хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс зөвшөөрөл олголтыг багасгах замаар тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг шат дараатай авах хэрэгтэй
- Байнгын зорчигч тээврийг графикийн дагуу явуулж чадах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах
- Уг асуудлыг шийдэхдээ хүнийг нь тусдаа, ачаа барааг нь тусдаа зөөж байхаар шийдвэл гаалийн байцаагчид авилгал авч өгөх үзэгдэл багасахаас гадна хилээр орж гарч байгаа бараа таваарын хяналтыг гүйцэд хийх техникийг зохих журамын дагуу ашиглах боломжтой болно.

Зориг сан

Зориг сан нь 1998 оны 10 дугаар сард С.Зориг агсаны дотны нөхөд, хамтран зүтгэгчид, гэр бүлийнхний санаачилгаар байгуулагдсан ашгийн бус, биеэ даасан, олон нийтийн, төрийн бус байгууллага /ТББ/ юм.

Сангийн эрхэм зорилго нь Монгол оронд ардчилсан нийгмийг төлөвшүүлэн хөгжүүлэх, улс төрийн шинэчлэлийг дэмжих, иргэдэд ардчиллын үнэт зүйлсийг хэвшүүлэх, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн шударга ёсыг хамгаалах, олон ургальч үзлийг хүндэтгэх, төр засгийн үйл ажиллагааг нийгэмд нээлттэй ил тод байлгах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэдэг.

Эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд дараах үндсэн гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг:

- Залуучуудын иргэний болон улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилалд тэдний оролцоог идэвхжүүлэн нэмэгдүүлэх,
- Ил тод байдал, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх болон авилгалын эсрэг үзэл санааг сурталчлах, олон нийтийг энэ чиглэлд гэгээрүүлэх,
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалж баталгаажуулах, хууль зүйн актуудыг боловсронгуй болгох.

Мониторингийн багийн бүрэлдэхүүн:

| | |
|------------|---------------------|
| Б.Наранзул | Төслийн зохицуулагч |
| Ч.Батбямба | Төслийн ажилтан |
| Г.Чинзориг | Төслийн ажилтан |
| Б.Оюунхүү | Төслийн ажилтан |
| Н.Галцог | Төслийн ажилтан |
| Т.Уянга | Социологич |

Ном зүй

1. Гаалийн хууль тогтоомжын эмхтгэл
2. Гаалийн эрх зүй, Ерөнхий Тусгай анги, Улаанбаатар хот, 2003 он, Ш. Цогтоо
3. Татварын шинэтгэл:Хувийн хэвшлийн санал, байр суурь, 2005 он, МҮХАҮТ
4. Main activities of the Mongolian National Chamber of Commerce and Industry for 2006
5. “Монгол Улсын Гаалийн Байгууллагын шинэчлэл, үр дүн” Тайлан-2005 он

6. “Монгол Улсын Гаалийн Байгууллагын шинэчлэл, үр дүн” Тайлан-2000-2004 он
7. ГЕГ-ын үйл ажиллагааны стратегийн зорилт, 2005 оны 4 дүгээр сар
8. ГЕГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2006 он
9. Монголын ноолуур хаашаа үрсчихваа?, 2004.11-р сар Өдрийн сонин
10. Хар төмрийн контрбандын хэрэг, 2006.6.5, Зууны Мэдээ
11. Татварын өөрчлөлт нь бизнесийн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэнэ, 2006.04.17, МОНЦАМЭ
12. Монгол Улсын Эдийн Засаг, Нийгмийн Байдлын тухай танилцуулга, 07/2005
13. Бизнесийн орчинг сайжруулахтай холбогдон гарсан санал, судалгаа, тайлангуудын нэгтгэл, 2005 он, Улаанбаатар
14. Монгол Улсын гаалийн байгууллагын өөрчлөлт, шинэчлэлд зориулав, С.Цэцэгээ, 2006.01.24, Өдрийн сонин
15. Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал
16. Гааль ил тод болно гэв үү, Болор, 2006.03.13, Өнөөдөр сонин
17. “Хуулиа дээдэлж хамтын ажиллагааны үр өгөөжийг сайжруулья 2004” сэдэвт зөвлөлгөөний тэмдэглэл, Замын-Үүд, 2004.04.25
18. Х.Баатарыг өмгөөлөх үндэслэл хангалттай байхад чинь, Ш.Цогтоогийн ярилцлага
19. “Хүнсний хангамж, Аюулгүй байдал, хоол тэжээл” Үндэсний Хөтөлбөр, 2004.11.01, Зууны мэдээ
20. Хүнсний Хангамж, Аюулгүй байдал, хоол тэжээл, Үндэсний хөтөлбөр ба салбар дундын хамтын ажиллагаа, 2004.11.18, Зууны мэдээ
21. Монгол улс: Хөрөнгө оруулалтыг дэмжиж ажлын байр бий болгох нь, Дэлхийн банкны тайлангийн хураангуй, 2006.02 дугаар сар
22. Монгол гааль, Эрдэм шинжилгээ, онол арга зүйн сэтгүүл, 2005. №01
23. Монгол Улсын Эдийн Засаг, Нийгмийн байдлын тухай танилцуулга, 06/2006
24. Бизнесийнхэн Хөгжлийн Төлөө, МХАҮТ, 2005 он, Улаанбаатар
25. Статистикийн Бюллетень, МУҮСГ, 04/2005
26. Статистикийн Бюллетень, МУҮСГ, 07/2005
27. Монгол улсын эдийн засаг, нийгмийн байдлын тухай танилцуулга, 6/2006
28. Гаалийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, 2005 оны эхний 10 сар
29. Хилийн хөдөлгөөний мэдээ

30. МУГЕГ-ын харьяа газар хороодын жилийн ажлыг дүгнэх хүснэгт
31. Гаалийн ажилтны зөвлөлгөөнд ГЕГ-ын дарга Б.Баттөмөрийн тавьсан илтгэл, 2/2006
32. Арушагийн шинэчлэгдсэн тунхаглал, 07/2003
33. Best practices in customs reform-lessons from Morocco, Apr.2002 U.S.Customs and Border protection
34. ГЕГ-ын Хүний нөөцийн хэтийн ба ойрын төлөвийн ерөнхий хөтөлбөр
35. Хил дээрх гаальтай машин гал ноцоох юм биш биз, 3.23.2006 Өнөөдрийн Монгол

Товчилсон нэр:

| | |
|----------|---|
| ОНМХ | Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл |
| ГЕГ | Гаалийн Ерөнхий Газар |
| ГУБ | Гаалийн Улсын Байцаагч |
| ДХБ | Дэлхийн худалдааны байгууллага |
| ДГБ | Дэлхийн гаалийн байгууллага |
| ОУ | Олон Улс |
| СЯ | Сангийн Яам |
| НӨАТ | Нэмүү өртгийн албан татвар |
| ААНБООАТ | Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар |

Төрөөс өрх, иргэнд газар өмчлүүлэх /эзэмшүүлэх/ үйлчилгээнд хийсэн мониторинг

Төслийн зорилго:

Өрхөд газар өмчлүүлэх болон иргэдэд эзэмшүүлэх харилцааг зохион байгуулах төрийн үйлчилгээнд мониторингийн үнэлгээ хийх.

Төслийн зорилт:

- Газрын харилцааны үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавин, хөндлөнгийн үнэлэлт өгөх,
 - а. Үйлчилгээний явцад ажиглалт хийж, иргэдийн хувьд зөрчилтэй, хүндрэлтэй байдлыг тодруулах,
- Нийтийн орон сууцанд амьдардаг өрхүүдийн:
 - а. Газар өмчлөлд хамрагдсан байдлыг тодорхойлох,
 - б. Газар өмчлөлтэй холбоотой хүндрэл гарсан байдлыг тодруулах, нэмэлт мэдээлэл авах.

Мониторингийн үндэслэл

Монгол Улсын Засгийн газар улс орны эдийн засаг, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын чадавхийг нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах үндсэн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс газрыг өмчлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж эхэлсэн.

Анх 1992 онд шинэчлэн батласан Үндсэн хуулинд Монгол Улсын иргэн хувийн өмчийн газартай байж болох үзэл баримтлалыг тусган өгсөн нь газрын шинэтгэлийн бодлогыг батлан хэрэгжүүлэх үндсэн суурь болж өгсөн бөгөөд 2003 онд “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль” батлагдаж, улмаар Засгийн газрын тогтоолоор 2023 он хүртэлх “Монгол Улсын газар

зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө"-г баталснаар газрын шинэтгэлийн үе эхэлсэн гэж үздэг.

Хуулинд зааснаар, гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг газар өмчлөх гэнэ. Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн газар өмчлөн авах эрхтэй ба Монгол Улсын иргэн, түүний гэр бүлийн гишүүнд дундаа хамтран өмчлөх хэлбэрээр гэр бүлийн хэрэгцээнд газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажээ.

Өнөөдөр улсын хэмжээнд 260.2 мянган иргэн 184.9 мянган га, 5.0 мянган төрийн байгууллага 3494.5 мянган га, 14.2 мянган аж ахуйн нэгж 1004 мянган га газрыг эзэмшиж, 394 гадаадын иргэн, харъяалалгүй хүн, байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж 51.0 мянган га газрыг шинэ хуулийн дагуу баталгаажуулан ашиглаж байна¹. 2003-2005 онд аймаг, нийслэлд бүгд 143 удаа газар эзэмших эрхийн дуудлага худалдаа, 50 төсөл шалгаруулалтыг зохион байгуулжээ.

Монгол Улс иргэддээ газар өмчлүүлэх ажлыг эхлүүлээд багагүй хугацаа өнгөрсөн ч өмчлөх эрх бүхий бүх субъектийг бүрэн хамарч чадаагүй байгаа бөгөөд 2006 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 138463 өрх гэр бүлийн хэрэгцээний газраа өмчилж аваад байгаа нь бүртгэгдсэн нийт өрхийн ердөө 24.81 хувь болж байгаа юм. Шинээр төлөвлөсөн суурьшлын бүсэд гэр бүлийн хэрэгцээндээ газар өмчилж авсан өрхийн тоо улсын хэмжээнд 23694 байна.

Төслийн хүрээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Орхон аймаг, Хөвсгөл аймгийн газрын албаны үйл ажиллагаанд мониторинг хийсэн ба тухайн нутаг дэвсгэрт харьяалагдах өрх, иргэдийн газрын үйлчилгээний талаарх мэдлэг, хандлага, оролцоог тодорхойлоход ч мөн анхаарсан болно.

¹ Эх сурвалж: "Төрөөс өрх, иргэдэд газар өмчлүүлэх /эзэмшүүлэх/ үйлчилгээг боловсронгуй болгох нь" мониторингийн төслийн үр дүнгийн хурал. "Иргэнд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх үйлчилгээний өнөөгийн байдал" Илтгэгч ГХГЗЗГазрын ГЗБ-ын хэлтэсийн дарга Ч.Гомбосүрэн

Мониторингийн аргачлал

1. Мэдээлэл цуглуулах

Хүснэгт 1

| Аргууд | Хэрэглэгдэхүүн | Хариулагч | Хэмжээ |
|---------------------------------------|---------------------------|-----------------------------|--------|
| Хөндлөнгийн стандартчлагдсан ажиглалт | Ажиглалтын хуудас | Үйлчилгээ | - |
| Стандартчлагдаагүй ажиглалт | Судлаачийн тэмдэглэл | Мэдээлэл өгөгч | - |
| Асуулга | Анкет | Үйлчлүүлэгч | 100 |
| Асуулга | Анкет | Оршин суугч | 500 |
| Ганцаарчилсан ярилцлага | Протокол | Үйлчлүүлэгч, мэдээлэл өгөгч | - |
| Бичиг баримтын шинжилгээ | Хуулбар, зураг, тэмдэглэл | Мэдээллийн самбар | - |

2. Мэдээллийг шалгах

- Эх сурвалжийг мэдэгдэлгүйгээр бичиг баримтын тулгалт хийх
- Эх сурвалжийг мэдэгдэлгүйгээр эзэн биегүй тодруулга хийх
- Эх сурвалжаас шалгах ярилцлага авах

3. Мэдээллийг баримтжуулах

- Бичгээр
- Бичлэгээр
- Зураг

4. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх

- Эмпирик мэдээлэлд тоон боловсруулалт хийх
- Эмпирик мэдээллийг хүн ам зүйн болон шинж тэмдгийн хүчин зүйлстэй харьцуулах
- Чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх
- Харьцуулсан шинжилгээ хийх
- Нэгтгэн дүгнэх

5. Мэдээллийг харьцуулан үнэлэх

- Бодит мэдээллийг хууль тогтоомжийн заалттай харьцуулан үнэлэх

- Бодит мэдээллийг стандарттай харьцуулан үнэлэх
- Мэдээллийг бодит байдалтай харьцуулах

б. Явцын нөлөөллийг хэрэгжүүлэх

- Албан хаагчдад шаардлага тавих, зөвлөгөө өгөх
- Албан тушаалтанд мэдээлэл өгөх, хүсэлт гаргах
- Холбогдох газар, албан тушаалтнуудын хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулах

Төслийн хамрах хугацаа, хүрээ, байршил

Төсөл нь 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж 2006 оны 5 дугаар сарын 30-ны өдөр хүртэл үргэлжилсэн бөгөөд нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Орхон, Хөвсгөл аймгуудын Газрын Албаны үйлчилгээ, газрын албаар үйлчлүүлэгсэд, орон сууцны оршин суугчдын хүрээнд хэрэгжүүлсэн болно.

Газар өмчлөлийн харилцаанд холбогдох хуулийн заалтууд

Хүснэгт 2. Газрын харилцаанд холбогдох хуулиуд²

| № | Хууль | Огноо | Хуулийн зүйл заалт |
|---|---|------------|--|
| 1 | Монгол Улсын Үндсэн хууль | 1992.01.13 | 1.6.1, 1.6.2, 1.6.3, 1.6.4, 1.6.5, 1.16.3, 3.38.1, 3.38.2.1, 3.38.2.4, 3.38.2.5, 3.38.2.7, 3.38.3 |
| 2 | Монгол Улсын Иргэний хууль | 2002.06.07 | 1, 10, 11 дүгээр бүлэг, 11 дүгээр бүлгийн 1, 2, 5, 6 дугаар дэд бүлэг, 13 дугаар бүлгийн 1, 3, 4 дүгээр дэд бүлэг, 1 дүгээр дэд хэсэг, 22 дугаар бүлэг 1, 4, 6 дугаар дэд бүлэг, 23 дугаар бүлэг, 25 дугаар бүлэг, 27 дугаар бүлэг, 28 дугаар бүлэг, 37 дугаар бүлэг |
| 3 | Газрын тухай хууль | 2002.06.07 | 7 бүлэг 64 зүйлтэй, агуулгын зарим тодотголыг тайлан-гийн дараах дэд гарчгаас уншина уу. |
| 4 | Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай | 2002.06.27 | 7 бүлэг 42 зүйлтэй, агуулгын зарим тодотголыг тайлан-гийн дараах дэд гарчгаас уншина уу. |

² Эх үүсвэр: Газрын харилцааны хууль тогтоомжийн эмхэтгэл УБ., 2006 Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн Газар

| № | Хууль | Огноо | Хуулийн зүйл заалт |
|----|---|------------|---|
| 5 | Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль | 2002.06.27 | 5 зүйл |
| 6 | Газрын төлбөрийн тухай хууль | 1997.04.24 | 13 зүйл |
| 7 | Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль | 2002.06.19 | 5 бүлэг 39 зүйл |
| 8 | Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай | 2005.07.07 | 6 бүлэг 29 зүйл |
| 9 | Геодези, зураг зүйн тухай хууль | 1997.10.31 | 3 бүлэг 15 зүйл |
| 10 | Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль | 1999.12.16 | 4 бүлэг 21 зүйлтэй. |
| 11 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль | 2000.11.17 | 10 зүйл |
| 12 | Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль | 1993.05.10 | 1 дүгээр зүйл 21 дүгээр зүйл |
| 13 | Ашигт малтмалын тухай хууль | 1997.06.05 | 10 бүлэг 65 зүйл |
| 14 | Монгол Улсын хилийн тухай хууль | 1993.10.21 | 1 дүгээр бүлэг 1, 3, 7, 8 дугаар зүйл 2 дугаар бүлэг 12, 13 дугаар зүйл |
| 15 | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль | 1994.11.15 | 8 бүлэг 44 зүйл |
| 16 | Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль | 1997.10.23 | 11 зүйл |
| 17 | Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль | 2004.01.02 | 5 зүйл |
| 18 | Тариалангийн тухай хууль | 2004.04.22 | 6 бүлэг 18 зүйл |
| 19 | Барилгын тухай хууль | 1998.08.07 | 7 бүлэг 19 зүйл |
| 20 | Хот байгуулалтын тухай хууль | 1998.10.29 | 4 бүлэг 16 зүйл |
| 21 | Чөлөөт бүсийн тухай хууль | 2002.06.28 | 1 дүгээр бүлэг 1, 3, 5, 7, 11, 12 дугаар зүйл, 3 дугаар бүлэг 13, 16, 17, 18 дугаар зүйл |
| 22 | Байгаль орчныг хамгаалах тухай хууль | 1995.03.30 | 1 дүгээр бүлэг 1, 2, 3, 4, 5, 6, 12 дугаар зүйл, 3 дугаар бүлэг 13, 15, 17, 18, 22 дугаар зүйл, 5 дугаар бүлэг 26, 27, 28 дугаар зүйл 6 дугаар бүлэг 30, 31 дүгээр зүйл |

| № | Хууль | Огноо | Хуулийн зүйл заалт |
|----|--|------------|---|
| 23 | Харилцаа холбооны тухай хууль | 2001.10.18 | 1 дүгээр бүлэг 1, 3 дугаар зүйл, 7 дугаар бүлэг 27, 28, 29, 32 дугаар зүйл |
| 24 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай | 1998.01.22 | 4 бүлэг 13 зүйл, хавсралттай |
| 25 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай хууль | 2000.01.28 | 6 зүйл |
| 26 | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль | 2000.02.01 | 1 дүгээр зүйл 15 дугаар зүйл |
| 27 | Авто замын тухай хууль | 1998.01.02 | 1 дүгээр бүлэг 1, 2, 3 дугаар зүйл, 2 дугаар бүлэг 4, 5 дугаар зүйл, 3 дугаар бүлэг 10, 11, 12 дугаар зүйл, 4 дүгээр бүлэг 15, 16, 17 дугаар зүйл |
| 28 | Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль | 2003.01.28 | 1 дүгээр зүйл 7 дугаар зүйл 12 дугаар зүйл 14 дүгээр зүйл 15 дугаар зүйл 18 дугаар зүйл 21 дүгээр зүйл |
| 29 | Төмөр замын тээврийн аюултай байдлын тухай | 1996.05.06 | 1 дүгээр бүлэг 1, 3, 7, 9, 11 дүгээр зүйл, 3 дугаар бүлэг 12, 14, 16 дугаар зүйл, 5 дугаар бүлэг 17, 18, 19 дугаар зүйл |

Хүснэгт 3. Монгол Улсын Засгийн газрын тогтоол³

| № | Нэр | Огноо | Дугаар |
|---|---|------------|--------------|
| 1 | Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | 1997.06.25 | ЗГТ 1997/152 |
| 2 | Хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | 2003.02.07 | ЗГТ 2003/28 |
| 3 | Аргачлал, үнэлгээ батлах тухай | 2003.04.30 | ЗГТ 2003/103 |
| 4 | Хураамжийн хэмжээ тогтоох тухай | 2003.09.17 | ЗГТ 2003/205 |
| 5 | Журам батлах тухай | 2003.09.25 | ЗГТ 2003/213 |
| 6 | Журам батлах тухай | 2004.02.25 | ЗГТ 2004/48 |

Хүснэгт 4. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын тушаал⁴

| № | Нэр | Огноо | Дугаар |
|---|--|------------|-----------------|
| 1 | Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | 2003.04.28 | ГХГЗЗГ 2003/157 |
| 2 | Журам батлах тухай | 2005.05.05 | ГХГЗЗГ 2003/165 |
| 3 | Аргачлал батлах тухай | 2003.07.09 | ГХГЗЗГ 2003/218 |

Хүснэгт 5. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дэд дарга бөгөөд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын ерөнхий бүртгэгчийн тушаал⁵

| № | Нэр | Огноо | Дугаар |
|---|---------------------|------------|--------------|
| 1 | Загвар батлах тухай | 2005.03.12 | ЭУЕБ 2005/24 |
| 2 | Журам батлах тухай | 2005.05.27 | ЭУЕБ 2005/39 |

³ Эх үүсвэр: Газрын харилцааны хууль тогтоомжийн эмхэтгэл УБ., 2006 Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн Газар

⁴ Мөн тэнд

⁵ Мөн тэнд

МОНИТОРИНГИЙН ДҮН

*Газар өмчлүүлэх арга хэмжээг газар өмчлөн авахыг хүссэн иргэний сайн дурын үндсэн дээр . . . явуулах;
/МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль- 5.1.1./*

Мониторингийн үр дүнг танилцуулахын өмнө сонгогдсон нэгжүүд дэх газрын үйлчилгээний ерөнхий дүр зураг, үйлчилгээг хүртэж буй болон хүртэх ёстой иргэдийн мэдлэг, хандлага ямар байдалтай байгааг авч үзэх нь зайлшгүй билээ. Учир нь үйлчилгээг хүргэх нөхцөл, үйлчлүүлэгсдийн идэвх оролцоо нь тухайн үйлчилгээ, түүний чанар, хүртээмжийг бодитой үнэлхэд нөлөөлөх чухал хүчин зүйлс болох юм.

Сонгогдсон нэгжүүд газрын үйлчилгээний дүр зураг

Газрын үйлчилгээний дүр байдлыг зураглахад ашиглагдаж буй мэдээллийг мониторингийн явцад стандартчлагдсан ажиглалтаар цуглуулан харьцуулж дундаж үзүүлэлтээр тооцон гаргасан болно.

Хүснэгт 5

| | Сонгинохайрхан дүүрэг | Хөвсгөл аймаг | Орхон аймаг |
|--|---|---|--|
| Ажлын нэг өдөрт үйлчлүүлж буй үйлчлүүлэгсдийн тоо | Дунджаар 156 | Дунджаар 2 | Дунджаар 35 |
| Ажлын нэг өдөрт нэг ажилтны үйлчилж буй үйлчлүүлэгсдийн тоо | Дунджаар 40 | Дунджаар 2 | Дунджаар 20 |
| Үйлчилгээний дотоод зохион байгуулалт, үйлчилгээний орчны нөхцөл | Ажлын 4 өрөөтэй үйлчлүүлэгсдэд зориулсан заал, хүлээлгийн суудалгүй, 7 хоногийн 2 өдөр гадуур ажилтай, үйлчилгээний нөхцөл хангалтгүй | Үйлчилгээний нөхцөл, дотоод зохион байгуулалт үйлчлүүлэгсдийн ачаалалтай харьцуулахад хангалттай. | Үйлчилгээний нөхцөл, дотоод зохион байгуулалт үйлчлүүлэгсдийн ачаалалтай харьцуулахад хангалттай. |
| Мэдээллийн үйлчилгээ, түүний хэлбэр, хүртээмж | Самбараар хэвлэмэл байдлаар голчлон өгдөг, зарим үйлчлүүлэгсдэд тайлбарт мэдээлэл өгдөг | Өдөрлөг байдлаар зохион байгуулж, орон нутгийн мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдээллийг түгээдэг. Өдөр тутмын болон байнгын мэдээллийн үйлчилгээ хангалтгүй | Самбараар хэвлэмэл байдлаар голчлон өгдөг, зарим үйлчлүүлэгсдэд тайлбарт мэдээлэл өгдөг Зохион байгуулалттайгаар оршин суугчдад мэдээлэл өгөх байдал нэмэгдсэн |
| Мэдээллийн самбарт хандан мэдээлэл авсан иргэдийн тоо | Үйлчлүүлж буй иргэдийн талаас илүү хувь | - | Үйлчлүүлж буй иргэдийн ихэнх хувь |

Сонгож авсан нэгжүүд дэх үйлчилгээний дүр зураг харилцан адилгүй байв. Өөрөөр хэлбэл мониторинг хэрэгжүүлсэн эхний нэгжийн ачаалал нь хэтэрсэн, хоёр дахь нэгжийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон, гурав дахь нэгжийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байлаа.

Сонгогдсон нэгжүүд дэх иргэд, оршин суугчдын газар өмчлөлийн талаарх ойлголт, хандлага


Сонгогдсон нэгжүүд дэх оршин суугчдын газар өмчлөлийн талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох үүднээс асуулга явуулсан бөгөөд судалгаанд сонгогдсон нэгжүүдийн харьяа нутаг дэвсгэрийн орон сууцны өрхүүд хамрагдсан болно.

График 1. Судалгаанд оролцогчдын газар өмчлөл, эзэмшихтэй холбоотой эрх зүйн мэдлэг



Асуулгын дүнгээс харахад иргэдийн дунд газар өмчлөлийн тухай ойлголт хангалтгүй байна гэсэн дүгнэлтийг хийж болох бөгөөд газар өмчлөхийн ач холбогдлыг ойлгоогүй, үл ойшоосон байдал багагүй байв. Ялангуяа орон нутагт энэ талын хэрэгцээ үүсээгүй байгааг өмчилж авсан газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл огт бүрдээгүй байгаагаар тайлбарлаж болох юм. Газрын үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхээр хандсан болон үйлчилгээ хүртэж буй иргэдийн хувьд энэ талын мэдлэг, ойлголт хангалтгүй байгааг дараах зургаас харж болно.


График 2. Газрын албаар үйлчлүүлэгсдийн газар өмчлөх, эзэмших эрхтэй холбоотой эрх зүйн мэдлэг



Хэдийгээр эл үйлчилгээг авч буй иргэд үйлчилгээнд хамрагдаагүй оршин суугчдаас илүү газрын эрх зүйн мэдлэгтэй ч, газрын үйлчилгээ харьцангуй сайн хэмээн үнэлэгдэж буй Орхон аймагт нэг өдөрт үйлчлүүлж буй иргэдийн 27-28 нь, ачаалал өндөртэй Сонгинохайрхан дүүргийн газрын албаар үйлчлүүлж буй гурван хүн тутмын хоёр нь холбогдох хуулиа судлаагүй байдаг байна.

Газар өмчлөлийн тухай ерөнхий мэдлэг ойлголт хангалтгүй байгаа ч иргэд харьяа газрын албаны үйлчилгээний талаар “илүү мэдэж” үнэлэлт өгч байв. Хамгийн сонирхолтой нь газрын үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлж буй хүмүүс үйлчлүүлж амжаагүй байгаа хүмүүсээс илүү сайн үнэлгээг өгчээ

График 3. Газрын үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлж байсан иргэдээс үйлчилгээг сайн гэж үнэлсэн байдал




Газар өмчлөлийн харилцаатай холбоотой иргэдийн идэвх оролцоо, хандлагыг тодорхойлогч үндсэн зүйл нь газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах явдал юм. Нийслэлийн оршин суугчдын хувьд өмчилж авсан газраа худалдах, зээлийн барьцаанд тавих, түрээслэх боломж харьцангуй өндөр бөгөөд 2004-2005 оны байдлаар газраа банкинд барьцаалан зээл авсан иргэд 4277 байгаагийн 28.37 хувийг Сонгинохайрханчууд эзэлж байна.

Хөвсгөл аймгийн хувьд үл хөдлөх хөрөнгө буюу барилга, байшин барьсан тохиолдолд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл бүрдэж байгаа ба үндсэндээ газрынх нь бус дээр байгаа үл хөдлөх хөрөнгийн үнэлгээгээр үнэ нь тогтож байгаа юм. Газрыг барьцаалан зээл олгох үйлчилгээ өнөөгийн байдлаар огт нэвтрээгүй байгаа төдийгүй хамгийн үнэ хүрдэг газрууд нь аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий газрууд байдаг ажээ. Өмчилж авсан газраа үл хөдлөх хөрөнгөтэй тохиолдолд л банкинд барьцаалах байдал Орхон аймгийн хувьд багагүй байдаг ч иргэд хоорондын газрын худалдаа хэрэгжих боломж бага байдаг байна.

Сонгогдсон нэгжүүдийн газрын үйлчилгээний тухай

График 4. Газрын үйлчилгээг хүртэхэд иргэдэд хүндрэл гарсан байдал



Мониторингийн явцад судалгаанд хамрагдсан иргэд, оршин суугчдаас өгсөн мэдээллээс үзэхэд газрын харилцаанд холбогдох үйлчилгээг авахад төвөгтэй байдаг гэжээ. Түүнчлэн энэ үйлчилгээг хүргэдэг төрийн албан хаагчид ч багагүй хүндрэлтэй тулгардаг аж.

Эндээс хэнд, ямар хүндрэл, юунаас шалтгаалан тулгарч байна вэ гэсэн асуулт урган гарч ирж байна. Эн тэргүүнд газрын үйлчилгээнд хамгийн түгээмэл тохиолдож байсан хүндрэлтэй асуудлыг авч үзье.

Үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмж

Иргэд, оршин суугчдын дунд хангалттай мэдээлэл байхгүй байх явдал мониторингийн явцад хамгийн түгээмэл тохиолдож байлаа. Иргэд газар өмчлөлийн үйл ажиллагаа, өмчлөх, эзэмших, ашиглах эрх, газрын үйлчилгээг хүртэх шат дараалал, цаг хугацааны талаар нэгдсэн зөв ойлголтгүй байсан төдийгүй өрх, ам бүл, гэр бүл хэмээх ойлголтуудыг ялгаж чадахгүйгээс болж төөрөлдөх байдал их байв.

Газар хаана өмчилж болох тухай ойлголт байгаагүй тул тодруулахаар 3 удаа очсон ч хангалттай мэдээлэл авч чадаагүй. Одоо яаж хөөцөлдөхөө ч мэдэхгүй байна.

Ч.А - СХД 6 хороо

Нөгөө талаас газрын үйлчилгээнд харилцан адилгүй түвшний боловсролтой үйлчлүүлэгчдэд зориулсан энгийн ойлгомжтой мэдээлэл, тайлбар өгөх сурталчилгааны хэрэглэгдэхүүн, тухайлсан асуудлаар нэмэлт мэдээлэл өгөх үйл ажиллагаа хангалтгүй байна.

Мэдээлэл авахаар ажлын зай завсраар Мөрөн сумын захиргаагаар ордог боловч хариуцсан мэргэжилтэнтэй нь таарч байгаагүй. Би лав сүүлийн 2 сарын дотор 4 удаа очсон.

М.Д Хөвсгөл, Мөрөн

Өрх иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээнд, тэр дундаа газрын үйлчилгээний хувьд холбогдох хууль, тогтоомж, журам заавар төдийгүй газрын нэгдсэн мэдээлэл, үйлчилгээний онцлог, бодлого, үйл ажиллагааны талаар иргэдэд байнга мэдээлэл өгч байх шаардлагатай нь эндээс харагдаж байсан ба үнэн зөв мэдээлэл хангалтгүйгээс иргэд, үйлчлүүлэгчдийн дунд хардалт, буруу ташаа ойлголт, идэвх оролцоо буурах зэрэг сөрөг хандлагууд бий болж, энэ нь эргээд үйлчилгээг хүргэхэд хүндрэл учруулдаг байна.

Мэдээлэл өгөх үйлчилгээ яагаад хангалтгүй байна вэ?

- Иргэдэд зориулсан мэдээллийн хэвлэмэл зурагт хуудас нь бөглөгдөөгүй хоосон өргөдлийн маягтууд байдаг. Үйлчлүүлэгчдийн хувьд энэ нь төдийлөн ойлгомжтой бус бөгөөд магадгүй хэрхэн бөглөх талаар заавар байсан бол иргэд түүнд илүү ач холбогдол өгөх байлаа.
- Газрын үйлчилгээнд ашиглагдаж буй самбар дахь хэвлэмэл мэдээлэл нь үйлчлүүлэгч бүрт жигд хүртээмжтэй бус, ачаалал ихтэй үед самбараас хэрэгтэй мэдээллээ олж харах, тэмдэглэж авахад түвэгтэй байв. Түүнчлэн мэдээлэл нь нийгмийн харьцангуй боловсролтой хэсгийнхэнд зориулагдсан ба бичиг үсгийн боловсрол багатай болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд самбараас хангалттай мэдээлэл авах боломжгүй юм.

- Олон нийтийн дунд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж буй болон зохион байгуулалттай өдөрлөг байдлаар хүргэж байгаа мэдээлэл нь ихэвчлэн иргэдийн газрын үйлчилгээнд хамрагдах идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байдаг. Тэгвэл мэдээлэл хангалтгүй хэмээн “бухимдаж” буй иргэд, үйлчлүүлэгчид нь газрын үйлчилгээний талаар илүү тодорхой мэдээллийг шаардаж байна.
- Үйлчилгээний ачаалал өндөртэй албадын хувьд мэдээлэл өгөх үйлчилгээнд зориулах цаг зав, нөөц боломж харьцангуй хязгаарлагдмал байдгаас үүдэлтэй бухимдал хаа хаанаа адилхан байдаг байна.

Зарим үйлчлүүлэгчид тайлбарлаж өгөөд явуулахад дахин ирэхдээ хангалтгүй ойлголттой хэвээр л ирдэг. Үндсэн үйлчилгээний хажууд хүн бүрт тайлбарлаж өгөөд байх цаг, боломж байдаггүй.

Газрын мэргэжилтэн СХД

- Хөдөө орон нутагт иргэд, оршин суугчдын дунд газар өмчлөх хэрэгцээ, сонирхол бага, өмчлөн авахын ач холбогдлыг ойлгоогүй, өмчөө үнэ хүргэх нөхцөл бүрэлдээгүй байгаа нь иргэдэд хүргэж буй мэдээллийн ач холбогдлыг бууруулж байна.

Үйлчилгээний ажилтнуудын ажил үүргээ гүйцэтгэх байдал

Газрын үйлчилгээний ажилтнуудтай холбоотой санал гомдол багагүй ирсэн бөгөөд албан хаагчдын мэдлэг, мэдээлэл, үйлчилгээ үзүүлэхэд бэлэн байдал, үйлчилгээний ажилтны хариуцлага, соёл хангалтгүй байдаг гэжээ. Мониторингийн явцад иргэдээс ирсэн мэдээлэлд тулгуурлан газрын үйлчилгээний ажилтнуудаас хамааран гардаг хүндрэлийг багцлан авч тайлбарлая.

Үйлчилгээний соёл, зан харилцаа:

Газрын үйлчилгээгээр үйлчлүүлж буй иргэдийн цөөнгүй хэсэг нь энэхүү гомдлыг гаргаж байв. Нэн ялангуяа энэ нь ажлын ачаалал өндөртэй СХД-ийн үйлчилгээнд олонтаа тохиолдлоо. Иргэд “үйлчлүүлэгчидтэй эелдэг харьцаад байдаггүй, сайн ойлгоогүй зүйлээ лавлаж асуухаар уурладаг” гэсэн бол үйлчилгээний ажилтнууд “ачаалал ихтэй тул их ядардаг, үйлчлүүлэгсэд өөрсдөө биднийг ажил үүргээ хэвийн гүйцэтгэж байхад харааж загнадаг, хардаж сэрддэг” гэсэн тайлбарыг өгч байв.

Мэдлэг, чадвар, ажлын хариуцлага:

Хөдөө орон нутагт газрын үйлчилгээний ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадвар дутмагаас шалтгаалан иргэдийг олон дахин явуулах, хугацаа ихээр зарцуулахад илүүтэй хүргэдэг бол төв суурин газарт ажлын хариуцлага алдах байдал илүү тохиолдож байлаа.

Газрын мэргэжилтэн овог, нэр буруу бичсэнээс болоод дахин хөөцөлдөж чирэгдэл гарсан, Эзэмших гэрчилгээг шинээр солиулж, өмчлөх материал дахин бүрдүүлж байна.

Д.Л, СХДүүрэг 12 хороо

Хүнд суртал, хууль зөрчсөн байдал:

Тангараг өргөсөн төрийн үйлчилгээний ажилтнуудын дунд танил талдаа болон өөрт нь анхаарал хандуулсан нэгэнд илүү түргэн шуурхай үйлчлэх, хангалттай тайлбар мэдээлэл өгөхөөс гадна хөөцөлдөх шат дарааллын зарим хэсгийг хөнгөвчлөн өмнөөс нь хөөцөлдөх зэрэг байдал байсаар байна.

Газар өмчлөх асуудлаа хөөцөлдөж байхдаа хариуцсан мэргэжилтэнд тал засах байдал гардаг. Би хувьдаа хоолонд оруулж байсан.

М.Д, Хөвсгөл аймаг

Энэ нь иргэдийг ихээр бухимдуулдаг бөгөөд эргээд үйлчилгээний ажилтнуудад үл итгэх, үл хүндэтгэх байдлыг бий болгодог ажээ.

Би хүмүүсээс сонсоод хөөцөлдөж буй материалынхаа дунд 1000 төгрөг хийгээд өгсөн чинь миний асуудлыг шийдвэрлэж өгөөгүй, лав мөнгөний хэмжээг нь голсон байх

А.Ч, СХД

М.Д, Хөвсгөл аймаг

Иргэдийн дунд зохих журмын дагуу үйлчлүүлэхээсээ өмнө танил талдаа хандах, бэлэг, шагнал өгөх, хариуд нь үйлчилгээний хөнгөлөлт шаардах зэрэг зохисгүй байдлыг өөрсдөө санаачлан гаргах байдал ч цөөнгүй байдаг байна.

Заримдаа таньдаг хүмүүс ирчихээд дараалал дайрч орж ирээд улайм цайм загнаад байдаг, бүр энгэрээсээ архи цухуйлгаад дохиод байдаг гээч. Энэ нь бидэнд маш хүндрэлтэй байдаг.

СХД, мэргэжилтэн

Үйлчилгээний ажилтнууд хүндрэлийн шалтгаан болж байгаагийн шалтгаан юу вэ?

Мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байдаг бөгөөд тухайн үйлчилгээг хүргэж буй ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулагддаг ч тэр бүр шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Салбарын ажилтнуудад зориулсан “Газрын харилцааны хууль тогтоомжийн эмхтгэл” гэх зэрэг зайлшгүй хэрэгцээтэй гарын авлагыг бэлтгэн гаргасан нь сайшаалтай ч үйлчилгээний ажилтнуудын ажил үйлчилгээгээ хөнгөвчлөх, янз бүрийн түвшний үйлчлүүлэгчдэд гарын авлага болгон ашиглуулах мэдээлэлт хэрэглэгдэхүүн байдаггүй.

Улс төрийн сонгууль, удирдах ажилтны томилгооноос үүдэлтэй мэргэжлийн хийгээд мэргэшиж буй боловсон хүчний тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл тэр бүр баталгаатай бус байдаг.

Ажлын ачаалал ихтэй газар цайны цагаар болон илүү цагаар ажиллах байдал илүү байдаг ч, боловсон хүчний бүтэц, тоо хэмжээ, ажлын хөлс, цалин урамшууллын уян хатан бодлого, зохицуулалт дутагдалтай байна.

Мэргэжлийн бус ажлаа баталгаатай бус хугацаанд эрхэлж буй зарим ажилтны хувьд өөрийн эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах, хүнд суртал гаргах байдал ажиглагдаж байлаа.

Дээд албан тушаалтан болон дээд шатны байгууллагаас газрын үйлчилгээтэй холбоотой хууль, журам зөрчсөн үйлдэл хийхийг шаардсан, тулгасан үйлдлүүд тохиолдож байсныг мониторингийн явцад илрүүлсэн ч мэдээллийн эх сурвалжийн аюулгүй байдлыг хангах үүднээс дэлгэрүүлэн дурьдах боломжгүй байна.

Үйлчилгээг хүртэхэд зарцуулж буй хугацаа ба зардал

Иргэд, үйлчлүүлэгчдийн хувьд газрын үйлчилгээг хүртэхэд хамгийн төвөгтэй буюу хүндрэлтэй нь цаг хугацаа их зарцуулах явдал бөгөөд олон шат дамжлага туулж, удаан дугаарлаж зогсох нь газрын үйлчилгээг хүртэж байгаа ихэнх хүмүүст тохиолддог байна.

Түүнчлэн олон дахин явах, өргөдөлд хавсаргах материалыг бүрдүүлэхэд гарсан зардал, гэрчилгээний үнэ зэрэг нь орлого багатай зарим иргэдэд хүндээр тусдаг ба “газрыг үнэ төлбөргүй өгнө” гэдэг нь худлаа гэсэн сөрөг ойлголтыг төрүүлэхэд хүргэдэг байна. Энэ нь хөдөө орон нутагт илүү таарах бөгөөд сумын иргэд газар эзэмших, өмчлөх эрхээ баталгаажуулж авахад 20 гаруй мянган төгрөгийн зардал гардаг, аймгийн төв орж баталгаажуулах нь хүндрэлтэй байдаг ажээ.

Би сүүлийн 2 жилийн турш газар эзэмших эрхээ баталгаажуулахаар хөөцөлдөж байна. СХД-т байнга оршин суугаад байдаггүй дээр нь төрийн албан хаагч болохоор ажлын цагаар хөөцөлдөж чаддаггүй. Хороон дарга олж уулзах гэж лав 4 сар болсон, харин дараа нь эзэмших эрхээ өмнө нь баталгаажуулаагүй гээд торгууль тавьсан. Дүүргийн Газрын албанд материалаа өгөөд 15 хоногийн дараа гудамж, талбайн асуудал шийдэгдээгүй, зөрчлийг арилга гээд буцаасан. Ажилтнуудын болон миний цаг зав таарахгүйгээс өнөөг хүртэл шийдэгдээгүй байна.

Д.Б – СБД 7хороо

Газрын үйлчилгээний байгууллагын ажлын цагийн хуваарь нь ихэнх байгууллага, аж ахуйн нэгжийнхтэй давхцдаг тул иргэдийн хувьд газрын асуудлаа хөөцөлдөхдөө ихэвчлэн ажлаасаа чөлөө авах, ээлжийн амралтаараа хөөцөлдөхөд хүргэдэг байна.

Олон дахин явуулж ажлын цаг таслуулснаас болж, цалингаа хасуулсан.
Ц.О – СХД 6 хороо

Газар өмчлөх шийдвэр гаргалт ба газрын хэмжээ, байршил

Хууль тогтоомжийн нийцэл, нөхөн гүйцээлт хангалтгүй зэргээс шалтгаалан шийдвэр гаргах эрх мэдэл давхцах, үүнээс үүдэн иргэд хохирсон, хүндрэл тулгарсан байдал нэг бус тааралдсан юм.

Аймгаас эзэмших эрх авсан газрыг Мөрөн сумаас давхардуулан өөр хүнд олгосон.

Ц.Ж – Хөвсгөл, Мөрөн 8-р баг

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар аймгийн төвийн газар нь аймгийн төвд орших сумын мэдэлд хамаардаг бол Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар инженерийн шугам сүлжээ бүхий газрууд аймгийн засаг даргын мэдэлд харьяалагддаг байна.

Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад амьдралд тэр бүр бүрэн бууж өгдөггүй зөрчилтэй асуудлууд цөөнгүй тохиолддог. Тухайлбал, газартай холбоотой хуулиудад өөрчлөлт оруулсан ч газрын төлбөрийн тухай хуулийг өөрчлөөгүй, хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө уялдахгүй байх, хоцрох зэргийг дурьдаж болох юм. Хот төлөвлөгөөний дагуу өрх, иргэдийн суурьшлын бус газар хэмээн төлөвлөгдсөн зарим газруудад шилжин ирсэн өрх олноор суурьшсан, улс төрийн сонгуулийн үеэр нэр дэвшигчид хурдны зам төлөвлөгдсөн газар тойргийн өрхүүдэд эзэмшлийн газар олгуулсан, шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөө, дэд бүтцийн асуудал шийдвэрлэгдээгүйгээс өмчлөх байдал удаашралтай байгаа зэрэг зөрчил дутагдлууд газрын үйлчилгээг хэвийн явагдахад саад болж байна.

Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулинд зааснаар аймгийн төвд 3500 м² хүртэлх газар нутаг өмчлүүлнэ гэсэн байдаг. Манай аймагт 1 хүн ийм хэмжээний газар авна гэж шүүхдэд заргаа авсан. Хүн болгонд ийм хэмжээний газар өгөөд байвал манай аймгийн газар хүрэлцэхгүй

Г.Б Орхон аймгийн газрын албаны мэргэжилтэн

Мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай газарт кадастрын зураглалын нарийвчлал хангалтгүй байгаа бөгөөд газрыг нарийн хэмжихгүй, илүү, дутуу олгосон тохиолдол цөөнгүй байв. Түүнчлэн иргэд эзэмшлийн болон өмчилсөн газраа нарийн хэмжүүлж авсныхаа дараагаар сунгаж, томсгон хашаа барих байдал ч тааралдсаныг дурьдах нь зөв болов уу.

Манай газрыг яг нарийн хэмжиж олгоогүй. Хажуу айлын газар манайхаас хамаагүй том.

Ц.М – Хөвсгөл, Мөрөн 8-р баг

ДҮГНЭЛТ

Филантропи төв Нээлттэй Нийгэм Форумын тэтгэлгээр “Төрөөс иргэд, өрхөд газар өмчлүүлэх /эзэмшүүлэх/ үйлчилгээнд хийх мониторинг” төслийг амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Монгол Улсын Засгийн газар улс орны эдийн засаг, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын чадавхийг нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааны түвшинг сайжруулах үндсэн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс газар өмчлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж эхэлсэн нь газрын шинэтгэлийн шинэ үеийг эхлүүлсэн. Гэр бүлийн хэрэгцээний газраа өмчилж аваад байгаа нь бүртгэгдсэн нийт өрхийн ердөө 24.81 хувь болж байгаа нь төлөвлөгдсөн хугацаатай харьцуулахад удаашралтай байгаа бөгөөд цаашид өрх, иргэдийн идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Мониторинг хэрэгжүүлэхээр сонгон авсан нэгжүүд болох гэр бүлийн хэрэгцээнд газар өмчлөх эрхтэй бүртгэгдсэн нийт өрхөд газар өмчлүүлсэн байдал харилцан адилгүй байгаа юм. Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг 60,3 хувь, Хөвсгөл аймаг 7,3 хувь, Орхон аймаг 38,82 хувьтай байгаа ба энэ хэрээр үйлчилгээний бодит байдал харилцан адилгүй байна. Тодруулбал, эхний нэгжийн ачаалал нь хэтэрсэн, хоёр дахь нэгжийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон, гурав дахь нэгжийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байв.

Газрын үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхээр хандсан болон үйлчилгээ хүртэж буй иргэдийн газар эзэмших, өмчлөх эрхийн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй, газар өмчлөхийн ач холбогдлыг ойлгоогүй, үл ойшоосон байдал багагүй байлаа. Ялангуяа орон нутагт энэ талын хэрэгцээ үүсээгүй байгааг өмчилж авсан газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл огт бүрдээгүй байгаагаар тайлбарлаж болох юм. Эндээс дүгнэхэд газар өмчлөлийг дэмжих орчин хангалттай бүрэлдээгүй байгаа бөгөөд энэ нь нэн ялангуяа хөдөө орон нутагт орхигдоод байна.

Мониторингийн явцад хамгийн түгээмэл тохиолдож байсан асуудал нь иргэд, оршин суугчдын дунд хангалттай мэдээлэл байхгүй явдал байв. Нөгөө талаас газрын үйлчилгээнд харилцан адилгүй түвшний боловсролтой үйлчлүүлэгчдэд зориулсан энгийн, ойлгомжтой мэдээлэл, тайлбар өгөх сурталчилгааны хэрэглэгдэхүүн, тухайлсан асуудлаар нэмэлт мэдээлэл өгөх үйл ажиллагаа хангалтгүй байна. Иргэд, оршин суугчдын мэдээлэл олж авах суваг, хүлээн авах түвшин, хэрэгцээг харгалзан, харилцан адилгүй үйлчилгээг нэвтрүүлэх шаардлагатай байгаа юм.

Газрын үйлчилгээний албан хаагчдын мэдлэг, мэдээлэл, үйлчилгээ үзүүлэхэд бэлэн байдал, үйлчилгээний ажилтны хариуцлага, соёл тэр бүр хангалтгүй байдаг нь тогтоогдсон бөгөөд энэ нь мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдал, ажлын ачаалал, хувь хүний алдаатай ажиллагаанаас хамаардаг байна.

Иргэд, үйлчлүүлэгчдийн хувьд газрын үйлчилгээг хүртэхэд хамгийн төвөгтэй буюу хүндрэлтэй нь цаг хугацаа их зарцуулах явдал юм. Олон шат дамжлага туулж, удаан дугаарлаж зогсох нь газрын үйлчилгээг хүртэж байгаа ихэнх хүмүүст тохиолддог байна. Түүнчлэн олон дахин явах, өргөдөлд хавсаргах материалыг бүрдүүлэхэд гарсан зардал, гэрчилгээний үнэ зэрэг нь орлого багатай зарим иргэдэд хүндээр тусдаг төдийгүй “газрыг үнэ төлбөргүй өгнө” гэдэг нь худлаа гэсэн сөрөг ойлголтыг төрүүлэхэд хүргэдэг. Энэ нь газрын үйлчилгээний механизмыг боловсронгуй болгох, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох хэрэгцээг харуулж байна. Иргэдийн дунд зохих журмын дагуу үйлчлүүлэхээсээ өмнө танил талдаа хандах, бэлэг, шагнал өгөх, хариуд нь үйлчилгээний хөнгөлөлт шаардах зэрэг зохисгүй байдлыг өөрсдөө санаачлан гаргах нь цөөнгүй байдаг бөгөөд энэ нь эргээд төрийн албан хаагч, үйлчлүүлэгчдийн дунд үл итгэлцэх байдлыг бий болгодог ажээ. Төрийн үйлчилгээг ил тод болгох, хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлэх, улс төрөөс ангид байлгах нь үйлчилгээг эрүүлжүүлэх үндэс болно.

Хууль тогтоомжийн нийцэл, нөхөн гүйцээлт хангалтгүйгээс шалтгаалан шийдвэр гаргах эрх мэдэл давхцах, үүнээс үүдэн иргэд хохирсон, хүндрэл тулгарсан байдал цөөнгүй байв. Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад амьдралд тэр бүр бүрэн бууж өгдөггүй зөрчилтэй асуудлууд цөөнгүй тохиолддог байна. Тухайлбал, газартай холбоотой хуулиудад өөрчлөлт оруулсан ч газрын төлбөрийн тухай хуулийг өөрчлөөгүй, хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг уялдуулаагүй, хоцрох зэргийг дурьдаж болох юм. Энэ нь газрын харилцаатай холбоотой эрх зүйн орчинг улам боловсронгуй болгохыг шаардаж байгаа ба ойлголт, нэр томъёоллыг цэгцлэх, зарим хуулийг шинэчлэх, нарийвчлах хэрэгтэйг харуулж байна. Эцэст нь төрөөс иргэд, өрхөд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх үйлчилгээг боловсронгуй болгох бодитой шаардлага байгаа ба уг асуудлыг шийдвэрлэхэд төр, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын идэвх оролцоог нэмэгдүүлэхэд нэн тэргүүнд анхаарах нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ

Төрөөс өрх, иргэдэд гэр бүлийн хэрэгцээнд газрыг үнэ төлбөргүй өмчлүүлэх эрхийн дуусгавар болох хугацаа нь 2008 оны 5 дугаар сарын 1 хэдий ч 2003 оноос өнөөг хүртэл газраа өмчлөхөөр бүртгэгдсэн нийт өрхийн дөрөвний нэг хувь нь л газраа өмчилж авсан. Эндээс дүгнэхэд төрөөс газрыг гэр бүлийн хэрэгцээнд нь үнэгүйгээр өмчлүүлэх үлдэж байгаа хугацаанд энэ ажлыг оновчтой зохион байгуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Төрийн үйлчилгээнд хөндлөнгийн мониторинг хэрэгжүүлсний дүнд бид газар өмчлүүлэх үйл явцыг боловсронгуй болгох дараах санал, зөвлөмжийг дурдаж болох байна.

1. Газар өмчлөлийн үйл явцыг дэмжих орчинг бүрдүүлэх

- Иргэдийн газар өмчлөх эрхтэй холбоотой мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ нь иргэд газрын үнэ цэнэ, ач холбогдлыг үнэлэх, эрх, үүргээ ухамсарлахад хэрэгтэй төдийгүй эргээд газрын үйлчилгээг иргэдэд хүргэхэд ч сайнаар нөлөөлөх талтай. Ингэхдээ ямар мэдээллийг, ямар арга замаар, хэнд, хэн хүргэж байгаа гэдэгт ч мөн анхаарах хэрэгтэй. Энэ тал дээр төрийн байгууллагууд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах бүрэн боломжтой юм.
- Газрын үнэлгээг үндэслэлтэй гаргаж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн бодитой алхамуудыг хийх хэрэгтэй байна.
- Газрын харилцаатай холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хуулийн заалтуудыг шинэчлэн сайжруулах, бусад хууль тогтоомжуудтай уялдуулахаас дутуугүй сурталчлан таниулах, хэрэгжилтийг хянах боломжийг нээлттэй, бодитой болгоход анхаарах шаардлагатай.

2. Газрын үйлчилгээний механизмыг боловсронгуй болгох

- Иргэд газрын үйлчилгээг хүнд сурталтай, хүндрэлтэй гэж үнэлэхэд хүргэж буй нэг үндсэн хүчин зүйл нь цаг хугацаа их зарцуулдаг, явдал чирэгдэл их байдагтай холбоотой. Өнөөдөр зах зээлийн нийгэмд иргэд бараа үйлчилгээг эрж хайж явдаг бус харин үйлчилгээ нь хэрэглэгчдийн хувьд хамгийн ойр байдгийн адил төрийн үйлчилгээ ч мөн нэгэн адил иргэд, үйлчилгээний ажилтнуудад хүндрэлгүй байж чадах тийм үйлчилгээг нэвтрүүлэх хэрэгтэй. Үүнд жишээ болгон цахим үйлчилгээг дурдаж болно.
- Үйлчилгээний байгууллагуудын шат дараалсан үйл ажиллагааг уялдуулахад анхаарах хэрэгтэй. Нэн ялангуяа төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн үйл ажиллагааг уялдуулах талаас нь эн тэргүүнд анхаарах шаардлагатай.
- Төрийн байгууллагыг тухайн объектын талаарх бодитой мэдээллээр хангахад анхаарах хэрэгтэй бөгөөд магадгүй энэ талын чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагууд гүйцэтгэх боломжтой.

3. Газрын үйлчилгээний бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах

- Харьяа газар нутаг, оршин суугчдын онцлогт тохируулан үйлчилгээний байгууллагын нөөцийг шинэчлэн зохион байгуулах /боловсон хүчин, ажлын нөхцөл гэх мэт/
- Мэдээллийн нэг цэгийн үйлчилгээг нэгжүүдэд төвлөрүүлэн ажиллуулах

4. Газрын үйлчилгээний мэргэжилтнүүдийг чадавхижуулах

- Мэргэшсэн боловсон хүчнээр хангах
- Ажил үүргээ гүйцэтгэж буй мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах
- Газрын үйлчилгээний ажилтнуудыг мэдээлэл, хэрэглэгдэхүүнээр хангах

5. Газрын үйлчилгээг ил тод болгох

- Дотоодын болон хөндлөнгийн хяналт-үнэлгээг төрийн хяналттай уялдуулан ашигласнаар үйлчилгээг ил тод болгоод зогсохгүй, улам боловсронгуй болгох боломжтой юм.
- Төрийн үйлчилгээг улс төрийн “тоглоом”-оос ангид байлгах

6. Газрын үйлчилгээтэй холбогдох хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох

- Хуулиудын харилцан нөхөн гүйцээх байдлыг нэмэгдүүлэх
- Газрын төлбөрийн тухай хуулийг шинэчлэн, газрын үнэлгээ, бүсчлэлийн асуудлыг бодитой шийдвэрлэх
- Өмчлөх газрын хэмжээ, байршилтай холбоотой зөрчилтэй асуудлуудыг хуулийн хүрээнд шийдвэрлэх
- Газар эзэмших, өмчлөх эрх шилжүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан хуульчлах

Филантропи төв

Филантропи төв нь хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд анх 1999 онд Солбилцол нартэйгээр байгуулагдаж нийгмийн судалгаа, сургалт хичээллүүлж байв. 2005 онд шинэчлэгдэн зохион байгуулагдаж, 2006 оны 6 дугаар сараас дахин ажиллаж эхэлсэн.

Мониторингийн багийн бүрэлдэхүүн

| | | | |
|-----------------------|--------------|---------------------------|-------|
| Төслийн удирдагч | Д.Сүнжид | хуульч | /LLM/ |
| Төслийн зөвлөх | В.Удвал | хуульч | /LLM/ |
| Төслийн багийн гишүүд | Р.Сэлэнгэ | социологич | /MA/ |
| | Ш.Бэрцэцэг | социологич | /MA/ |
| | Ч.Мөнхцэцэг | хуульч | /LM/ |
| | Б.Буян-Өлзий | хуульч | /LM/ |
| Туслах ажилтан | Ц.Энхмандах | төрийн удирдлагын менежер | /MA/ |
| | Б.Батжаргал | япон хэлний орчуулагч | |

Барилга байгууламж барих зорилгоор иргэн, хуулийн этгээдэд газар олгох төрийн үйлчилгээнд хийсэн мониторинг

Төслийн зорилго:

Газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа зөрчил дутагдлыг арилгах, энэ талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахад энэхүү ажлын гол зорилго оршино. Уг ажлын хүрээнд Нийслэлийн газрын алба, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн газрын албаны ажилтай танилцах, газар эзэмших, ашиглахыг хүссэн иргэн, хуулийн этгээдүүдийн төлөөлөгчид, Сууц Өмчлөгчдийн холбоо /СӨХ/-ын дарга нартай уулзав.

Төслийн зорилт:

- Газар олголтын ил тод байдлыг нэмэгдүүлэх;
- Газар олгох явцад гарч байгаа олон шат дамжлага, хүнд суртлыг багасгах;
- Газартай холбоотой хууль тогтоомжийн талаарх хэвлэл, мэдээллийн сурталчилгааг нэмэгдүүлэх;
- Хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг эрчимжүүлэхэд чиглэв.

Мониторингийн үндэслэл

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийг эрх зүйн хувьд баталгаажуулах шинэтгэлийн хүрээнд Улсын Их Хурал /УИХ/ 2002 оны 6 дугаар сарын 7-нд “Газрын тухай”, 2002 оны 6 дугаар сарын 28-нд “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийг батлан гаргаж мөрдүүлсэн билээ. Эдгээр хуулийн дагуу гагцхүү төрийн өмчлөлд байсан газрыг иргэд хувьдаа өмчлөн авч газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж, орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, улмаар ядуурлыг бууруулахад чухал ач

холбогдолтой юм. Гэвч уг хуулиудын зарим зүйл, заалт зөрчигдөж, хэрэгжилт нь хангалтгүй байна.

Монгол Улсын хэмжээнд иргэнд газар өмчлүүлэх үйл ажиллагааг 2 жилд буюу 2003 оны 05 дугаар сарын 1-нээс 2005 оны 5 дугаар сарын 1-ний хооронд багтааж дуусгана гэсэн төлөвлөгөөтэйгээр эхэлж, улсын хэмжээнд нийт 600 албан хаагч бүхий газрын алба гэсэн цоо шинэ байгууллага үйл ажиллагаагаа явуулсан боловч хуулиар тогтоосон хугацаа дуусахад нийт өмчлүүлэх газрын 32 хувийг иргэдэд өмчлүүлсэн байсан нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм.

Газрын асуудал эрхэлсэн төр захиргааны байгууллага, иргэдийн хооронд газар өмчлөх, өмчлөх эрхээ сэргээлгэх, бусдад шилжүүлэх, эзэмшүүлэн ашиглуулах үйл ажиллагаанд дээрх хуулиудын заалт зөрчигдсөн тохиолдол олон гарсан. Нөгөө талаар иргэдэд үйлчилгээг ойртуулж, санаачлагыг нь өрнүүлэх механизм байхгүйгээс иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хугацааг 2008 оны 5 дугаар сарын 1 хүртэл сунгасан юм. Уг үйл ажиллагаа нь Монгол Улсын иргэдийг бүхэлд нь хамруулсан төрийн үйлчилгээ болохын хувьд энэ асуудлаар мониторинг хийх нь зүйтэй гэж тус байгууллага үзсэн болно.

Мониторингийн хугацаа, хамарсан хүрээ, байршил

Мониторинг нь 2006 оны 1 дүгээр сараас 2006 оны 8 дугаар сарын 1 хүртэл үргэлжилсэн.

- Нийслэлийн газрын алба /НГА нь аж ахуйн нэгж, байгууллагуудад хотын төв, барилгажсан газарт газар эзэмших эрх олгодог/
- Сүхбаатар дүүргийн газрын алба /СДГА нь иргэн, хуулийн этгээдүүдэд нийтийн эдэлбэр газар /зуслангийн газар/ олгох асуудлыг түлхүү шийдвэрлэдэг. Ийм ч учраас газар тойрсон маргаан их гардаг/
- Иргэд, хуулийн этгээд

Мониторингийн аргачлал


- Тодорхой, бодит жишээ цуглуулах;
- Хууль тогтоомж, шүүхийн шийдвэрүүдэд анализ хийх;
- Газрын маргааныг хянан шийдвэрлэсэн Нийслэлийн захиргааны хэргийн шүүх /НЗХШ/, Улсын Дээд Шүүх /УДШ/-ийн шийдвэрийг судлан дүгнэх, газар олгох эрх мэдэл бүхий байгууллагын үйл ажиллагааг фото зургаар баримтжуулах;
- НГА, СДГА-ын үйл ажиллагаатай танилцах;
- Газрын эрх зүйн харилцааны зохицуулалтын талаар радио нэвтрүүлэг хийж, нийтийн анхаарлыг төвлөрүүлэх.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар олгох хууль зүйн орчин

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар олгох харилцааг дараах хууль, тогтоомжоор зохицуулна. Үүнд:

- Иргэний хууль, 2002 он
- Газрын тухай хууль, 2002 он
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 2002 он
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2002 он
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, 1999 он
- Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай, 2003 он
- Барилгын тухай, 1998 он
- Хот байгуулалтын тухай, 1998 он
- Засгийн газрын 2003 оны 2 дугаар сарын 7-ны “Хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний талаар” тогтоол №28
- Засгийн газрын 2003 оны “Аргачлал, үнэлгээ батлах тухай” тогтоол №103
- Засгийн газрын 2003 оны “Журам батлах тухай” тогтоол №213
- Засгийн газрын 2004 оны “Журам батлах тухай” тогтоол № 48
- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дүрэм
- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2003 оны “Журам батлах тухай” тушаал №165
- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2003 оны “Аргачлал батлах тухай” тушаал №218
- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2003 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тушаал №157

Диаграм 1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар олгох үе шатууд



МОНИТОРИНГИЙН ДҮН

Мониторингийн явцад нийслэл, дүүргийн газрын албадын хүний нөөц, санхүү-эдийн засгийн хүчин чадал өнөөгийн шаардлагыг хангахуйц хэмжээнд хүрэхгүйн зэрэгцээ тэдгээр байгууллагын үйл ажиллагааны зохицуулалт боловсронгуй бус, газрын болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн нэгж, албадын уялдаа холбоогүй, давхардсан ажиллагаа, газар олголтыг хот төлөвлөлтийн бодлоготой тэр болгон уялдуулан хийхгүй байгаа, авилгал авдаг зэрэг нөхцөл байдал ажиглагдлаа.

Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар /НЗДТГ/ болон НГА-ын үйл ажиллагаан дахь алдаа, зарим дутагдалтай талууд

Газар эзэмших эрх олгох үйл ажиллагаа эрхэлдэг төрийн байгууллагуудын хүнд суртал, шат дараалал, “гар харах”, авилгалд өртөх зэрэг сөрөг үзэгдлүүд нь иргэдийн эрх ашгийг зөрчиж, төрийн үйлчилгээний чанар, үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал, газар эзэмших хугацаа нь хуулиар 15-60 жил байна гэсэн атал газар эзэмших эрх болон гэрээг бодит байдал дээр 2-5 жилээр хийж иргэдийг чирэгдүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, 2 жил тутам гэрээг сунгахыг шаардаж авилгалын зах зээлийг бий болгож байна. Газар эзэмших эрх сунгах ажиллагаанд ч мөн ийм байдал ажиглагдаж байв. Тухайлбал, эрх бүхий засаг дарга өөрийн үзэмжээр хугацааг сунгаж байгаа тул нэг удаад 10-аас доошгүй, 40-өөс дээшгүй жил шууд сунгахаар хуульчлах хэрэгтэй байна.

Газрын албадын ажлын зохион байгуулалт нь иргэдэд хурдан шуурхай үйлчлэхэд чиглэх бус харин ч хүнд суртлын гол шалтгаан болж байгаа юм.


Сүхбаатар дүүргийн ...р хорооны өндөр настан Ө Дүүргийн газрын албанд газар эзэмших тухай хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт гаргасан. Гэтэл тус дүүргийн засаг дарга солигдох асуудал шийдэгдэхгүй байгаа гэдэг шалтгаанаар асуудлыг 3 сар гаруй хугацаагаар сунжруулсаар өдий хүрчээ.

Сүхбаатар дүүргийн иргэн А гэгч эмэгтэй зөвхөн газар эзэмших гэрчилгээ авах, гарсан эсэхийг нь мэдэх гэж хүлээсээр өдөр болгон ирдэг тухайгаа ихэд бухимдсан сэтгэгдэлтэй ярьж байв. Ер нь зарим иргэд энэ тухай асуудлаар илэн далангүй ярихаасаа айж эмээж, өөрсдийн асуудлыг нь хүндрүүлнэ гэж болгоомжилсон байдлаар хандаж байлаа


Иргэд газар эзэмших, өмчлөх гэрчилгээ гарсан эсэх талаар зөвхөн хариуцсан албан тушаалтнаас мэдэж болох ба мэдээллийн самбарт энэ талаар гаргадаггүй байна. Үүнээс болж иргэд тухайн албан тушаалтантай заавал уулзаж, түүнийг олон цагаар хүлээх шаардлагатай болдог. Доорх зургаас НГА-ын мэдээллийн самбарыг харж болно.



Зураг 1: Газрын кадастрын хэлтсийн самбарт мэдээлэл огт байхгүй байдал



Зураг 2: Газрын зохион байгуулалтын хэлтсийн самбарт зохих мэдээлэл тавигдаагүй байдал



Зураг 3: Газрын өмчлөлийн хэлтсийн самбарт мэдээлэл огт байхгүй байдал



Зураг 4: Газрын төлбөрийн хэлтсийн самбарт мэдээлэл огт байхгүй байдал

Газартай холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэх ажиллагаа

Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлд зааснаар газартай холбогдон үүссэн дараах маргааныг дор дурдсан байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ:

1. Газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон Засаг даргын хооронд үүссэн маргааныг тухайн Засаг даргын дээд шатны Засаг дарга;
2. Газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргаан, газар ашиглах гэрээний нөхцөл, болзлын талаар газар эзэмшигч ба ашиглагчийн хооронд үүссэн маргааныг зохих шатны Засаг дарга;

3. Газрын төлөв байдал, чанар, түүнийг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу зохих мэргэжлийн байгууллагын хяналт хариуцсан албан тушаалтан буюу тухайн шатны Засаг дарга;
4. Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах болон газартай холбогдон үүссэн эд хөрөнгийн маргааныг шүүх.

Хэрэв дээр заасан байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг маргааныг тэдгээрийн дээд шатны албан тушаалтан, байгууллага, эсвэл шүүхээр шийдвэрлүүлнэ гэж заасан боловч эдгээр заалтууд цаг үеийн шаардлагыг хангахааргүй болжээ.

2005 оны байдлаар, 1146 иргэн НГА-д хандаж өргөдөл, гомдол, санал ирүүлсний 284 нь УИХ-ын гишүүд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар /ЗГХЕГ/, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид /НИТХТ/, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улаанбаатар хотын Ерөнхий менежер, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраар уламжлагдан иржээ. Дээд шатанд гаргасан гомдлыг доод шатны байгууллагын даргад буцаан хүргүүлдэг журам үйлчилдэг учир өмнө нь гаргасан шийдвэрээ хамгаалаад л дуусдаг аж. Иймд маргаан шийдвэрлэх журмыг шинэчлэх шаардлагатай нь тодорхой байна.

Улсын нэгдсэн бүртгэлийн асуудал болон газар давхардуулан олгож буй талаар

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх буюу /ҮХХБҮА, газрын албыг нэгтгэх замаар/ нэгдсэн бүртгэлийн байгууллага хийх учиртай. Газрын тухай хуулийн 31.3-т “Хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна” гэсэн заалт зөрчигдөж, нийслэл, дүүргийн засаг даргын газар олголт хэсэгчлэн болон бүхэлдээ давхарддаг байна.

Хууль тогтоомжид зааснаар дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ бүхий газар буюу ирээдүйд холбогдохоор төлөвлөгдсөн газрыг аймаг, нийслэлийн үлдсэн газруудад дүүрэг, сумын засаг дарга нар газар олголт хийдэг. Хэдийгээр хуулиар энэхүү засаг дарга нарын эрх мэдлийг зааглаж өгсөн боловч Нийслэлийн засаг дарга /НЗД/ нь Дүүргийн засаг дарга /ДЗД/-ын бүрэн эрхэд халдах тохиолдол давамгайлж байна. Газар олголтын нэгдсэн мэдээллийн сан байхгүйгээс сум, дүүргийн засаг дарга нар газар давхардуулан олгосон тухай маргаан түгээмэл гарчээ. Уг асуудлыг НЗД-ын захирамжийг хүчингүй болгох байдлаар шүүх шийдвэрлэж байна.

Баянгол аманд /Найрамдал зуслангийн орчим газар/ хуулиар СХД газар олголт хийх учиртай байтал НЗД-ийн захирамжаар хэд хэдэн газар олголт хийгдсэн тул иргэд хоорондын маргаан өнөөг хүртэл үргэлжилсээр байна.

Түүнчлэн дүүргийн газрын албанаас авсан газар эзэмших эрхээ улсын эрхийн бүртгэлд бүртгүүлэх тухай хуулийн заалт байдаг ч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд бүртгүүлдэггүй учир нэг газрын эзэмших эрхийн гэрчилгээг алга болсон нэрийдлээр хэд хэдэн удаа авч улмаар түүнийгээ хэд хэдэн банк, Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/, Хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/-д барьцаалах тохиолдол байнга гарч байна. Иймд хуульд заасан улсын бүртгэлийг бүх түвшинд хийх нь зүйтэй юм.

Иргэн Б. газар эзэмших гэрчилгээг зохих хууль журмын дагуу бичиг баримтаа бүрдүүлээд өгөхөд, Газрын албаны кадастраар уг газрыг шүүлгээд тухайн газар дээр ямар нэгэн эзэмшигч байхгүй гэж үзэж газар эзэмших гэрчилгээг авсан. Гэтэл газар эзэмших гэрчилгээг авснаас хойш 2 сарын дараа иргэн Ц. Иргэн Б.-г өөрийн газрыг авч, хашааны мод хулгайлсан гэж цагдаагийн хэлтэст өргөдөл гаргасны дагуу эрүү үүсгэж шалгасан. Хэрэг шалгагдах явцад иргэн Ц.-д өмнө нь Сонгинохайрхан дүүргийн засаг даргын дугаар тоот газар эзэмших захирамж гарсан болох нь тогтоогдсон. Харин тухайн үед иргэн Ц. нь захирамж гарснаас хойш гэрчилгээгээ ерөөсөө аваагүй байсан. Өөрөөр хэлбэл газар эзэмших эрх нь албан ёсоор баталгаажуулаагүй байсан учраас газар эзэмших эрхгүй болж байгаа юм. Сонгинохайрхан дүүргийн засаг дарга захирамжаараа иргэн Б.-д олгосон газар эзэмших эрхийн дугаар тоот гэрчилгээг хууль бус баримт бүрдүүлэн авсан гэдэг үндэслэлээр хүчингүй болгосон байна. Уг маргаан Улсын Дээд Шүүхээр иргэн Ц. Газар олгосон захирамж болон иргэн Б.д олгосон газар эзэмших эрхийн тоот гэрчилгээг хууль бус баримт бүрдүүлэн авсан гэдэг үндэслэлээр хүчингүй болгосон захирамжийн заалтуудыг түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Эрх бүхий Засаг дарга иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар олгохоос өмнө эхний ээлжинд тухайн шатны газрын албаны мэдээллийн сан, сумын газрын даамлаас лавлагаа авах шаардлагатай. Эдгээр өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүрт газрын мэдээллийн санд оруулах талаар хуулинд нэмэлт өөрчлөлтийг нэн даруй хийх шаардлагатай байна. Энэ утгаараа эрх бүхий албан тушаалтан дээрх мэдэээлийг газрын мэдээллийн санд оруулаагүй тохиолдолд хүлээх хариуцлагыг мөн хуульчлах хэрэгтэй байна.

Иргэн Э. Нийслэлийн засаг даргад газар хүссэн баримтаа бүрдүүлэн хүсэлт тавьсны 1999 онд дугаар тоот захирамж гарч Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт 0,07 га газар ашиглуулах эрх олгож, мөн 2001 онд дугаар тоот захирамжаар нэмж 0,25 га газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг баталгаажуулсан байна. Гэтэл Нийслэлийн засаг дарга 2004 онд..дугаар захирамжаар иргэн Э.-ийн өмчилж авсан объектыг эзэмжиж буй газрын талбайг үндэслэлгүй хасаж 0,07 га газар болгохоор захирамж гаргажээ. Мөн захирамжаараа Н. нэртэй ХК-д 1500 м,кв газар эзэмшүүлэх эрхийг шинээр олгож Газрын тухай хуулийн 31-р зүйлийн 31.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймээс УДШ нэхэмжлэгч иргэн Э.-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах үндэслэлтэй байна гэж үзэж хуульд заасан журмын дагуу бусдын эзэмшиж буй газартай давхцуулахгүйгээр асуудлыг шийдвэрлэхийг эрх бүхий захиргааны албан тушаалтанд хариуцуулах шаардлагатай гэж шүүх шийдвэрлэжээ.

Газрын тухай хуулийн 31-р зүйлийн 31.3-д хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна гэж заажээ.

Орон нутгийн төрийн болон мэргэжлийн байгууллагын хүнд суртал, авилгалын дарамтын талаар

Бидний хийсэн тооцоогоор газрын зөвшөөрөл авч, барилга барихад давхардсан тоогоор 60 гаруй албан тушаалтны гарын үсэг шаардлагатай байдаг. Комиссийн шийдвэр гаргах, дүгнэлт өгөх, гарын үсэг зурж эцэслэн батлах хугацааг нарийвчлан тогтоогоогүйгээс хүнд суртал гаргах, “гар хүндрүүлэх” шаардлага гардаг гэж ярилцлагад оролцсон зарим иргэд гомдоллож байлаа. Эдгээр 60 хүний гарын үсэг, зөвшөөрлийг авахад дунджаар 2.5 жил зарцуулах бөгөөд харин уг газар дээр 10 сарын хугацаанд барилга барих бололцоотой байдаг аж. Барилга барих зөвшөөрөл авах нь барих хугацаанаас 3 дахин урт байна.

Ийнхүү хүнд суртал ихтэй төрийн үйлчилгээнээс залхсан, нөгөө талаар танил тал харж, шан харамж өгч, асуудлыг түрэмгийлэн шийдвэрлэдэг байдал газар авсан тул зөвшөөрөлгүй баригдсан барилга байгууламжийн амнист /өршөөл/-ийн асуудлыг хэлэлцэх хэрэгтэй мэт санагдаж байна. Өөрөөр хэлбэл өнөөгийн хэмжээнд иргэд, байгууллагын зүгээс хөрөнгө оруулалт хийж баригдсан, холбоо, дулаан болон бусад шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн хувьд зөрчилгүй баригдсан барилгад газрын төлбөрөө хийх болзолтойгоор хялбаршуулсан журмаар газрын зөвшөөрөл, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ /ҮХЭХБГ/-г олгож болох юм. Ингэснээр эдгээр этгээдүүд ч өөрийн хөрөнгийг баталгаажуулах, түүнийгээ зээлийн барьцаанд тавих зэргээр алдагдсан боломжийг нөхөж болно.

Газар олгох, барилгын зөвшөөрөл олгох асуудалд мэргэжлийн хяналт тавих үүрэгтэй аймаг, нийслэлийн улсын мэргэжлийн хяналтын газрын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилдог нь чоноор хонь мануулахтай адил зүйл. Өөрөөр хэлбэл, Засаг даргын зүгээс газрын хууль тогтоомжийг зөв хэрэгжүүлж байгаа эсэхэд мэргэжлийн хяналт тавих үүрэгтэй байгууллагын дарга нь Засаг даргаасаа томилогдох, түүнээс хараат байгаа өнөөгийн байдлыг үтэр түргэн өөрчлөх хэрэгтэй байна.

Хуулиар зохицуулагдаагүй харилцааны тухай

Орон сууцны 1 давхрыг бизнесийн зорилгоор өргөтгөх, нэмэлт барилга байгууламж барих тохиолдолд Нийслэлийн ерөнхий менежер тушаал гарган зөвшөөрөл олгодог. Гэтэл газар олголт хийгдсэн гэж үздэггүй учир газрын төлбөр авах эрх зүйн үндэслэл байхгүй гэж үзэж газрын төлбөр ногдуулдаггүй. Түүнээс гадна эдгээр нэмэлт барилгын техникийн шаардлага, барилгын аюулгүй байдалд нөлөө үзүүлж болох эсэхэд төрийн хяналт муу хийгддэг ба улсын комисс хүлээж авахыг хуулиар шаарддаггүй. Барилгын тухай хуулинд нэмэлт барилгын талаарх зохицуулалт байдаггүй ба гаднах заслын өнгө үзэмж, дизайн, шаардлагын талаар нэгдмэл бодлого байхгүй, хотын үзэмж, архитектур төлөвлөлтийн бодлого хэрэгжихгүй байна.

Иргэн Ц. 2000 онд... тоот захирамжаар Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт 0,006 га газар /захирамжид газар эзэмших хугацааг тодорхой заагаагүй/ -ыг олгосон бөгөөд 2004 онд...тоот бүртгэлийн дугаартай иргэн аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших, ашиглах гэрээг тус дүүргийн албатай байгуулан газрын төлбөрийг бүрэн барагдуулсан боловч түр зориулалттайгаар газрын шийдвэр гаргасан учир гэрчилгээ олгоогүй түүнчлэн газрын маргаан гарсан шалтгаанаар 2005 оны гэрээнд сунгалт хийгдээгүй байна. Газрыг баталгаажуулж өгөх тухай Нийслэлийн Засаг даргад, Нийслэлийн газрын албаны даргад, Хотын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст өргөдөл гаргасан боловч өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй байна. Гэтэл иргэн Ц.-ийн газарт иргэн Б. Улаанбаатар хотын ерөнхий менежерийн дугаар тоот тушаалаар, үйлчилгээний барилгын өргөтгөлийн батлагдсан зураг, барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх дугаар тоот зөвшөөрөл гарсан байна.

Түүнчлэн гараж, автомашины ил зогсоол, худалдаа үйлчилгээний цэгүүдийн газар эзэмшлийн асуудал хуульчлагдаагүй байдаг. Дээрх зориулалтаар дуудлага худалдаа явуулах, төсөл сонгон шалгаруулах зарчмаар эрх бүхий этгээдэд сум, дүүргийн засаг даргын шийдвэр, гэрээний үндсэн дээр түр ашиглуулж болно. Хугацаа нь 2 жил хүртэл байж болох ба нөхөн олговоргүйгээр олгоно.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Газрын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа зөрчил дутагдлыг хянан шийдвэрлэдэг хурдан шуурхай, төрийн болон газар, хот байгуулалт, хуулийн мэргэжлийн болон /шүүхээс бусад, өмгөөллийн болон их дээд сургуулийн эрдэмтэн, шинжээч зэрэг/ хуулийн байгууллага /ТББ, мэргэжлийн холбоо/-ын оролцоо бүхий байнгын ажиллагаатай, хурдан шуурхай, мэргэжлийн өндөр түвшинд шийдвэр гаргах чадвартай, маргаан хянан шийдвэрлэх тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Өнөөгийн байдлаар дүүргийн засаг дарга, газрын албаны хэлтэс, газрын дарга нараас бүрдсэн байнгын бус ажиллагаатай маргаан таслах комиссийн эрх зүйн статус, үйл ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтгүй байгаа учраас комиссоос гарсан шийдвэр эрх зүйн хувьд хүчин төгөлдөр болж чадахгүй байна.
2. Иргэдэд учирч буй бэрхшээл, чирэгдлийг багасгах, хүнд суртал, зөрчил дутагдлыг арилгах хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор гарч байна. Мэргэжлийн болон Техникийн комиссийн бүрэлдэхүүнд хамаардаг албан тушаалтны тоог цөөрүүлэх буюу бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилладаг график хуваарь тогтоон мөрдүүлэх, асуудлыг хүлээн авснаас хойш шийдвэр гаргах хүртэл хугацааг хуульчлан тогтоож, хугацаа хэтэрсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх нь зүйтэй.

3. Иргэнд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг ил тод шийддэг болгох. Газар олголтын үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын хяналт тогтоох, мэдээлэл авах боломжийг өргөжүүлэх шаардлагатай байна. Мөн газар олголтын мэдээллийг самбарт байрлуулах, мэдээллийн сангаар тогтмол үйлчлэх зэрэг зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээ авах нь зүйтэй.
4. Төрийн захиргааны байгууллагаас олгосон газар эзэмших, ашиглах гэрчилгээний үндсэн дээр иргэд газартаа их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, барилга байгууламж барьсны дараа өмчлөх эрхийн гэрчилгээ авах хүсэлт гаргахад эрх бүхий байгууллага хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд орсон гээд газар өмчлөх эрхийг нь олгодоггүй. Энэ тохиолдолд тухайн газрыг аль болох урт хугацаагаар /60 жил гэх мэт/ эзэмших эрх олгох замаар шийдвэрлэж болох талтай.
5. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон кадастрын зураг нь олон нийтэд нээлттэй, ил тод биш учраас сонголт хийх боломжгүй зэрэг нөхцөл байдлууд бий болсноос иргэн хуулийн дагуу газар өмчлөх, эзэмших эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүй байгаа тул ил тод байх зарчмыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай.
6. Илт хууль зөрчиж бариагүй хашаа байшин, “зуслангийн” харшуудыг албадан буулгах, нүүлгэхэд төрөөс олгох нөхөн олговрын эх үүсвэрийг хаанаас олох нь ойлгомжгүй байгаа тул уг асуудлыг эцэслэн шийдвэрлэж чадаагүй байна. Бидний үзэж байгаагаар тухайн газрыг суллаж авах дараагийн эзэмшигч уг зардлыг хариуцаж болох юм.
7. Газар өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээг авах үйл ажиллагаа нь барилга байшин зэрэг үл хөдлөх хөрөнгийн бүртгэлээс тусдаа явагдаж байна. Энэ утгаараа иргэн, байгууллага газар эзэмших, барилга байшин өмчлөх эрхээ баталгаажуулахын тулд Газрын алба, ЭХӨЭТХЭХБЭ-ийн улсын бүртгэлийн албаны давхардсан процессийг түүлж, олон төрлийн төлбөр хураамж давхцуулан төлж байна. Иймд энэ хоёр байгууллагыг нэгтгэх, наанадаж байршлыг нь нэг дор болгож, үйлчилгээг шуурхай болгох арга хэмжээ авах нь зүйтэй.
8. Дундын өмчлөлийн орон сууцны байрны доорх газар нь нийтийн буюу нийслэл, аймгийн /сум/ хөрөнгө байгаа өнөөгийн зохицуулалт нь үзэгний үзүүрээр олон хүний амьдрал ахуйг шийдэх өргөн эрх мэдлийг хотын Засаг даргад олгож байгаагаас цэцэрлэгийн талбайд байшин барих эрх олгосон. Жишээ нь, Сансар хорооллын тунель дээр 8 хүнд барилга барих газар олгосон байна. 1950-1960 онд баригдсан барилгууд удахгүй нурж унах гамшгийг араасаа дагуулж байна. Тэгвэл хотын төвийн нурсан орон сууцны өмчлөгчид газрын өмчлөгч биш тул хаашаа очих вэ? Түргэний гол руу юу, эсвэл Эмээлтийн хөндий рүү юу, гэдэг асуудал тавигдана. Иймд иргэн бүрт газар өмчлүүлэх асуудлыг заавал шийдвэрлэсэн байх, хоёрдугаарт, уг нурсан орон сууцны газар дээр барилга барих эрх авч

байгаа дараагийн эзэмшигч тодорхой хэмжээгээр хохирол барагдуулах ажиллагаанд оролцдог байх эрх зүйн зохицуулалт бий болгох нь зүйтэй. Түүнчлэн иймэрхүү тохиолдолд зардлыг төрөөс гаргах асуудлыг илүү нарийвчлан судалж шийдвэрлэх хэрэгтэй.

9. Үл хөдлөх эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөгчдийн асуудал. Өнөөгийн байдлаар дундаа хэсгээр өмчилж байгаа барилгыг анх барилга бариулсан этгээд эзэмших буюу өмчилж байна. Иймд шинэ өмчлөгчид уг газрыг дундаа хэсгээр өмчлөх эрхийг нарийвчлан зааж өгөх шаардлагатай.
10. Өнөөгийн хэмжээнд иргэд, байгууллагын зүгээс хөрөнгө оруулалт хийж баригдсан, холбоо, дулаан болон бусад шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн хувьд зөрчилгүй баригдсан барилгад газрын төлбөрөө хийх болзолтойгоор хялбаршуулсан журмаар газрын зөвшөөрөл, ҮХЭХБ Гэрчилгээг олгож болох юм. Ингэснээр эдгээр этгээдүүд ч өөрийн хөрөнгийг баталгаажуулах, түүнийгээ зээлийн барьцаанд тавьж, цаашид хөдлөх зэргээр алдагдсан боломжийг нөхөх боломжтой.
11. Газар олгосон тухай Засаг даргын захирамж гарсан боловч газрын алба нь гэрээ байгуулж, газар эзэмших тухай гэрчилгээг олгохгүй хүнд суртал гаргадаг тул гэрчилгээ олгох хугацааг хуульчлах хэрэгтэй байна. Газрын тухай хуульд газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгах хугацаа 40 жил хүртэл буюу доод хугацаа байхгүйгээр заасныг өөрчилж газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгах доод хугацааг 10 жил болгох нь зүйтэй. Учир нь газар нь бусад үл хөдлөх эд хөрөнгийн суурь, үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын хугацаа урт, өртөг өндөр байдаг тул 10 жилээс бага хугацаанд эзэмшигч буюу өмчлөгчийн эрх ямар нэг байдлаар зөрчигдөх талтай.
12. Газрын тухай хуульд зааснаар, СӨХ-д орчны газрыг нь ашиглуулахдаа орчны газрын ерөнхий төлөвлөгөөг батлах шаардлагатай бөгөөд үүнийг орон нутгийн Газрын алба, Хот байгуулалтын алба хамтран батлахаар зохицуулсан байна. Дээр дурдсан 2 этгээд эрх бүхий этгээдүүдийн шийдвэрийг зөвхөн хэрэгжүүлэх үүрэгтэй байх тул СӨХ-д орчны газрыг нь ашиглуулах ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал баталдаг байвал Газрын тухай хуулийн ерөнхий зарчимд нийцэхээр байна. Ингэснээр өвгөд хөгшид, хүүхэд багачууд салхинд гарч, нарлах боломжгүй болдог хандлагыг арилгах болно. Нөгөө талаар газрын асуудлаар иргэд төлөөлөгчдөөрөө дамжуулан шийдвэр гаргах оролцоог өргөжүүлэх юм.
13. Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх үүргийнхээ дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлж, ашиглуулахдаа юуны өмнө дээр дурдсан мэдээллийн системээс тухайн газрын талаарх лавлагаа / зөвшөөрөл/-г авсны үндсэн дээр шийдвэрээ гаргадаг байх, Засаг дарга эргээд мэдээллийн системд шийдвэрээ хүргүүлж, түүнийг нь үндэслэн

мэдээллийн системд заавал өөрчлөлт оруулдаг байх, энэ журмыг зөрчиж гаргасан Засаг даргын захирамж хүчингүй байхаар хуульчлах нь зүйтэй. Энд дурдсан үйлдэл, үйл ажиллагааг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхийг орон нутгийн Газрын албаны эрх, үүрэгт тодорхой тусгах нь зүйтэй.

Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо

Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо /МХЭХ/ нь 1992 онд байгуулагдсан бөгөөд 21 аймаг, хот, дүүргүүдэд нийт 38 салбар зөвлөлтэй, 800 орчим хуульч, өмгөөлөгч, шүүгч мэргэжилтэй болон бусад эмэгтэйчүүдийг эгнээндээ нэгтгэсэн, нийтэд үйлчлэх зорилготой, ашгийн бус, төрийн бус байгууллага /ТББ/, мэргэжлийн холбоо юм. Үйл ажиллагааны хүрээ:

- Иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлэх /эрх зүйн боловсрол олгох, эрх зүйн туслалцаа, сурталчилгааг нийт иргэдийн дунд явуулах/,
- Ниймийн хөгжилд эмэгтэйчүүд, нэн ялангуяа хуульч эмэгтэйчүүдийн байр суурийг бэхжүүлэх, шийдвэр гаргах түвшинд тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх асуудлуудаар төрийн бодлого, шийдвэр гаргагчдад нөлөөлөх, бодлого боловсруулах,
- Судалгаа хийх, суурь баримт бүрдүүлэх,
- МХЭХ-ын чадварлаг бүтцийг бүрдүүлэх, гишүүдийг чадавхижуулах зэрэг болно.

Манай холбоо 2005 онд Mama Cash-аас санхүүжүүлсэн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн сургалт явуулах”, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай аймгийн салбарыг дэмжих зорилгоор “Тэмүүлэл-2”, Нэгдсэн үндэстэний байгууллагын хөгжлийн хөтөлбөр /НҮБХХ/-ийн санхүүжилтээр “Эмэгтэйчүүдийн хорих ангийн хоригдлуудад хууль зүйн зөвлөгөө өгөх” гэх мэт олон төслийг амжилттай хэрэгжүүлсэн.

Мониторингийн багийн бүрэлдэхүүн

| | |
|--------------|-----------------------------------|
| Х. Оюунцэцэг | МХЭХ-ын гүйцэтгэх захирал |
| Ц. Оюунчимэг | ГХГГЗА-ийн Хуулийн хэлтсийн дарга |
| А. Жаргалан | Өмгөөлөгч |
| Я. Нямжав | Хуулийн зөвлөх, өмгөөлөгч |
| Л. Жавзмаа | МХЭХ-ын хуулийн зөвлөх |
| Б. Ундармаа | МХЭХ-ын ажилтан |
| Х. Энхзаяа | МХЭХ-ын ажилтан хуульч |

Уг төслийг хэрэгжүүлэх явцад манай холбооны дэргэдэх Мандухай клубын гишүүд болох МУИС-ийн оюутнууд, Удирдлыгбн Академи /УА/-ийн сонсогчид идэвхитэй оролцсон болно.

Ном зүй

Нэг. Монгол Улсын хууль:

- Монгол Улсын Үндсэн Хууль, 1992 он
- Газрын тухай хууль, 2002 он
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, 2002 он
- Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай, 2003 он
- Барилгын тухай, 1998 он
- Хот байгуулалтын тухай, 1998 он
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, 1999 он

Хоёр. Ном, эмхтгэл, журам, тогтоол

- Газрын харилцааны хууль тогтоомжийн эмхтгэл, ГТХАН, ГХГЗЗГ, 2006 он
- “Газрын харилцааны шинэтгэл” иргэдэд зориулсан гарын авлага, Нээлттэй Нийгэм форум, 2004 он
- Р. Ганхуяг, Монгол Улсын газрын шинэтгэлийн асуудал, Нээлттэй Нийгэм форум, 2005 он
- Барилгын норм, норматив баримт бичгийн лавлах. МУЗГХА., Барилга Архитектурын Газар. 2000 он.
- Нийслэлийн Газрын албаны Иргэдийн өргөдөл гомдол шийдвэрлэсэн тухай 2004, 2005, 2006 (1-р улирал) оны тайлан
- Нийслэл Улаанбаатар хотын хот байгуулалт барилгажилтын журам
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар гарсан танилцуулга, 2005 он

Үгийн товчлол

| | |
|---------------|--|
| АНЗД | Аймаг, нийслэлийн засаг дарга |
| ГТХАН | Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг |
| ГХГЗЗГ | Газрын харилцаа, Геодези, Зураг зүйн газар |
| МННХ | Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн |
| МУИС | Монгол Улсын Их Сургууль |
| МУЗГХА | Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэх Агентлаг |
| МХЭХ | Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо |
| НГА | Нийслэлийн Газрын Алба |
| НГХХБМК | Нийслэлийн газрын харилцаа, хот байгуулалтын мэрэгжлийн комисс |
| НЗДТГ | Нийслэлийн засаг даргын тамгын газар |
| СӨХ | Сууц Өмчлөгчдийн Холбоо |
| ХЗДС | Хууль Зүйн Дээд Сургууль |
| УДШ | Улсын Дээд Шүүх |
| УИХ | Улсын Их Хурал |
| УА | Удирдлагын академи |
| ЭХӨЭТХЭХБЭУБТ | Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль |

Газрын харилцаа ба иргэд

Төслийн зорилго:

Орон нутагт газар өмчилж, хувьчилж авах хүсэлт гаргасан байгууллага, иргэдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч буй байдал, тэдэнд үйлчилж буй Газрын албаны үйл ажиллагааг ил тод болгон сайжруулах.

Төслийн зорилт:

- Газар олголтын байдал, хуулиудын хэрэгжилтэд ажиглалт хийн хяналт тавих,
- Шийдвэрлэж буй албан тушаалтны ажилд хүнд суртал авилгал байгаа эсэхийг тодруулах,
- Хүнд суртлын шалтгааныг арилгах арга замыг тодорхойлох,
- Газар өмчлөх, эзэмшүүлэх явцад хүндрэл бэрхшээлтэй асуудлууд хэр зэрэг байгааг олж тогтоох,
- Тухайн жилд газар олгох өргөдөл, хүсэлтийг хүлээн авах хугацааг олон нийтэд хүрээмжтэй зарлаж буй эсэхэд ажиглалт хийх,
- Иргэдийн өргөдөл, хүсэлт хүлээн авахдаа бүртгэл, журнал хэрхэн хөтлөж байгаа болон дарааллыг баримталж байгаа эсэхэд хяналт тавих.

Мониторингийн үндэслэл

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн шинэ харилцаанд шилжин орсноор газар ашиглалтын олон хэлбэр бий болж, газрын харилцааны зохицуулах цар хүрээ улам өргөжин нарийсч, тэдгээрийг тухай бүрт нь зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдийг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж иржээ. 1994 оноос мөрдөгдөж ирсэн Газрын тухай Монгол Улсын хуулийг нийгэм-эдийн засгийн

чиг хандлагад нийцүүлэн шинэчлэн найруулж, баталгаажуулсны зэрэгцээ манай орны түүхэнд анх удаа зөвхөн Монгол Улсын иргэдэд газар өмчлөх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд уялдуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэн хангасан. Улс орноо хөгжүүлэхийн тулд иргэн бүр газартайгаа харьцах, улмаар газрын харилцааны шинэчлэлийн асуудлуудыг зөв ойлгох нь чухал ач холбогдолтой. Монгол Улсад газар хувийн өмчид байж болно гэдгийг шинэ Үндсэн хуулиар зааж өгсөн боловч энэ эрхийг хэн, хэзээ, хэрхэн эдлэх тухай асуудал өнөө хүртэл тавигдсаар л байна. Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан заавар журмыг иргэд зөв ойлгох, газар эзэмших, ашиглах, өмчлөхийн мөн чанарыг хэрхэн танин мэдсэнээс газрын харилцааг шинэчлэх ажлын эцсийн үр дүн хамаарна.

Ард иргэдийн дунд Монгол Улсын Газрын тухай хууль, Монгол Улсын иргэдэд газар өмчлүүлэх тухай хуулийг тайлбарлан таниулах, сурталчлах, газрын нөөцийг зөв тогтоож, олон түмэнд мэдээлэх асуудал хангалтгүй байгаагаас газрыг иргэн бүрт тэгш эрхтэй хуваарилж өмчлүүлэх, эзэмшүүлэх асуудал бүрэн хэрэгжихгүй байгаа билээ. Энэ нь нэг талаар, хууль амьдралд бүрэн нийцэхгүй байгаа, нөгөө талаар хууль төгс биш ч гэсэн хуулийг хэрэгжүүлэх явцад төрийн эрх бүхий албан тушаалтны мэдлэг чадвар, ёс суртахууны байдлаас шалтгаалан хөрөнгө, албан тушаал, нутаг ус, танил тал, албан тушаалтны хувийн сонирхол зэргээс хамааралтайгаар Монгол Улсын Үндсэн хуулийн “Иргэн бүхэн тэгш эрхтэй” гэсэн заалт жирийн ядуу иргэдэд хамааралгүй шахам болсон нөхцөл байдал бий болсон.

Багануур дүүргийн хувьд Засаг даргын тамгын газрын /ЗДТГ/ дэргэдэх Газрын албанаас /ГА/ аж ахуйн болон хувийн хэрэгцээнд газар хуваарилдаг боловч газрын нөөцөө зөв тогтоох, ард иргэд тэгш эрхтэй, хуулийн хүрээнд шударга хуваарилах асуудал алдагдаж байгаа нь харагдаж байв. Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүйгээс орчин үеийн барилга байгууламж барих талбай гэр хороололд шахагдан хомсдож, хотын төв, нийтийн эзэмшлийн гудамж талбай, түүгээр ч үл барам хүүхдийн тоглоомын талбай дээр газар олгож байгаа нь туйлын харамсалтай. Газрын харилцааны хуулиудад бие биетэйгээ зөрчилдсөн, амьдралд хэрэгжих боломжгүй зүйл заалтууд их байгаад дүгнэлт хийх нь зүйтэй.

Иймд Багануур дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх ГА-ын үйл ажиллагаа, Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, өнөөгийн дүүргийн газар эзэмшлийн болон хувьчлалын үйл явц хэрхэн явагдаж байгаа зэргийг судалж дүгнэлт гарган, цаашид хэрхэн ажиллах талаар санал дэвшүүлэх нь зүйтэй. Газрын эзэмшил, өмчлөлд шударга бусаар хандаж байгаа тухай баримт материалд үндэслэн шүүмжлэлтэй хандаж, уг зохисгүй байдлыг арилгахад анхаарал хандуулах зорилгоор энэхүү мониторингийн төслийг хэрэгжүүлсэн юм.

Мониторингийн аргачлал

- Шууд ажиглалт: Шинээр олгохоор зөвшөөрөгдсөн газарт өргөдөл, хүсэлт хүлээн авах хугацааг олон нийтэд ил тод, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүртээмжтэй зарлаж, өргөдөл, хүсэлт хүлээн авахдаа бүртгэлийн дугаарыг дарааллаар нь тогтоож буй эсэхийг хянахын тулд ажиглагчдаа оролцуулах хүсэлт тавин ажилласан.
- Хоёрдогч мэдээ баримт цуглуулах: Албан ёсны мэдээлэл, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээлэл, шалгалтын материалууд, хууль тогтоомж, баримт бичиг, бүртгэл журнал, гарсан шийдвэрүүдтэй танилцаж, иргэдийн дунд судалгаа явуулж, анализ дүгнэлт хийн ажилласан.
- Хэсэгчилсэн болон ганцаарчилсан, фокус ярилцлагууд зохион байгууллаа. Кейс бодит байдал дээр очиж танилцан видео бичлэг, зураг авалт хийв.
- Мэдээлэл цуглуулахдаа мэргэжлийн байгууллагууд, тэдгээрийн гаргасан тогтоол шийдвэр, удирдамж, үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөтэй танилцаж, ажиглаж тогтоосон зүйл тус бүр дээр тайлан дүгнэлт гаргасан.
- Мэдээллийг хүлээн авах бүлэг бүрт нийцүүлэн зөвлөмж боловсруулан ажиглалтаар олж илрүүлсэн зүйлийг олон нийтэд танилцуулахын зэрэгцээ хэлэлцүүлэг, хэвлэлийн бага хурал хийж, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол явуулж байсан.

Хамарсан хүрээ, хугацаа, байршил

2005 оны 11 дүгээр сараас 2006 оны 8 дугаар сар хүртэл 9 сарын хугацаатай Улаанбаатар хотын Багануур дүүргийн 1, 3, 4 дүгээр хороонд хэрэгжүүлсэн.

Монитринг хийхэд баримтлал болгосон холбогдох хууль тогтоомжууд

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай Монгол Улсын хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журам, Газрын харилцааны талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагын тогтолцоо, заавар журам, Газар өмчлөх, эзэмших эрх, Газар эзэмших, өмчлөх тухай хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

МОНИТОРИНГИЙН ДҮН

Ерөнхий дүгнэлт бодит байдал

Орон нутагт газрын шинэтгэлийн асуудал хэрхэн явагдаж байгаад мониторинг хийхдээ доорх асуудлуудад голчлон анхаарлаа.

1. Газартай холбоотой хууль тогтоомж амьдралд хэр нийцэж байна вэ?
2. Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, ЗДТГ, газартай холбоотой хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх талаар хэрхэн ажиллаж байгааг бодит байдал дээр судлах,
3. Төрийн үйлчилгээ явуулж буй газрын албаны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх,
4. Ард иргэдийн дунд тэдний хууль эрх зүйн мэдлэг боловсрол, иргэний үүргийн биелэлт, газрын харилцаатай холбоотой асуудлаар судалгаа явуулж, дүн шинжилгээ хийн нөлөөллийн арга хэмжээг бололцооны хирээр авч хэрэгжүүллээ.

Газартай холбоотой хууль тогтоомж амьдралд хэр нийцэж байна вэ?

Мониторинг хийх явцад газрын харилцааны зохицуулалтыг цаашид Иргэний хуулийн суурь зарчмуудтай нийцүүлэн шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдаж байна. Иргэний хуульд эдийн баялгийг өмчлөх эрх болон газрын харилцааны зохицуулалтын хооронд нэр томъёоны хувьд төдийгүй зарчмын хувьд өөр хоорондоо зөрчилтэй зүйл анги ч байгаа ба Иргэний хуульд орсон институтийг Газрын тухай хууль болон Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нарийвчлан тусгаж, зохицуулалт хийхийг амьдрал шаардаж байна. Түүнчлэн хот суурин газрын харилцаа нь барилга байгуулалт, хот төлөвлөлт, нийтийн эрүүл ахуйн харилцаатай нягт холбоотой юм. Хамгийн наад захын жишээ л гэхэд Монгол Улсын иргэн гэр бүлийнхээ хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчилж авах эрхээр хангагджээ. Гэвч энэ нь гэр бүл болоогүй л бол Монгол Улсын иргэн хэн ч бай хамаагүй, үнэгүйгээр газар өмчлөх эрхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ хүн насаараа гэр бүл авахгүй бол насаараа газар өмчлөх эрхгүй болж байгаа нь иргэний эрхийг ноцтой зөрчиж байгаа хэрэг мөн.

Газар эзэмших эрхийн бичгээ барьцаалах, худалдах зэргээр захиран зарцуулахтай холбогдсон эрхийг боловсронгуй болгох шаардлагатай. Жишээлбэл, банкууд газар барьцаалан зээл олгохгүй байгаа нь, газрыг зах зээл, эдийн засгийн баталгаа болгох талаар хууль эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг харуулж байгаа юм. Иргэд газар өмчилж авсан ч тухайн газар дээрээ хөрөнгө оруулалт хийх, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах эдийн

засгийн чадавх сул байгаагаас гадна газар эзэмших эрхийн хугацаа богино байгаа талаар иргэд шүүмжлэлтэй хандаж байна.

Үүнээс болоод газар өмчлөл, эзэмшлийн асуудал эрчимтэй явагдахгүй байгаа байдал ажиглагдав. Нөгөөтэйгүүр, энэ талаар гарсан хуулиудыг санаатайгаар зөрчиж буй албан тушаалтнуудад хүлээлгэх хариуцлагын тогтолцоо илт үгүйлэгдэж байгаа нь харагдлаа.

Газар өмчлөлийн байдлаар 460 өрх, газрын шинэтгэлийн асуудлаар 280 хүнээс санал асуулга авч дүн шинжилгээ хийлээ. 5 асуудлаар судалгааны асуулга боловсруулж 280 иргэнээс судалгаа авахад:

1. Газрын харилцааны хуулиудыг та хэр сайн судалсан бэ? Хуулийн сурталчилгаа хэр зэрэг байна вэ? гэсэн асуултад:

Мэднэ-50

Мэдэхгүй -100

Дунд зэрэг мэднэ гэж 130 хүн хариулжээ.

2. Та газар эзэмших, өмчлөх явцад тэгш эрхтэй оролцож чадаж байна уу? гэсэн асуултад:

Чадаж байна-80,

Чадахгүй байна-140,

Оролцоогүй гэж 60 хүн хариулжээ.

3. Дүүрэгт газар өмчлүүлэх, эзэмшүүлэх асуудал хэр шударга явагдаж байна вэ? гэсэн асуултад:

Шударга-156

Шударга бус - 64

Мэдэхгүй гэж 60хүн хариулсан байна.

4. Газрын албаны үйл ажиллагаа, Газрын хуваарилалтын талаарх таны дүгнэлт:

Хангалттай-38%

Хангалтгүй-32 %

Дунд зэрэг-30% хариулсан байна.

Газрын шинэтгэлийн асуудлаар тодорхой санал ирсэнгүй. Багануур дүүргийн 1,3,4 дүгээр хороо буюу гэр хорооллын 460 өрхөөс Газар өмчлөл, эзэмшлийн талаар 10 асуудлаар судалгаа авч, дүн шинжилгээ хийсэн.

Орон нутгийн Иргэдийн төлөөллийн байгууллага, төр захиргааны байгууллагын үйл ажиллагаа

Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас Газрын харилцаатай холбогдсон хуулиуд орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа талаар газрын албаны үйл ажиллагаа, газар зохион байгуулалтын өнөөгийн байдалд

шалгалт хийсэн дүнгийн материалаас харахад газар зохион байгуулалтын ажлын төлөвлөгөөнд нийт 28 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөний 11 нь биелэгдсэн, 9 нь дутуу биелэлттэй, бусад ажил нь биелэгдээгүй байна. Тухайлбал, дүүргийн нутаг дэвсгэрт мөрдөгдөж байсан газрын харилцаатай холбоотой заавар, дүрэм журмыг шинэчлэх, шинээр боловсруулах, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгжүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх, тэднийг энэ чиглэлээр төлөвлөгөөтэй ажиллуулах, суурин газрын ойролцоох бэлчээрийн газрыг хамгаалах, төлбөрийн ялгавартай бодлогоор зохицуулах, газрын төлбөрийн зохих хэсгийг газрын нөөцийг нөхөн сэргээх, ашиглалтыг сайжруулахад зарцуулах, газрын бохирдолд хяналт тавих, зэрэг хамгийн чухал ажлууд хэрэгжээгүй байна. Эдгээрийг тооцон үзвэл газар зохион байгуулалтын төлөвлөгөөний /2 жилийн/ биелэлт 57,1 хувьтай байна гэж дүгнэжээ. Гэвч Багануур дүүрэгт өнөөдөр хот байгуулалт, хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө байхгүй, хот байгуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, архитекторгүйгээс хот байгуулалт, төлөвлөлтийн бодлого алдагдаж, төрийн захиргааны эрх бүхий албан тушаалтнууд танил тал, албан тушаал, зэрэг дэв хөрөнгө чинээ харгалзан газар олгох байдал нилээд гарч байна.

Өнөөдрийн хэлэлцүүлэг чухал ач холбогдолтой болж байна. Хот байгуулалтын бодлого, ерөнхий төлөвлөгөөний асуудал тавигдаж байна. Энэ асуудал Нийслэлээс хамааралтай дүүргийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах шатандаа байна.

ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга Шагдарсүрэн

Газрын асуудал яригдахын өмнө хот байгуулалтын асуудал яригдах ёстой. Хот байгуулалт алдагдаж байна. Хот байгуулалт, хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө байхгүй, хариуцсан мэргэжилтэн, архитектор байхгүй байгаа нь газрын асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл учруулж албан тушаалтнууд дураараа шийдвэр гаргах боломжийг нээж өгч байна. Газрын албаны бүтэц зохион байгуулалт албан тушаалтны ажил үүргийн хуваарийг шинэ шатанд гаргаж, албан тушаалтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна.

ЗДТГ-ын түшмэл Эрдэнэчимэг

2006 оны 4 дүгээр сард Ерөнхий төлөвлөгөөний шаардлага өгсөн. Мэргэжлийн алба архитектор байхгүй, Засаг даргын захирамжаар шийдвэрлэдэг. Дуртай нь л байшин барилга барьж хаалга үүд гаргаж байгаад анхаарах ёстой.

Мэргэжлийн хяналтын албаны ажилтан Мандах

Газрын албанаас зохион байгуулсан 45 хоногийн аян зөв зүйтэй арга хэмжээ боллоо. Багануур дүүрэг хот төлөвлөлт, хот байгуулалтын төлөвлөгөө огт байхгүй байгаа нь туйлын харамсалтай бөгөөд иргэдийн хурал түүний төлөөлөгчид, төрийн захиргааны түшмэлүүдийн энэ талаархи мэдлэг туйлын хангалтгүй байна. Түүгээр ч үл барам эрх мэдэл, албан тушаалаа ашиглан төрөл садан, танил тал, хөрөнгө, зорьтой хүмүүст хотын төв нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбай дээр газар олгож байгааг яаралтай таслан зогсоох хэрэгтэй.

1-р хорооны иргэн Ж Баяраа

Төрийн албаны ажлын уялдаа холбоо муугаас газар олгох асуудлыг удаашруулах, газрыг давхардуулан олгосноос иргэдийн дунд маргаан үүсэн чирэгдүүлж, нэг нь зөвшөөрч байхад нөгөө нь татгалзах, бие биерүүгээ түлхэх асуудал гарч байна. Асуудлыг тодорхой шалтгаангүйгээр шийдвэрлэхгүй удаах, иргэдийг олон дахин явуулж байгаа хэд хэдэн асуудалд анализ дүгнэлт хийж үзэхэд албаны ажлын уялдаа холбоогүй, хүнд сурталтай, шийдвэрлэж болох асуудлаар олон дахин явуулж байгаа нь харагдаж байв.

Газар өмчлөх, эзэмших гэрчилгээ давхардуулан олгож шүүхээр яваад ч шийдвэрлүүлж чадахгүй байгаа асуудал хэд хэдэн удаа гарч төслийн багт хандан материалаа өгснийг судлан үзэхэд, ажил хариуцсан хүмүүсийн хариуцлага муу, нэгдсэн мэдээлэлгүй байгаатай холбоотой байна гэж үзлээ. Шүүх, хууль хяналтын байгууллагууд газрын маргаантай асуудлыг шийдэхдээ хэт нэг талыг баримтлан иргэдийг хохироосон шийдвэр гаргаж байна.

| | |
|----------|---|
| Баримт 1 | Жаргалантын 6-1 тоотод оршин суугч Л.Отгоны гомдол Айлын байшинг голоор нь хувааж өмчлөх шийдвэр гаргасан. |
| Баримт 2 | 4 дүгээр хороо Залуусын 25-10 тоот Х Батхүү 3 жилийн өмнө амины орон сууц барих зөвшөөрөл авч гэрчилгээ, бичиг баримт байсаар байтал өөр айлд давхар зөвшөөрөл олгосныг 3 шатны шүүх өөр өөрөөр шийдвэрлэн чирэгдүүлсээр л байна. |
| Баримт 3 | 4 дүгээр хорооны иргэн Оюунтүлхүүр 2003 онд Нарийний 7-2 тоот хашааг Ойдов гэдэг хүнээс худалдаж аваад гэрчилгээ авсан байтал 2004 онд Ойдовт дахин гэрчилгээ олгосон ба Ойдов энэ газрыг дахин өөр хүнд худалдаад айл буулгасан байтал асуудлыг шийдвэрлэж чадахгүй л байна. |

Төрийн үйлчилгээ явуулж буй газрын албаны үйл ажиллагааны өнөөгийн байдал:

Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар газар олгохдоо дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулах тендер зарлаж олгох зарчмыг баримталдаггүй, эрх мэдэл, албан тушаалаа ашиглан төрөл садан, танил тал, хөрөнгө мөнгөтэй хүмүүст газар олгох шийдвэр гаргаж байсан бөгөөд асуудлыг хөндөж тавьснаар хэд хэдэн газрын зөвшөөрлийг хүчингүй болгосон. Үүнд: 24 дүгээр байрны үрд, 38 дугаар байрны хажууд, 66 дугаар сургуулийн баруун талын уурхайн нийтийн байрны дэргэдэх 550м-ийн зөвшөөрөл өгсөн газруудыг хүчингүй болгосон байна.

Нийслэл, дүүргийн газрын албаныхан иргэдэд үнэгүй өмчлөн өгөх газрыг зохион байгуулалттайгаар худалдаж, авилга хээл хахууль авч, танил талдаа үйлчилдэг. Газрын эзэмшил өмчлөлд шударга бус байдлаар хандах явдал гарч байв.

Тухайн оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу шинээр газар олгохдоо 1-2 сарын өмнө бүх нийтэд зарлан өргөдөл, хүсэлт хүлээн авдаг журамтай. Гэтэл 2005 оноос өмнө энэ журмыг зөрчиж нийт иргэдэд зарлахгүй, ерөөний хаалганы гадна талд зар нааж, зарлал явуулж, тухайн өдөрт дараалалд багтаж, өргөдлөө өгсөн хүмүүст газар олгож байсан. Энэ байдал нь иргэд мэдээлэлгүйгээс хоцорч газар өмчлөх, эзэмших эрх нь хязгаарлагдаж, шударга бус байдлаар газрыг хуваарилан олгож байсан.

2006 онд өргөдөл, хүсэлт хүлээн авах хугацааг радио, телевизээр олон нийтэд зарлан өргөдлийн ирсэн цаг хугацааг тавин дарааллаар нь бүртгэн дугаар тогтоож зөвшөөрөл олгодог журамд шилжсэн. Энэ үеэр төслийн баг газрын албанд хүсэлт тавьж тогтмол ажиглалт хийн ажилласан бөгөөд ямар нэг гомдол санал гараагүй.

Газрын асуудлаар өргөдөл, хүсэлт хүлээн авч буй байдал, газар олгож байгаа баримт материалтай танилцахад хэд хэдэн зөрчлүүд гарсан. Өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэж буй байдал удаан, захирамжгүй газар зөвшөөрөл олгосон, холбогдох албан тушаалтны гарын үсэг дутуу шийдэх боломжтой асуудлыг шийдвэрлэхгүй удаах зэрэг асуудал гарч байгаад дүгнэлт хийн ярилцлага хэлэлцүүлгийн үеэр асуудлыг хөндөж тавьлаа.

Газар өмчлүүлэхдээ тухайн газрыг харьяалж буй хороо, багийн засаг даргын тодорхойлолт, өрхийн бүртгэлийг үндэс болгон газар өмчлүүлэх шийдвэрийг гаргаж байгаа нь газар өмчилсөн иргэд хэд хэдэн удаа ч зохих баримт бичгийг бүрдүүлсний үндсэн дээр үнэ төлбөргүйгээр газар өмчилж авах боломжтой болгож байгаа юм. Мөн нэг газрыг хэд хэдэн хүнд ч эзэмшүүлж гэрчилгээ олгох тохиолдол гарч байна. Иймээс өмчлүүлэх хүсэлт гаргаж буй иргэн бүрийн талаарх гэр бүлийн дэлгэрэнгүй бүртгэл, газрын бүртгэлийн сан бүхий газрын мэдээллийн системийг улсын хэмжээнд буй болгож, уг системээр дамжуулан газар өмчлүүлэх шийдвэр гаргахын өмнө тухайн иргэн урьд нь газар өмчилж байсан эсэхийг нягтлан магадласны үндсэнд шийдвэрлэж байх шаардлагтай.

Ард иргэдийн хууль эрх зүйн боловсрол, иргэний үүргийн биелэлт

Газар өмчлөх, газрын тухай хууль тогтоомжийн талаарх жирийн иргэдийн ойлголт, мэдлэг муу байгаа нь хууль тогтоомжийн талаарх сурталчилгаа, мэдээлэл, нөлөөллийн ажлууд хийгдэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Иргэд газар өмчилж авсан ч гэсэн эдийн засгийн эргэлтэд оруулах мэдлэг муу, газрын зах зээлийн орчин бүрдээгүй байна. Газар өмчлөх, эзэмших өргөдлөө өгөөд өөрсдөө ирэхгүй алга болох, гэр бүлийн хүмүүсийн хоорондын зөрчил их гардаг. Газраа заалгачихаад хашаа барихгүй, ашиглахгүй байсаар 2 жил болоод хуулийн дагуу хурааж дахин хуваарилалтад оруулах асуудлууд ч их гарч байна.

Иргэд бичиг баримтын зөрчилтэй, бичиг баримтын бүрдүүлэлт дутуу, зөвшөөрөлгүй газарт дураараа буусан, газар эзэмших ашиглах эрх нь үүсээгүй, гэрээ гэрчилгээгүй, газрын төлбөрөө төлдөггүй зөрчил гаргаж байна. Нийтийн эзэмшлийн зам талбайг хааж хашаа барьснаас зарим айл гэртээ ч орох боломжгүй хэд хэдэн айлын хашаа дамжин орж байна. Айлын хашаа сахиж буучихаад хэдэн жил болоод гэрчилгээ давхар авч маргаан үүсгэж байна. Зөвшөөрөлгүй газар гудамжны ам таглан бууж дуртай газраа хашаа барин мухар гудам гарснаар нэг айл усандаа хүрэх гэж хичнээн гудам дамжиж явна.

Иймэрхүү байдлаас болж гудамжнууд хэтэрхий урт, битүү, гудам ихтэй, эмх замбараагүй байдал үүсгэж байгааг баримтжуулж зарим иргэдтэй уулзан ярицлага авч, бичлэг хийн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн нь ард иргэд хуулиа дээдлэн газрын харилцаанд оролцохдоо эрх үүргээ мэддэг байх, дүүргээ өнгө үзэмжтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, эмх цэгцтэй болгох талаар анхааруулга өглөө.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Газар өмчлөл, хувьчлалыг шударга явуулах, Газрын тухай хууль болон Монгол Улсын иргэдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх тухай хуулийг хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод шуурхай болгоход нөлөөлөх, хуулийн хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгосноор хууль завхруулагчдад шахалт үзүүлж, хууль зөрчих болон элдэв үйл ажиллагааг таслан зогсооход нөлөөлөх шаардлагатай байна.

Ингэхийн тулд мэргэжлийн хуульч, өмгөөлөгч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг багтаасан хурдан шуурхай, мэргэжлийн өндөр түвшинд шийдвэр гаргах чадвартай, маргаан шийдвэрлэх тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

2. Бодит байдал, иргэдийн санал хүсэлтийг харгалзан хуулийн зарим заалтыг өөрчлөх, зарим заалтуудыг нэмж оруулах шаардлагатай. Тухайлбал, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд заасан Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн газар өмчлөн авах эрхтэй. Монгол Улсын иргэн гэр бүлийн хэрэгцээнд 1 удаа үнэ төлбөргүй газар өмчлөх эрхээр хангагджээ. Гэтэл амьдралын янз бүрийн шалтгаанаар ганц бие амьдарч буй хүмүүсийн энэ эрх хангагдахгүй байгааг харгалзан хуулийн энэ заалтыг өөрчлөх эсвэл тодорхой тайлбар өгөх шаардлагатай байна.
3. Хууль журам зөрчиж, дураараа авирлаж буй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог яаравчлан буй болгохыг өнөөгийн бодит байдал шаардаж байна.
4. Орон нутаг, хот суурин газар, ялангуяа Багануур дүүрэгт хөгжлийн чиг хандлагыг харгалзан газар төлөвлөлт, хот байгуулалт, хот төлөвлөлтийн мэргэшсэн алба, мэргэжлийн архитектортой болгох, газрын албыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх нь зүйтэй.
5. Багануур дүүргийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг иргэд, олон нийтийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор яаравчлан боловсруулж олон нийтэд ил тод хүргэн түүнтэй уялдсан газар төлөвлөлтийн бодлого, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.
6. Газрын албаны үйл ажиллагааг ил тод, иргэдэд нээлттэй байлгах зарчмыг хэрэгжүүлбэл зохино.
7. Иргэдийг газрын харилцаанд идэвхитэй оролцуулахын тулд тэднийг мэдээллээр ханган хуулийн талаар мэдлэг олгох, сургалт сурталчилгаа явуулснаар тэдний идэвхийг нэмэгдүүлж, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласнаар газрын хуулийн хэрэгжилтийг хангах хэрэгтэй.

8. Иргэдтэй ойр ажилласнаар зөрчил дутагдал, баримт мэдээллийг олж авч, түүндээ анализ дүгнэлт хийн тус бүрд тайлан зөвлөмж боловсруулан, мэдээллийг хэвлэлийн бага хурал, хэлэлцүүлэг, ярилцлагын үеэр асуудал болгон тавьж уг асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, хэрхэн хамтран ажиллах, ажлын үялдаа холбоог сайжруулахад юунд анхаарах зэрэг тодорхой бодитой ажлуудыг зохион байгуулдаг механизм бий болгох нь зүйтэй.
9. Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар газар олгохдоо дуудлага худалдаа явуулж, төсөл сонгон шалгаруулдаггүйгээс эрх мэдэлтнүүд танил тал хөрөнгө мөнгө харж хотын дунд өнгө үзэмжгүй байшин барих асуудал их гарч байна. Энэ нь хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй, мэргэжлийн алба байхгүй байгаатай шууд холбоотой бөгөөд албан тушаалтнуудад дураараа авирлах боломжийг нээн өгч байна.
10. Иргэдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх гэрчилгээ давхардуулан олгож байгаа нь мэдээллийн нэгдсэн системгүй, нэг хүн хэдэн ч удаа үнэ төлбөргүй газар авах боломжтой байна. Иймд газрын мэдээллийн системийг улсын хэмжээнд бий болгон, нягтлан магадласны үндсэн дээр шийдвэрлэж байх хэрэгтэй байна.
11. Дүүргийн хэмжээнд газрын асуудлаар сүүлийн нэг жилд өргөдөл гомдол гарах нь багасч, өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэж байгаа хэдий ч өмнөх жилүүдийн маргаантай асуудлыг шийдвэрлэж цэгцлэх шаардлагатай гэж үзлээ.

Cedaw Watch

Cedaw Watch 1999 онд байгуулагдсан бөгөөд орон нутгийн эмэгтэйчүүдийн эрх, тэдний нийгмийн асуудлуудад анхаарал тавихын хажуугаар орон нутгийн хөгжилд зохих хувь нэмэрээ оруулах зорилготой ажилладаг төрийн бус байгууллага юм.

Мониторингийн багийн бүрэлдэхүүн:

| | |
|---------------|---------------------|
| Ё. Туул | Төслийн зохицуулагч |
| Т. Олзбаяр | Төслийн ажилтан |
| Ч. Наранцэцэг | Нягтлан бодогч |

Ном зүй:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Газрын тухай Монгол Улсын хууль, 2002 он.
3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай Монгол Улсын хууль, 2002 он.
4. Шинэчлэн найруулсан Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол, 2003 он.
5. Монгол Улсын газрын шинэтгэлийн асуудал, 2005 он.
6. Газрын харилцааны шинэтгэл, 2005 он.
7. Газрын харилцааны хууль тогтоомжийн эмхтгэл ГТХАМ, ГХГЗЭГ, 2006 он.
8. Газрын харилцааны шинэтгэл “Иргэдэд зориулсан гарын авлага”, Нээлттэй Нийгэм Форум.
9. Р. Ганхуяг “Монгол Улсын газрын шинэтгэлийн асуудал”, Нээлттэй Нийгэм Форум, 2005 он.
10. Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас газрын албанд хийсэн шалгалтын материал, 2004 он.
11. Хот байгуулалт, газрын харилцаа, геодези зураг зүйн чиглэлээр хийсэн шалгалтын материал, 2004, 2005 он.

Товчилсон нэр:

| | |
|------|------------------------------|
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ГА | Газрын алба |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |

Нийтийн орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайн газар олголт, эзэмшилтийн мониторинг

Төслийн зорилго:

“Нийтийн орон сууцны хүүхдийн тоглоомын талбайн газар олголт, эзэмшилтийн мониторинг”-ийн зорилго нь орон сууцны хороолол дахь хүүхдийн тоглоомын талбайн хууль, эрх зүйн орчны бүрдэлт, түүний хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийх, энэ талаар оршин суугч, хүүхдүүд, тэдгээрийн төлөөлөл болсон Сууц өмчлөгчдийн холбоо /СӨХ/-д мэдээлэл өгөх, гарч буй зарим дутагдал, зөрчлийг нийтэд ил тод болгох, судалгааны дүгнэлтэд үндэслэн цаашид анхаарах асуудлын хүрээг тогтоон зохих холбогдох байгууллага, хүмүүст зөвлөмж болгох явдал юм.

Төслийн зорилт:

- Орон сууцны хороолол дахь хүүхдийн тоглоомын талбайн хууль, эрх зүйн орчны бүрдэлт, түүний хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийх,
- Орон сууцны хороолол дахь хүүхдийн тоглоомын талбайн хууль, эрх зүй, баримталбал зохих норм, нормативын талаар иргэд, оршин суугчдад мэдээлэл хүргэх,
- Орон сууцны хороолол дахь хүүхдийн тоглоомын талбайн хууль, эрх зүйн талаар СӨХ-д мэдээлэл хүргэх,
- Хүүхдийн тоглоомын талбайг хамгаалах шаардлагатай байгааг хэвлэл, мэдээлэл, нөлөөллийн бусад хэрэгслийг ашиглан нийтэд мэдээлж, анхааруулах,
- Орон сууцны хороолол дахь хүүхдийн тоглоомын талбайн талаар гарч буй зөрчил, дутагдлыг илрүүлэх, тэдгээрийг арилгах талаар санал, зөвлөмж боловсруулах,
- Судалгааны дүгнэлтэд үндэслэн цаашид төр засаг, холбогдох байгууллага, албан тушаалтнаас авах арга хэмжээний хүрээг тогтоон санал, зөвлөмж гаргах.

Мониторингийн багийн баримталсан зарчмууд

- Хор, хохиролтой үр дагавар гаргахгүй байх,
- Урьдчилан тодорхойлж тогтсон дүрэм, төлөвлөгөөг баримтлах,
- Нэгдмэл нэг ойлголттойгоор ажиллах,
- Бэрхшээлтэй асуудал тулгарсан үед мэргэжлийн экспертүүдтэй зөвлөлдөх,
- Эрх мэдэлтнүүдийг хүндлэх,
- Найдвартай байх, чадахгүй зүйлийн талаар амлалт өгөхгүй байх,
- Эх үүсвэрийн нууцыг хадгалах,
- Нөхцөл байдлын цаад учрыг судалж танилцах,
- Төвийг сахисан, тогтвортой байх,
- Мэдээлэл цуглуулах, шинжлэх болон түгээхэд бодитой хандах,
- Хүний эрхийг хүндэтгэн хүлцэл, тэвчээртэй байх,
- Мэргэжлийн түвшинд ажиллах.

Мониторингийн хугацаа, хамарсан хүрээ, байршил

Мониторингийн үйл ажиллагаа нь Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгино-хайрхан зэрэг 6 дүүрэг, Дархан-Уул аймгийн Дархан хот, Орхон аймгийн Эрдэнэт хотын орон сууцны хорооллуудыг хамарсан болно.

Мониторингийг 2006 оны 1 дүгээр сараас 2006 оны 10 дугаар сар хүртэл 3 үе шаттайгаар явуулав. Мониторингийн үндсэн үйл ажиллагаа 4 сар 15 хоногийн хугацааг хамран үргэлжилсэн бөгөөд тайлан эцэслэн боловсруулах үйл ажиллагаа 9, 10 дугаар саруудад үргэлжлэн явагдлаа.

Мониторингийн аргачлал

Судалгаа, мэдээллийг цуглуулахад төр засгийн вэб хуудас, интернэтийн мэдээлэл, хэвлэл мэдээллийн эх сурвалжтай танилцах, ажиглалт тандалт хийх, ганцаарчилсан ярилцлага, бүлгийн хэлэлцүүлэг, телевизийн нээлттэй нэвтрүүлэг зохиох, зураг авах, тусгайлан бэлтгэсэн хуудсаар асуулга авах, албан бичгээр санал солилцох зэрэг аргыг хэрэглэв. Мониторингийн үед нийт 277 иргэн, албан тушаалтантай ярилцлага хийж, асуулгын хариуг авлаа.

Олж авсан мэдээллийг ярилцлага, бүлгийн хэлэлцүүлгийн үед олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглан ил тод болгох, нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллав. Түүнчлэн Улаанбаатар хотын 5 дүүрэгт тус бүр 2, Дархан уул (Дархан хот), Орхон (Эрдэнэт хот) аймагт тус бүр 2, Улаанбаатар хотод үндэсний хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт орон сууц эзэмшигчид, хүүхдүүд, газрын харилцаа, мэргэжлийн хяналтын газар болон иргэний байгууллагуудын төлөөлөл болсон 10-15 хүн оролцов. Бүлгийн

хэлэлцүүлгээр газар олголт, эзэмшүүлэлттэй холбоотой нийтлэг асуудлуудын талаар ярилцлаа.

Баримталсан хууль тогтоомжууд

- Газрын тухай хууль, 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр, Улаанбаатар хот.
- Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдөр, Улаанбаатар хот.
- Монгол Улсын Их Хурал /УИХ/-ын Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоол, 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдөр, №43, Улаанбаатар хот.
- Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм
- Засгийн газрын 1999 оны 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм
- Монгол улсын эрүүгийн хуулийн 263, 264 дүгээр зүйл

МОНИТОРИНГИЙН ДҮН

Өнөөгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн дагуу Монгол улс 21 аймаг, 340 сум, дүүрэгт хуваагдаж байна. Ойролцоогоор хүн амын гуравны нэг нь, 0-14 насны 410.4 мянган хүүхэд нийслэл Улаанбаатар хотод тус тус амьдардаг. Нэг өрхөд 4.3 хүн ногддог. Монголын орон сууц өмчлөгчдийн Дээд зөвлөлийн 2006 оны мэдээгээр тус улсын нийслэл Улаанбаатар хотод 278 орон сууц өмчлөгчдийн холбоо бүртгэлтэй бөгөөд үүнээс 234 нь ямар нэг хэлбэрийн хүүхдийн тоглоомын талбайтай байна.

“Нийтийн орон сууцны хүүхдийн тоглоомын талбайн газар олголт, эзэмшилтийн мониторинг”-ийн үр дүнгээс дараах байдал ажиглагдаж байна.

Хууль, эрх зүйн орчны талаар

Нийтийн орон сууцны хүүхдийн тоглоомын талбайн төлөвлөлт, түүний хэрэгжилт, газар олголт, эзэмшилтийг тодорхой хэмжээнд зохицуулах эрх зүйн боломж хангалттай байна.

- 2004 онд Монгол Улсын Дэд бүтцийн яамнаас /МУДБЯ/ гаргасан норм, нормативт тоглоомын талбайг орон сууцны нэг оршин суугчид 0.7 ам метр байхаар бодож төлөвлөж бариулах, тоглоомын талбайд хамгийн ойр байгууламж нь 12 метрээс хол зайд байхаар тодорхойлжээ.
- Газрын тухай хуульд “Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн суугч, өмчлөгчдөд зориулагдсан ногоон зүлэг, мод, бут, сөөг, хүүхдийн тоглоомын талбай гэх зэрэг барилгын нормын дагуу баригдсан байгууламжийг... СӨХ-д ашиглуулж болно” гэж заасан нь тоглоомын талбайг оршин суугчдад эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.
- Уг хуульд, СӨХ-д гэрээгээр ашиглуулж байгаа орчны газарт хийх засвар, үйлчилгээ нь газар ухах, хүүхдийн тоглоомын талбай, сүүдрэвч, явган хүний болон авто машины зам, машины зогсоолыг буулгах зэргээр тухайн газарт өөрчлөлт оруулахаар бол мэргэжлийн байгууллага нь СӨХ-той урьдчилан тохиролцож, гэрээ байгуулахаар заажээ. Энэ заалтын дагуу орон сууцны орчны тоглоомын талбайд хамаарах газрыг оршин суугчдын зөвшөөрөлгүйгээр бусдад олгохыг хориглосон байна.
- УИХ-ын 2005 оны 43 дугаар тогтоолд зааснаар нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орчны газарт улсын хэмжээний үзлэг, тооллого явуулж, орчны газрыг баталгаажуулах ажлыг 2005 онд багтаан зохион байгуулах, уг ажлыг улсын хэмжээнд явуулж дуусгах хүртэлх хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад орчны газарт шинээр газар эзэмшүүлэх, ашиглуулахаар шийдвэр гаргахгүй байхаар заасан нь тоглоомын талбайн газарт халдахгүй байх эрх зүйн нөхцөлийг бүрдүүлжээ.
- Мөн бусад хууль, тогтоомжуудад дээрх хууль, эрх зүйн актыг зөрчсөн хүмүүст хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон байна.

Хууль, тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар

Нийтийн орон сууцны хүүхдийн тоглоомын талбайн төлөвлөлт, түүний хэрэгжилт, газар олголт, эзэмшилтийн талаарх хууль, тогтоомжийг мөрдөж биелэлтийг хангах ажил орхигджээ. Засаг дарга нар, газрын албадын зүгээс хүүхдийн тоглоомын талбайг зохих норматив хэмжээнд байлгах, байгааг нь хамгаалах талаар баримталж байгаа ямар нэгэн бодлого, чиглэл байхгүй байна.

Дээр дурдсан болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудын хэрэгжилт, тэдгээрийн биелэлтэд тавих хяналт туйлын хангалтгүй байгаа юм.

- Орон сууц төлөвлөх, барих зөвшөөрөл олгох, барилгын ажлыг гүйцэтгэхдээ хүүхдийн тоглоомын талбайг орхигдуулдаг байдал даамжирч байна.

Манай байранд 60-аад айл амьдардаг. Түүнээс гадна “Өнөр III, IV, V, VI “ СӨХ-ын байруудад ойролцоогоор 300-аад айл амьдардаг. Биднийг банкныхан гэдэг. Гэтэл хүүхдүүд тоглох талбайгүйгээс өөр байрны хүүхдийн тоглоомын талбайг ашигладаг. Хүүхдийн тоглоомын талбайтай “Өнөр-II” байрныхан дургүй гэдэг тоймгүй. Зарим үед хүүхдүүд боломжийн хэрээр бяцхан авилгал өгнө гээч. Яахаараа ийм шавааралдсан олон барилга нэг дор барьдаг байна аа. Хүүхдийн тоглоомын талбайгүй шүү. Энд уртаашаа 30, өргөөшөө 10-аад метр л газар үлдээв шив. Үүнийг хүүхдийн тоглоомын талбай болговол зүгээрсэн...

/Сонгино хайрхан дүүргийн 12 дугаар хорооны
СӨХ-ийн дарга Норовсүрэнгийн ярианаас

Бидний ажиглалтад хамрагдсан шинээр баригдсан 6 хэсэг орон сууцны нэгийг нь ч тоглоомын талбай зохих нормативийг хангаагүйн дээр дөрөвт нь тоглоомын талбай огт байхгүй байв.

- УИХ-ын 43 дугаар тогтоолыг цаг хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс орон сууцны хороолол дахь хүүхдийн тоглоомын талбай тодорхой хариуцах эзэнгүй, түүний төлөө санаа тавьдаг байгууллага байхгүй байна. Хот тохижилтийн компани, хэлтсүүдэд харьяалагддаг гэх боловч тэдгээрийн зүгээс бодитой зохиож байгаа ажил алга байна. Сууц өмчлөгчдийн зарим холбоод өөрийн байрны орчны газар санаа тавьж, хичнээн хөөцөлдлөө ч тэдний тэмцэл ямар ч үр дүнд хүрч чаддаггүй аж. “Та нарын мэдэлд очоогүй” гэдгээр тэдний амыг тагладаг байна. Үүнийг Орхон аймагт хийсэн ярилцлага, хэлэлцүүлгийн дүнгээс харж болно.

Манай Эрдэнэт хот анхнаасаа тэр үеийн төлөвлөлт, эрүүл ахуйн нормативийн дагуу орон сууцны хорооллууд нь баригдсан амьдралын бүхий л хэрэгцээнд тохирсон сайхан хот шүү. Хороолол бүрийн 1-2 байшингийн дунд цэлгэр том тоглоомын талбайтай, олон төрлийн тоглоомтой, биеийн тамирын талбайтай даа.

Харин хүмүүсийн хувийн ашиг сонирхол, төрийн албан хаагчдийн увайгүй бодлогоос энэ байдал алдагдаж алхам, алхмаар дордож байна. Тоглоомын талбайд байшин, барилга барих байтугай түүний ойр орчин нь дархлагдсан байхаар хууль, тогтоомжинд заасан байдаг. Харин орон сууцны орчны талбайг СӨХ-үүдэд ашиглуулах Их хурлын тогтоол, хуулиудын заалтыг хэрэгжүүлэхгүй байгаагаас хүүхдийн тоглоомын талбайнууд одоогоор эзэнгүй болоод байна. Хот тохижуулахын эзэмшилд байгаа гэсэн бодол хүмүүст байгаа ч үнэн хэрэгтэй тийм биш болоод байна.

Одоо эзэнгүйдсэн энэ байдлыг далимдуулан хотын захирагч, газрын харилцааны албаныхан тоглоомын талбайн газраар бизнес хийж байна. Худалдаа үйлчилгээ эрхэлдэг хүмүүс энэ байдлыг ашиглан тэдэнтэй хуйвалдан хүссэн газраа буюу орон сууцнууд дундах хүүхдийн тоглоомын талбайд архины дэлгүүр, баар болон бусад газрууд барьж байна. Хүүхдүүд согтуу томчуудаас дайжиж орцныхоо хаалга үүд, шатны орчмоор тоглодог боллоо. Манай 2 СӨХ-өөс асуудал тавьдаг боловч ямар ч үр дүнгүй байна.

СӨХ-үүдийг цөөрүүлж хоёр хоёроор нь нэгтгэж байж газрынх асуудлыг шийднэ гэж биднийг гацаанд оруулаад орчны газраа авах асуудлыг минь зориудаар хойшлуулаад, хугацаа хожиж тоглоомын талбайн газрыг бусдад олгон бизнесийг цэцэглүүлж байна. Уг нь 2005 онд багтаан тооллого хэмжилт явуулсны үндсэн дээр СӨХ-д газрыг ашиглуулах гэрээ хийх, энэ хүртэл хугацаанд орчны газраас хэн нэгэнд олгохгүй байх хууль, тогтоомж байгаа боловч ёстой түүнийг тоож байгаа хүн алга. Бид ч хөөцөлдөж аргаа барж цөхрөөд байна. Бушуухан тоглоомын талбай болон түүнд хамаарах газрыг мэдэлдээ авч зөв зохистой ашиглахсан. Бидэнд ирээгүй болохоор энэ талаар дутмаг анхаардаг явдал СӨХ-үүдэд байгааг ний нуугүй хэлье.

/Орхон аймгийн Баян-Өндөр сум, Эрдэнэт хотын орон сууцны хорооллын “Алтан дуулга”, “Бадмаараг”, “Цог” СӨХ-ийн дарга, захирал, байцаагч нартай хийсэн ярилцлагаас.../

- УИХ-ын 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 43 дугаар тогтоолын дагуу орон сууцны орчны газрын тооллого явуулж, СӨХ-д газрыг нь өгч ашиглуулах ажлыг тухайн онд багтаан зохион байгуулах ёстой боловч энэ ажил үрсгал байдлаар явагдаж, газраа өөрийн болгон ашиглах саналаа, дүүрэг, хотын газрын албадад гаргасан СӨХ-д ямар ч хариу шийдвэр өгөлгүй өдийг хүрчээ.
- Хүүхдийн тоглоомын талбайг оролцуулан орчны газраа ашиглах, түүний бүрэн бүтэн байдлын талаар оршин суугчид, СӨХ дорвитой ажил хийхгүй байна. Зарим СӨХ орчны газрын зургаа гаргаж ашиглах саналаа холбогдох байгууллагад одоо болтол тавиагүй байна. Орхон, Дархан-Уул аймгийн хэмжээнд хүүхдийн тоглоомын талбайг ашиглахаар эзэмшилдээ авсан СӨХ нэг ч байхгүй бөгөөд 2006 оны хагас жилийн байдлаар орчны газрын хэмжилт, тооллого ч явагдаагүй байна. Улаанбаатар хотод явуулсан судалгаанд хамрагдсан СӨХ-ын зөвхөн нэг (Сонгино-хайрхан дүүргийн 12 дугаар хороо, “Өнөр-2” СӨХ) нь тоглоомын талбайн газраа баталгаажуулж авсан байна. Эл баримтаас үзэхэд оршин суугчид,

СӨХ дорвитой хөөцөлдвөл газраа ашиглахаар баталгаажуулж авах боломж байгаа нь харагдаж байгаа юм. Энэ талаар “Өнөр-2” СӨХ-ын дарга Ухнаа “Оршин суугч, СӨХ-ын хөөцөлдлөгөө л мэднэ дээ. Манай “Өнөр-2” СӨХ хүүхдийн тоглоомын талбай, хөгшчүүдийн нарлах газраа баталгаажуулж авч үлдсэн, цаашид тохижилт сайн хийнэ дээ” гэж ярьсан юм.

Тоглоомын талбайг оролцуулан газар хэрхэн олгож байгаа талаар

- Орон сууцны орчны газрын тооллого бүртгэлийн ажил явагдаж дуустал ямар нэгэн зориулалтаар газар олгохгүй байхыг УИХ-аас бүх шатны засаг дарга нарт үүрэг болгосон ч үүнийг мөрдөж биелүүлэхгүй байна. Нийслэлийн дүүргүүд болон Дархан, Эрдэнэт хотод газар олгосон хэвээр байгаа юм. Дээрх богино хугацаанд ядаж хүүхдийн тоглоомын талбайн газрыг хөндөхгүй байх боломжтой боловч хууль тогтоомж, норм норматив зөрчин тоглоомын талбайг оролцуулан газар олгож байгаа нь газрын албаныханд хувьд нь ашигтай байдгийг харуулж байна.

Манайх ам бүл долуулаа амьдардаг. Манай дүү бид хоёроос бусад нь одоо насанд хүрлээ. Манай ах, эгч бидний хүүхэд нас Эрдэнэт хотын их бүтээн байгуулалтын үед хамаарна. Багаасаа байрны хажуугийн цэлгэр сайхан тоглоомын талбайд найз нөхөдтэйгээ тоглож үерхэж байсан болохоор сайхан дурсамжаар дүүрэн байдаг. Тиймээс ч би хүүхдийн тоглоомын талбайг хүүхдийн эрүүл мэнд, үерхэл нөхөрлөл, чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэхэд маш их ач холбогдолтой гэж бодож байна.

Сүүлийн жилүүдэд хувь хүмүүс өөртөө ашигтай бизнес эрхлэх зорилгоор бидний тоглож өссөн тоглоомын талбайг архины дэлгүүр, баарны талбар болгож байгаад үнэхээр харамсаж байна. Хүүхэд бидний нүдэнд ил харагдаж буй энэ ажил сүүлийн 2 жилд бүр ч эрчимтэй явагдаж байна. Би ч яахав арай томд орох болж гэж бодоход манай дүү, бусад бага хүүхдийн эрх ашгаар томчуул ингэж тоглож байгаа нь ёстой онцгүй байна. Архины дэлгүүр нь л гэхэд манай аймгийн нэлээн том албан тушаалтны өмч гэсэн. Манай байрныхан бас заргалдаж хяналтын байгууллагад өгсөн ч тэгсгээд чимээгүй өнгөрсөн байх. Үүнийг бариулсан ах лав л манай байрныханд дийлдэхээргүй чухал албаны хүн байх. Газар олгож өгч байгаа нь ч, тэр газрыг авна гэж захиалж зааж байгаа нь ч, хяналт тавьдаг нь ч тэр хуулиа тоож дээдлэхээ больсон юм аа гэхэд хүүхэд биднийг бодож болдоггүй юм байх даа. Өөрсдөө хүүхэд байгаагүй юм шиг, өөрсдөө хүүхэдгүй юм шиг зан гаргаж буй тэр хүмүүст үнэхээр гомдож байна. Өөрсдийн хойч залгамж үеийн төлөө санаа тавьж чадахгүй, тэднийг ийн хөсөр хаяж буй тоглоомын талбайн өчүүхэн газраар хувьдаа ашигтай бизнес хийгч аймгийн засаг дарга, хотын захирагч, газрын албаныхан больё оо... больё оо.... больё оо!

Орхон аймгийн Баян-Өндөр сум, Эрдэнэт хотын
6-р бичил хороололд оршин суугч нэгэн
эрэгтэй сурагчийн ярианаас...

- Захирагчийн болон газрын харилцааны албаныхан өөрсдөө зохиомлоор үүсгэсэн энэ байдлаа ашиглан голдуу бизнесийн чиглэлээр тоглоомын талбайг оролцуулан газар олгож байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийн тоглоомын талбайн газрыг мөнгөний хэрэгсэл болгох божээ. Жишээлбэл,

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 7, 8 дугаар хорооны 5, 6, 8, 9 дүгээр байрны хүүхдийн тоглоомын талбайг автомашины зогсоол байгуулах зориулалтаар хувь хүмүүст олгосон бөгөөд 8, 9 дүгээр байрны дундах талбайг бүрэн нурааж байхгүй болгожээ.

- Хүүхдийн тоглоомын талбайг оролцуулан бизнесийн чиглэлээр газар олгодог нь албан тушаал, танил тал, авилгалтай холбоотой гэж иргэд үзэж байна. Тухайлбал, хүүхдийн тоглоомын талбайн газар эзэмшилтийн эрх нь зөрчигдсөн СӨХ-ын дарга, менежер, ажилтан 18 хүнээс 17 нь газар олголтод албан тушаал, танил тал, авилгал маш их гэж хариулжээ.
- Орон сууцны хороолол дахь газар нь хүн амд ойрхон талаасаа үйлчилгээний бизнес эрхлэхэд хамгийн ашигтай, тохиромжтой, тэгээд ч одоо эзэнгүй байгаа гэдгээрээ авилгалын гол нөхцөлийг бүрдүүлдэг гэж хүмүүс, оршин суугчид үзэж байна. Үүнийг асуулгад оролцсон нийт хүмүүсийн 98 хувь нь тодорхойлж байгаа бөгөөд газрын албаны зарим ажилтнууд ч ийм байдал байгааг хүлээн зөвшөөрч байгаа юм.


Гэм буруутай хүмүүст хариуцлага тооцдог уу?

- Эрх бүхий албан тушаалтнууд УИХ-ын 43 дугаар тогтоолыг зөрчиж хүүхдийн тоглоомын талбайн газрыг хэсэгчлэн буюу бүхэлд нь өөр зориулалтаар олгоод байхад гэм буруутныг тогтоож, түүнд хариуцлага тооцсон нэг ч тохиолдол одоогоор алга байна. Баянгол дүүргийн 8 дугаар хорооны 8 дугаар байр, Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны 8, 9 дүгээр байрны оршин суугчид, СӨХ-ынхон хотын захирагч н.Батбаяр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн НИТХТ-ийн дарга н.Болормаа нарт гомдол гаргасан боловч ямар ч хариу өгөөгүй, арга хэмжээ ч аваагүй байна.
- Нийслэлийн засаг дарга, аймаг, дүүргүүдийн газрын харилцааны албаныхан санаатай болон санамсаргүй хийсэн газрын өч төчнөөн будлианыхаа асуудалд чих дөжрөн газрын талаарх аливаа асуудалд хариу өгөхгүй, хөөцөлдсөн хүмүүсийг нь чирэгдүүлж зоригийг нь мохоодог байна. Олон удаа явсаар оршин суугчид халшран тэгсгээд орхиход хүрдэг ажээ. Энэхүү мониторингийг хийх болсон талаар дурдаад зохих дэмжлэг үзүүлэхийг сум, дүүргийн засаг дарга, газрын харилцааны албаны ажилтнуудаас хүсэхэд 11 тохиолдлын дөнгөж хоёр нь л албан ёсоор хариу өгч байлаа.
- Үнэндээ нийтийн орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайг хэн, хэрхэн хамгаалах болон хүүхдийн тоглоомын талбайруу дайрч хувийн орон сууц, үйлчилгээний байгууламж, орд харш барихад хяналт тавих, хариуцлага тооцох механизм алга байна. Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд энэ талаар иргэд, хүүхдийн гомдол, шүүмжлэл гаргадаг ч анхаарах газар байхгүй байгаа юм.

Олон нийтийн санал, бодол

- Диаграмм №1-ээс харахад судалгаанд оролцсон 180 иргэд, хүүхдүүдээс 172 хүн өөр зориулалтаар хүүхдийн тоглоомын талбайг бусдад шилжүүлж байгааг (4 дүгээр асуулт) буруу гэж үзэж байна.
- Оршин суугчид, СӨХ-ын ажилтнууд тоглоомын талбайн талаарх эрх зүйн мэдлэг, мэдээлэл муутай байдаг. Судалгааны дүнгээс харахад нийт хамрагдагсдын 92 хувь нь хүүхдийн тоглоомын талбайн газрын норм, норматив, эрх зүйн талаар мэдээлэл хангалтгүй авдаг гэсэн дүн гарчээ.
- Төрийн албан хаагч өөрийн эрх мэдлээ буруугаар ашиглах боломж нэг нам дангаар засгийн эрхийг барьж байсан 2000-2004 онуудад урьдынхаас илүү байсан бөгөөд харин ийм байдал 2005-2006 онуудад илүү газар авсан байна. Ялангуяа УИХ-ын 2005 оны 7 сарын 1-ний өдрийн “Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль батлагдсаны дараа нийтийн орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайг дуудлага худалдаанд оруулах, хувийн бизнесийн ажилд ашиглах явдал улам цэцэглэсэн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд тоглоомын талбайн маргаантай асуудлаар телевиз, радио, сонин хэвлэлээр олон нийтлэл, нэвтрүүлэг, сурвалжлага гарч, хохирсон СӨХ, оршин суугчдын бүхимдал нэмэгдэж зарим талаар тэмцлийн хурц хэлбэрийг хэрэглэх болсон, УИХ-ын гишүүд, удирдах албан тушаалтнууд иргэдтэй уулзах үед байн байн яригддаг зэргээр батлагдаж байна.


Диаграмм №1 Нийтийн байрны оршин суугчид, хүүхдүүдийн тоглоомын талбай (оролцсон иргэд, хүүхдийн тоогоор)



Асуултад хариулсан байдал

1. Хүүхдийн тоглоомын талбай ач холбогдолтой гэж үзсэн.
2. Заримдаа тоглоомын талбайг өөр байрны хүүхдүүд ашигладаг.
3. Газар хуваарилан олгож байгаа одоогийн үйл ажиллагаа санаанд нийцдэггүй.
4. Өөр зориулалтаар ашиглуулахаар олгож байгааг буруу гэж үздэг.
5. Хүүхдийн тоглоомын талбайн норматив байдлыг мэддэггүй.
6. Гомдлоо төр захиргаанд гаргана.

Диаграмм №2 Газар эзэмшлийн эрх зөрчигдсөн сууц өмчлөгчдийн холбооны дарга, менежер, ажилтнууд (хүний тоогоор)



Асуултад хариулсан байдал

1. Газар олгож буй одоогийн үйл ажиллагаа санаанд нийцдэггүй.
2. Газар олгох үед хүүхдийн тоглоомын талбайг хөндөхгүй байх боломжтой.
3. Хүүхдийн тоглоомын талбайн норматив байдгийг мэдэхгүй.
4. Хүүхдийн тоглоомын талбайг оролцуулан газар олгодог явдал дэд бүтцээс хамаардаг гэж үздэг.
5. Хүүхдийн тоглоомын талбайг оролцуулан газар олгодог нь төр, засгийн хариуцсан ажилтантай холбоотой байдаг.
6. Газар олголтод албан тушаал, танил тал, авилгал маш их байгаа.

Энэ диаграммаас харахад газар эзэмшилтийн эрх зөрчигдсөн СӨХ-ын дарга, менежер, ажилтан 18 хүнээс 17 нь газар олголтод албан тушаал, танил тал, авилгал маш их (6 дугаар асуулт) гэж хариулжээ.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Энэхүү мониторингийн үр дүн дээр үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Нийтийн орон сууцны хүүхдийн тоглоомын талбайн төлөвлөлт, түүний хэрэгжилт, газар олголт, эзэмшилтийг тодорхой хэмжээнд зохицуулах эрх зүйн боломж хангалттай байна.
2. Нийтийн орон сууцны хүүхдийн тоглоомын талбайн төлөвлөлт, түүний хэрэгжилт, газар олголт, эзэмшилтийн талаарх хууль, тогтоомжийг мөрдөж биелэлтийг хангах ажил орхигдсон байна.
3. Дээр дурдсан болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудын хэрэгжилт, биелэлт, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих ажиллагаа туйлын хангалтгүй байна.
4. УИХ-ын 43 дугаар тогтоолыг цаг хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс орон сууцны хороолол дахь хүүхдийн тоглоомын талбай тодорхой хариуцах эзэнгүй, түүний төлөө санаа тавьдаг байгууллага байхгүй байна. Хот тохижилтийн компани, хэлтсүүдэд харьяалагддаг гэх боловч тэдгээрийн зүгээс бодитой зохиож байгаа ажил алга байна. Сууц өмчлөгчдийн зарим холбоод өөрийн байрны орчны газар санаа тавьж, хичээн хөөцөлдлөө ч тэдний тэмцэл ямар ч үр дүнд хүрч чадахгүй байна. “Та нарын мэдэлд очоогүй” гэдгээр тэдний амыг тагладаг аж.
5. УИХ-ын 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 43-р тогтоолын дагуу орон сууцны орчны газрын тооллого явуулж, СӨХ-д газрыг нь өгч ашиглуулах ажлыг тухайн онд багтаан зохион байгуулах ёстой боловч энэ ажил урсгал байдлаар явагдаж, газраа өөрийн болгон ашиглах саналаа, дүүрэг, хотын газрын албадад гаргасан СӨХ-д ямар ч хариу шийдвэр өгөлгүй өдийг хүрчээ.
6. Хүүхдийн тоглоомын талбайг оролцуулан орчны газраа ашиглах, түүний бүрэн бүтэн байдлын талаар оршин суугчид, СӨХ дорвитой ажил хийхгүй байна. Зарим СӨХ орчны газрын зургаа гаргаж ашиглах саналаа холбогдох байгууллагад одоо болтол тавиагүй байгаа юм.
7. Орон сууцны орчны газрын тооллого бүртгэлийн ажил явагдаж дуустал ямар нэгэн зориулалтаар газар олгохгүй байхыг УИХ-аас бүх шатны засаг дарга нарт үүрэг болгосон ч үүнийг мөрдөж биелүүлэхгүй байна.
8. Захирагчийн болон газрын харилцааны албаныхан өөрсдөө зохиомлоор үүсгэсэн эл байдлаа ашиглан голдуу бизнесийн чиглэлээр тоглоомын талбайг оролцуулан газар олгож байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийн тоглоомын талбайн газрыг мөнгөний хэрэгсэл болгох болжээ.
9. Хүүхдийн тоглоомын талбайг оролцуулан бизнесийн чиглэлээр газар олгодог нь албан тушаал, танил тал, авилгалтай холбоотой гэж иргэд үзэж байна.

10. Орон сууцны хороолол дахь газар нь хүн амд ойрхон талаасаа үйлчилгээний бизнес эрхлэхэд хамгийн ашигтай, тохиромжтой, тэгээд ч одоо эзэнгүй байгаа гэдгээрээ авилгалын гол нөхцөлийг бүрдүүлэгч болдог байна.
11. Эрх бүхий албан тушаалтнууд УИХ-ын 43 дугаар тогтоолыг зөрчиж хүүхдийн тоглоомын талбайн газрыг хэсэгчлэн буюу бүхэлд нь өөр зориулалтаар олгоод байхад гэм буруутныг тогтоож, түүнд хариуцлага тооцсон нэг ч тохиолдол одоогоор алга байна.
12. Нийслэлийн засаг дарга, аймаг, дүүргүүдийн газрын харилцааны албаныхан санаатай болон санамсаргүй хийсэн газрын өч төчнөөн будлианыхаа асуудалд чих дөжрөн газрын талаарх аливаа асуудалд хариу өгөхгүй, хөөцөлдсөн хүмүүсийг нь чирэгдүүлж зоригийг нь мохоодог байна. Олон удаа яваад оршин суугчид халшран тэгсгээд орхиход хүрдэг ажээ.
13. Нийтийн орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайг хэн, хэрхэн хамгаалах, хүүхдийн тоглоомын талбайруу дайрч хувийн орон сууц, үйлчилгээний байгууламж, орд харш барихад хяналт тавих, хариуцлага тооцох механизм алга байна. Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд энэ талаар иргэд, хүүхдийн гомдол, шүүмжлэл гаргадаг ч анхаарах газар алга байна.
14. Оршин суугчид, СӨХ-ын ажилтнууд тоглоомын талбайн талаарх эрх зүйн мэдлэг, мэдээлэл муутай байдаг. Судалгааны дүнгээс харахад нийт хамрагдагсдын 92 хувь нь хүүхдийн тоглоомын талбайн газрын норм, норматив, эрх зүйн талаар мэдээлэл хангалтгүй авдаг байна. Энэ нь маргаан тэмцлийн үед мэдлэггүйгээсээ ялагдахад хүргэдэг аж.
15. Төрийн албан хаагч өөрийн эрх мэдлээ буруугаар ашиглах боломж нэг нам дангаар засгийн эрхийг барьж байсан 2000-2004 онуудад урьдынхаас илүү байсан бөгөөд ийм байдал 2005-2006 онуудад илүү газар авчээ. Ялангуяа УИХ-ын 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн “Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль батлагдсаны дараа нийтийн орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайг дуудлага худалдаанд оруулах, хувийн бизнесийн ажилд ашиглах явдал улам цэцэглэсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Нийтийн орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайн газар олголт, эзэмшилтийг боловсронгуй болгохын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Эрх зүйн орчинг бүрдүүлэх, дэг журам тогтоох талаар:

- Шинээр барих орон сууцны хороолол, барилгыг төлөвлөх, зураг төслийг зохиоход хүүхдийн тоглоомын талбай болон тоглоомын барилгыг иж бүрэн тусгаж барих ажлыг хамтад нь гүйцэтгэдэг журмыг тогтоон хэрэгжүүлэх ажлыг Барилга, хот байгуулалтын яам, нийслэл, аймгийн удирдлагууд зохион байгуулж ажиллах. Ер нь энэ талаар Засгийн газраас тусгайлан шийдвэр гаргах нь зүйтэй.
- Нийтийн орон сууцны дэргэд одоо байгаа хүүхдийн тоглоомын талбайн газрыг орчны бусад газар, байгууламжийн хамт тухайн орон сууцнуудыг харьяалж байгаа СӨХ-ын эзэмшилд шилжүүлэх асуудлыг шуурхай шийдвэрлэх. Энэ талаар зохих хуулинд оруулсан өөрчлөлтүүд болон УИХ-аас 2005 онд гарсан тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, энэ талаар зөрчил гаргасан газрын харилцааны алба, албан тушаалтанд захиргааны болон хуулийн хүрээнд хариуцлага тооцож байхыг аймаг, нийслэлийн засаг дарга нарт хатуу үүрэг болгох.
- Орон сууцны орчны газрыг СӨХ-д шилжүүлэх ажлыг удаашруулж (2005 онд багтаан хийх ёстой), улмаар хүүхдийн тоглоомын талбайн газрыг оролцуулан дур мэдэн газар олгосон газрын харилцааны албаны дарга, хот, тосгоны захирагч, эрх баригч нарт захиргааны хуулийн дагуу арга хэмжээ авах, СӨХ-д орчны газрыг эзэмшүүлэх асуудлыг энэ онд багтаан бүрэн шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн төлөөлөгчдийн хуралд зөвлөмж болгох.

Үзлэг, шалгалт зохион байгуулах талаар:

- Улсын мэргэжлийн хяналтын газраас 1 сарын хугацаатай тусгай байцаагч томилон орон сууцны орчмын газар олголтын байдалд хяналт шалгалт хийлгэж холбогдох арга хэмжээг авч, цэгцлэх.
- Газар олголтын одоогийн байдалд энэ онд багтаан үзлэг шалгалт явуулж, хүүхдийн тоглоомын талбайд болон түүний хэсгийг оролцуулан газар олгосон зэрэг хууль, журам зөрчсөн газар олголтын гэрээ шийдвэрийг хүчингүй болгож цуцлах ажлыг аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас зохион байгуулах. Ямар нэг шийдвэр, зөвшөөрөлгүйгээр барьсан ТҮЦ, согтууруулах ундаа худалдаалж буй дэлгүүр, нийтийн хоолны болон баар, цэнгээний газар, автомашины зогсоолуудыг албадан буулгах, нүүлгэх арга хэмжээг энэ хүрээнд зохион байгуулах.

Мэдээлэл, сурталчилгааны талаар:

- Нийтийн орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайн газрын талаарх эрх зүйн акт, энэ талаар СӨХ, оршин суугчдын эрх хэмжээг тодорхойлсон анхааруулга-гарын авлагыг нэгдсэн журмаар 2000 хувь хэвлүүлж Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон болон бусад аймгийн СӨХ-д тараах.
- Газар олголтын талаар баримталж буй бодлого, цаашид анхаарах асуудлын талаар сургалт явуулах. Тухайлбал, эрх ашиг нь зөрчигдсэн болон анхааралд өртсөн СӨХ-ын удирдлага оролцсон нэг өдрийн сургалтыг газрын алба, мэргэжлийн хяналтын байгууллага, мониторингийн багийн оролцоотойгоор Улаанбаатар (75 хүн-5 дүүрэгт), Дархан (20 хүн), Эрдэнэт (15 хүн) хотуудад зохион байгуулах.
- Улаанбаатар хотын бүх дүүрэг, Дархан, Эрдэнэт хотын газрын харилцааны албаны дарга, газар олголтын ажилтан нарын тайланг СӨХ-ын удирдлага, оршин суугчдын өмнө тавиулах ажлыг зохион байгуулах.
- Газар олголтод хүүхдийн тоглоомын талбайн асуудлыг хэрхэн харгалзаж байгаа, ямар ямар зөрчил дутагдал гарч буй болон СӨХ, оршин суугчдын санал, гомдлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд тогтмол сурталчилж байх. Өдөр тутмын зарим сонинд 6 сарын хугацаатай тусгай булан нээж мониторингийн явцын зарим материал болон тулгамдаж буй нөхцөл байдлын тухай тогтмол мэдээлэл гаргаж байх (7 хоногт 1-2 удаа).

Монголын худалдаа, эд хэрэглэгчдийн хоршооллын төв холбоо

Монголын худалдаа, эд хэрэглэгчдийн хоршооллын төв холбоо /МХЭХТХ/ нь голлон худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын гишүүнчлэл бүхий нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /ТББ/ билээ.

Төв холбоо /ТХ/ нь худалдаа, үйлчилгээ эрхэлдэг компани, хувийн худалдаа эрхлэгчид, сонирхогч болон дундын хоршоо, холбоод, бусад байгууллагуудын мэргэжил, нутаг дэвсгэрийн шинж байдлыг үндэслэн үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, ашиг сонирхлоо төрийн болон бусад байгууллага, олон улсын хоршооллын хөдөлгөөнд төлөөлөхөөр сайн дураараа элсэж, эвлэлдэн нэгдсэн, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

Мониторингийн багийн бүрэлдэхүүн

| | |
|---------------------|--|
| Ерөнхий зохицуулагч | Г.Мянганбаяр, МХЭХХ-ын Төв Холбооны дарга |
| Зохицуулагч | Г.Маналжав, МХЭХХ-ын Төв Холбооны гүйцэтгэх захирал Д.Байгалмаа, МХЭХХ-ын Төв Холбооны нягтлан бодогч Ш.Жаргалсайхан, МХЭХХ-ын Төв Холбооны хуулийн зөвлөх Б.Эрдэнэчимэг, МХЭХХ-ын Төв Холбооны менежер |
| Туслах ажилтан | Ж. Сайнбаяр, МХЭХХ-ын Төв Холбооны менежер Д.Даваахүү, Дархан уул аймгийн ХЭХХХ-ны дарга М.Зулаа, Орхон аймгийн ХЭХХХ-ны ажилтан |

Товчилсон нэр

| | |
|--------|---|
| МХЭХТХ | Монголын худалдаа, эд хэрэглэгчдийн хоршооллын төв холбоо |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТХ | Төв холбоо |
| СӨХ | Сууц өмчлөгчдийн холбоо |
| УИХ | Улсын Их Хурал |
| МУДБЯ | Монгол улсын дэд бүтцийн яам |
| НИТХТ | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид |

Эрүүл Мэндийн Яам эмийн лицензийг мэргэжлийн бус хүмүүст олгож байгаа явдалд хяналт тавих

Төслийн зорилго:

- Эмийн лицензийн хэрэгжилтийн талаарх тохиолдол, нотлох баримт зэргийг цуглуулах,
- Эмийн лицензийн журмын хэрэгжилтийн талаарх мэдээллийг олон нийтэд таниулах,
- Хяналтын үйл ажиллагаанаас гарсан зөвлөгөөний үндсэн дээр ирээдүйд өөрчлөгдөх нөхцөл байдлаас хүн амыг хамгаалах.

Төслийн зорилт:

- Эрүүл мэндийн яам /ЭМЯ/-ын эмийн мэргэжилтний лиценз олгох асуудлын талаарх мэдээлэл болон тэдгээрийн үйл явцыг олон нийтэд ил тод болгох,
- Эмийн мэргэжлийн бус хүмүүс, мэргэжлийн ёс зүйн зөрчилтэй мэргэжилтнүүдэд эм барих лиценз олгож, хугацааг нь сунгахад албан тушаалтнуудын авлигад автсан байдалд хяналт тавих.

Мониторингийн үндэслэл

Монголын эрүүл мэндийн эм хангамжийн салбарт зах зээлийн чөлөөт эдийн засаг бий болж, хувийн хэвшлийн эм хангамжийн салбарын тоо нэмэгдсээр байна. Одоогоор эмийн үйлдвэр 33, эм ханган нийлүүлэх байгууллага 92, эмийн сан 807, нийт 932 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг гэсэн судалгаа бий. Эдгээр байгууллагуудад эм барих лицензтэй 762 эм зүйч, 2671 эм найруулагч ажилладаг. Монгол улсад эм зүйн ажиллагааг эмийн дээд боловсролтой эм зүйч, эмийн дунд боловсролтой эм найруулагч гэсэн 2 төрлийн мэргэжлийн хүмүүс эрхлэн явуулж байхаар хуульчилсан.

Эм хэмээгч бүтээгдэхүүн нь мэргэжлийн бус хүний гарт очвол хүн амын эрүүл мэндэд асар их хор хөнөөл учруулж, үр удамд гаж нөлөө үзүүлж, эмийн

гаж донтон, хорт мансууруулагчдийг бий болгох, улмаар улс, орны тусгаар тогтнолд онц аюултайгаар нөлөөлөх магадлал өндөртэй байдаг. Гэтэл ЭМЯ-ын харьяа Эрүүл Мэндийн Хөгжлийн Үндэсний Төв /ЭМХҮТ/-ийн магадлан итгэмжлэл, лицензийн албанаас эмийн мэргэжлийн бус хүмүүст эм барих лиценз олгодог гэх хардлага олон нийтийн дунд түгээмэл байдаг. Эмийн мэргэжилтнүүдийн эм барих лицензийн олголт, сунгалт, шалгалт авах явц нь ил тод биш, хүнд суртал ихтэй, авилга авдаг, олон дахин явуулж чирэгдүүлдэг байдал газар авсан нь эмийн мэргэжлийн хүмүүсийн хувьд хамгийн төвөгтэй, тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Иймд гишүүддээ үйлчлэх зорилго бүхий тус холбоо уг асуудлыг анхааран авч үзээд эмийн мэргэжилтнүүдийн эрх ашиг зөрчигдөн, чирэгдэж, хохирч байгааг засаж залруулах зайлшгүй шаардлага байгааг олж харан энэ талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.

Мониторингийн хугацаа, хамарсан хүрээ, байршил

Мониторингийн үйл ажиллагаа нь 2005.12.1-2006.5.30 хүртэл хугацаанд хөдөөгийн /Архангай, Завхан, Булган, Өмнөговь, Говь-Алтай, Ховд, Увс, Өвөрхангай, Хэнтий, Дорнод, Дорноговь/ аймгуудын хувийн болон эмийн эргэлтийн сангийн эм зүйч, эм найруулагчид, түүнчлэн Улаанбаатар хотын хэмжээнд /Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Хан Уул, Сонинохайрхан, Налайх, Багануур дүүрэг/ төвийн хувийн эмийн сангуудын эмийн мэргэжилтнүүдийн дунд нээлттэй ярилцлага, анкет асуулга, кейс жишээ, хоёрдогч мэдээлэл цуглуулах ажил хийж нийт 150 гаруй мэдээлэл хүлээн авч, судлав.

Мониторингийн аргачлал

Эмийн мэргэжилтнүүдэд эм барих лиценз олгож буй байдал, лиценз сунгах шалгалт хэрхэн явагдаж байгаа үйл явцийг ажиглан дүрс бичлэг хийх, газар дээр нь очиж судлан, ярилцлага бичлэг хийх, хоёрдогч мэдээлэл цуглуулан баталгаажуулах, шалгалтын асуудлуудын баримтыг цуглуулан, лицензийн шалгалтад оролцогчдоос анкетын асуулга авах аргуудад үндэслэн мэдээ, баримт цуглуулсан ба үүнд хотын хэмжээнд 150 аж ахуйн нэгж, хөдөө орон нутагт 200 аж ахуйн нэгжийг хамруулсан. Тухайлбал, хөдөө орон нутгийн хувийн хэвшлийн эм хангамжийн салбарт ажиллаж буй 290, хотын 150 гаруй эмийн мэргэжилтнүүдээс 21 асуудалтай анкетын судалгаа авч, дүгнэлт гаргав. Түүнчлэн чанарын судалгааны аргаар, ганцаарчилсан ярилцлага, кейс жишээ, нийт 16 материал цуглуулж, 2 цаг 58 минутын бичлэг хийсэн.

Мониторинг хийхэд баримтлал болгосон холбогдох хуулийн заалтууд

Эрүүл Мэндийн тухай хуулийн /ЭМТХ/ 17-ийн 3,4 дугаар заалтуудыг баримтлал болгов.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам /ЭМНХЯ/-ын сайдын 1999 оны А/42 тоот тушаалын дагуу мөн оны 3 дугаар сард Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийн бүрэлдэхүүнд багтаан Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх албыг байгуулсан юм. Тус алба нь улсын хэмжээнд эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрөл олгох үйл ажиллагааг эрхлэн явуулах болсон. Энэхүү байгууллагаас эм барих лиценз олгож байгаа үйл ажиллагаанд мониторинг хийхэд дараах зөрчлүүд ажиглагдлаа.

Эмийн лиценз олгох асуудлыг хариуцан явуулдаг төрийн үйлчилгээний байгууллага нь эмийн мэргэжилтнүүдийг эм барих лиценз авах, сунгуулахаар очиход олон дахин явуулж чирэгдүүлэх, Монгол Улсын ЭМТХ-ийн "... 20 жилээс дээш мэргэжлээрээ ажилласан мэргэжилтэнд хугацаагүй зөвшөөрөл олгоно" гэсэн 17-ийн 4 дүгээр заалтыг баримтлахгүй байв.

Иргэн Б: Би 30 гаруй жил эм хангамжид ажилласан. Лицензээ сунгуулах гээд очсон чинь эмийн холбоон дээрээ оч. Та кредит цуглуулаагүй бол шалгалт л өгнө дөө, гээд халгаахгүй байна. Зарим нь мөнгө өгөөд сунгуулдаг гэсэн. Хуулийн заалт нь хэрэгждэггүй юм бол захиргааны шүүхэд уул нь өгөх ёстой л гэсэн.

Хүн бүрийг компьютерийн шинэ программаар явагддаг шалгалтад заавал оруулах гээд байдаг. 20-30 жилийн өмнө мэргэжлийн сургууль төгссөн хүмүүсийн хувьд уг шалгалтыг өгөхөд хүндрэлтэй асуудлууд тулгардаг гэх шалтгаанаар хүмүүс ихэвчлэн хангалтгүй дүн авдаг.

Иргэн Т: Би 1989 онд Анагаах ухааны их сургууль /АУИС/-ийг онц дүнтэй төгссөн. Шалгалтанд ороход тестээр шалгалт авсан. Мэдэхгүй, манай мэргэжлийн биш асуудлууд албаар оруулдаг. Ер нь дахин дахин унагах сонирхолтой юм шиг ээ. 2 удаа, 3 удаа шалгалт өгч байна гэсэн хүмүүс байна лээ.

Түүнчлэн дипломын дараах тасралтгүй сургалтад суралцахад сургалтын төлбөр өндөр, ажилтай хүмүүс ажлаа таслаад сургалтад суухад цалин хасагддаг тул чирэгдэлтэй байдаг байна.

Иргэн О: Кредит цуглуулах сургалтын төлбөр өндөр байна. Нэг кредит нь 15.000 төгрөг. Эм зүйчид 30 кредит цуглуулах ёстой. Нийт 450.000 төгрөг болдог. Хүний эмийн санд ажилладаг болохоор эмийн сангаа хаагад суралцаад суухаар цалин хасагддаг тул их хүндрэлтэй байдаг.

Ингээд цөхөрсөн хүмүүс танил тал хайх, улмаар авилга өгөхөд хүрдэг нь туйлын бэрхшээлтэй асуудлуудын нэг болж, хэнд, хаашаа хандахаа мэдэхээ больсон дүр зурагтай байв.

Иргэн Ц: Лицензийн сунгалтын сургалтад сууж бидэн шиг цаг алддаггүй юм байна. Тэдэнд хэдэн төгрөг өгөөд л лицензээ сунгуулдаг гэж ярьж байна лээ. Урьд нь 50-60.000 төгрөг байсан. Одоо 100.000 гарсан гэнэ лээ. Лицензээ сунгуулж л байвал явхав дээ.

Нэг талаас хяналтын байгууллагууд мэргэжлийн эм барих зөвшөөрөлгүй, нөгөө талаас сунгуулаагүй тохиолдолд мэргэжлийн ажлыг нь хийлгэхгүй гэдэг 2 талын бэрхшээлээс болоод эмийн мэргэжилтнүүдийн хэвийн ажиллах нөхцөл үндсэндээ алдагдаад байсан билээ. Улмаар эмээр үйлчлэх үйл ажиллагаанд ч доголдол гарах байдал үүсээд байв.

Эм зүйн мэргэжилгүй мөртлөө хуурамч диплом, лиценз олж аваад хувийн мөнгө олох явцуу эрх ашгийн үүднээс хууль бусаар нарийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа мэдээллүүд бидний судалгаагаар гарсан билээ.

Иргэн А: ... чинь мэргэжлийн биш мөртлөө ямар их хөнөөлтэй гэж бодно? Хүмүүст буруу зөрүү хэлж эмээ зарчихаад, байнга танайхыг хяналтын албаар шалгуулна, хаалгана гэдэг юм.


Иргэн С: ... лав мэргэжлийн биш ээ. Арай хэтэрхий даварчихсан. Одоо ч хэл амтай нь л дийлдэг болчихсон цаг. Энийг болиулах хэрэгтэй. Хаа хамаагүй хүмүүс эмийн сан ажиллуулаад л байж байх юм. Их л эдийн засгийн ашигтай бололтой.

Эдгээр мэдээллийг УМХГ (Улсын мэргэжлийн хяналтын газар)-т өгч шалгуулахад,

Иргэн У: Олон хүн ...-ийг эмийн мэргэжлийн биш байдаг. Очоод шалгахаар яах аргагүй эм барих лиценз авчихсан байдаг юм. Бид нар хяналтын байгууллага болохоор үзээд л өнгөрдөг, цааш нь шалгаад байх эрх бидэнд байхгүй шүү дээ.

Эмийн мэргэжлийн чиглэлээр хичнээн мэргэжилтэн шинээр төгсөх, хэдэн онд, хичнээн мэргэжилтэн бэлтгэгдсэн болон тэдгээрийн диплом, лицензийн дугаарын улсын нэгдсэн бүртгэл байдаггүй нь эмийн мэргэжлийн бус хүмүүс лиценз эзэмших, улмаар хариуцлагаас бултах боломжийг олгож байна.

Түүнчлэн ЭМХҮТ дөнгөж он гармагц архивын материалаа устгасан бичиг үзүүлээд бидний тандалтын ажлыг мухардуулсан ба зарим нэр бүхий этгээдүүд хууль бус ажиллагаагаа илэрхээс эмээн, сүрдүүлэх тохиолдол ч гарч байв. Мониторингийн дүнд эмийн лицензийн хэрэгжилтийн явцад эмийн мэргэжлийн бус хүмүүст эм барих лиценз олгосон 16 тохиолдол, нотлох баримтыг олж тогтоов.



НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Мэргэжлийн бус хүмүүс эм барих лиценз эзэмшин эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага ажиллуулж байгаа нь хууль зөрчсөн хэрэг төдийгүй тэдгээрийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа нь эм барих лиценз олгодог эрх бүхий төрийн захиргааны байгууллага нь хариуцлага тооцох зохион байгуулалт сул, авлигад автсан, дотоод хяналтгүй болсон, албан тушаалтнууд нь хоорондоо нэгдэж нэг баг болон зохион байгуулалтад орсон зэрэгтэй холбоотой болох нь бидний ажиглалтаас харагдаж байна.

Мониторингийн явцад ажиглагдсан дээрх зөрчлүүд эмийн лицензийн асуудал хариуцсан байгууллагын боловсон хүчний бодлого алдагдснаас гол төлөв үүдэн гарах болсон гэсэн дүгнэлтэд бид хүрлээ. “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Эмийн тухай хууль”, “Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө” батлагдаж, Монгол улсын эмийн үндэсний бодлого хэрэгжиж байгаа боловч түүнийг гардан гүйцэтгэх, ажлын “хар гар” дутагдаж байгаа нь илэрхий байна. Хэдийгээр боловсон хүчинтэй холбоотой асуудал эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөнд тусгагдсан боловч өнөөг хүртэл хэрэгжээгүй байна. Иймд ЭМЯ-ын дэргэд цомхон орон тоотой, чадварлаг, туршлагатай эм зүйч нараас бүрдсэн эм хангамжийн удирдах газрыг бий болгож улсын эм хангамжийн бодлогын асуудлыг нэгтгэж явуулах зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

Байгууллагын зохион байгуулалтыг доор үзүүлсэн байдлаар зохион байгуулах нь оновчтой.

Эрүүл Мэндийн Яам

Эм Хангамжийн Удирдах Газар

Эмийн маркетингийн хэлтэс

Тусгай зөвшөөрөл, импортын эрх, эмийн хэрэгцээг тодорхойлох, эмийн зах зээлийн судалгаа хийх

Хүний эмийн зөвлөл

Улсын эмийн бүртгэл, хотр наркотик эмийн зарцуулалт

Статистик мэдээллийн алба

Эмийн үйлдвэр /ЭҮ/, Эм ханган нийлүүлэх байгууллага /ЭХНБ/, Эмийн сан /ЭС/, эмийн мэдээлэл, сурталчилгаа, эмийн зохистой хэрэглээ

Төгсөлтийн дараах сургалт, ёс зүйн хороо

Боловсон хүчин, сургалт, мэргэжлийн эм барих лиценз

Төгсөлтийн дараах сургалт, ёс зүйн хороо нь боловсон хүчний асуудал хариуцан, эмийн мэргэжлийн чиглэлээр хичнээн мэргэжилтэн шинээр төгсөх, хэдэн онд, хичнээн мэргэжилтэн бэлтгэгдсэн, тэдгээрийн диплом, лицензийн дугаарын улсын нэгдсэн бүртгэлийг хийх, эмийн мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан байдлын нэгдсэн мэдээлэл, мэргэжлийн эм барих лиценз олголт, хугацаа, сунгалт, шалгалтад орох гэх мэт асуудлыг хариуцах нь зүйтэй.

Нийслэл хотын хэмжээнд эм хангамжийн салбарт ЭХНБ, ЭҮ-ээс гадна 455 эмийн сан, эмийн сангийн 286 салбар үйл ажиллагаагаа явуулж, нийт эмийн мэргэжилтний 80 шахам хувь нь төвлөрсөн байна. Гэтэл Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар /НЭМГ/-т хувийн хэвшлийн эмийн сангийн асуудал хариуцсан ганцхан эмийн мэргэжилтэн ажиллаж байгаа нь ажлын ачаалал асар ихтэй, бодлого зохицуулалтын асуудлуудад хүрч ажиллах ямар ч боломжгүй байгаа тул тус байгууллагыг доор үзүүлсэн байдлаар өргөтгөн зохион байгуулах нь эмийн салбарын өнөөгийн шаардлагад илүү нийцнэ гэж үзлээ.

Ахлах мэргэжилтэн

*Эмийн бодлого, зохицуулалт, хангамж, нэр
төрөл, үнэлгээ хариуцсан /ЭХНБ, ЭҮ/*

Эмийн сан хариуцсан мэргэжилтэн

Эмийн мэргэжилтний сургалт, зөвшөөрөл
хариуцсан мэргэжилтэн

Эмийн хэрэгцээ судалгаа, зохистой хэрэглээ,
мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Тус холбоо нь сайн засаглалыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах, иргэний нийгмийн нөлөөллийг сайжруулах зорилгоор цаашид зориг үл шантран нийгэмд оршин байгаа авилга, хээл хахуульд автсан албан тушаалтнаас болж иргэний эрх зөрчигдөж байгаа байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтийн дутагдалтай талууд, хуулийн цоорхой доторх эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж гарган, олон нийтийн анхаарлыг хандуулж, цогц нөлөөллийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Монголын Эм Найруулагчдын Холбоо

Монголын Эм Найруулагчдын Холбоо /МЭНХ/ нь 1997 оны 9 дүгээр сарын 29-нд байгуулагдсан ба 2004 оноос үйл ажиллагаагаа тогтвортой явуулж эхэлсэн билээ. Тус холбоо нь хөдөөгийн 290 сумын эмийн сан, эмийн эргэлтийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагуудтай ажил төрлийн холбоо тогтоож, захидал мэдээлэл солилцох, дугтуйт зайны сургалтанд хамруулах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх, эм зүйн талаар явагдаж буй төрөл бүрийн хурал зөвлөлгөөн, сургалтад хамруулах зэргээр орон нутагт ажиллаж буй эмийн мэргэжилтнүүдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэн ажилладаг, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ТББ/ юм.

Мониторингийн багийн бүрэлдэхүүн

Төслийн удирдагч: У.Төгсбилэг, эм зүйч, Анагаах Ухаан /АУ/-ын магистр

Төслийн ажилтан: Л.Санжид, эм зүйч, АУ-ын магистр

Төслийн ажилтан: Х.Сэргэлэн, эм зүйч, АУ-ын магистр

Төслийн судлаач: Д.Ичинхорлоо, “Улаанбаатар” Анагаах ухааны Коллеж /АУК/-ийн эм найруулагчийн ангийн оюутан.

Төслийн судлаач: У.Нарангэрэл, “Улаанбаатар” АУК-ийн эм найруулагчийн ангийн оюутан.

Ном зүй

1. Эрүүл мэндийн салбар “Сумын эмнэлгийг дэмжье”, Улаанбаатар хот, 2003 он
2. Монгол Улсын Эм зүйн салбар “Үнэлгээний тайлан 2004”, Улаанбаатар хот, ЭМЯ, 2004 он
3. “Эрүүл мэндийн үзүүлэлт” Эмнэлгийн тусламжийн удирдах газар /ЭТҮГ/, 2003 он
4. “Эрүүл мэндийн талаархи мэдээлэл”, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/, 2004 он
5. “Эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох талаар” гарын авлага, Эрүүл мэндийн магадлан итгэмжлэл лицензийн алба /ЭММИЛА/, Улаанбаатар хот, 1999 он
6. М.Уранчимэг, Д.Цэндээхүү “Эм зүйч, эм найруулагч нарт зориулсан гарын авлага”, Улаанбаатар хот, 2004 он
7. “Эрүүл мэндийн болон эмийн холбогдолтой хууль эрхийн актын эмхтгэл”, Улаанбаатар хот, 2002 он

Товчилсон нэр

| | |
|--------|---|
| МЭНХ | Монголын Эм найруулагчдын Холбоо |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ЭМЯ | Эрүүл Мэндийн Яам |
| ЭМТХ | Эрүүл мэндийн тухай хууль |
| ЭМХҮТ | Эрүүл Мэндийн Хөгжлийн Үндэсний Төв |
| ЭМНХ | Эрүүл Мэнд Нийгэм Хамгаалал |
| АУИС | Анагаах ухааны их сургууль |
| ЭҮ | Эмийн үйлдвэр |
| ЭС | Эмийн сан |
| АУ | Анагаах ухаан |
| АУК | Анагаах ухааны Коллеж |
| ЭТУГ | Эмнэлгийн тусламжийн удирдах газар |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| ЭММИЛА | Эрүүл мэндийн магадлан итгэмжлэл лицензийн алба |

Тусгай зөвшөөрлийн мониторинг

Төслийн зорилго:

Аж ахуйн нэгжид олгож буй тусгай зөвшөөрөл /лиценз/-ийн ил тод, шуурхай байдал, хууль журам, шударга ёс хэрэгжиж байгаа эсэх, иргэдэд учирч буй хүндрэл бэрхшээлийн байдалд иргэний нийгмийн байгууллагын зүгээс хяналт-үнэлгээ хийж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Төслийн зорилт:

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол улсын хуулийн хэрэгжилтийн байдлыг:

- Согтуурах үндэс худалдах, түүгээр үйлчлэх /16.2.5 /
- Эмнэлгийн хэрэгсэл худалдаалах зөвшөөрөл олгох / 15.12.2 /

гэсэн хоёр заалтад тулгуурлан Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хотын эрүүл мэндийн салбарын холбогдох байгууллагуудтай танилцаж, тэдгээрт хяналт-үнэлгээ хийнэ.

Мониторингийн үндэслэл

Монгол Улсад хувийн хэвшил хөгжиж эдийн засгийн харилцаанд зохих байр сууриа эзэлсээр байна. Хувийн хэвшлийн хөгжил нь эдийн засгийн голлох салбар болж байгаагийн хувьд ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад ихээхэн үүрэгтэй юм. Гэвч хувийн хэвшлийн аж ахуй, ялангуяа жижиг аж ахуй хөгжин цэцэглэх таатай нөхцөл боломж тэр бүр бүрдээгүй, уг нөхцөлөөр хангах нийгмийн сэтгэлгээ бүрэн төлөвшөөгүй, ялангуяа хууль эрх зүйн орчин, төрийн захиргааны байгууллагын дэмжлэг учир дутагдалтай байгаа нь иргэдийн санаачлага, үйл ажиллагааг зарим талаар боогдуулж, хувийн хэвшлийн хөгжилд саад бэрхшээл учруулж

байгаа юм. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод, шуурхай, шударга болгон төлөвшүүлэх нь хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих гол нөхцөл юм гэдгийг иргэдийн санал шүүмжлэл харуулж байна.

Жижиг бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдийн хувьд тусгай зөвшөөрөл авах явдал ихээхэн хүндрэл бэрхшээлтэй байдаг. Манай байгууллагад ирсэн зарим гомдол саналыг үндэслэн Согтууруулах ундаа зарах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл болон Эмнэлгийн хэрэгсэл худалдаалах тусгай зөвшөөрлийн олголтод хяналт-үнэлгээ хийж, хүнд суртал бэрхшээлийг арилгах, нөгөө талаар ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс цэгцлэн сайжруулах шаардлага нийгэмд байгааг харгалзан “Тусгай зөвшөөрлийн мониторинг” төслийг хэрэгжүүлэв. Төслийн ажлын хүрээнд сонгосон чиглэлийн тусгай зөвшөөрөл олголтын үйл ажиллагаанд байгаа дутагдал бэрхшээлийг илрүүлж, цаашид сайжруулах арга замын талаар зөвлөмж гаргаж, холбогдох байгууллагууд, шийдвэр гаргагчдад хүргүүлсэн болно.

Мониторингийн аргачлал

Бизнесийн тусгай зөвшөөрөл олголтод мониторинг хийхдээ дараах аргачлалуудыг ашиглана. Үүнд:

1. Холбогдох хууль журам, тогтоол, шийдвэрийг судлах,
2. Холбогдох талуудтай газар дээр нь уулзах, санал сэтгэгдлийг сонсох, ажлын хэлбэр, арга барилтай танилцах,
3. Тодорхой баримт жишээ (кейс), хоёрдогч мэдээлэл, баталгаажуулах баримт цуглуулах. Энэ нь бизнесийн зөвшөөрөл олгох, авахтай холбогдон болж буй үйлдлийг баримтжуулж, болсон зүйлийг тодорхойлохын тулд бодит хүмүүсийн мэдүүлгийг цуглуулахад үндэслэнэ. Мөн баримт бичиг цуглуулах, ярилцлага авах, нөхцөл шалтгаан, учир зүйг тодорхойлох, фото зураг авах зэрэг өргөн хүрээтэй хэлбэртэй байна.
4. Санал асуулгын хуудас (анкет) бэлтгэж, өргөн хүрээнд санал авч дүгнэлт гаргах. Тодорхой баримт жишээн дээр үндэслэсэн шүүмжлэл хэр зэрэг тархалттай байгааг харуулах зорилготой. Өөрөөр хэлбэл, санал асуулгад оролцогчдын хэдэн хувь нь бодит баримтаар гарсан үйлдлийг хүлээн зөвшөөрч байгааг харуулна.
5. Баримт, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж гаргах. Бизнесийг дэмжих, ажлын байр бий болгох орчинг өргөжүүлэхийн тулд юуг, хэрхэн өөрчлөх шаардлагатай байгааг шийдвэр гаргагчдад ойлгуулах, дэмжлэг авах зорилготой. Өөрчлөлт хийгдэхгүй байгаа байдлын учир шалтгаан нь хүсэл зориг дутсанаас уу, зохион байгуулалт дутсанаас уу, аль эсвэл хүч хөрөнгө, арга хэрэгсэл дутаж байна уу, хүний хөгжил, арга барилын дутагдал уу, санаатайгаар тийм нөхцөл бий болгож байна уу гэдгийг нягтлан шинжилж дүгнэлт хийсэн.

6. Хяналт-үнэлгээний дүнг олон нийтэд танилцуулах, шийдвэр гаргагчдад уламжлах зэрэг нөлөөллийн арга хэмжээ авах. Нөлөөллийн арга хэмжээнд:
- хэвлэлийн бага хурлууд,
 - өдөр тутмын болон иргэний нийгмийн байгууллагын сонинд үр дүнг хэвлэх,
 - нээлттэй хэлэлцүүлэг,
 - холбогдох дээд байгууллагад албан бичиг илгээх,
 - эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах санал тавих зэрэг хэлбэрээр явагдана.

Холбогдох хуулийн заалтууд

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулдаг хууль эрх зүйн баримт бичгийн судалгаа:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол Улсын хууль,
- Архидан согтуурахтай тэмцэх тухай Монгол Улсын хууль,
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам (Нийслэлийн захирагчийн ажлын алба-НЗАА) нь дээрх харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогч талын бүтэц, зохион байгуулалтын судалгааг “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”, хот, дүүргийн үйлдвэр үйлчилгээний хэлтэс, үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгжийн практик үйл ажиллагаанд тандалт хийх замаар тодорхойлж гаргав. Үүнд:

1-р шатанд:

- Согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх аж ахуйн нэгж байгууллага, иргэн нь өргөдөл хүсэлтээ албан бичгээр гаргаж Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар /НМХГ/-т өгнө.
- Уг өргөдөлийг НМХГ хүлээн авч хянаж үзээд дүүрэг хариуцсан улсын байцаагчид цохолт хийж өгнө.
- Дүүрэг хариуцсан байцаагч, мөн дүүргийн эрүүл ахуйн улсын байцаагчтай хамтран газар дээр нь шалгаж ажлын байр нь стандартын шаардлага хангасан эсэхийг тогтооно. Стандартын шаардлагыг 85%-иас дээш хангасан байвал ажлын байрны дүгнэлт гаргаж өгнө. Хэрэв шаардлага хангаагүй бол хугацаа өгч шаардагдах зүйлийг хийлгэнэ. Үүнийг 1 сарын дотор шийдвэрлэж өгөх үүрэгтэй.

2-р шатанд:

- Тусгай зөвшөөрөл хүсэгч өргөдлөө дахин гаргаж хорооны даргаар хянуулан тодорхойлолт гаргуулж, аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбарын хамт Нийслэлийн захирагчийн ажлын албаны үйлдвэр үйлчилгээний хэлтэст өгнө.
- Дүүргийн тохижилт үйлдвэр, үйлчилгээний хэлтсээс үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл давхар хүсэх ба хариуцсан ажилтан газар дээр нь очиж үзнэ.
- Зөвшөөрөл хүсэгч нь өөрийн байгууллагын хаяг, гэрэлтүүлгийн фото зургийг авч өргөдөлд хавсаргана.
- Хэрэв гэр хороололд байрладаг бол шахмал түлшний үйлдвэртэй байгуулсан гэрээг хавсаргана.
- Дээрх материалуудыг бүрдүүлж 16500 төгрөгийн хураамж төлнө.
- Эцэст нь хотын ерөнхий менежерийн тушаал гарч тусгай зөвшөөрлийг 21 хоногийн дотор олгох ёстой.

Эмнэлгийн хэрэгсэл худалдаалах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулдаг хууль эрх зүйн баримт бичгийн судалгаа:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эмийн тухай хуулиуд нь энэхүү харилцааг зохицуулж байна.

Эдгээр хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдож дараах эрх зүйн актууд гарчээ. Үүнд:

- Эрүүл мэндийн сайдын 2001 оны 168 тоот тушаал /Зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт/
- Эрүүл мэндийн сайдын 2001 оны 317 тоот тушаал /Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн талаар баримтлах үндсэн чиглэлийн тухай/
- Эрүүл мэндийн сайдын 2002 оны 296 тоот тушаал /Тусгай зөвшөөрөл олгох журам, тусгай зөвшөөрлийн дүрэм батлах тухай/

Эмнэлгийн хэрэгсэл худалдаалах тусгай зөвшөөрөл олгогч талын бүтэц, зохион байгуулалтын судалгааг энэ талаар гарсан дүрэм журмын хэрэгжилт, Эрүүл мэндийн яам /ЭМЯ/, Улаанбаатар хотын эрүүл мэндийн газар, үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгжийн практик үйл ажиллагаанд тандалт хийх замаар тодорхойлж гаргав.

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7.1-д энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно гэжээ.
- Эрүүл мэндийн тухай хуулийн заалтын дагуу эмнэлгийн хэрэгсэл худалдаалах тусгай зөвшөөрлийг ЭМЯ-ын тусгай зөвшөөрөл хариуцсан 1 мэргэжилтэн материалуудыг хүлээн авч, тусгай зөвшөөрөл олгох 10 хүний бүрэлдэхүүн бүхий комиссын шийдвэрээр олгогдож байна

МОНИТОРИНГИЙН ДҮН

Согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрлийн лиценз олгох үйл ажиллагааны мониторингийн дүн

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч (авагч) талын санал сэтгэгдэл, бодит жишээ баримтад түшиглэн дээр дурдсан хууль эрх зүйн баримт бичиг хэрхэн хэрэгжиж байгааг судлахад дараах зөрчил дутагдал ажиглагдлаа. Үүнд:

Нэг. Шийдвэр гаргагчдаас боловсруулан гаргасан эрх зүйн баримт бичиг болох дүрэм журам нь амьдралд нийцэхгүй, хувийн хэвшил хөгжихөд чөдөр тушаа болж байна.

Иргэн А. Хууль дүрмээ амьдралд ойр болгож өгөөч. Гэр хороололд 40 м² байртай байхыг шаарддаг. Юм бүр үнэ цэнтэй болсон үед 2-3 хүн үйлчлүүлээд гарах газарт ийм илүү талбай, зардал хэрэггүй биз дээ? Амьдралаа болгоод явах гэсэн жирийн хүмүүст хаалттай, баян чинээлэг хүмүүст зориулсан хууль дүрэм гаргахаа болимоор байна.

Иргэн Б. Стандарт гээд нэг 12 000 төгрөгийн номыг шахаж зардаг. Тэр нь амьдралд нийцэхээр юм үнэхээр хомс, ойлгохын ч аргагүй. Үнэхээр зах зээлд шилжсэн юм бол иргэдийн эрэлт хэрэгцээгээр үнэлэх, зохицуулах тухай ямар ч стандарт байхгүй. Хуучин цагийн баримт бичгийг хуулбарласан зүйл байдаг.

Иргэн М. Хотын төв ба захад байрлах үйлчилгээний байгууллагын стандарт өөр өөрийн онцлогтой байх ёстой. Стандартаа зөв боловсруулаад 3 жил тутамд аттестатчилж тусгай зөвшөөрөл олгож баймаар байна. Нэгэнт ажил үйлчилгээ нь жигдэрсэн, хөл дээрээ тогтсон байгууллагыг 7 хоног тутам дарамталж хоол иддэг, барааг нь хурааж авч явдаг, улирал тутам эрүүл ахуйн дүгнэлт гаргуулдаг гэх мэт хүнд суртал, дарамт маш их байна.

Хоёр. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авсан үйлчилгээний байгууллагуудад төрийн үйлчилгээний байгууллага, түүнд ажилладаг түшмэдүүдийн дарамт, хариуцлагагүй байдал хүндрэл учруулж байна.

Иргэн С. Мянган төгрөгийн хямд архи үйлдвэрлэх, бөөнөөр нь худалдах зөвшөөрлийг төрийн яам нь өгчихсөн мөртлөө жижиглэнгээр зарлаа гэж хянаж торгодог. Архины үйлдвэрүүд чинь дандаа дарга нарынх байдаг гээ биз дээ? Үйлдвэрлэхээ больчихвол бид ч зарахгүй, хүмүүс ч хямд чанаргүй архи авах гэхгүй шүү дээ. Шийдвэр, хяналт нь үг ажлын зөрөөтэй байна.

Иргэн М. Яг адилхан зөрчилтэй гэдгээ мэдэж байхад нэгийг нь торгож хаагаад хамаг бичиг баримтыг нь аваад явчихсан байхад нөгөө нь яагаа ч үгүй ажиллаж л байдаг. Яаж аргалсныг нь хэн хэн нь мэдэж л байдаг. Шударга хандлага үнэхээр дутагдаж байна. Дарга нарын хамаатан садан хүмүүсийн бизнесийг илт дэмжиж, жирийн иргэдийнхийг дарамталдаг.

Иргэн Д. Нэг байгууллагад 2 зөвшөөрөл олгодог. I давхарт нь дэлгүүр, II давхартаа баар ажиллуулж байгаа нэг байгууллага хоёрын 2 зөвшөөрөл авах ямар шаардлага байна аа? Хоёр өөр байгууллага бол өөр хэрэг. Хууль дүрэмдээ бол нэг л тусгай зөвшөөрөлд хамрагддаг юм билээ.

Иргэн А. Хууль дүрэмдээ 21 хоногийн дотор зөвшөөрөл олгох ёстой байдгийг одоо л мэдлээ. Манайх хэдэн сар байтугай жил тойрон явж байж зөвшөөрөл авсан. Материалаа зохих ёсоор бүрдүүлээд өгчихөөр өөрсдийн хариуцлагагүйгээс алга болгочихоод дахиад бүрдүүлээд ир гэж бөөн чирэгдэл болгодог.

Иргэн А. Зөвшөөрлийн бичгийг жил бүр сольдог. Уул нь сунгалт хийх хугацааг хэдэн жилээр ч тэмдэглэж болохоор хэмжээний цаас шүүдээ. Энэ нь тухайн байгууллага хэд дэх жилдээ ажиллаж байгааг ч харуулах ач холбогдолтой юм. Гэтэл жил хүрэхгүй ч сольж байсан.

Иргэн Ц. Согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл авахад шахмал түлшний гэрээ хийх шаардлага тавьдаг. Үүний цаана бас л өөрсдийн бизнесээ тулган хүлээлгэх дарамт явж байдаг.

Иргэн Д. Хяналт шалгалт нь ядарсан, өрх толгойлсон, зээл авсан, амиа тэжээх гэж яваа над шиг эмэгтэйчүүдэд их дарамт учруулдаг. Байнгын айдас хүйдэстэй байдаг. Адилхан зэрэгцээ хоёр дэлгүүрт мянган архи байхад минийхийг хурааж торгоод, нөгөөдөх нь зарж л байдаг. Тэр хууль хэнд нь үйлчлээд хэнд нь огт үйлчилдэггүй юм бүү мэд.

Иргэн Ц. Давхардсан шалгалт маш их. Цагдаа, эрүүл ахуй, мэргэжлийн хяналт, улсын байцаагч, дүүрэг, хотын ажилтнууд, хорооноос хүртэл ирж бүгд шалгаж дарамталдаг. Хэн нь торгох, хураах эрхтэй юм бүү мэд. Тусгай зөвшөөрлөө ил өлгө гэдэг. Нэг шалгалт нь ирээд аваад явчихдаг. Хэн авсан нь олддоггүй. Алга болох ч тохиолдол бий. Ирсэн хүмүүст олигтой үйлчилж, үнэгүй хоол архиар дайлахгүй бол сүр далайлгаж байгаад л зөвшөөрлийн бичгийг хураагаад аваад явчихдаг.

Гурав. Сogтyууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, авах үйл явцад авилга бодитой оршиж байна.

Иргэн Г. Сogтyууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл авахад 16 500 төгрөг төлдгийг одоо л мэдлээ. Надаас 500 000 төгрөг авна гэсэн. 300 000-ыг нь олоод өгчихсөн.

Иргэн Д. Зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг хэрнээ цагаа тулахаар хэнд ч хамаагүй өгчихсөн байдаг. Манайх бол танил талыг нь олж, өгдөг мөнгө төгрөгийг нь дамжуулж өгөөд л авсан. Өөрөөр авна гэж байхгүй шүү дээ. Хууль дүрэм их ярина аа. Тэр нь хэрэгждэггүй.

Санал асуулгын дүн:

Чингэлтэй дүүргийн хэмжээнд согтyууруулах ундаагаар үйлчилдэг 300 гаруй аж ахуйн нэгж байгууллагын 50 орчим хувьд асуулга-судалгаа явуулсан дүнг авч үзвэл:

Хүснэгт 1. Зөвшөөрлөө санал тавьсанаас хойш ямар хугацаанд авсан:

| | |
|--------------------|-----|
| Ажлын 7 хоногт | 8% |
| Ажлын 14 хоногт | 14% |
| Нэг сарын дараа | 48% |
| Гурван сарын дараа | 16% |
| Хагас жилийн дараа | 6% |
| Нэг жилийн дараа | 8% |

Хүснэгт 2. Зөвшөөрлийн хураамж төлбөр:

| | |
|--------------------------------|-----|
| Хэт үнэтэй | - |
| Гайгүй | 36% |
| Боломжийн | 54% |
| Хураамжаас гадна хахууль өгдөг | 10% |

Хүснэгт 3. Авилгалын мэдрэмж: Зөвшөөрөл авахад захиргааны ажилтнаас үзүүлсэн харьцааны шинж:

| | |
|--------------------------------------|-----|
| Эелдэг, хөнгөн шуурхай, цөөн очсон | 32% |
| Дээрэнгүй хүнд сурталтай, олон очсон | 68% |
| Үүнээс: | |
| Хоолонд урьж оруулсан | 28% |
| Гарын бэлэг өгсөн | 36% |
| Таньдаг хүнээрээ авдаг | 10% |
| Бусад | 26% |

Хүснэгт 4. Ажлын дарамт: Захиргааны ажилтны зүгээс дарамт үзүүлдэг эсэх:

| | |
|------------------------|-----|
| Байнга шалгаж торгодог | 80% |
| Гайгүй | 20% |

Хүснэгт 5. Эрх зүйн баримт бичгийг өөрчлөх шаардлага:

| | |
|---|-----|
| Одоогийн эрх зүйн баримт бичгийг өөрчлөх шаардлагатай | 46% |
| Дүүрэг, нийслэл гэх мэт олон шат дамжлагыг болиулах | 18% |
| Зөвшөөрлийг 2-3 жилээр өгч байх | 60% |
| Зөвшөөрлийг хугацаагүй болгох | 4% |

Асуулга-судалгааны дүнг үзэхэд судалгаанд оролцогчдын 60 гаруй хувь нь ямар нэг хэмжээгээр гар хүндрүүлж байж тусгай зөвшөөрөл /лиценз/-ийг арай түргэн хугацаанд авдаг, 60 гаруй хувь нь материалаа өгсөнөөс хойш 1-3 сарын дараа авдаг. 10 хувь нь огт мэдэхгүй, таньдаг хүнээ гуйгаад авдаг гэж хариулсан байна. Үүнээс харахад тусгай зөвшөөрөл авахад ямар нэг хэмжээгээр хээл хахууль байгааг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм.

Судалгаанд хамрагдсан зөвшөөрөл хүсэгчдийн 60 гаруй хувь нь хүнд суртал, танил тал харах, шударга бус байдал байгаа талаар дурдсан байна. Тусгай зөвшөөрөл авахын тулд тал засах, машин унаагаар үйлчлэх, цайлж дайлах байдлыг захиргааны ажилтнууд өөгшүүлж иржээ.

Зөвлөмж

Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар:

1. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн тусгай зөвшөөрөл олгоход баримтлах зарчим, шаардлага гэсэн 9 дүгээр зүйлийн 1.2-т “Аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх”, 9.1.3-т “Ил тод, шуурхай байх” гэсэн зарчмууд нийслэл хот, дүүргийн хэмжээнд илт алдагдсан байгааг хүлээн зөвшөөрч, холбогдох ажилтнуудтай хариуцлага тооцох,
2. Тус хуулийн 11 дүгээр зүйлийн “Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг” гэсэн хэсэгт заасан заалтууд Нийслэлийн захирагчийн албанаас гаргасан журам, хэрэгжүүлж буй практик үйл ажиллагаанд ихээхэн алдагдаж хүнд суртал, хээл хахууль цэцэглэх нөхцөл болсныг хүлээн зөвшөөрч, засч залруулах,
3. Тус хуулийн 12.1-т “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.” 12.4-т “Магадлан шинжилгээ хийлгэх тохиолдолд өргөдлийг шийдвэрлэх хугацааг 14 хоногоор сунгаж болно” гэсэн заалтууд хэрэгжихгүй, захиргааны хүнд суртал газар авч, иргэдэд хүндрэл бэрхшээл учруулан жижиг аж ахуйг дэмжих, ядуурлыг бууруулах төрийн бодлогод харшилж ирснийг засч залруулах,
4. Архидан согтуурахтай тэмцэх тухай Монгол Улсын хуулийн 4.3-т “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг сум, дүүргийн засаг даргын санал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн засаг дарга, улсын зэрэглэлийг хотын захирагч олгоно” гэж заасан нь шат шатны Засаг дарга, захирагч нарын эрх мэдлийг хязгааргүй болгож, төрийн байгууллагад хүнд суртал, хээл хахууль дэлгэрэх үндэс болохын зэрэгцээ хууль бус наймаа дэлгэрэх хөрс болсныг засч залруулах,
5. Хуульд заасан тусгай зөвшөөрлийг 3 жилээр олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлж жил бүр шинэчилдэг практикийг өөрчлөх талаар Нийслэлийн захирагчийн ажлын албанаас гаргасан журамд оруулах,
6. Тусгай зөвшөөрлийн нууцлалыг сайн хийгээд олон дахин өөрчилдгийг болиулж, хугацааг нь сунгадаг хэлбэрээр хийх,
7. Зөвшөөрөл олголтыг харьяа дүүрэгт нь шилжүүлж төвлөрлийг сааруулах,
8. Хууль дүрмээ олон нийтэд сурталчилж байх. Иргэд хуулийн мэдлэг муугаас болж хээл хахууль авагчдыг өөгшүүлж байгааг анхаарах. Жишээ нь, НЗАА-аас гаргасан журмыг согтууруулах ундаагаар үйлчилдэг байгууллагуудын ихэнх нь огт мэдэхгүй, зарим нь зөвшөөрөл авахад 500 000 төгрөг төлдөг гэсэн ойлголттой байв.

9. Стандартыг хөрөнгө зардлын чинээгээр бус хүний эрүүл мэндийн талаас нь голлож шинэчлэх,
10. Гэр хороолол, хотын төвийн үйлчилгээний цэг салбарт тавигдах стандартын шаардлагыг ялгавартай тогтоох,
11. Тусгай зөвшөөрөл олгохдоо байгууллага, хувь хүнийг ялгаварлахаа больж ижил тэгш хандах, иргэдэд боломж олгох тухай хуулийн заалтаа хэрэгжүүлэх журам бий болгох.

Хүнд суртал, хээл хахуулийг таслан зогсоох зохион байгуулалтын ажлын талаар:

12. Өнгөрсөн хугацаанд тусгай зөвшөөрлөөс орсон орлого-зарцуулалтыг шалгаж, жил бүр авсан хураамж улсын орлого болсон эсэхийг нягтлах ба хууль бусаар жил бүр хурааж олсон орлогыг хураан жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих сан байгуулах,
13. Тусгай зөвшөөрлийг олгохдоо ажлын байрыг газар дээр нь очиж шалгаад зөвшөөрлийг онлайнаар олгож байх,
14. Тусгай зөвшөөрлийг олгохдоо хууль дүрэм, журмаас давсан илүү зүйл шаардах, баяр тэмдэглэх мөнгө гаргуулах, ном, кассет, СД, урлагийн билет гэх мэт зүйл шахаж бизнес хийдгийг таслан зогсоох,
15. Аливаа шалгалтыг зөвхөн согтууруулах ундаагаар үйлчилж буй дэлгүүр дээр нь бус архи үйлдвэрлэгч, бөөний төв, зуучлагч байгууллага дээр нь хийж байх,
16. Бөөний худалдааны газрууд жижиглэнгээр архи зарж буй буруу практикийг шалгаж, зогсоох,
17. Хямд архи үйлдвэрлэгчидтэй хариуцлага тооцож, жижиг худалдаалагчдад дарамт үзүүлдэг практикийг таслан зогсоох,
18. Улсын мэргэжлийн хяналтын газар /УМХГ/, НМХГ, эрүүл ахуйн байцаагч, цагдаа, мал эмнэлэг, олон нийтийн байцаагч зэрэг олон чиглэлийн хүмүүс торгууль тавьж, тусгай зөвшөөрлийг хураадаг явдлыг цэгцэлж дүрэм, журмыг тодорхой болгох ба ил тод мэдээлэх, зөрчсөн ажилтныг төрийн албанд тэнцэхгүй гэж үзэх, эдгээр болно.

Эмнэлгийн хэрэгсэл худалдаалах тусгай зөвшөөрлийн лиценз олгох үйл ажиллагааны мониторингийн дүн

Эмнэлгийн хэрэгсэл худалдаалах тусгай зөвшөөрөл хүсэгч (авагч) талын санал сэтгэгдэл, бодит жишээ баримтад түшиглэн дээр дурдсан хууль эрх зүйн баримт бичиг хэрхэн хэрэгжиж байгааг судлахад дараах зөрчил дутагдал ажиглагдлаа. Үүнд:

Нэг. Төрийн үйлчилгээний одоогийн түвшин нь нарийн мэргэжлийн шаардлага хангахгүй байгаагаас иргэд, байгууллагыг ноцтойгоор хохироох үндэс суурь тавигдсан.

Иргэн Б. Монгол Улсын хэмжээнд эмнэлгийн тоног төхөөрөмжид хяналт шалгалт, тохируулга хийх лаборатори байхгүй. Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг мэргэжлийн бус хүмүүс оруулж ирж байгаа нь стандартад нийцэхгүй, үр дүн багатай хэрэгслээр олон түмнийг төөрөгдүүлэх, буруу онош тавих, орлогын төлөө хөөцөлдөх явдлыг хавтгайруулсан.

Иргэн С. Мал эмнэлгийн эхо аппарат оруулж ирээд хүн эмнэлгийн салбарт ашигласан тодорхой жишээ байдаг. Олон хүмүүс хавдартай гэж оношлогдоод зарим нь энд буруу эмчилгээ хийлгэж, зарим нь урагшаа явж өчнөөн хөрөнгө мөнгөө үрээд хавдаргүй байснаа мэдэж ирдэг нь нууц биш болсон.

Хоёр. Эмнэлгийн хэрэгсэл худалдаалах тусгай зөвшөөрөл авсан үйлчилгээний байгууллагуудад төрийн үйлчилгээний байгууллага, түүнд ажилладаг түшмэдүүдийн дарамт, хариуцлагагүй байдал хүндрэл учруулж байна.

Иргэн С. Тусгай зөвшөөрлийг байгуулагад нь нэг удаа өгөх биш бүтээгдэхүүн оруулах бүрт авдаг. Тэгэхээр жилд хэдэн ч удаа авах болно гэсэн үг. Тэр бүрд виски, гайгүй шиг чихрийн цуглуулгатай очихгүй бол ажил бүтнэ гэж байхгүй. Хэд хэд очих, хэдэн цагаар хүлээх бол юу ч биш, арай хийж бичгээ хийлгэж аваад хил дээр очиход тоог нь буруу тавьчихсан, буруу биччихсэн байх жишээтэй. Хүнд суртал, ажлын хариуцлагагүй байдал дээд зэргээр газар авсан.

Иргэн Д. Бид тусгай зөвшөөрлөө өөрсдөө бичиж бэлтгээд зөөврийн дискэнд хийж өгдөг. Үүнийг компьютерт хийж ганц товч дараад л хэвлээд гаргаад ирэх байтал 14 хонуулдаг, тэгээд 500 ширхэг гэж байсныг 50 ширхэг болгочих жишээтэй. Хил дээрээс буцааж байж бах нь ханадаг, албаар тэгж царай алдуулдаг юм шиг байгаа юм. Энэ нь өөртөө л юм авах сонирхол агуулж байдаг нь илт байдаг.

Гурав. Эмнэлгийн хэрэгсэл худалдаалах тусгай зөвшөөрөл олгох, авах үйл явцад авилга бодитой оршиж байна.

Иргэн М. ЭМЯ-ын хүмүүс маш хүнд сурталтай. Хичнээн бичиг баримтаа зөв бүрдүүлсэн ч царай алдаж байж авдаг. Хамт гаръя гэж дэлгүүрт ороод би энэ сервисийг хэзээнээс авах гээд л чадахгүй байгаа юм гээд авахуулж байсан.

Иргэн С. Мэргэжил дээшлүүлсэн, гадаад хэлтэй гээд яриад байдаг мөртлөө орчуулчих гэдэг. Орчуулаад ирэхээр би орос хэлийг чинь мэдэхгүй байна гэдэг. Дараа нь англи хэл рүү орлоо. Сүүлдээ бүр аргаа барж байгаа юм чинь. 5 сар хөөцөлдөж хөөцөлдөж бүр сүүлдээ хахууль өгч байж нэг юм авсан.

Иргэн М. Материал өгснөөс хойш ЭМЯ-ны лиценз олголтын комиссын хурал хэд хэд болсон боловч манай хүсэлт хэлэлцэгдэхгүй орхигдсоор байсан. Эцэст нь бид хувийн өмгөөлөгч авч комиссын хурал дээр хүчээр орж байж асуудлаа шийдүүлсэн. Энэ хугацаанд сэтгэл санааны дарамт ихтэй байсан. ЭМЯ, мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнууд нь хоорондоо сүлжээнд орсон. Хэнийг дэмжихээ, бусдыг нь ялангуяа шинээр орж ирэгсдийг дэмжихгүй байхаа тохиролцсон байдаг. Монголчуудад дэлхийн стандартын, чанартай эмнэлгийн хэрэгсэл орж ирэх нь тэдэнд падгүй, өөрсдийн бизнесийн сүлжээ нь илүү чухал байдаг. Тэр нь голцуу урдаас ирсэн, чанаргүй зүйл байдаг. ЭМЯ-ын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн дээр орох нь Улсын ерөнхийлөгч, Ерөнхий сайд дээр орохоос ч хэцүү, эрхэмсэг хадагтай байдаг байлаа. Манай салбарынхан бүгд мэднэ дээ. Эрх барих намын томоохон даргын ивээлийн хүн гэдгийг нь ч сэм ярилцдаг.

Санал асуулгын дүн:

Нийслэлийн хэмжээнд 400 гаруй эмийн сан, үүнээс 330 нь хувийн хэвшлийн, 30 нь төрийн өмчийн эмийн сан байгаа ба 100 орчим эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг. Судалгаанд эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэж, худалдаалдаг 80 гаруй аж ахуйн нэгж хамрагдсан. Зарим тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд бүртгэлтэй хаяг дээрээ байхгүй байв. Судалгааны дүнг Хүснэгт 6-д үзүүлэв.

Хүснэгт 6. Судалгааны дүн

| | |
|--|-----|
| Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зарах хэлбэр: | |
| жижиглэнгээр зардаг | 70% |
| бөөнөөр | 30% |
| Тусгай зөвшөөрөл аваад хэд дэх жилдээ ажиллаж байгаа: | |
| эхний жилдээ | 20% |
| 2-5 дахь жилдээ | 20% |
| 6-10 жилдээ | 30% |
| 10-аас дээш | 10% |
| Зөвшөөрлөө санал тавьснаас хойш ямар хугацаанд авсан: | |
| 14 хоногт | 10% |
| нэг сарын дотор | 10% |
| 3-6 сарын дотор | 20% |
| хагас жилээс дээш хугацаанд | 60% |
| Зөвшөөрөл авахад захиргааны ажилтны харьцааны шинж, төлөв: | |
| Эелдэг хөнгөн шуурхай | 10% |
| Дээрэнгүй, хүнд сурталтай | 70% |
| Үүнээс: Хоолонд урьж оруулсан | 10% |
| Гарын бэлэг өгсөн | 30% |
| Одоогийн эрх зүйн баримт бичиг, тогтолцоог өөрчлөх шаардлагатай | |
| Тийм | 80% |
| Үгүй | -% |
| Түдгэлзсэн | 20% |

Асуулга-судалгаанд хамрагдагсдын 60% нь хагас жилээс дээш хугацаанд хөөцөлдөж зөвшөөрөл авсан, 70% нь зөвшөөрөл олголтод хүнд суртал, хээл хахууль байгааг хүлээн зөвшөөрсөн байна.

Зөвлөмж

Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар:

1. Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хууль, Эрүүл мэндийн хууль, Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн талаар баримтлах үндсэн чиглэлийн тухай ЭМС-2001.317, Хүний эм, эмнэлгийн тоног төхөөрөмжид импортын лиценз олгох журам ЭМС-2002. 296, Жагсаалт шинэчлэн батлах тухай ЭМС-2001.168 тоот тушаалуудын эмнэлгийн хэрэгслийн ангилал, нэр томъёог шинжлэх ухааны үндэстэйгээр орчин цагийн шаардлагад нийцүүлэн нэг мөр болгох,

2. Эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл гэдэг нэр томъёоны дор юуг ойлгох тухай нэг мөр дүрэм журмыг гарган улсын хэмжээнд мөрдүүлэх,
3. Эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл импортоор оруулж ирэх тусгай зөвшөөрлийг 3-аас дээш жил тогтвортой ажилласан, мэргэжлийн компанид хуульд заасан 3 жилийн хугацаагаар олгодог байх,
4. Тусгай зөвшөөрлийн хугацаанд оруулж ирж буй эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмж, багажийг ангилж бүртгэх, хяналт тавих ажлыг мэргэжлийн комисс гүйцэтгэдэг болох. Энэхүү комисс нь эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмжийн стандарт ангилал, тохируулга, засвар үйлчилгээг явуулах мэргэжлийн хүний нөөцийн бэлтгэлийг яамны өмнө бодлого, зохион байгуулалтын хувьд хариуцах,
5. Энэ ажлыг хийхдээ мэргэжлийн хүмүүсийн санал, орчин үеийн эрүүлийг хамгаалах шинжлэх ухааны хэмжээнд тавигдаж шаардлагыг тусгах,
6. Эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмжийн хяналт шалгалт-тохируулга, засвар үйлчилгээний улсын лабораторитой болох,
7. Тусгай зөвшөөрлийн нууцлалыг нь сайн хийгээд олон дахин өөрчилдгийг болиулж, хугацааг нь сунгадаг хэлбэрээр хийх,
8. Хууль дүрмээ энэ чиглэлээр ажилладаг байгууллага, иргэдэд сурталчилж байх. Иргэд хуулийн мэдлэг мүүгаас болж хээл хахууль авагчдыг өөгшүүлж байгааг анхаарах.

Хүнд суртал, хээл хахуулийг таслан зогсоох зохион байгуулалтын ажлын талаар:

9. Өнгөрсөн хугацаанд тусгай зөвшөөрлөөс орсон орлого-зарцуулалтыг шалгаж, жил бүр, бүтээгдэхүүн оруулах бүрт авсан тусгай зөвшөөрлийн хураамж улсын орлого болсон эсэхийг нягтлах ба хууль бусаар хурааж олсон орлогыг эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмжийн тохируулга, засвар хийх мэргэжлийн ажилтан бэлтгэхэд зарцуулах,
10. Тусгай зөвшөөрлийг олгохдоо олон жил мэргэжлээрээ ажилласан мэргэжилтнийг түшиглэж, тогтвортой ажилласан компанид ажлын байрыг газар дээр нь очиж шалгаад онлайнаар олгодог болох,
11. Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон байдалд дүн шинжилгээ хийж, материалаа бүрдүүлэлгүйгээр авсан, хаягтай газраа байхгүй газруудыг эрэн сурвалжиж, зөвшөөрлийг хураах, хил гаалийн байгууллагууд, олон нийтэд мэдээлэх,
12. Хяналтгүйгээр эмнэлгийн аппарат оруулж ирсэн болон ашиглаж байгаа газруудад мэргэжлийн комиссын шалгалт хийж дүгнэлт гаргуулах,

13. Эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмжийн тохируулга, засварыг тодорхой хугацаанд хийлгэж, стандартын баталгаажуулалт хийдэг журам мөрдүүлэх,
14. Тусгай зөвшөөрлийг олгохдоо хууль дүрэм, журмаас давсан илүү зүйл шаардах, хүндрэл бэрхшээл учруулах, гар харах зэргээр төрийн ажлын нэр хүндийг унагасан хүмүүсийг халж, шинэ залуу, эх оронч сэтгэлтэй хүний нөөцөөр бэхжүүлэх, ажлын байрны тодорхойлолтыг гаргахдаа ёс зүйн шаардлагыг оруулах,
15. Яамны олон шат дамжлагатай комисс, хурлуудыг цөөлж төрийн төв байгууллагын ажилтан, комиссын гишүүдийг мэдлэг чадвартай, нэр хүндтэй, ёс суртахууны хувьд төлөвшсөн хүмүүсээр бэхжүүлэх, эдгээр болно.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт:

Төслийн хэрэгжилтийн байдал буюу тусгай зөвшөөрөл олгогч, авагч талын сэтгэгдэл, ажлын зохион байгуулалт, санал асуулгын дүнгээс үзэхэд жижиг аж ахуй эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох төрийн үйлчилгээнд хүнд суртал, хээл хахуулийн тодорхой хэлбэр бодитой оршиж байгаа нь харагдаж байна. Эдгээр байдлыг засаж сайжруулах талаар дараах Зөвлөмжийг гаргаж холбогдох байгууллага, шийдвэр гаргагчдад хүргүүлэв. Үүнд:

Нэг.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олголт дахь бэрхшээл дутагдлыг засаж, цаашид сайжруулах талаар дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

А. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар:

1. Хуульд заасан тусгай зөвшөөрлийг 3 жилээр олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлж, жил бүр шинэчилдэг практикийг өөрчлөх талаар Нийслэлийн захирагчийн ажлын албанаас гаргасан журамд өөрчлөлт оруулах,
2. Тусгай зөвшөөрлийн нууцлалыг нь сайн хийгээд олон дахин өөрчилдгийг болиулж, хугацааг нь сунгадаг хэлбэрээр хийх,
3. Зөвшөөрөл олголтыг харъяа дүүрэгт нь шилжүүлж төвлөрлийг сааруулах,
4. Хууль дүрмээ олон нийтэд сурталчилж байх. Иргэд хуулийн мэдлэг муугаас болж хээл хахууль авагчдыг өөгшүүлж байгааг анхаарах. Жишээ нь, НЗАА-аас гаргасан журмыг согтууруулах ундаагаар үйлчилдэг байгууллагуудын ихэнх нь огт мэдэхгүй, зарим нь зөвшөөрөл авахад 500 000 төгрөг төлдөг гэсэн ойлголттой байв.
5. Стандартыг хөрөнгө зардлын чинээгээр бус хүний эрүүл мэндийн талаас нь голлож шинэчлэх,
6. Гэр хороолол, хотын төвийн үйлчилгээний цэг салбарт тавигдах стандартын шаардлагыг ялгавартай тогтоох,
7. Тусгай зөвшөөрөл олгохдоо байгууллага, хувь хүнийг ялгаварлахаа больж ижил тэгш хандах, иргэдэд боломж олгох тухай хуулийн заалтаа хэрэгжүүлэх журам бий болгох.

Б. Хүнд суртал, хээл хахуулийг таслан зогсоох зохион байгуулалтын ажлын талаар:

8. Өнгөрсөн хугацаанд тусгай зөвшөөрлөөс орсон орлого-зарцуулалтыг шалгаж, жил бүр авсан хураамж улсын орлого болсон эсэхийг нягтлах ба хууль бусаар жил бүр хурааж олсон орлогыг хураан жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих сан байгуулах,

9. Тусгай зөвшөөрлийг олгохдоо ажлын байрыг газар дээр нь очиж шалгаад зөвшөөрлийг онлайнаар олгож байх,
10. Тусгай зөвшөөрлийг олгохдоо хууль дүрэм, журмаас давсан илүү зүйл шаардах, баяр тэмдэглэх мөнгө гаргуулах, ном, кассет, CD, урлагийн билет гэх мэт зүйл шахаж бизнес хийдгийг таслан зогсоох,
11. Аливаа шалгалтыг зөвхөн согтууруулах ундаагаар үйлчилж буй дэлгүүр дээр нь бус архи үйлдвэрлэгч, бөөний төв, зуучлагч байгууллага дээр нь хийж байх,
12. Бөөний худалдааны газрууд жижиглэнгээр архи зарж буй буруу практикийг шалгаж зогсоох,
13. Хямд архи үйлдвэрлэгчидтэй хариуцлага тооцож, жижиг худалдаалагчдад дарамт үзүүлдэг практикийг таслан зогсоох,
14. УМХГ, НМХГ, эрүүл ахуйн байцаагч, цагдаа, мал эмнэлэг, олон нийтийн байцаагч зэрэг олон чиглэлийн хүмүүс торгууль тавьж, тусгай зөвшөөрлийг хураадаг явдлыг цэгцэлж дүрэм, журмыг тодорхой болгох ба ил тод мэдээлэх, зөрчсөн ажилтныг төрийн албанд тэнцэхгүй гэж үзэх, эдгээр болно.

Хоёр.

Эмнэлгийн хэрэгсэл үйлвэрлэх худалдах тусгай зөвшөөрөл олголт дахь бэрхшээл дутагдлыг засаж, цаашид сайжруулах талаар дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

А. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар:

1. Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хууль, Эрүүл мэндийн хууль, Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн талаар баримтлах үндсэн чиглэлийн тухай ЭМС-2001.317, Хүний эм, эмнэлгийн тоног төхөөрөмжид импортын лиценз олгох журам ЭМС-2002. 296, Жагсаалт шинэчлэн батлах тухай ЭМС-2001.168 тоот тушаалуудын эмнэлгийн хэрэгсэлийн ангилал, нэр томъёог шинжлэх ухааны үндэстэйгээр орчин цагийн шаардлагад нийцүүлэн нэг мөр болгох,
2. Эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл гэдэг нэр томъёоны дор юуг ойлгох тухай нэг мөр дүрэм журмыг гарган улсын хэмжээнд мөрдүүлэх,
3. Эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл импортоор оруулж ирэх тусгай зөвшөөрлийг 3-аас дээш жил тогтвортой ажилласан, мэргэжлийн компанид хуульд заасан 3 жилийн хугацаагаар олгодог байх,
4. Тусгай зөвшөөрлийн хугацаанд оруулж ирж буй эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмж, багажийг ангилж бүртгэх, хяналт тавих ажлыг мэргэжлийн

комисс гүйцэтгэдэг болох. Энэхүү комисс нь эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмжийн стандарт ангилал, тохируулга, засвар үйлчилгээг явуулах мэргэжлийн хүний нөөцийн бэлтгэлийг яамны өмнө бодлого, зохион байгуулалтын хувьд хариуцах,

5. Энэ ажлыг хийхдээ мэргэжлийн хүмүүсийн санал, орчин үеийн эрүүлийг хамгаалах шинжлэх ухааны хэмжээнд тавигдаж шаардлагыг тусгах,
6. Эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмжийн хяналт шалгалт-тохируулга, засвар үйлчилгээний улсын лабораторитой болох,
7. Тусгай зөвшөөрлийн нууцлалыг нь сайн хийгээд олон дахин өөрчилдгийг болиулж, хугацааг нь сунгадаг хэлбэрээр хийх,
8. Хууль дүрмээ энэ чиглэлээр ажилладаг байгууллага, иргэдэд сурталчилж байх. Иргэд хуулийн мэдлэг муугаас болж хээл хахууль авагчдыг өөгшүүлж байгааг анхаарах.

Б. Хүнд суртал, хээл хахуулийг таслан зогсоох зохион байгуулалтын ажлын талаар:

9. Өнгөрсөн хугацаанд тусгай зөвшөөрлөөс орсон орлого-зарцуулалтыг шалгаж, жил бүр, бүтээгдэхүүн оруулах бүрт авсан тусгай зөвшөөрлийн хураамж улсын орлого болсон эсэхийг нягтлах ба хууль бусаар хурааж олсон орлогыг эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмжийн тохируулга, засвах хийх мэргэжлийн ажилтан бэлтгэхэд зарцуулах,
10. Тусгай зөвшөөрлийг олгохдоо олон жил мэргэжлээрээ ажилласан мэргэжилтнийг түшиглэж, тогтвортой ажилласан компанид ажлын байрыг газар дээр нь очиж шалгаад онлайнаар олгодог болох,
11. Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон байдалд дүн шинжилгээ хийж, материалаа бүрдүүлэлгүйгээр авсан, хаягтай газраа байхгүй газруудыг эрэн сурвалжиж зөвшөөрлийг хураах, хил гаалийн байгууллагууд, олон нийтэд мэдээлэх,
12. Хяналтгүйгээр эмнэлгийн аппарат оруулж ирсэн болон ашиглаж байгаа газруудад мэргэжлийн комиссын шалгалт хийж дүгнэлт гаргуулах,
13. Эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмжийн тохируулга, засварыг тодорхой хугацаанд хийлгэж стандартын баталгаажуулалт хийдэг журам мөрдүүлэх,
14. Тусгай зөвшөөрлийг олгохдоо хууль дүрэм, журмаас давсан илүү зүйл шаардах, хүндрэл бэрхшээл учруулах, гар харах зэргээр төрийн ажлын нэр хүндийг унагасан хүмүүсийг халж, шинэ залуу, эх оронч сэтгэлтэй хүний нөөцөөр бэхжүүлэх, ажлын байрны тодорхойлолтыг гаргахдаа ёс зүйн шаардлагыг оруулах,
15. Яамны олон шат дамжлагатай комисс, хурлуудыг цөөлж төрийн төв байгууллагын ажилтан, комиссын гишүүдийг мэдлэг чадвартай, нэр хүндтэй, ёс суртахууны хувьд төлөвшсөн хүмүүсээр бэхжүүлэх, эдгээр болно.

Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо

Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо (МЭХ) нь 1924 онд байгуулагдсан, эмэгтэйчүүдийн иргэний нийгмийн байгууллага юм. Эгнээндээ эмэгтэйчүүдийн төрийн бус 65 байгууллагыг нэгтгэсэн тус холбоо нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, аймаг сум, хот, дүүрэг, хороо бүрт эмэгтэйчүүдийн зөвлөлтэй, нийгэмд үйлчлэх статустай болно.

Холбооны үндсэн зорилго нь монголын эмэгтэйчүүдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлж, эмэгтэй хүн бүр итгэл үнэмшил, сонголт хийх эрх, боломжтой байхын төлөө нэгдэж үйл ажиллагаа явуулах явдал бөгөөд энэхүү зорилгынхоо хүрээнд төрөл бүрийн сургалт-мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулж, Монголжингоо сониныг эрхлэн гаргаж, иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх, эмэгтэйчүүдийн ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох төрөл бүрийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Төслийн баг

Ж.Эрдэнэчимэг
Ж.Маралмаа
Ж.Билэгдэмбэрэл
Т.Гүндэгмаа
Н.Цогзолмаа
Г.Ганчимэг

Ном зүй

1. Нээлттэй нийгэм хүрээлэн/ ННХ/-ээс явуулсан I сургалтын материал
2. ННХ-ээс явуулсан II сургалтын материал
3. Human Rights Documentation and Information System, International What is Monitoring. <http://www.huridocs.org/basmonen.htm>
4. Transparency International, The Integrity Pact: The concept, the Model and the Present Applications. http://www.transparency.org/building_coalitions/integrity_pact_i_pact.pdf

Цэргийн дүрэмт хувцасны хангалтад хийсэн мониторинг

Төслийн зорилго:

Батлан хамгаалах салбарт төрөөс үзүүлж байгаа нийтлэг үйлчилгээ, цэргийн дүрэмт хувцасаар хангах үйл ажиллагаанд мониторинг /хяналт- үнэлгээ/ хийх.

Төслийн зорилт:

- Цэргийн албан хаагчдын дүрэмт хувцасны хангалт, түүний хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаар бодит баримт, мэдээлэл цуглуулах, хангалтын үйл ажиллагаан дахь эерэг сөрөг талууд, бэрхшээл, дутагдлыг илрүүлж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох;
- Цэргийн албан хаагчдын дүрэмт хувцасны хангалт, түүний хэрэгжилтийн талаар олон нийтэд нээлттэй мэдээлэл хийх;
- Олон нийт болон шийдвэр гаргах түвшнийхний анхаарлыг татаж идэвхижүүлэх.

Мониторингийн үндэслэл

Монгол улсад ардчилал хөгжиж нийгмийн бүх салбарт иргэний хяналт, нийгмийн оролцоо нэмэгдэж ирсэнтэй холбоотойгоор батлан хамгаалах салбарт ардчилал, зах зээлийн эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэж, иргэний ардчилсан нийгэмд нийцсэн өөрчлөлт, хандлагууд бий болсон билээ.

Ардчилсан нийгэм дэх иргэний хяналт гэдэг нь Зэвсэгт хүчнийг удирдахад иргэдийн оролцоог хангах, үүний тулд цэрэг иргэний харилцааг хууль тогтоомжоор зохицуулах тухай асуудал юм. Зэвсэгт хүчинд хэрэгжүүлэх иргэний хяналт нь үндэсний аюулгүй байдлын чухал асуудлуудын нэг бөгөөд үүнийг онолын үндэслэлтэй, зөв зүйтэй хэрэгжүүлэхийн тулд 1996 оноос улс төрийн нам эвсэл, мэргэжлийн хүмүүсийн хамтын ажиллагааны дүнд Батлан

хамгаалахын сайдаар энгийн хүн ажиллаж, төрийн захиргааны болон цэргийн мэргэжлийн удирдлагыг зааглан салгах ажил эхэлсэн байна.

Түүнчлэн ардчилсан нийгмийн үед татвар төлөгч иргэн бүр өөрөөс нь татаж хуримтлуулсан төсвийн хөрөнгийн тодорхой хувь эх орны батлан хамгаалахад хэрхэн зарцуулагдаж байгааг мэдэх эрхээ эдлэх ёстой. Цэргийн төсөвт тодорхой тооны нууц зүйл анги байдаг нь мэдээж. Энэ нь зөвхөн олон нийтийн хувьд нууц байхаас бус парламентийн хувьд бол тийм биш. Батлан хамгаалах салбарт хамаарах асуудлаар парламентаас өрөөсгөл шийдвэр гаргахад хүргэхгүйн тулд зэвсэгт хүчний үйл ажиллагаа ард түмэнд нээлттэй байх зарчим нь зэвсэгт хүчний тухай мэдээллийг аль болох нээлттэй болгох, төрийн бус байгууллага, иргэдийн үзэл бодлыг заавал сонсож байх замаар хэрэгжинэ. Үүнийг үндэслэн батлан хамгаалах салбар дахь цэргийн дүрэмт хувцасны хангалтын өнөөгийн байдалд хяналт үнэлгээ хийж энэ талаархи мэдээллийг олон нийтэд ил тод хүргэхийг хичээлээ.

Батлан хамгаалах салбар дахь цэргийн дүрэмт хувцасны хангалт нь төрийн хөрөнгөөр бараа материал худалдан авах хуулиар зохицуулагдана. Энэ үйл ажиллагааны гол хэрэгсэл болох төрийн хөрөнгө нь татвар төлөгчдийн бүрдүүлсэн хөрөнгө буюу улсын төсөв юм. Иймд цэргийн дүрэмт хувцасны хангалт нь улсын төсвөөс оногдсон төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулиар зохицуулагдаж иржээ.

Зэвсэгт хүчний салбарын хангалтыг яам дундын тендерийн шалгаруулалтын үндсэн дээр зохион байгуулдаг. Төрийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу явагддаг хувцас хангалтын гол үйл ажиллагаа болох тендер нь захиалах, шалгаруулах, хянах үйл ажиллагаанаас бүрддэг.

Бид уг үйл ажиллагааны өнөөгийн байдалд ажиглалт, дүгнэлт хийж, түүний талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохыг зорьсон билээ. Төслийн хүрээнд офицер, ахлагч нарын дүрэмт хувцасны хангалтын асуудлыг сонгон авч мониторинг /хяналт-үнэлгээ/ хийсэн болно. Хууль, дүрэм журмын хэрэгжилт, Зэвсэгт хүчин /ЗХ/-ий хангалтын анги, ажилтны үйл ажиллагаа, хэрэглэгчид хүрч байгаа байдал, хэрэглэгчдийн бодит хэрэгцээ шаардлагад тандалт хийх замаар цэргийн дүрэмт хувцасны хангалтын үйл ажиллагааны явц, хангалт хариуцсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтын судалгааг тодорхойлж гаргав. Цэргийн дүрэмт хувцасны чанар хэрэглэгчдийн шаардлагад нийцдэггүй гэх чанарын талаарх зөрчил, дутагдал нь хэрэглэгчдийн санал, судалгаагаар нотлогдсон нь цэргийн дүрэмт хувцасны хангалтын үйл ажиллагаанд мониторинг хийх төслийг санаачлах үндсэн шалтгаан болсон юм.

Дүрэмт хувцасны хангалтын үйл ажиллагааны явц:

Хангалтын захиалгын үйл ажиллагаа нь Монгол Улсын “Төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 7.1.1-д нээлттэй

тендер шалгаруулах журам, 45.2.2-д “төрийн захиргааны төв байгууллага нь байгууллагын хэрэгцээнд худалдан авах 50 саяас дээш төгрөгийн өртөг бүхий бараа, үйлчилгээ, 150 саяас дээш төгрөгийн өртөг бүхий ажлын хувьд захиалагч нь байна”, 47.1-д “үнэлгээний хороо байгуулна” гэж тус тус заасны дагуу явагдана. Энэ журмыг үндэслэн Батлан хамгаалах яамны БХЗГ-аас /Бодлогын салбарын хэрэгцээний хувцас, материал хэрэгслийн тэндэрийн ажлыг хариуцан зохион байгуулдаг. Захиалагч нь Зэвсэгт хүчний жанжин штаб /ЗХЖШ/-ын Ар талын газар /АТГ/ байна.

ЗХЖШ-ын АТГ /Зэвсэгт хүчний жажин штаб, Ар талын газар/ нь тендерт захиалагч шалгаруулж, захиалсан хувцас, хэрэглэлийг төвлөрсөн хангалтаар ЗХ-ний хангалтын ...дугаар ангид захиалгын дагуу бөөнөөр нь нийлүүлнэ. Хувцас хэрэглэлийг нийлүүлэх явц дараахи журмаар явагддаг:

- Хангалтын ...дугаар ангиас бусад ангиуд өөрсдийн хэрэгцээг тодорхойлсон мэдүүлгийн үндсэн дээр хувцас, хэрэглэлийг авдаг байна. Ингэхдээ анги бүр цэргийн албан хаагчдын хэрэглэлийн болон дүрэмт хувцасны карт хөтөлдөг.
- Тухайн ангийн хангалт хариуцсан ажилтан хэний хувцас, малгай, гутлын норм хэдийд дуусч байгааг хүн нэг бүрийн картыг шүүж тодорхойлсны эцэст жилийн хэрэгцээгээ тодорхойлно.
- Хэрэгцээт тоо хэмжээгээ тодорхойлсон мэдүүлэг бичиж, эхлээд АТГ-ын даргын зөвшөөрөл /Мэдүүлгэн дээр цохолт хийлгэнэ/, дараа нь хангалтын ангийн даргын зөвшөөрөл /Цохолт хийлгэнэ/ зэргийг авч хангалтын ангид хүргүүлнэ.
- Эцэст нь хангалтын ангийн няраваас тухайн ангийн хангалтаа авдаг байна. Ингээд бүх хэрэглэгчдэд дундаж хэмжээгээр /размер/ үйлдвэрлэсэн хувцасыг авна. Энэ нь цэргийн дүрэмт хувцасны ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааны үе шатууд юм.

Хамарсан хугацаа, хүрээ, байршил

2005 оны 12 дугаар сарын 1-нээс 2006 оны 5 дугаар сарын 30 хүртэл. Хэрэглэгч, захиалагч, хангагч, шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд /БХЯ, ЗХЖШ-ын Ар талын газар, Улаанбаатар цэргийн хүрээ болон хөдөөгийн алслагдсан анги салбарууд/-ыг хамруулсан.

Мониторингийн аргачлал

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, ажиглалт, газар дээр нь очиж судлах, анкетын асуулга, хоёрдогч мэдээлэл баримт цуглуулах зэрэг аргуудаар ажиллалаа.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Тендерийн үйл ажиллагааны өнөөгийн байдал Хувцас хангалтын гол үйл ажиллагаа болох тендер нь захиалах, шалгаруулах, хянах үйл ажиллагаанаас бүрддэг. 1990-ээд оны эхээр төвлөрсөн зах зээл задарч, зах зээлийн харилцаанд шилжин орсноор улсын өмчийг хувьчлах, төрийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах, тусгай эрх зөвшөөрөл олж эзэмших зэрэг бүхий л үйл явц тендерээр дамжин хэрэгжих болжээ. Уг чанартаа тендер нь зах зээлийн эдийн засгийн маш чухал механизм төдийгүй тэгш боломж, шударга өрсөлдөөн, ил тод байдлыг илэрхийлнэ.

Зэвсэгт хүчний салбарын хангалтыг яам дундын тендерийн шалгаруулалтын үндсэн дээр зохион байгуулдаг. 2005 оны тендерийн шалгаруулалт удааширнаас үүдэн зарим нэр төрлийн хувцасны хангалт тасарчээ. Батлан хамгаалах яам /БХЯ/ тендерийг хэвлэл мэдээллээр зарладаггүй, өрсөлдөөнт тендер байдаггүй, гэрээгээ зөрчиж чанаргүй бүтээгдэхүүн нийлүүлдэг зэрэг тендерийг тойрсон тааламжтай бус мэдээлэл олон. Тухайлбал, өвлийн гуталны норм батлагдсан боловч тендерт оролцож байгаа байгууллагын санал болгосон гутал нь шаардлага хангаагүйгээс хангалт бүрэн бус хийгдэж, хөдөөгийн анги салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч нар зуны гуталтай өвөлжсөн байна. Энэ нь 2005 оны тендерийг будлиантай, хугацаа алдаж явуулснаас болжээ.

Батлагдсан төсөвт захируулан захиалга хийдэг нь шаардлага хангахгүй материалаар үйлдвэрлэл явагдаж, зах зээлийн үнээс харьцангуй доогуур үнэлэгдэх шалтгаан болдог гэж албаны хүний мэдээлэлд тайлбарлажээ. Төсөв хүрэлцдэггүйгээс хангалт тасардаг, чанартай бараа материал авч чаддаггүй, тэндэрт оролцох байгууллага ч цөөхөн байдаг гэсэн мэдээлэл бий. Энэ нь чанартай хувцас нийлүүлэхэд төсөв хүрэлцдэггүйг харуулж байна.

Тендер нь ч яахав, явагддаг л байх. Тендерт шалгарсан хойноо чанарт анхаардаггүй болчихдог юм шиг байгаа юм. Тэгэхээр тендерийн дараа ямар байхыг нарийн зааж баймаар юм уу. Яаж хяналт тавьдагийг нь мэдэхгүй юм.

2006 оны 1 дүгээр сард зарлагдсан энэ оны тендерт арваад байгууллага оролцсон байна. Тендерийн зарыг Зууны мэдээ сонинд мэдээлсэн. Харин Сангийн яам /СЯ/-ны тендерийн мэдээллийн вэб хуудсанд мэдээлэл огт байхгүй байгаа нь сурталчилгаа муу байсныг харуулж байгаа юм. Үүнээс аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх боломж нээлттэй бус байжээ гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Тендер шалгаруулалт хэзээ, яаж явагддагийг бид мэдэхгүй. Тендерт ялсан байгууллага хийсэн, ийм тийм дутагдалтай гээд яригддаг л юм байна лээ. Тендерийн талаар ойлголт байхгүй. Хамгийн гол нь чанартай болж байвал хэрэглэгч бидэнд сайн байна.

Цэргийн дүрэмт хувцсыг төвлөрсөн хангалтаар бус мөнгөн хангалтаар хангах, хүн өөрийн өмсөж хэрэглэх эдэлгээнээс шалтгаалан дэлгүүрээс худалдан авч байх журамд шилжих сонирхол хэрэглэгчдийн дунд ихээхэн байдаг байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар цэргийн дүрэмт хувцасны загвар, норм батлагддаг. Энэ нь цэргийн дүрэмт хувцасны бусдаас ялгарах загвар, онцлог, ялгах тэмдэг ямар байх ёстойг заасан байдаг, харин үйлдвэрлэлийн стандарт биш гэдэг нь хэнд ч ойлгомжтой.


Цэргийн дүрэмт хувцас нь нарийн оёдол, чанар шаардсан хувцас байдаг. Гэвч тендерээр шалгарсан байгууллага бүр энэ шаардлагыг хангаж чаддаггүй. Хувцас хэрэглэлийн хэрэгцээ шаардлагын талаар нэгдсэн мэдээллийн сан байдаггүйгээс хангалтын тоо хэмжээний захиалга дутуу хийгддэг, хэрэглэгчийн биед таарамжгүй байдаг. Дундаж хэмжээний хувцас нь биед сууж өгөхгүй, том, жижиг янз бүр харагддаг тул хувь хүний биед нь тааруулж оёх нь тохиромжтой санагдлаа.

Стандарт байхгүйгээс тэндэрт шалгарсан байгууллага чанар муутай материалаар шаардлага хангахгүй хувцас үйлдвэрлэж нийлүүлдэг. Хувцасны чанарын талаарх олон тооны гомдол, саналд тухайн компани “батлагдсан стандарт байхгүй” гэсэн хариулт өгсөн байв.


Цэргийн дүрэмт хувцасны чанарын асуудал

Бид цэргийн дүрэмт хувцасны чанар хэрэглэгчдийн шаардлагад хэрхэн нийцдэг талаар бодитой мэдээлэл цуглуулах зорилгоор хэрэглэгчдийн дунд хувцасны материал, эдэлгээний чанарын судалгааг явуулсан билээ. Судалгааны хүрээнд Улаанбаатар хот, хөдөөгийн цэргийн ангиудад очиж, хэрэглэгчидтэй уулзалт, ярилцлага зохион байгуулсан юм. Үүнд Улаанбаатар хотын цэргийн хүрээний 5, хөдөө орон нутгийн /Өвөрхангай, Зүүнбаян, Дорнод/ анги байгууллагат алба хааж байгаа офицер, ахлагч нар, нийт 150 гаруй хэрэглэгч хамрагдсан.


Диаграм 1. Хувцасны чанар, биед таарамжтай байдал



Диаграм 2. Тендерийн тухай мэдээлэл



Диаграм 3. Хүнд суртал /гар хардаг/



Түүнчлэн хэрэглэгчидтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үед дүрэмт хувцасны чанар, хүртээмж хангалтгүй тухай яригдаж байв.

... дугаар ангийн офицер /хэрэглэгч/-той уулзаж ярилцав. Чанарын хувьд сайн биш байна. Уг нь биед наалдацтай материал баймаар. Халуунд халуун, хүйтэнд хүйтэн материалтай шүү дээ. 1999 оны үед анх шинэчлэгдэхдээ их дажгүй байсан.

Эмэгтэй ахлагч /хэрэглэгч/-тай уулзаж ярилцав. Эрээн хувцасны чанар ер нь хүйтэнд хүйтэн, халуунд халуун хэцүү материал. Эмэгтэй хүнд хэцүү л байдаг. Тэр нь ч яахав, бүгд л тийм юм өмсөнө гэснийг эрэгтэй эмэгтэй гэхгүй өмсөнө л дөө. Материалын чанарыг сайжруулах боломж бололцоог хайж байгаа гэж яригддаг. Тендерт ялсан газар л тэгж хийдэг байх. Тэр нарийн ажиллагааг сайн мэдэхгүй. Хувцас размертаа таарахгүй хэцүү байдаг. Дах дэгтий өмсчихсөн юм шиг л байдаг.


Бид, хэрэглэгчдийн дунд хийсэн судалгаа, ярилцлагын дүнд үндэслэн дараах дүгнэлтэд хүрсэн юм.

Цэргийн дүрэмт хувцасны материал, загварын шаардлага нь хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцдэггүй, чанарын шаардлага хангадаггүй гэдгийг бүгд мэдэх

боловч сайжруулах талаар санал гомдол гаргадаггүй, хангалт хаанаас эхэлж хаана дуусдаг талаар мэдээлэл байхгүй, хаалттай байна.

Чанарын талаар гаргасан энэхүү дүгнэлттэй хобоотойгоор цэргийн дүрэмт хувцсанд чанарын тогтсон үзүүлэлтийн жишиг бий эсэхийг судалж үзэх хэрэгтэй болсон. Эл үүднээс судалгаа хийхэд энэ талаар батлагдсан хувцас үйлдвэрлэх, ханган нийлүүлэхэд дагаж мөрдөх жишиг үзүүлэлт байдаггүй нь тодорхой болсон бөгөөд үүнээс үүдээд тендерт шалгарсан байгууллага чанар муутай эдээр шаардлага хангаагүй хувцас үйлдвэрлэж нийлүүлдэг нь болох харагдсан. Тухайлбал, цэргийн нормд нийлүүлсэн суран бүс 10 хоногийн эдэлгээ даалгүй арал нь эвдэрч, сур нь тасрах шахдаг тухай мэдээлэл бий.

Зураг 1. Тасархай бүс



Шаардлагатай үед бүсээрээ бэхэлгээ хийж, хавцал дээгүүр ган утсаар дамжиж гарах зэргээр зөвхөн бүслэхээс өөр зориулалтаар ашиглагдах суран бүс өдөр тутмын хэрэгцээ даахгүй байна гэдэг дэндүү хариуцлагагүй хэрэг. Хэрэв суран бүсний стандарт байсан бол чанар муутай эдлэл хэрэглэл нэвтрэхгүй нь ойлгомжтой. Өвлийн эрээн хувцасны тендерт шалгарч, нийлүүлсэн компаний гологдол их хэмжээгээр хадгалагдаж байдаг. Өгсөн захиалгаар хийгээгүйн дээр захиалсан размераас өөр өмсгөлтэй зэрэг дэндүү их өөтэй хувцас нийлүүлжээ. Энэ бүх хувцасны чанарын талаар олон гомдол саналын хариуд тухайн компани “батлагдсан стандарт байхгүй” гэсэн хариулт өгсөн тухай мэдээлэл ч байдаг.

Хувцасны чанартай холбоотой бидний хараанд өртсөн бас нэг асуудал нь цэргийн дүрэмт хувцасыг хэрэглэх дүрэм журам тогтоогоогүйн улмаас энгийн хүмүүс ажлын хувцас болгон өмсдөг явдал байв. Энэ нь төслийн зорилготой хамааралгүй мэт харагдавч хувцасны чанарын асуудалтай шууд холбоотой юм.

Цэргийн дүрэмт хувцасны зориулалтыг баталгаажуулсан хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна. Цэргийн эрээн хувцасыг манаач, үйлчлэгч, ачигч

нар ажлын хувцас болгон хэрэглэхээс гадна “хурандаа” каракул зах малгайг сайд дарга нар гоёлын зориулалтаар өмсөх зэрэг нь энгийн иргэдэд цэргийн албаны нэр төр, дэг журмын талаар сөрөг ойлголт төрүүлж байна. Цэргийн дүрэмт хувцасны материал, хэв загвараар хувцас үйлдвэрлэж цэргийн бус байгууллагад нийлүүлдэг аж ахуйн нэгжүүд ч байдаг аж. Үүнээс, цэргийн дүрэмт хувцасыг хэрэглэх хүрээ, үйлдвэрлэх хэмжээ хязгаар, эдгээрт тавих хяналт хэрэгтэй байгаа нь харагдаж байна.

Цэргийн дүрэмт хувцасыг тендерт шалгарсанаас өөр байгууллага үйлдвэрлэхгүй байх, мөн энгийн ард иргэдэд өмсөхийг зөвшөөрөхгүй байх, цэргийн албан хаагчид нь өмсөх дүрмээ биелүүлдэг байх талаар эрх зүйн акт гарган, журамлан мөрдөх нь энэ цоорхойгоор үйлдвэрлэгчид чанаргүй бүтээгдэхүүн нийлүүлэхийг зогсооход нөлөөлөх магадлалтай.

Мэдээллийг нээлттэй болгох нь: Хувцасны хангалт, үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох, мэдээллийн сан байгуулах зайлшгүй хэрэгцээ байна. Хувцасны хуваарилалт хийдэг хангалтын ангийн нярав, ажилтнуудын зарим нэг нь хүнд сурталтай, гар хардаг нь энгийн офицер, ахлагч төдийгүй, шинээр төгссөн залуу офицер, /хангалтын ажилтан/-уудын ажлыг ихээхэн хүндрүүлдэг. Хөдөө орон нутгаас ирсэн залуу ажилтнууд цагаан идээ авчрах, хоолоор дайлах боломжгүй бол ажил бүтнэ гэж бодохын ч хэрэггүй, улмаар ангидаа буцаж очоод ажил бүтээхгүй байна гэсэн зэмлэл хүртдэг байна.

Зэвсэгт хүчин /ЗХ/-ийн ... дугаар ангийн хангалтын ажилтантай уулзаж ярилцав. Захиалгын мэдүүлгээ хэрэгцээний дагуу бичээд очдог, ар талын дарга цохохдоо хэдийг хасаад цохдог. Хангалтын даргаар бас цохуулна. Тэнд бас хэд хасагдаж цохогдоно. Тэгээд нярав дээр очиход нярав нь хүртэл хэдийг дутуу өгнө. Ингээд л хаанаа ч хүрэлцэхгүй дутуу ирнэ. Ирсэн хэдийгээ эхлээд шинээр ирсэн албан хаагчиддаа өгнө. Жишээ нь, гутал. Энэ жил дотортой гутал 45 ширхэг ирсний 25-ыг шинэ төгсөж ирсэн хүмүүст өгөөд үлдсэн 20 гутлыг 100 гаран хүнд хуваарилах болдог.

Хангалтын /310 дугаар/ ангийн ажилтнууд хүнд сурталтай. Нярав эд нар нь их зантай, гар хараад сурчихсан. Хөдөөнөөс ирсэн биднийг айраг авчирсан уу, хоолонд оруулах уу ч гэх шиг, хийх ёстой ажлаа жижиг гэлтгүй хээл хахууль маягийн юм болж байж хийх гээд байдаг.

Хувцасны хэрэгцээт тоо хэмжээг үнэн зөв тодорхойлж захиалгаа хийдэггүй, мэдээллийн нэгдсэн сан байдаггүйгээс захиалгын тоог дутуу хийж байна. Мөн захиалгыг өөр хүнд өгөх, захиалсан хүний нэр дээр гарын үсэг зурж өмнөөс нь авах, зарим нь гарын үсгээ зуралгүй хувцас авснаас хариуцсан нярав, ажилтан өрөнд орох, гэх мэт анхан шатны бүртгэл хөтлөлт муу байдаг зөрчил ч харагдав.

Дүрэмт хувцас хугацаатай. Хугацаа нь дуусахаар шууд л мэдүүлгээ бичээд авч байх ёстой. Гэтэл энэ нь амьдрал дээр биелэгддэггүй. Уг нь өгөх ёстой юм чинь хүндрэлгүй л авах ёстой. Гутал, малгай зэрэг нь тооны хүрэлцээ муутай ирдэг юм байна лээ. Манай хангалтын ажилтан олж авчирч чаддаггүй юм уу, цаанаасаа тийм цөөхөн байдаг юм уу, бид сайн мэдэхгүй.

БХЯ, ЗХЖШ-ын ажилтнууд хувцасыг голж, шилж авах эрх мэдэлтэй байхад анги салбарынхан, тэр дундаа хөдөөгийн ангид ажиллаж байгаа офицер, ахлагч нар хугацаа дуусаад байхад нормт хувцсаа олж өмсөж чадахгүйд хүрдэг байна. Тухайлбал, өвлийн малгайны норм дууссан байхад малгайгүй, хүний малгай гуйж өмсөөд явж байсан.

Иймд, хангалтын ангид мэдээллийн сан байгуулах, бусад ангуидын хувцасны карт хөтлөлт, захиалга, олголтын ажлын анхан шатны бүртгэлийг сайжруулах, мэдээллийн сангийн сүлжээнд холбогдох, хяналтыг боловсронгуй болгох шинэлэг арга хэрэгжүүлэх шаардлагатай болжээ.

ДҮГНЭЛТ

Батлан хамгаалах салбарын хувцас хэрэглэлийн хангалтын үйл ажиллагааны өнөөгийн практик байдалд мониторинг хийх ажлын хүрээнд хангалтын ажилтнууд, цэргийн албан хаагчидтай уулзаж, цэргийн дүрэмт хувцасны талаар санал сэтгэгдэл солилцоход дүрэмт хувцасны хангалтын үйл ажиллагааны талаар мэдээлэл байхгүй, хувцасны материалын чанар, хэмжээ нь хэрэгцээ шаардлагад нийцдэггүй, нийлүүлэлт нь захиалгын тоо хэмжээнд хүрэлцдэггүй, хугацаандаа ирдэггүй, олон нийтэд мэдээлэх мэдээллийн орчин бүрхэг, цэргийн дүрэмт хувцасыг өмсөж хэрэглэх баталгаажуулалтын эрх зүйн орчны зохицуулалт дутагдалтай байна.

Бодит байдлыг тоймлон дүгнэвэл:

1. Цэргийн дүрэмт хувцасны хангалт нь төвлөрсөн хангалтаар, өөрөөр хэлбэл тендерийн шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулснаар захиалга хийгдэж, түүний дагуу нийлүүлэгддэг. Гэрээнд тоо хэмжээ, хугацаа, чанар, 2 талын үүрэг хариуцлага тусгагддаг. Тендерийн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулснаас тухайн жилийн хангалт, хувцас хэрэглэлийн нийлүүлэлтийн үр дүн шалтгаална. Тендер явагдах зарыг олон нийтэд мэдээлснээр тендерийн ажиллагаа эхэлнэ. Тендерийн зар нь дотоодын хэвлэлээс гадна СЯ-ны вэб хуудсанд зарлагдаагүй, БХЯ өөрийн гэсэн тендерийн талаарх мэдээллийн өөр хэлбэр хэрэглээгүй зэрэг нь тендерт өрсөлдөөнийг дэмжих, оролцогчдийг нэмэгдүүлэх, эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, чанар үр ашгийн хүртээмжийг сайжруулах боломжийг эрж хайгаагүй, нээлттэй бус болгоход хүргэжээ. Тендерийн шинэ хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Тогтмол оролцдог хэдэн байгууллагын хүрээнд явагдсан нь үүнийг харуулж байгаа юм.
2. Цэргийн дүрэмт хувцасны хангалтын тендер шалгаруулалтын дараагийн үе шат нь захиалгын дагуу нийлүүлэгдэх хувцас хэрэглэлийг хангалтын... дугаар ангид төвлөрсөн хангалтаар нийлүүлэх байдлаар хэрэгжинэ. Хангалтаар нийлүүлэгдсэн хувцас хэрэглэлийг бусад цэргийн ангиуд өөрсдийн хэрэгцээт тоо хэмжээг илэрхийлсэн мэдүүлэг бичиж ирж авна. Уг үйл явцад хийсэн бидний судалгаагаар хэрэглэгчдэд хэрэгцээтэй байгаа тоо хэмжээ дутуу нийлүүлэгддэг. Энэ нь хувцас хэрэглэлийн нэгдсэн мэдээллийн сан байхгүйтэй холбоотой. Хувцас тараадаг албаны ажилтнууд нь гар харах, хүнд суртал үзүүлэх байдалтай нь нотлогдсон.
3. Хэрэглэгчдийн бодит хэрэгцээ шаардлагын асуулга, судалгаанаас үзэхэд цэргийн дүрэмт хувцасны материалын чанарт өөрчлөлт хийх шаардлагатай байгаа нь харагдаж байна. Дүрэмт хувцасны материалын чанар муу байгааг цэргийн байгууллагын бүх түвшний хүмүүс мэдэх боловч сайжруулах талаар үр дүнд хүрэлгүй өдий хүрчээ. Харин, зориулалтын чанартай материал сонгон, тендерийг оёдолд зарлах

болсон өөрчлөлт оруулж байгаа юм байна. Хувцас, хэрэглэлийн норм, техникийн шаардлага байгаа боловч хувцасны стандарт байхгүй байна. Стандарт нь чанарын баталгаажуулалт бөгөөд энэ талаарх сөрөг ойлголтыг нэг мөр болгох ач холбогдолтой юм. Цэргийн дүрэмт хувцасыг энгийн иргэд ажлын хувцас болгон хэрэглэж, цэргийн дүрэмт хувцасыг өөр байгууллагад нийлүүлж байгаа зэргийг цэгцлэх шаардлагатай байна. Энэ нь цэргийн албаны нэр хүндийг хамгаалах, цэргийн албан хаагчид өөрсдөө ч дүрэм журмын дагуу хувцсаа өмсөж хэрэглэхэд нөлөөлөх юм.

ЗӨВЛӨМЖ

Хууль эрх зүйн орчны хүрээнд:

1. Тендер сүүлийн хэдэн жил тогтмол хэдэн байгууллагын дунд явагдаж байгааг анхааран зар мэдээг олон нийтэд мэдээлэх орчныг нээлттэй болгож, хэвлэлээс гадна интернэт ашиглах зэргээр гадаад, дотоодын байгууллага сонирхох боломжийг бүрдүүлэх, оролцогчдийг нэмэгдүүлэх, тэгш өрсөлдөөний боломжийг олгох;
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар цэргийн дүрэмт хувцасны загвар, норм батлагддаг. Энэ нь төрийн тусгай зориулалтын хувцасны загвар, түүний ялгах тэмдгийг хэрэглэх норм хэмжээг заасан журам болохоос үйлдвэрлэлийн стандарт биш. Иймд, чанарыг сайжруулах шаардлагын үүднээс хувцасны стандарт боловсруулж, мөрдүүлэх;
3. Цэргийн дүрэмт хувцасыг зориулалтаар нь өмсөж хэрэглэх эрх зүйн орчныг баталгаажуулахад анхаарч, энгийн иргэд ажлын хувцас болгон хэрэглэж, олноор үйлдвэрлэж ажлын хувцас болгон нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцох гэх мэт эрх зүйн зохицуулалттай болгох;
4. Цэргийн дүрэмт хувцасны хангалтын үйл ажиллагаа, тэндэрийн талаарх мэдээлэл хэрэглэгчдэд хүрэхгүй байгааг анхааран мэдээллийн сан байгуулах шаардлагатай байна.

Нийгмийн хөгжлийн шаардлагын хүрээнд:

5. Цэргийн дүрэмт хувцасны хангалтыг төвлөрсөн хангалтаар хийж буй механизмын алдаа дутагдлыг тооцох, өөр байдлаар оновчтой шийдвэрлэх арга зам байгаа эсэхийг судлах;
6. ЗХ-ийн хэмжээнд хувцасны нэгдсэн мэдээллийн сан байгуулах зэргээр бараа, материалын захиалга хийхэд хяналт тавих механизмыг боловсронгуй болгох;

7. Санал асуулга, судалгаанд хамрагдсан үзүүлэлтээс харахад хувцасны хангалт хугацаандаа ирдэггүй, жишээ нь эрээн хувцасны норм 2 жил байдаг бол 4 жил болж байхад сольж чадаагүй явж байгаа нь жил бүр хийгдэж буй захиалгын тоо хэмжээ яаж хийгдэж, түүнд төлөвлөгдсөн төсөв хэрхэн зарцуулагдаж байгаад хяналт тавих ажлыг сайжруулах;
7. Цэргийн албан хаагчдын хувцасны картны мэдээллийг агуулсан мэдээллийн нэгдсэн сан, сүлжээг бий болгож, хэрэглэгчдийн биед таарамжтай хувцас, хэрэглэл авах боломжийг бүрдүүлэх;

Эдийн засаг, зохион байгуулалтыг бололвсронгуй болгох:

8. Хувцас хэрэглэлийн хангалтыг хүндрэлгүйгээр хүргэхэд анхааран хангалтыг ангиудад хүргэж өгдөг болох зэргээр зохион байгуулалтын шинэ арга хэлбэрт шилжих;

Хүнд суртал, хээл хахуулийг таслан зогсоох зохион байгуулалтын ажлын талаар:

9. Хангалтын ангийн ажилтнууд болон цэргийн ангиудын хангалтын албаны ажилтнууд хүнд суртал гаргах, гар харах зэргээр төрийн албаны нэр хүндийг унагаж байгаатай хариуцлага тооцох, шинэ залуу, эх оронч сэтгэлтэй хүний нөөцөөр бэхжүүлэх, ажлын байрны тодорхойлолтод ёс зүйн шаардлагыг нэмж оруулах.

Төслийн эцэст манай байгууллага, Нээлттэй нийгэм форум /ННФ/-ын санхүүжилтээр цэргийн дүрэмт хувцасны хангалт үйлчилгээний үйл ажиллагааны талаархи дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан “мэдээллийн сан” байгуулах зорилт тавьж байна.

Бэрцэцэг холбоо

Бэрцэцэг хобоо нь 2000 онд “Цэргийн болон цэрэгжсэн байгууллагын эмэгтэйчүүдийн холбоо” нэртэйгээр, эмэгтэйчүүдийн боловсрол нийгмийн хамгаалал, сургалт сурталчилгааны чиглэлээр ажиллаж эхэлсэн бөгөөд 2004 онд Зэвсэгт хүчний эмэгтэйчүүд, гэр бүлийн Бэрцэцэг Холбоо болон шинэчлэгдэн зохион байгуулагдсан юм.

Мониторингийн багийн бүрэлдэхүүн

Б.Оюун /ахлагч/

Гишүүд: Ю.Нарангэрэл /хуулийн зөвлөх, хууль зүйн ухааны магистр/

Б.Үүрцайх /Сэтгэл зүйн ухааны магистр/

Ш.Чингэрэл /Эдийн засгийн ухааны магистр/

Ц.Энхчимэг /Түүхийн ухааны доктор/

Ном зүй

1. “Монгол Улсын хуулиуд” эмхтгэл, 2004 он
2. “Монгол Улсын Зэвсэгт хүчний эрх зүйн үндэс” хууль тогтоомж, эрхийн актын эмхтгэл, ЗХЖШ, 2002 он
3. “Батлан хамгаалагчдыг хэн, хэрхэн хянах вэ” орчуулгын ном, Г.Мягмар, 2004 он
4. “Цэргийн шинэчлэл” сэтгүүл, 2005, 2006 он
5. “Батлан хамгаалах судлал”, 2004 №2 2006 он
6. “Хууль тогтоомжийн эмхтгэл”, Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, 2002 он
7. “Батлан хамгаалах салбарын шинэчлэлийн зарим асуудалд” генерал, офицеруудын цугларалтад хэлсэн үг, Б.Эрдэнэт, 2005он.
8. “Монгол дахь авилгалын асуудалд холбогдох ном зүй”, ННФ, 2005 он
9. “Defense Budgets and Civilian Oversight”, Jeanne Kinney Giraldo, Эрдэм шинжилгээний өгүүлэл
10. “Төрийн батлан хамгаалах бодлого ба зэвсэгт хүчинд хэрэгжүүлэх иргэний хяналтын асуудалд”, илтгэл, Д.Мягмар
11. “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүд, 2004-2006 он
12. “Төрийн мэдээлэл” сэтгүүл, №48 /429/, 2005 он.

Нийгмийн халамжийн үйл ажиллагааны “Тусгал” төсөл

Төслийн зорилго:

Улсын төсвөөс санхүүждэг нийгмийн халамж үйлчилгээний нэг төрөл болох асрамжийн үйлчилгээ үзүүлдэг Баянхонгор, Дорнод аймгууд дахь улсын асрамжийн газруудын улсаас тогтоосон норм нормативууд, тэдгээрийн хэрэгжилт, чанар хүртээмж, албан ёсоор тогтоосон норм нормативийн үзүүлэлтүүдэд мониторинг хийх, энэ чиглэлийн хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, зөрчилтэй байгаа асуудлуудыг илрүүлэн гаргаж, баримтжуулах, олон нийтэд нөлөөллийн үйл ажиллагааг явуулах, дээрх асуудлыг хэрхэн шийдвэрлэж болох талаар зөвлөмж боловсруулан гаргах зорилготой.

Төслийн үндсэн зорилт:

- Баянхонгор, Дорнод аймгууд дахь асрамжийн газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй норм, нормативын хэрэгжилтэд мониторинг хийх,
- Норм нормативтай холбоотой зөрчилтэй асуудлуудыг илрүүлж, баримтжуулах, учир шалтгааныг нь тодорхойлох,
- Мониторингийн дүгнэлтэд үндэслэн санал, зөвлөмж боловсруулах,
- Олон нийтэд нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах.

Мониторингийн үндэслэл

Монгол Улсад өнөөгийн нийгмийн халамжийн олон талт үйлчилгээг зохицуулж буй Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу нийгмийн халамж, үйлчилгээний нэг төрөл болох улсын төвлөрсөн асрамжийн газруудын ажил үйлчилгээн дэх зөрчил дутагдлууд, тэнд үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдийн эрх зөрчигдөж буй асуудлуудын талаар мэргэжлийн байгууллага, хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд

багагүй хэлэлцэн бичиж байгаа билээ. Гэвч энэ талаар яг тухайлсан баримт жишээ, бодит нөхцөл байдалд тулгуурласан судалгаа, үнэлгээ, мониторингийн тайлан мэдээлэл байхгүй төдийгүй энэ чиглэлээр цаашид хэрхэн сайжруулж ажиллах бодлогын баримт бичиггүй байгаа байдалд үндэслэн төслийн баг асрамжийн үйлчилгээний орцын норм нормативын хүрээнд гүйцэтгэлийн хэрэгжилт ямар байдлаар явагддагийг авч үзэхээр энэхүү мониторингийн төслийг хэрэгжүүлсэн болно.

Тус чиглэлээр мониторинг хийх болсон шалтгааныг дараах байдлаар гаргаж байна.Үүнд:

- Төрөөс санхүүжилттэй улсын төвлөрсөн асрамжийн үйлчилгээний одоо явуулж буй ажил, үйлчилгээний нийтлэг зөрчил тухайн салбарын хувьд томоохон анхаарал татсан асуудал болж удаа дараа сонин хэвлэлээр яригдаж бичигдэж байгаа,
- Асруулагчдад үзүүлж буй үндсэн үйлчилгээний орцын норм нормативын хэрэгжилтийг мэргэжлийн хяналтын байгууллага болон бусад зохих байгууллагууд төдийлөн анхаарч үзэхгүй орхигдуулан нийгмийн халамжийн үйлчилгээний дотор дайвар мэтээр авч үзэж байгаа байдал,
- Асруулагчдын амьдралын орчин, нөхцөл байдал, тэдгээрийн сэтгэл ханамж, орчны тав тух, хангамж муу байгаа зэрэг нь энэхүү мониторингийн төслийг хэрэгжүүлэх үндсэн шалтгаан болж байна.

Төслийн хамарсанх хүрээ, хугацаа, байршил

Хамрах хүрээ, байршил Баянхонгор, Дорнод аймгуудын асрамжийн газар, норм нормативт үйлчилгээг зохион байгуулагч болон хүртэгчид, бодлого боловсруулагчид. 2005 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2006 оны 4 дүгээр сарын 30 хүртэл

Мониторингийн аргачлал

- Баримт материал цуглуулж, анализ хийсэн. /Мониторингийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан ёсны холбогдох хууль тогтоомжууд, асрамжийн газруудын талаарх үндсэн мэдээллүүд,
- Шууд ажиглалт явуулсан.
- Ярилцлага – Видео болон кэйсээр баримтжуулсан.
- Тусгайлан боловсруулсан кэйс маягт

Мониторинг хийхэд баримтлал болгосон холбогдох хуулийн заалтууд

- Нийгмийн халамжийн тухай хууль
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль
- Асрамжийн газрын үлгэрчилсэн дүрэм
- 1999 онд батлагдсан Улсын Нийгмийн Халамжийн Газар /УНХГ/-ын даргын 15 тоот тушаалын 2, 3, 4, 5 дугаар хавсралтаар батлагдсан норм нормативууд

МОНИТОРИНГИЙН ДҮН

Мониторингийн үр дүнг дараах байдлаар ангилж авч үзсэн. Үүнд:


- Норм нормативт зардлын тооцоо буюу санхүүгийн баримтуудад хийсэн мониторинг,
- Норм нормативт үйлчилгээ тус бүрт хийсэн мониторингийн нэгтгэл, илрүүлсэн зөрчилтэй асуудлууд, тэдгээрийн учир шалтгаан.

Норм нормативт зардлын тооцоо буюу санхүүгийн баримтуудад хийсэн мониторинг

Мониторингийн ажлын хүрээнд 2 асрамжийн газар тус бүрийн санхүүгийн баримтуудыг авч үзэх ёстой байсан боловч Баянхонгор аймгийн асрамжийн газрын хувьд санхүүгийн баримттай танилцуулаагүй бөгөөд хориг тавьж, мониторинг хийх боломж олгоогүй. Дорнод аймгийн асрамжийн газрын хувьд хоол хүнсний бүтээгдэхүүн худалдан авч зарцуулсан сүүлийн 3 сарын баримт, хувцас хэрэглэл худалдан авсан сүүлийн 1 жилийн баримт, эм тариа худалдан авч зарцуулсан сүүлийн 1 жилийн санхүүгийн баримтуудад мониторинг хийсэн.


Дорнод аймгийн асрамжийн газар нь 2005 онд улсын төсвөөс 14532800 төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд үүнээс хоол хүнсэнд 11296800 төгрөг, хувцас, ариун цэврийн хэрэгсэл болон зөөлөн эдлэлд 2730000 төгрөг, эм тарианд 206000 төгрөг, эд хогшилд 300000 төгрөгийг /График 1/ тус тус зарцуулсан гэх боловч санхүүгийн тайлантай танилцах боломж олгоогүй.

График 1. 2005 оны нормативт үйлчилгээний төсвийн зарцуулалт



Жилийн нийт төсөв 25939700 төгрөг байдаг бөгөөд үүнээс 14532800 төгрөг буюу 56%-ийг асруулагчийн норм нормативт үйлчилгээнд зарцуулж, үлдсэн 44%-ийг ажилтнуудын цалин, гэрэл цахилгаан, дулаан зэрэгт зарцуулдаг байна.

График 2. Нэг жилд, нэг хүнд ногдох нормативт үйлчилгээний зардал /төгрөгөөр/



Дээрхээс харахад нэг асруулагчид 1 сард нийт 94000 төгрөг зарцуулах ёстойгоос норм нормативт үйлчилгээнд сард 55048 төгрөг зарцуулдаг тооцоо гарч байна. Энэ нь шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс илүүд тооцогдож байна.

Норм нормативт үйлчилгээний санхүүгийн баримтуудад хийсэн шинжилгээг дараах байдлаар нэгтгэлээ.

Хоол хүнс худалдан авсан болон зарцуулсан байдалд хийсэн мониторингийн нэгтгэл

Мониторингийн баг Дорнод аймгийн асрамжийн газрын асруулагчид олгогдож байгаа хоол хүнс худалдан авалт, зарцуулалтын сүүлийн 3 сарын

буюу 2005 оны 10 дугаар сараас 2006 оны 1 дүгээр сар хүртэлх санхүүгийн баримтыг цуглуулж, тухайн орон нутгийн зах зээлийн үнэтэй /Дорнод аймгийн хэрэглээний бараа үйлчилгээний сагс 2005, 2006 он/ харьцуулалт хийсэн. Мөн төслийн ажиглалтын ажилтан бараа материал худалдан авалт, таталт, түгээлт зэрэгт ажиглалт хийсэн. Мониторинг хийсэн дээрх 4 сарын хугацаанд баримтаар нийт 3673915 төгрөгийн хоол, хүнсний бараа бүтээгдэхүүн худалдан авчээ. Үүнийг зах зээлийн үнийн судалгаатай харьцуулан дүгнэхэд 2005 оны 10 дугаар сард 48836 төгрөг, 11 дүгээр сард 71659 төгрөг, 12 дугаар сард 73711 төгрөг, 2006 оны 1 дүгээр сард 70225 төгрөг, нийт 264431 төгрөгийн зөрүүтэй байна.

Түүнчлэн асруулагчидтай хийсэн кэйс ярилцлагаас дүгнэхэд мониторинг хийсэн сүүлийн 2 сард цагаан будаа огт хэрэглээгүй гэх боловч баримтаар 139140 төгрөгийн цагаан будаа авсан гэж хуурамч баримт үйлдсэн байна. Хоол хүнсний таталтыг 10 хоног тутам хийдэг боловч санхүүгийн баримтыг сараар нь гаргуулж авдаг аж. Баримтаар худалдан авсан хүнсний материалыг тогоочид хүлээлгэн өгдөг бөгөөд өдөрт хэр хэмжээний материал зарлагадсан баримт бүрдүүлэлт хийгддэггүй нь ажиглалтаар тогтоогдсон боловч санхүүгийн баримтад хүлээн авсан хэмжээгээр нь зарлагдаж бичсэн байна. Энэ нь өдөрт хэр хэмжээний мах, ногоо, бусад хүнсний материалаар хоол хийж, асруулагчдад өгдөг нь тодорхойгүй байна.

Хувцас худалдан авсан баримтад хийсэн мониторингийн нэгтгэл

2005 онд нийт асруулагчдад зориулан 10 төрлийн хувцасыг нийт 1106000 төгрөгийн өртөгтэйгээр худалдан авсан баримтад мониторинг хийсэн бөгөөд үнийн хувьд зах зээлийн дундаж үнэ ханшаар худалдан авсан байна. Худалдан авсан хувцасыг хэрхэн олгосон талаар баримт материалтай танилцах гэсэн боловч ня-бо гаргаж өгөөгүй учраас асруулагчидтай хийсэн кэйс ярилцлагаар 2005 онд олгогдсон шинэ хувцасны тоог гаргаж харьцуулан дүгнэлээ.

Нийт асруулагчдын зүгээс өмсөж хэрэглэж байгаа хувцас, асрамжийн газраас өгсөн хувцасны талаар нилээд тодорхой мэдээллийг бидэнд өгсөн. Олгох ёстой нийт хувцаснаас эрэгтэй биеийн тамирын өмд, пүүз огт олгогдоогүй бөгөөд баримтад тусгасан бусад хувцаснуудаас асруулагчдад тодорхой хэмжээгээр олгогдсон байна. Үүнийг мөнгөн дүнгээр авч үзвэл 1106000 төгрөгийн хувцаснаас 388500 төгрөгийн хувцас олгогдож, 717500 төгрөгийн хувцас олгогдоогүй гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Эм тариа худалдан авсан баримтад хийсэн мониторингийн нэгтгэл

Мониторингийн баг 2005 онд худалдан авч, зарцуулсан баримтад мониторинг хийв. 2005 оны 1, 4, 5, 6, 7, 11, 12 дугаар саруудад нийт 67 төрөл, 196590 төгрөгийн эм тариа худалдан авсан баримттай байгаа ба эмийн тайлан болон асруулагчдад зарцуулсан эм тарианы жагсаалтыг бүрэн

хөтлөсөн байна. Хэдийгээр баримтын бүрдүүлэлт бүрэн байсан боловч нийт 3 удаагийн эм тариа худалдан авалтын баримт буюу 58990 төгрөгийн баримтыг санхүүгийн стандарт маягтаар бус гар бичмэлээр үйлдсэн байна.

Асруулагчдад зарцуулсан эмийн маягтаас худалдан авсан эм тарианы зарцуулалтыг дүгнэхэд асруулагчдын гарын үсгийг хуурамчаар үйлдсэн байв. Зарим нэг асруулагчдын үнэлснээр эм тариа огт өгдөггүй, өөрсдийн тэтгэврийн мөнгөөр эм тариа худалдан авах тохиолдол байдаг гэсэн бөгөөд эдгээр асруулагчид нь эм тариа хүлээн авч гарын үсэг зурсан асруулагчдын тоонд орсон байгаа нь хуурамч гарын үсэг үйлдсэн байдлыг нотолж байна. 2005 оны эмийн нэгдсэн тайлангаас харахад улсын төсвөөс 1 сард 17200 төгрөг, 1 жилд 206400 төгрөг олгосон бөгөөд 2005 онд 196590 төгрөг зарцуулж, 9810 төгрөгийн ашигтай ажилласан гэсэн тооцоо гаргажээ. Энэ нь нилээн хэдэн асруулагчид өвчин намдаах эм авч өгөх хэмжээний мөнгө юм.

Норм нормативт үйлчилгээ тус бүрт хийсэн мониторинг, илрүүлсэн зөрчилтэй асуудлууд, тэдгээрийн учир шалтгаан

Мониторинг хийсэн 2 асрамжийн газрын нийт асруулагчидтай хийсэн кэйс ярилцлагууд, видео бичлэгээр баримтжуулсан асруулагчдын санал, дүгнэлтүүд, ажиглалтаар олж авсан мэдээллүүдэд үндэслэн норм, нормативаар үзүүлж буй үйлчилгээ тус бүрт мониторинг хийж, зөрчилтэй гэсэн асуудлуудыг фокуслан авч үзэж, учир шалтгааныг нь тодорхойлж, баримтжуулсан.

Хоол хүнсний хангамж үйлчилгээнд хийсэн мониторингийн нэгтгэл, зөрчилтэй асуудлууд

Хоолны чанар, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн байдал: Хоол хүнсний хангамж үйлчилгээний хэрэгжилтэд мониторинг хийхийн тулд хэд хэдэн шалгуур үзүүлэлт, харьцуулалтыг дараах байдлаар хийсэн.

Хоол хүнсний хангамж үйлчилгээний талаар асруулагчдын сэтгэл ханамжийг судалж үзэхэд нийт асруулагчдын 59% нь үйлчилгээний чанар, хүртээмж муу гэсэн дүгнэлтийг хийсэн. Нэг асруулагчийн хоногт хэрэглэх хоол хүнсний нормативт зардал хэр бодитой байгаад дүгнэлт хийхэд нэг асруулагчид хоногт 1046 төгрөгийн хоол олгохоор нормчилсон байдаг боловч улсын төсвөөс хоногт дунджаар 1225 төгрөгийн хоол олгохоор тооцоолон санхүүжилт хийдэг байна. Гэтэл норм нормативт тусгасан нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг өнөөдрийн зах зээлийн ханшаар тооцож үзвэл 1640 төгрөг байх тооцоо гарч байгаа нь даруй 594 төгрөгөөр зөрүүтэй байгаа юм. Хоолны нэр төрлийн хувьд 1 дүгээр хоол 4 төрөл, 2 дугаар хоол 4 төрлийн хоол, цагаан хоол огт өгдөггүй байна. Дээрхээс дүгнэхэд асруулагчдын хэрэгцээ, сонирхолд нийцсэн хоол олгогдохгүй байгаа нь харагдаж байгаа юм. Нормативт олгохоор заасан хүнсний бүтээгдэхүүнийг орцоор ангилж мах, гурил, хүнсний ногоо, бусад материалууд буюу тос, амтлагч зэргийг олгодог эсэхийг судалсан.

Ихэнх тохиолдолд адууны мах, 1, 2 дугаар гурил, гоймон, хүнсний ногооны хувьд төмс, лууван, сонгино, хааяа нэг байцааны орцтой хоолоор үйлчилдэг байна. Хүнсний ногооны нэр төрөл цөөхөн байгаа нь хүний өдөрт авах ёстой витамин хэрэгцээг хангаж чадахгүй байгаа юм. Мониторинг хийх явцад орон нутгийн Эрүүл ахуй халдвар судлал /ЭАХС/-ын мэргэжлийн шалгалт, шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан бөгөөд өмнөх онд хийсэн дүгнэлтийг харьцуулан мониторинг хийсэн.

Дорнод аймгийн асрамжийн газрын хувьд 2005 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн дүгнэлтээр 2122,3 ккал байсан бөгөөд 2006 оны 2 дугаар сарын 8-ны байдлаар 3137,6 ккал болж сайжирсан ч хоолны эрүүл ахуй, чанар, хадгалалтын хувьд нилээд зөрчилтэй дүгнэлт гарсан.

Баянхонгор аймгийн асрамжийн газрын хувьд сүүлийн 1 жилийн хугацаанд хоол хүнсний нэр төрөл олширч байгаа хэдий ч шинжилгээгээр амт, чанар болон илчлэг тэр бүр нэмэгдэж чадахгүй байна.

Асруулагч Ш: Шөл нь богширсон, уухад хэцүү. Үхрийн мах нь туранхай, амт шимтгүй, адууны мах нь үнэр орсон. Хоол амтлагч нь халуун ногоотой байдаг. Ахмадуудад тохирсон хоол байдаггүй. Хоол хүнсний хувьд баталгаагүй зүйл өгөгдөж байна гэж үзэж байна.

Бараа материал худалдан авалт, зарцуулалтын санхүүгийн үйл ажиллагааны явц ил тод бус, зөрчилтэй байсан. Бараа материалыг 10 хоногийн хэрэгцээгээр худалдан авдаг боловч баримтыг 1 сараар үйлддэг. Хоол хүнсний бүтээгдэхүүн татан авсан баримт дээрх үнийг тухайн орон нутгийн зах зээлийн үнийн судалгаатай харьцуулахад 1 сард 70-75 мянган төгрөгийн зөрүү тогтоогдсон. /Дорнод аймаг/ Байгууллагын санхүүгийн хяналтгүй ажилладаг. 1 дүгээр сарын санхүүгийн баримтыг 2 дугаар сард нөхөж бүрдүүлж байх жишээтэй. Журмын дагуу нягтлан бодогч, нярав, асруулагчдын зөвлөлийн төлөөлөлтэйгээр бараа материалд таталт хийх ёстой боловч хоол хүнсийг Хөдөлмөр, Халамж, Үйлчилгээний Хэлтэс /ХХҮХ/-ийн ахлах мэргэжилтэн болон асрамжийн газрын зохион байгуулагч нар гардан зохион байгуулдаг бөгөөд үүнд ня-богийн оролцоо бага харагдсан /Дорнод аймгийн асрамжийн газар /АГ//. Хоол хүнсний таталтын тайланг нярав, тогооч нар хөтлөдөг байна /Баянхонгор аймгийн АГ/.

Хоол хүнсний чанар, эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй, хүртээмжгүй байна. Хоол хүнсний бүтээгдэхүүнийг хадгалалтын технологид үл нийцүүлэн хадгалдаг нь бүтээгдэхүүний чанар, илчлэг муудахад нөлөөлж байна. Түүнчлэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахдаа танил талаа харж, хямд төсрийг нь бодож муудсан бүтээгдэхүүн худалдан авдаг нь ажилтнуудын хариуцлагагүй байдалтай холбоотой. Асруулагчидтай хийсэн ярилцлагын үеэр асрамжийн газрын удирдлага, ажилтнууд олон жил хамт ажилласан учраас ямар нэгэн хяналтгүй байдаг бөгөөд хоногийн хоолоо асруулагч нарын хоолноос нууцаар зөөж гэр бүлээ тэжээдэг байна.

Мониторингийн ажлын явцад тухайн орон нутгийн ЭАХС-ийн үзлэг шалгалт хийлгэхэд хоол хүнс бэлтгэн нийлүүлж байгаа ажилтнуудын хэрэгслүүдээс 41,6%-д гэдэсний савханцар илэрчээ. Хоол хүнсний материал нь ямар нэгэн шинжилгээ баримтгүй байв. Ажилтнуудын хувьд ажлын байранд дүрэмт хувцас өмсдөггүй байна. Ажиглалтаар асрамжийн газрын бохир цэвэрлэдэг, цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлдэг асрагч, үйлчлэгч нар гал тогоонд өдөржин байж, асруулагчдын хоол хүнсийг бэлтгэхэд оролцдог нь харагдсан.

Асруулагч С.: Зээрний өөх өгсөн. Асрагч нар жорлон цэвэрлээд, шууд хоол хийдэг. Тордолтын хоол биш торгоолтын хоол өгдөг. Цагаан идээ, аарц, сүүтэй цай уумаар байна.

Хоол хүнсний найрлага, илчлэгийн горим мөрддөггүй, зөрчдөг. Нормативаар олгох ёстой хоол хүнсний найрлага, өдөрт хэрэглэх ёстой сүү, цагаан идээ, хүнсний зарим төрлийн ногоо, будаа зэрэг нь огт олгогддоггүй байна. Асруулагчдын гомдол саналаар, зохион байгуулагч нь асруулагчдын хоол хүнсэнд хэрэглэх ёстой адууны махыг зээрийн махаар сольж асруулагчдад хоол хийж өгсөн бөгөөд энэ нь асруулагчдын гэдэс дотор хямрахад хүргэжээ. Хоолны порц хэвийн илчлэг муутай байдаг нь хоолонд орох ёстой орцын дутагдалтай холбоотой.

Асруулагч О, Е.Б, Л.О, Б.С: Хоолны амт ерөнхийдөө муу. Зээрний мах өгдөг. Ямаа, адууны мах нь хатуу. Тэжээллэг баймаар байна. Адууны мах дотор муу байхад хэцүүхэн байдаг. Муудсан мах өгсөн.

Асруулагчдын хэрэгцээнд тохирсон хоол хүнсээр хангадаггүй. Асрамжийн газрын удирдлагын зүгээс асруулагчдын хоол хүнсийг нормчлох биш хэрэгцээнд суурилсан хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг хийсэн ба асрамжийн газарт асруулагчдын ихэнх нь ахмадууд, цөөн тооны хэвтрийн өвчтэй хүмүүс байдаг. Эдгээр хүмүүст зориулсан хоолыг тэр бүр хийж өгдөггүй бөгөөд хэт хурц, тостой, хатуу махтай хоолыг ахмадууд идэхэд хүндрэлтэй байдаг бөгөөд эрүүл мэндэд муу нөлөө үзүүлдэг байна.

Хувцасны хангамж үйлчилгээнд хийсэн мониторингийн нэгтгэл, илрүүлсэн зөрчилтэй асуудлууд

Хувцас хэрэглэлийн хангамж үйлчилгээнд нийт асруулагчдын 41% нь хувцас дутмаг, асруулагчдын хэрэгцээнд тохирохгүй хувцасаар хангадаг гэсэн дүгнэлтийг хийсэн. Жишээ нь хэт томдсон, нэг ижил загвар, хэмжээтэй, аль эсвэл хямд төсрийг нь бодож хуучин хувцас олгодог байна.

Хувцас олголтын байдал, нормативт эдэлгээт хугацаа болон чанарын шаардлагыг хангадаггүй, олгогдох ёстой хувцас бүрэн олгогддоггүй. Дорнод аймгийн хувьд нормативаар олгогдох ёстой хувцаснаас ойрын 2 жилд нийт 6

төрлийн хувцас олгогдсон бөгөөд энэ нь нормативт хугацаанд олгогдох ёстой хувцасны төрөл, тоонд хүрэхгүй байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар асруулагчдад олгогдсон хувцасны ихэнх нь комиссын хуучин хувцас бөгөөд энэ нь чанарын шаардлага, эрүүл ахуйг хангахгүй байгаа юм. Хэдийгээр асрамжийн газрууд хөрөнгө мөнгө хүрэлцдэггүй гэх шалтгаанаар хуучин хувцас олгож байгаа ч энэ нь норматив болон тухайн хүний эрхийг зөрчсөн асуудал болж байна. Асруулагчдын зүгээс биеийн хэмжээнд тохирсон чанартай хувцас өмсөх, улирлын чанартай хувцсаар хангагдах хэрэгцээ байгаа нь харагдсан. 2004-2005 онд асруулагчдад хувцас олгосон баримтыг үзүүлээгүй болно.

Хувцас хэрэглэлийн нормативт зардлын хүртээмж хангалтгүй байна. Дорнод аймгийн хувьд санхүүгийн баримтаар худалдан авсан хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг тооцож үзэхэд 1 асруулагчид жилд 109200 төгрөгийн зардал байхаар дүн гарч байна.

Баянхонгор аймгийн хувьд хувцас зөөлөн эдлэлийн зардал 1 асруулагчид жилд 66700 төгрөг байхаар төсөвлөгдсөн нь харьцуулж үзэхэд нилээд зөрүүтэй байгаа юм. Улсаас төсөвлөж олгосон санхүүжилтээр хувцас олгож байгаа гэх боловч энэ нь асруулагчдын хэрэгцээг хангаж чадахгүй байна. Дотуур хувцас л гэхэд 1, 2 ээлжийнх, зуны халуун улиралд өвлийн гутал, бакалтай байх тохиолдол нилээд байлаа.

Улирлын чанартай хувцас хэрэглэлээр хангаж чаддаггүй. Нормативт заасан эдэлгээт хугацаа боломжийн боловч төсөвт тусгасан санхүүжилтээр хувцас авч өгөхөд төсөв хүрдэггүй гэсэн тайлбарыг АГ-ын удирдлагууд хийж байсан. Асрамжийн газарт анх ирснээс хойш гутал огт өгөөгүй тохиолдол ярилцлагын явцад гарч байв. Гэтэл 2005 оны байдлаар санхүүгийн баримтаар худалдан авсан хувцасны 1/3 нь эзэндээ очсон байна. Асруулагчдын зүгээс өвөл, зун, хавар, намрын зэрэг улирлын чанартай хувцас хэрэгтэй байна.

Хувцасны чанарт анхаардаггүй. Асруулагчдад ихэнх тохиолдолд үнээс шалтгаалан хямд төсөр, чанар муутай хувцас олгодог гадна хүмүүнлэгийн байгууллагуудаас олгосон тусламжийн хувцасыг хэрэгцээг нөхөх хэлбэрээр олгодог нь мониторинг хийсэн 2 асрамжийн газарт нийтлэг байв. Улсаас тогтоосон норм, нормативт дотуур хувцас болон ажлын өмднөөс бусад бүх төрлийн хувцаснууд жишээлбэл гутал, ноосон цамц, тэрлэг гэх мэтчилэнг 2 жилд 1 ширхэгийг олгохоор тусгасан байдаг. Гэвч эдгээр нь чанар муутайгаас амархан элэгдэж урагддаг. Дорнод аймгийн хувьд нас барсан хүний хувцасыг бусдад нь шилжүүлэн олгосон тохиолдол байсан.

Норм нормативаар олгогдож байгаа хувцас нь асруулагчийн хэрэгцээнд нийцээгүйгээр хуаранчилж олгодог. Нормативаар олгож байгаа хувцас нь асруулагчийн биеийн хэмжээ, онцлогт, хүсэл сонирхолд нийцээгүй байдаг. Зарим хэвтрийн асруулагчдын хувьд дулаан зөөлөн хувцас хэрэгтэй байдаг бол өвлийн цагт асруулагч нар хөвөнтэй цамц гэхээсээ илүү зөөлөн куртка,

дулаан дээл өмсөх хүсэлтэй байдаг байна. Асруулагч нарын биеийн хэмжээ харилцан адилгүй байдаг ч нэг ижил хэмжээтэй, нэг ижил загварын хувцасыг нормчилж олгодог. Зарим асруулагчдын хувьд хувцас нь томдсон, аль эсвэл багадсан учраас нэг ээлжийн хувцастай байдаг.

Дотуур хувцасны хангамж муу байна. Нормативт тусгаснаар дотоожийг жилд 2 ширхэг, нимгэн зузаан оймс жилд 8 ширхэг, хөхний даруулгыг жилд 2 удаа олгохоор тусгасан байдаг. Асруулагчдын бодит нөхцөл байдал, хэрэгцээг авч үзвэл ихэнх асруулагч нар 1-2 ээлжийн дотуур хувцастай байна. Энэ нь ариун цэврийн наад захын шаардлагыг хангахгүй байгаа юм.

Асруулагч Т.Г.: Өрөөсгөл нэгд нь өгөөд нөгөөд нь байхгүй. Ноосон цамц комиссынх байсан. Хүний сэтгэлд нийцтэй, хүн хүний онцлог, размерт тааруулж хийх хэрэгтэй юм. Матрас гудсыг 4-5 жилд солиогүй.

Асруулагч О.О., М.Т., М.Б.: Комиссын хувцас өгдөг. Настай хүмүүст дээл, савхин гутал хэрэгтэй байна.

Асруулагч Б.Э: Нас барсан хүний хувцас савхин гутал өмсөж байна. Хөнжлийн болон орны даавуу нь их будагтай, хятад даавуу өгдөг.

Ариун цэврийн хэрэглэлийн хангамж, үйлчилгээнд хийсэн мониторингийн нэгтгэл, илрүүлсэн зөрчилтэй асуудлууд

Асруулагчидтай ярилцахад 45% нь ариун цэврийн хангамж үйлчилгээ хангалтгүй гэсэн дүгнэлт өгсөн. Ариун цэврийн хэрэглэлийн олголт, чанар, хэрэглээний хувьд улсаас тогтоосон норм нормативаар нийт 6 төрлийн ариун цэврийн хэрэглэлийн зүйлс олгогдохоор тусгагдсан боловч мониторинг хийсэн асрамжийн газруудад нүүр гарын алчуур, нүүр гарын саван 2-оос өөр хэрэглэл огт олгогдохгүй байна. Хүний наад захын эрүүл амьдрах хэрэгцээг хангасан ариун цэврийн хэрэглэл болох оо, сойз огт олгогддоггүй нь асруулагчдын эрүүл мэндэд муугаар нөлөөлөх нь ойлгомжтой. Зарим нэг асруулагчид өөрийн тэтгэвэрийн мөнгөнөөс оо, сойз, сам зэрэг өөрт хэрэгцээтэй зүйлээ худалдан авдаг аж. Олгосон саван, алчуур зэрэг нь нормативт заасан эдэлгээт хугацаанд зарим тохиолдолд хүрдэггүй.

Нормативаар олгох ёстой ариун цэврийн хэрэглэл олгогдохгүй байгаагийн шалтгааныг асрамжийн газрын удирдлагууд үүнийг мөн л төсөв санхүү хүрэлцдэггүй гэж тайлбарлаж байна.

Ариун цэврийн хэрэглэлийн нормативт зардлыг авч үзэхэд норм нормативын дагуу жилд 1 асруулагч 5600 төгрөгийн ариун цэврийн хэрэглэл хэрэглэх ёстой боловч мониторинг хийсэн асрамжийн газрууд ойролцоогоор 2000 төгрөгийг зарцуулж байна. Ариун цэврийн хэрэглэлийн зардлыг хувцас, зөөлөн эдлэлийн зардалтай нэгтгэн санхүүжүүлдэг байна.

Асруулагч Ч.Б., Б.Э.: Оо огт өгдөггүй, өөрсдөө авдаг. Оо сойз хэрэгтэй байна.

Асруулагч М.Б.: Саван ойрд өгөөгүй.

Зөөлөн эдлэлийн хангамж, үйлчилгээнд хийсэн мониторингийн нэгтгэл, илрүүлсэн зөрчилтэй асуудлууд

Энэ талаар асруулагчдын 53,6% нь зөөлөн эдлэлийн хангамж дутагдалтай, зөрчилтэй гэсэн дүгнэлтийг хийсэн. Зөөлөн эдлэлийн олголт, чанар хэрэглээг авч үзэхэд норм нормативаар нийт 8 төрлийн зөөлөн эдлэл олгохоор заасан байдаг. Мониторинг хийсэн асрамжийн газруудын хувьд зөөлөн эдлэл нэр төдий олгогддог. Учир нь анх асрамжинд ирэхэд олгосон хөнжил, матрас, гудас, орны бүтээлэг, дэр зэрэг нь огт шинэчлэгдээгүй, 10 гаруй жил хэрэглэгдсээр байна. Зөөлөн эдлэлийн эдэлгээт хугацаа урт байдгаас хөнжлийн даавуу, орны даавуу, дэрний уут зэрэг нь эдэлгээт хугацаанаас өмнө хуучирч элэгддэг. Тухайлбал, жилд 1 асруулагчид 1 ор, хөнжлийн даавуу олгохоор заасан бөгөөд мониторинг хийсэн аймгуудын хувьд угаалгын машинаар угаадаг тул амархан сэмэрч урагддаг. Асруулагчдын хувьд 1 ээлжийн даавуутай байх нь ариун цэврийн наад захын шаардлагыг хангаж чадахгүй байна. Гудас матрас, хөнжлийн хувьд зайлшгүй солих шаардлагатай байна.

Зөөлөн эдлэлийн зардлыг хувцас, ариун цэврийн хэрэглэлийн зардалтай нэгтгэн санхүүжүүлдэг ба нормативт 3 жилд нэг асруулагчид 49000 төгрөгийн зөөлөн эдлэл олгохоор тусгасан байдаг боловч жилд шинэчлэн олгодог ор, хөнжлийн даавууны зардлыг тооцож үзвэл 8000 төгрөг, 3 жилд нийт 24000 төгрөг зарцуулж байна. Асрамжийн газруудын хувьд матрас, гудасны хэрэгцээ их байдаг. Дорнод аймагт 3 ширхэг, Баянхонгор аймагт 1 ширхэг матрас байдаг бөгөөд бүх асруулагчид ганц дан гудастай байна. Дорнод аймгийн асрамжийн газарт шинээр ирсэн асруулагчид нас барсан хүний муудаж, элэгдсэн, өтгөн шингэнтэй холилдсон гудсыг олгосон тохиолдол гарсан.

Асруулагч Л.С.: Солих даавуу байдаггүй. Ариун цэврийн хэрэглэл дутмаг байдаг.

Асруулагч Л.С.: Ирж байгаа асруулагчид үхсэн хүний чацгатай эсгий гудас өгсөн.

Эм тарианы хангамж үйлчилгээнд хийсэн мониторингийн нэгтгэл, илрүүлсэн зөрчилтэй асуудлууд

Нийт асруулагчдын 60% нь эрүүл мэндийн буюу эм тарианы хангамж, үйлчилгээ хангалтгүй гэсэн дүгнэлтийг хийсэн. УНХГ-ын даргын 1999 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн тушаалын 2 дугаар хавсралтад асрамжийн газарт байвал зохих эмийн жагсаалтыг заасан байдаг бөгөөд үүнд 27 төрлийн эм тариаг багтаасан байдаг. Анхан шатны тусламжийн болон

эмийн шүүгээнд байх ёстой наад захын эм тариагаар дутмаг байдаг нь эрүүл мэндийн үйлчилгээ асрамжийн газруудад нийтлэг байдлаар дутмаг байдгийг харуулж байна.

Дорнод аймгийн хувьд асруулагчид эм тариа байдаггүй, огт өгдөггүй, зарим тохиолдолд өөрсдийн мөнгөөр худалдан авдаг нь ярилцлагаас дүгнэгдсэн ба эмчийн үйл ажиллагаанд сэтгэл дундуур байдаг нь харагдсан. Баянхонгор аймгийн хувьд мэргэжлийн эмч ажилладаг бөгөөд эмгүй эмчилгээг нэвтрүүлснээр эм тарианы хэрэгцээг нөхөж байгаа хэдий ч хэвтрийн асруулагчдад эм тариа зайлшгүй дутагдалтай байдаг байна. Улсын төсвөөс асрамжийн газрын асруулагчдын тоог үл харгалзан 1 сард 17200 төгрөг төсөвлөн олгодог. Гэтэл Дорнод аймгийн АГ нийт 23 асруулагчтай, Баянхонгор аймгийн АГ нийт 12 асруулагчтай хэдий ч эм тарианы хүртээмж харилцан адилгүй байдаг байна.

Норм нормативт эм тарианы зардлыг нарийвчлан тусгаагүй байдаг бөгөөд улсаас олгож буй эм тарианы зардал хүрэлцдэггүй. УНХГ-ын даргын 1999 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн тушаалын 2 дугаар хавсралтад асрамжийн газарт зайлшгүй байвал зохих эмийн жагсаалтыг баталсан боловч нэг сард нэг асруулагчид олгох эм тариа, витамин зардлыг нарийвчлан тусгаагүй байна. Мониторинг хийсэн 2 асрамжийн газрын хувьд улсын төсвөөс асруулагчдын тоог үл харгалзан нийтлэг байдлаар 1 сард 17200 төгрөгөөр тогтоосон байдаг. Дорнод аймгийн хувьд нийт 23 асруулагчтай бөгөөд 1 хүнд сард 747 төгрөг, Баянхонгор аймгийн хувьд 1433 төгрөгийн эм тариа олгогддог байна. Гэвч хэвтрийн өвчтэй асруулагчдын хувьд өндөр үнэтэй эм тариа хэрэглэх шаардлагатай болдог учир 17200 төгрөгөөр 1 удаагийн эм тариа авах тохиолдол гардаг байна. Зарим тохиолдолд асруулагч нар өөрсдийн мөнгөөр эм тариагаар худалдан авдаг аж.

Эм тариа худалдан авч, зарцуулсан баримтууд зөрчилтэй байна. Дорнод аймгийн асрамжийн газрын хувьд эм тариа худалдан авч, зарцуулсан санхүүгийн баримтад нилээд зөрчил ажиглагдав. Эм тарианы төсөв бага, зарим хэвтрийн асруулагчид өөрсдийн мөнгөөр эм тариа худалдан авч хийлгэж байна. Гэтэл төсөв бага, хүрэлцэхгүй байна гэсэн боловч жилийн эцсийн тайлангаас харахад 8810 төгрөг хэмнэсэн гэсэн үзүүлэлт байгаа юм. Эм тариа худалдан авсан болон зарцуулсан баримт, асруулагчидтай хийсэн ярилцлагаас үзэхэд зарлагын баримт, санхүүгийн баримтын маягтыг гараар үйлдсэн, үйлчлүүлэгчид олгосон эмийн картад тухайн үйлчлүүлэгчийн гарын үсгийг хуурамчаар үйлдсэн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Асруулагч Ч.Б.: Эм тариа тэр бүр авч чаддаггүй. Ядаргааны эм тариа хэрэгтэй.

Асруулагч Д.Х., Т.Г.: Эмийн фонд байхгүй, эм тариа дутагдалтай байдаг.

Асруулагч Г.Ү.: Эмнэлэгт хэвтэж, 3 эм бичүүлсэн боловч одоо хүртэл авч чадаагүй. Эмнэлэгт хэвтэхэд эргэлт байдаггүй байсан.

Асруулагч О.О.: Хэвтрийнх болохоор их л олон эм тариа хэрэгтэй байна. Өөрийн мөнгөөр гуйж авдаг. Эмч, эмчилгээ, эм 3 хэрэгтэй байна.

*Оршуулгын үйл ажиллагаанд хийсэн мониторингийн нэгтгэл,
илрүүлсэн зөрчилтэй асуудлууд*

Асрамжийн газарт асруулагч нас барсан тохиолдолд асрамжийн газрын ажилтнууд, асрагч, эмч, манаач нар талийгаачийг оршуулах ажлыг зохион байгуулан ажилладаг. Оршуулгын үйл ажиллагааг зохион байгуулахад хөрөнгө санхүү, хүн хүчний хүндрэл их байдаг. Ялангуяа өвлийн цагт газар хөлдүү үед газар ухах ажил хүндрэлтэй байдаг байна. Мониторинг хийсэн асрамжийн газрууд нас барсан асруулагчийг бусдын адил оршуулдаг бөгөөд асруулагчдад зориулан цагаалгын ажлыг ч мөн зохион байгуулдаг.

Оршуулгын нормативт зардлын хүртээмж:: Асрамжийн газруудад тулгамддаг асуудлуудын нэг нь нас барсан үйлчлүүлэгчийг оршуулах асуудал байдаг. Улсын нийгмийн халамжийн газрын даргын 1999 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан асрамжийн газарт нас барсан асруулагчийг оршуулах зардлын дундаж хэмжээ 24700 төгрөг байдаг ба энэ нь оршуулгын зардалд хүрэлцдэггүй. Мониторинг хийсэн 2 асрамжийн газрын хувьд оршуулгын ажиллагаанд 110000-130000 төгрөг зарцуулдаг байна. Үүнийг нийгмийн халамжийн сангаас гаргадаг. Бодит байдал дээр нэг модон хайрцаг 60000 төгрөг байдаг бөгөөд асрамжийн газрууд өөрсдийн нөөц бололцоонд түшиглэн 110000-150000 төгрөгийг нас барсан асруулагчийг оршуулах ажиллагаанд зарцуулдаг.

ДҮГНЭЛТ

Мониторингийн баг нь мониторингийн эхний шатанд мониторинг хийсэн Дорнод, Баянхонгор аймгууд дахь улсын асрамжийн газруудын талаарх үндсэн мэдээллүүдийг цуглуулах, асрамжийн газрууд улсын нийгмийн халамжийн газрын даргын 1999 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн тушаалын 2, 3, 4, 5, 6 дугаар хавсралтуудаар тогтоосон үйлчилгээнүүдийн норм нормативууд, түүнийг хэрхэн дагаж мөрдөж, ажил үйлчилгээгээ зохион байгуулж, хэрэгжүүлж байгааг үнэлэх зорилготойгоор дээрх 2 асрамжийн газарт ажиллалаа.

Бид холбогдох шатны байгууллагуудаас асрамжийн газруудын үндсэн мэдээллийг бүрдүүлж, хууль эрх зүйн орчны хувьд дотоод, гадаад орчинтой холбоотой дагаж мөрдөгддөг эрх зүйн хэм хэмжээний хүрээнд авч судалж, 1999 онд батлагдсан норм норматив нь цаг хугацааны хувьд, чанар, хүртээмж, үнэ тариф, зохион байгуулалтын хувьд одоогийн бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байгааг хэд хэдэн учир шалтгаанаар тайлбарласан. Иймд энэхүү норм нормативыг холбогдох дээд байгууллагын зүгээс дахин нягтлан үзэж, хууль эрх зүйн хүрээнд нь шинэчлэх шаардлагатай байна.

Асрамжийн газрууд дахь норм нормативын хэрэгжилтэд мониторинг хийх, мэдээлэл цуглуулах үндсэн үйл ажиллагааны нэг нь асрамжийн газрын удирдлага, асруулагч, мэргэжлийн байгууллага гэсэн 3 үндсэн субьектээс норм нормативын бодит хэрэгжилтэд өөр өөрийн гэсэн мониторинг санал, дүгнэлт гаргуулж, нэгтгэн дүгнэж, харьцуулалт хийх ажиллагаа байв. Энэ ажлын хүрээнд норм, нормативаар олгогдох хоол хүнс, хувцас хэрэглэлийн хангалт, эм тариа, оршуулгын үйлчилгээний чанар, хүртээмж гэх мэт асуудлуудыг хөндөж, байж болох боломжуудыг нэгтгэсэн кэйс маягыг боловсруулж, ярилцлага, ажиглалт, бодит нөхцөл байдалд мониторинг хийх зэрэг аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж, мониторинг хийсэн.

Нийт 35 асруулагч, 2 асрамжийн газрын удирдлага, 4 мэргэжлийн байгууллагын санал дүгнэлтийг гаргуулж нэгтгэсэн. Энэхүү мониторингийн ажлын үр дүнд асруулагчдад олгож буй хоол хүнсний чанар, орц, найрлага, илчлэг чанар төдийлөн сайн бус, асруулагчдын сэтгэл ханамж доогуур, үйлчилгээний эрүүл ахуй хангалтгүй, асруулагчдын хэрэгцээнд тохирдоггүй, хувцасны хувьд асруулагчдын хэрэгцээнд үл нийцсэн, чанар муутай, хуучин, эдэлгээт хугацаанд тохирдоггүй, улиралд тохирсон гутал, хувцасны хэрэгцээ их, ариун цэврийн хэрэглэлийн хувьд нүүр гарын саван, алчуурнаас өөр зүйл олгогддоггүй, асруулагч нарт оо, сойз бусад хэрэглэлүүд зайлшгүй хэрэгтэй, зөөлөн эдлэл, хөнжил, гудас, матрасны хувьд шинэчлэх шаардлагатай, анх асрамжийн газар байгуулагдсанаас хойш огт солиогүй ор, дэрний даавууны олголтын тоог нэмэгдүүлэх шаардлагатай, ихэнх асруулагч 1 ээлжийн хэрэглэлтэй байгаа гэх мэтчилэн олон тулгамдсан асуудлууд байгааг олж харсан. Түүнчлэн оршуулгын зардлын хувьд бодит нөхцөл байдалд гарч байгаа зардалтай нийцдэггүй нь ажиглагдлаа.

Дээрхээс дүгнэхэд асруулагчдад олгож буй нормативт эд зүйлс, хоол хүнс, үйлчилгээг нормчлох бус хувь хүний хэрэгцээнд суурилсан хэлбэрээр зохион байгуулах нь илүү үр дүнтэй, төсөв, мөнгө хэмнэсэн, үйлчлүүлэгчийн эрхийг хангасан, тэдний хэрэгцээнд нийцсэн үр дүнтэй үйл ажиллагаа болох юм. Мониторингийн ажлын нэг чухал зорилт бол норм нормативийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарч буй зөрчилтэй асуудлуудыг илрүүлж, тэдгээрийн учир шалтгаан, үр нөлөөг тодорхойлох явдал юм.

Дорнод, Баянхонгор аймаг дахь улсын асрамжийн газруудын хувьд нийтлэг зөрчил дутагдлууд их байсан. Хоол хүнсний илчлэг чанар алдагдсан, асруулагчдад өгөөж муутай, хүнсний баталгаат чанар муу, хадгалалт горимын дагуу бус, бараа материал худалдан авч, зарцуулах санхүүгийн үйл ажиллагаа зөрчилтэй, асруулагчийн эрх ашиг, хэрэгцээ сонирхлыг үл харгалзан үйлчилгээг хүргэдэг, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангахгүй хоол хүнс, хувцас хэрэглэл олгож, норм норматив зөрчсөн гэх мэтчилэн олон зөрчил дутагдлуудыг илрүүлсэн. Түүнчлэн Дорнод аймгийн хувьд нас барсан хүний хувцас, хэрэглэлийг бусдад шилжүүлж олгох тохиолдол гарсан байна. Норм нормативт үйлчилгээтэй холбоотой дээрх зөрчил дутагдлууд үүсэх болсон шалтгааныг дараах байдлаар тайлбарлаж болох юм.

- Улсаас тогтоосон норм норматив нь бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байна. Жишээлбэл, норм нормативт тусгаснаар 1 асруулагчид хоногт 1046 төгрөгийн хоол хүнсний зүйл олгох ёстой боловч эдгээр бүтээгдэхүүнийг өнөөдрийн зах зээлийн ханшаар тооцоход 1634 төгрөг болж байгаа бөгөөд зөрүү болох 588 төгрөг нь асруулагчид авах ёстой хоол хүнснийхээ 2/3-ийг дөнгөж авч байна гэсэн үг юм. Энэ байдал хувцас хэрэглэл болон эм тариа, оршуулгын зардал дээр хүртэл давтагдаж байна.
- Дээрх зөрчил дутагдлууд үүсэх нэг шалтгаан нь асрамжийн газрын ажил үйлчилгээ, санхүүгийн үйл ажиллагаа болон ажилтнуудын ажлын гүйцэтгэлд тавих хяналт байдаггүй. Тухайлбал ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт ажлын байрны дотоод дүрэм журам мөрдөгддөггүй. Асруулагчидтай хийсэн кэйс ярилцлагаар хөндөгдсөн нэг чухал асуудал бол асрамжийн газрын ажилтнуудын харилцаа холбоо, ажил үйлчилгээ, зан байдалтай холбоотой гомдол хүсэлтүүд их байсан. Түүнчлэн бараа бүтээгдэхүүн худалдан авсан болон зарцуулсан баримтад хийсэн мониторингоос харахад баримтыг хуурамчаар бүрдүүлсэн, стандартын бус маягт үйлдсэн, зах зээлийн үнээс дээгүүр ханшаар үнэлсэн зэрэг ажилтнуудтай холбоотой зөрчлүүд их байсан.
- Асруулагчдын эрхийг зөрчсөн хандлагууд нь норм нормативт үйлчилгээний зохион байгуулалт муутай байдалтай холбоотой юм. Жишээлбэл, шинээр ирсэн асруулагчид нормативын дагуу шинэ гудас, матрас, хөнжил, ор дэрний даавуу олгох ёстой байтал Дорнод аймагт хүний өтгөн шингэнтэй

холилдсон гудас өгсөн, түүнчлэн нас барсан хүний хувцасыг олгосон, асруулагчид олгох ёстой хоол хүнсний зүйл хангалттай олгогдохгүй байгаа зэрэг асруулагчийн эрхийг зөрчсөн асуудал гарсан байна. /Асруулагч Л.Сумьяагийн 2005 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Хүний эрхийн Үндэсний комиссын Дорнод аймаг дахь зөвлөлд гаргасан гомдол/

Дээрх зөрчил дутагдлуудыг арилгахын тулд асруулагч нарын эрхийг хүндэтгэсэн, хэрэгцээ, сонирхолд нийцсэн үйлчилгээг үзүүлэх, асрамжийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, ажилтнуудын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт, дотоод дүрэм, журмыг мөрдөж ажиллах зайлшгүй шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Өнөөдөр дэлхийн улсуудад, ялангуяа өндөр хөгжилтэй Ази, Европын орнуудад насжилт их байгаатай холбоотойгоор тэдгээрт зориулсан үйлчилгээ олон янзын төрөл хэлбэрээр хөгжиж байна. Хөгжлийн гол үндсэн тулгуур зарчим нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж, асрамжийн үйлчилгээ, урт, богино хугацаат мэргэжлийн асрах төвүүд, өдөр өнжүүлэхболон нөхөн сэргээлтийн төвүүд гэх мэт олон төрөл хэлбэрээр хөгжиж байгаа бөгөөд эдгээр нь бүгд тус тусдаа тохирсон стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Сүүлийн үед ихэнх үйлчлүүлэгчид урт хугацаат, тусгайлсан асрамжийн үйлчилгээ авахаас татгалзаж, гэрийн нөхцөлд нийгэм, хамт олны дунд амьдарч үйлчилгээ авах сонирхол нь илүү давамгайлж, дийлэнх улс орнуудад төвлөрсөн, хуаранчилсан урт хугацаат үйлчилгээнээс аль болох татгалзаж, нийгэм хамт олон дунд нь хэрэгцээт нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна.

Саяхан батлагдаж, энэ оны 7 дугаар сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн Нийгмийн халамжийн тухай шинэ хуулинд дээрх хандлагуудыг эрх зүйн орчинд нь нилээн сайн тусгасан хууль боллоо гэж үзэж байгаа. Гэхдээ хэрэгжүүлэх явцад нилээдгүй бэрхшээлтэй тулгарахаар байна. Хамгийн гол нь хуулийн зүйл заалтуудыг иргэд сайн ойлгож хандах нь чухал. Энэ хуулинд зааснаар асрамжийн үйлчилгээний төвлөрсөн, хуаранчилсан байдлыг багасгах, стандарт бүхий сайн үйлчилгээ хөгжих боломж бүрдсэн гэж хэлж болно. Тухайлбал, хүүхэд, өндөр настныг гэртээ асрамжлах нөхцөлд мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ бий болох боломж бүрдлээ. Мөн олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний хүрээнд нийгэм, хамт олон дунд асрамжаас гарсан үйлчлүүлэгчид нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ авах боломжтой болсон гэж хэлж болно.

Үйлчилгээний стандартын хувьд өнөөдөр яг барьж ажиллах батлагдсан стандартгүй явж байгаа. Харин төрөөс иргэдэд үзүүлэх асрамжийн үйлчилгээний суурь хууль нь Нийгмийн халамжийн тухай хууль, түүний дагалдах баримт бичгүүд болох Асрамжийн газрын үлгэрчилсэн дүрэм, Асрамжийн газарт хөдөлмөр эмчилгээг зохицуулахад баримтлах журам, УНХГ-ын даргын 1999 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн тушаалын 2, 3, 4, 5 дугаар хавсралтуудаар баталсан хоол, хувцас хэрэглэл, эм, тариа, оршуулга, хүүхдийн хичээлийн хэрэглэлийн зардлуудын нормативуудыг тогтоож тэдгээрийг мөрдөн ажиллаж байна. Харин одоо хэрэгжиж байгаа шинэ хуулийн хүрээнд саяхан асрамжийн үйлчилгээг хөгжүүлэх Засгийн газрын хөтөлбөр батлагдлаа. Түүнчлэн асрамжийн үйлчилгээний стандартуудыг батлан гаргах бэлтгэл ажил хийгдэж байна.

Мониторингийн ажлын үр дүнд үндэслэн асрамжийн үйлчилгээний бодлого боловсруулагчид болон хэрэгжүүлэгчдэд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам /НХХЯ/-д илгээх зөвлөмж

Асрамжийн үйлчилгээ нь төрөөс үзүүлж байгаа халамжийн үйлчилгээний нэг төрөл болохын хувьд шинэ нөхцөл байдлаар хөгжиж төлөвших нь чухал байна. Ингэхийн тулд шинээр мөрдөгдөж буй Нийгмийн халамжийн хуулийн хүрээнд түүний дагалдах бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх явцдаа хэд хэдэн асуудлуудын хүрээнд ажиллах шаардлагатай юм. Тухайлбал, асрамжийн үйлчилгээний стандартыг нэн тэргүүнд гаргаж мөрдүүлэх, асрамжийн үйлчилгээг нормчлох бус, асруулагчдын онцлог хэрэгцээнд нийцүүлсэн байдлаар зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж хийх нь чухал байна.

Улсын Хөдөлмөр, Халамж, Үйлчилгээний Газар /УХХҮГ/-т илгээх зөвлөмж

Асрамжийн үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчийг хүлээн авдаг, буцаах тогтолцоог оновчтой болгож асрамжийн үйлчилгээг төрөлжүүлж ангилах, асрамжийн үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын хувьд хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг анхааран үзэж, мэргэшсэн ажилтнуудаар хангах, асрамжийн газруудын бие даасан статусыг баталгаажуулж, тэдгээрт тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, асруулагчдын амьдарч буй орон байрны нөхцөл, амьдрах тав тухтай орчныг сайжруулахад зориулсан дорвитой хөрөнгө оруулалтыг үр ашигтайгаар хийх, асрамжийн үйлчилгээний чанар хүртээмж, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт, мониторингийг сайжруулах хэрэгтэй.

Мониторинг хийсэн Баянхонгор, Дорнод аймгуудын асрамжийн газарт илгээх зөвлөмж

Асрамжийн үйлчилгээнд үйлчилгээ авах боломжгүй асруулагчид, тухайлбал залуучууд, гэр бүл, өөрсдийн хүсэлтээр нийгэм, хамт олон дунд гарч амьдрах

хүсэлтэй асруулагчдыг нийгэм хамт олон руу хөгжлийн төлөвлөгөөний дагуу гаргаж нийгэмшүүлэх гээд маш олон ажлуудыг хийх шаардлагатай байна.

Асруулагчдын эрх ашиг, сонирхлыг хүндэтгэсэн асрамжийн үйлчилгээг төлөвшүүлэн ажиллах, асруулагчдыг зохих журмын дагуу хөдөлмөр эрхлэх, нийгэм, хамт олон дунд бие даан амьдрах чадварыг эзэмшүүлэхэд анхаарч ажиллах, асруулагчдын нөөц бололцоог эерэгээр ашиглах оновчтой, үр дүнтэй зохион байгуулалтыг хийх шаардлагатай байна.

Нийгмийн халамж–Хамтын ажиллагаа сан

Нийгмийн халамж-Хамтын ажиллагаа сан /НХХАС/ нь 2002 онд байгуулагдсан, нийгмийн халамж үйлчилгээний чиглэлийн төрөл бүрийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тухайн салбарт ажиллаж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ, зөвөлгөө өгөх, сургалт хийх чиглэлээр ажилладаг, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /ТББ/ бөгөөд үйл ажиллагааны гол зорилго нь “Бусдын төлөө” байгууллага байж, үндэсний сайн дурынхны оролцоотойгоор нийгмийн халамж үйлчилгээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар эмзэг бүлгийн иргэдийн эрсдэлийг бууруулж тэдгээрийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх явдал юм.

Мониторингийн төслийн багийн бүрэлдэхүүн

| | |
|------------------------------|---------------|
| Төслийн удирдагч | Р.Олонбаяр |
| Төслийн менежер, халамж зүйч | Э.Эрдэнэцэцэг |
| Мэдээллийн ажилтан | Э.Дөлгөөн |
| Туслах ажилтан | М.Отгонтуяа |
| Ажиглалтын ажилтан | Б.Жалмаа |
| Ажиглалтын ажилтан | Н.Болормаа |

Товчилсон нэр

| | |
|-------|--|
| ЗГ | Засгийн Газар |
| НХХЯ | Нийгмийн Хамгаалал Хөдөлмөр Яам |
| ЭМЯ | Эрүүл Мэндийн Яам |
| УХХҮГ | Улсын Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Газар |
| ХХҮХ | Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Хэлтэс. |
| УНХГ | Улсын Нийгмийн Халамжийн Газар |
| СХҮТ | Стандарт Хэмжил зүйн Үндэсний Төв |
| ХСҮТ | Хоол Судлалын Үндэсний Төв |
| ЭММХГ | Эрүүл Мэндийн Мэргэжлийн Хяналтын Газар |
| НХҮТ | Нийгмийн Халамж Үйлчилгээний Төв |
| МХА | Мэргэжлийн Хяналтын Алба |
| УМХГ | Улсын Мэргэжлийн Хяналтын Газар |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |
| АГ | Асрамжийн газар |
| НД | Нийгмийн Даатгал |
| ДНБ | Дотоодын Нийт Бүтээгдэхүүн |
| СЭКЭ | Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлэг |
| НАБ | Нийтээр Амьдрах Байр |

| | |
|-------|--|
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ЗД | Засаг дарга |
| СЭЗЯ | Санхүү Эдийн Засгийн Яам |
| НХСХХ | Нийгмийн Хамгааллын Салбарын Хөгжлийн Хөтөлбөр |
| ХЭҮК | Хүний эрхийн Үндэсний Комисс |
| ЭАХС | Эрүүл ахуй халдвар судлал |
| АГ | Асрамжийн газар |

Ном зүй

1. НХХЯ, “Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг, ” УБ 2003 он.
2. НХХЯ, “Засгийн газраас нийгмийн хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ,” УБ 2005 он.
3. НХХЯ, “Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын мөрдөх үлгэрчилсэн дүрэм,” УБ 2005 он.
4. НХХЯ, “Төрөлжсөн асрамжийн хөтөлбөр,” УБ 2004 он.
5. НХХЯ, “Асрамжийн газрын үлгэрчилсэн дүрэм,” УБ 1999 он.
6. УИХ, “Монгол Улсын Нийгмийн Халамжийн тухай Хууль,” УБ 1999 он.
7. УНХГ, “Насжилтын асуудлаархи үндэсний стратеги,” УБ 2002 он.
8. С.Баярсайхан, “Нийтийн хоолны газрын хөдөлмөр хамгаалал, аюулгүйн техникийн талаар хийх зөвлөмж,” УБ 2003 он.
9. Ч.Дагвадорж, “Нийгмийн хамгаалал,” УБ 2004 он.
10. Г.Далайжамц, “Эмзэг бүлгийн эрхийн талаархи үндэсний болон Олон Улсын стандарт, хууль тогтоомжийн эмхтгэл,” УБ 2004 он.
11. Жейн, Пемброук, “Мааньтийн сэтгэцийн эмнэлгийн хүүхэд, Залуучуудын мониторинг ба асрамжийн үзлэг шалгалт,” УБ 2003 он.
12. Козлов, “Хилийн чанад дахь нийгмийн ажил,” УБ 2002 он.
13. АХИС, “Нийгмийн ажил” кейс менежмент ба үйл явцын тэмдэглэл, УБ 2003 он.
14. Т.Амаржаргал, “Нийгмийн ажлын технологи,” УБ 2003 он.
15. УА, БНУС, “Хүн ам зүй шилжих хөдөлгөөн, ядуурал тогтвортой хөгжил,” УБ 2003 он.
16. ЭМЯ, “Орчны эрүүл мэндийн холбогдолтой хууль тогтоомжийн эмхтгэл,” УБ 2004 он.
17. ЭМЯ, “Ахмад настны эрүүл мэндийн нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөр хэрэгжилт,” УБ 2002 он.
18. МУ-ын төрийн албаны зөвлөл, НҮБХХ, “Нийгмийн аудит: Монгол улсын туршлагаас,” УБ 2005 он.
19. МУ-ын төрийн албаны зөвлөл, “Нийгмийн аудит /Гадаадын зарим орны туршлагаас/,” УБ 2005 он.

Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэгүй олгох эд зүйлийн хүртээмж, олголтын байдалд хийсэн мониторингийн “Халамж үйлчилгээ” төсөл

Төслийн зорилго:

Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэгүй олгодог эд зүйлийн олголт, хүртээмжийн асуудалд мониторинг хийх.

Төслийн зорилт:

Олгогдож байгаа эд зүйлсийн чанар хүртээмжийг сайжруулах, ажиллагааны явцад гарч байгаа хүндрэл бэрхшээлүүдээс гарах арга замыг эрэлхийлж, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

Мониторингийн үндэслэл

Өнөөгийн нөхцөлд манай улс оронд хөгжлийн бэрхшээлтэй, тэр тусмаа зорчих бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэд хүссэн газраараа чөлөөтэй явж, нийгмийн амьдралд өөрийн дураар оролцох боломжгүй, тэдний хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн дэд бүтэц байхгүй, төр захиргаа, олон нийтийн үзвэр үйлчилгээний газрууд тэдний асуудлуудыг орхигдуулсаны улмаас хязгаарлагдмал нөхцөл байдалд амьдрахаас өөр аргагүй байдал үүсээд байна.

Нэгэн жишээ дурдахад Бүх Хятадын зэрэмдэгийн холбооны ерөнхийлөгч Дэн Пү Фангийг Монголд ажиллах үеэр Засгийн газрын ордонд оруулах гэхэд хаалгаар нь багтахгүй байсан учир тэргэнцэрийнх нь дугуйг салгаж оруулж, гаргаж байсан нь хүний эрхийг бүдүүлгээр зөрчиж байгаагийн баримт юм. Эдгээр нөхцөл байдлаас үүдэн зорчих бэрхшээлтэй иргэд олон нийтийн газар явах, төрөл бүрийн үзвэр үйлчилгээ, нийгмийн амьдралд тэгш эрхтэй хамрагдан оролцох боломж хязгаарлагдмал байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд өөрсдөө “Тахир дутуу хүний барилгын стандарт, норм, норматив”-ийг санаачлан батлуулсан боловч зохих шатны байгууллагууд дэмжиж хэрэгжүүлэхгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан комисс байгуулагдан ажиллахгүй байгаа зэргээс тэргэнцэртэй иргэдээс шаардаж буй стандартад нийцэхгүй, буруу хийцтэй, ашиглах боломжгүй, хөрөнгө дэмий үрсэн ажлууд хийгдэж байна.

Ийнхүү мониторинг хийх болсон шалтгаан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын нөхцөл байдлаас урган гарсан бөгөөд бидний өдөр тутмын байнгын хэрэглээ, *Нүд, Чих, Хөл*-ийг орлож, амьдралд тохиолдсон бэрхшээлийг хөнгөвчилж байдаг эд зүйлс бидэнд ямар нөхцөл байдлаар, хэрхэн олдож, ямархуу чанар эдэлгээтэй, хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаа, цаашид чанар, хүртээмжийг сайжруулах, энэхүү үйл ажиллагаатай холбогдон гарах арга замыг хялбар дөхөм болгох, түүнд нь хэрэглэгч бидний дуу хоолой яаж нөлөөлөх, зохих газруудтай хамтран ажиллах ямар боломж байгааг эрэлхийлэх явдал юм. Оролцооны аргаар хийсэн энэхүү мониторингийн гол зорилго нь төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэж байгаа халамж үйлчилгээний нэг хэсэг ямархуу байдалтай байгааг судалж, олж авсан мэдээллийг холбогдох газар, олон нийтэд түгээхэд оршино. Энэ нь Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Хэлтэс /ХХҮХ/-үүдийн ажиллагаанд үнэлэлт өгч байгаагаараа онцлог юм.

Төслийн хамарсан хүрээ, хугацаа, байршил

2005 оны 12 дугаар сараас 2006 оны 8 дугаар сар хүртэл, 8 сарын хугацаанд нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Налайх дүүргийг хамран ажилласан.

Мониторингийн аргачлал

Энэхүү судалгаанд анкетын, фокус бүлгийн ярилцлагын аргууд, тоон болон чанарын судалгааны аргуудыг тус тус ашиглав. Судалгааны мэдээлэл цуглуулах ажил үндсэн 2 хэсгээс бүрдэнэ.

Уг судалгаанд стратеги болон бодлого боловсруулахад санал нь төдийлөн тусч чаддаггүй зорчих бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэдийг зорилтот бүлгийн ярилцлагад оролцуулсан.

Зорилтот бүлгээс анкетын аргыг ашиглан зориудын, санамсаргүй түүврийн аргаар мэдээлэл цуглууллаа. Санал асуулгын анкет нь хаалттай болон хагас хаалттай асуултуудаас бүрдсэн. Үүнд:

- Судалгааны үндсэн мэдээлэл буюу нас, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт, гэрлэлтийн байдал,

- Өрхийн ам бүл, сарын дундаж орлого, өөрийн гэрт амьдардаг эсэх,
- Төсөл болон бусад байгууллагаас тусламж дэмжлэг авч байсан эсэх,
- Нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй байдал,
- ХХҮХ болон дүүрэг, хороодын халамжийн үйлчилгээ, халамжийн байгууллагын ажилчдын иргэдэд үйлчилж буй байдал.

Мөн чанарын судалгааны аргыг ашиглан асуулгын судалгааны мэдээллийг дэлгэрэнгүй болгох, асуулгын судалгаанд орхигдсон байж болох мэдээллийг олж авах зорилгоор фокус бүлгийн ярилцлага зохион байгуулав. Үйл ажиллагаа, холбогдох зүйлсийг фото зургаар баримтжуулсан болно.

Мониторинг хийхэд баримтлал болгосон холбогдох хуулийн заалтууд

- Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-ын Ерөнхий Ассамблейн 48 дугаар чуулганаар баталсан Тахир дутуу хүмүүст Тэгш боломж олгох стандарт дүрэм /1993 оны 12 дугаар сарын 20-ны 48/96 тоот тогтоол/
- Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалын тухай хууль /1995 он/
- “Ази, номхон далайн бүсийн тахир дутуу иргэдийг дэмжих 10 жил” 2003-2012 Ази, номхон далайн бүсийн тахир дутуу иргэдийн бүрэн оролцоог хангасан, саад тотгоргүй, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх талаарх үйл ажиллагааны “Бивакогийн мянганы хөтөлбөр”
- Тахир дутуу иргэдийн эрх, аж байдлыг хамгаалах, дэмжих зорилго бүхий олон улсын цогц конвенцийн асуудлаарх “Бээжингийн тунхаглал” /2003 оны 11 дүгээр сарын 7/
- Тахир дутуу иргэдийн хэрэгцээнд нийцсэн, эрүүл орчинг цаг тухайд нь бий болгох талаарх “Бангкокийн тунхаглал”

Эдгээр хөтөлбөр тунхаглалуудыг манай улс хүлээн зөвшөөрсөн боловч хэрэгжүүлэх шатандаа хариуцлагагүй, идэвхгүй хандсаар байна.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Мониторингийн ажлын хүрээнд хийсэн ажиглалтаар халамж үйлчилгээ, хорооны ажилтнууд, өрхийн эмч, нар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ/-тэй хайхрамжгүй, үл тоомсорлосон, хөндий хүйтэн байдлаар харьцаж, хүнд суртал, хөшүүн хойрго, ихэмсэг зан гаргаж байгаа нь иргэдийг бухимдуулдаг болох нь илэрхий байв.

Төрийн үйлчилгээ хариуцсан ажилчид ХБИ-дэд хэрхэн ханддаг тухай анкетын асуулгаар судалж үзэхэд ХХҮХ-ийн ажилчид ХБИ-тэй жирийн хүмүүсийн адилаар ханддаг гэж 60 хувь нь хариулсан бол 8 хувь нь жирийн хүмүүсээс илүү анхаарал тавьж ханддаг, 15 хувь нь хааяа гадуурхах үл тоомсорлох байдлаар ханддаг, 2 хувь нь үргэлж гадуурхах үл тоомсорлох байдлаар ханддаг гэжээ.

Түүнчлэн бүрдүүлэх материалын жагсаалт, ажлын хуваарь, зохицуулалт тодорхой бус, холбогдох байгууллагуудын ажлын уялдаа муугаас иргэдийг дахин дахин явуулж чирэгдүүлдэг байна.

Үйлчилгээ хэр шуурхай явагддаг талаар тандаж үзэхэд, ХХҮХ-ээс тусгай хэрэгслийн тусламж авахад олон тооны бичиг баримт бүрдүүлэх шаардлага гардаг, гол нь ХХҮХ-ийн ажилчид ХБИ болон жирийн иргэдийг олон удаа явуулж хүндрэл чирэгдэл учруулдаг байна. ХБИ нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахын тулд:

1. Холбогдох иргэний бичиг баримтаа бүрдүүлэн, өргөдлөө бичиж, хорооны засаг даргаар цохолт хийлгэж тодорхойлуулна,
2. Өрхийн их эмчийн магадлагааг үндэслэн групп тогтоолгоно,
3. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар орно,
4. Дүүргийн ХХҮХ-т баримтуудаа бүрдүүлэн өгөх гэх мэт нилээн байгууллагын олон шат дамжлагыг туулж байж төрөөс үнэгүй олгогдох эд зүйлийг авах эрх нээгддэг.

Гэвч халамж үйлчилгээнд хамрагдахын тулд ийм бичиг баримтуудыг ямар шат дарааллаар бүрдүүлж, долоо хоногийн аль өдөр хурлаар хэлэлцэн шийдвэрлэх тухай заавар, журмаа үйлчлүүлэгч иргэдийн нүдэнд ил харагдах газар байрлуулсан байгууллага харагдсангүй. Энэ нь шинээр ирж байгаа иргэдэд ойлгомжгүй тул дугаарлан үйлчлүүлж байгаа хүмүүсийн дундуур зүтгэн ажилтан, ажилчдаас асууж чирэгдэл үүсгэн төрийн үйлчилгээний ажилчдын ажилд саад учруулдаг байна.

Нэг, хоёр удаагийн явалтаар энэ бүхэн бүтчихгүй тул олон дахин явах шаардлага гардаг. Үүнд ХБИ тэр бүр өөрөө явж чадахгүй, гэр бүлийнхэн болон бусдын ажлын зав зайг харан байж тэдний дэмжлэг тусалцаатайгаар явахад /тэргэнцэртэй хүнд үйлчлэх лифттэй автобус улсын хэмжээнд байхгүй тул ХХҮХ, хороо, өрхийн эмнэлэгрүү таксигаар хүргүүлдгээс нэмэгдэл зардал

их гардаг/ ихэнх ХХҮХ-үүд автобусны буудлаас зайтай, буудлаас ХХҮХ хүрэх зам бартаа саад ихтэй ХБИ явахад хүндрэлтэй, зориулалтын зам, дэд бүтэц байхгүй учир хүнээр үүрүүлж, түшүүлж, урт удаан цаг хугацаа зарцуулан явж очлоо гэхэд үүдний шат довжооноос эхлээд саад бэрхшээл мундахгүй. Тэдгээрийг даван ороход тэдний асуудлыг шийдэх хүмүүс, дарга нар нь дээд давхарт байрласан байдаг нь харагдлаа. Иймд эдгээр асуудлуудын талаар зохих газруудад хандан асуудал тавихаар төлөвлөөд байна.

Зураг 1. Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс



Зураг 2. 20см өндөр довжоо. Тэргэнцэртэй иргэд бусдын туслалцаагүй энэ байгууллагад нэвтрэх боломжгүй



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн эрүүл мэнд, зорчих, нэвтрэх боломж хязгаарлагдмал, асран халамжлагчийн ажлын ачаалал, зав чөлөө хомс зэргээс шалтгаалан заасан ёсоор 20 хоногийн дотор хөөцөлдөж шаардлагатай зүйлээ авсан иргэн ховор байгаа төдийгүй өргөдөл бичсэнээс хойш 3 сар өнгөрчихөөд байхад ч авч чадаагүй иргэн байгаа нь нийгмийн халамжийн үйлчилгээний заавар журам, ажилтан ажилчдын харьцаа хандлагад шинэчлэл хийж, цаг үеийн шаардлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүнийх нь хувьд хүндэтгэн үзэх үүднээс зөв боловсон харьцаж, хөнгөн шуурхай үйлчлэх соёлтой үйлчилгээг цаг алдалгүй нэвтрүүлэх хэрэгтэй болсныг харуулж байна.

Бидний санал асуулгын хариуд, тусламжийн зүйлс олгохдоо танил талдаа эхлээд өгдөг гэжээ. Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах талаар ХБИ өөр өөрийн санаа бодлыг илэрхийлсэн бөгөөд иргэдэд чирэгдэл гаргалгүй түргэн шуурхай үйлчлэх, санал хүсэлтийн хариуг сар жилээр сунжруулахгүй байх, ХХҮХ-ийн ажилчдын харилцааны соёл, ажлын үр чадварыг нэмэгдүүлэх, дүүрэг, хороонд хүсэлт гаргахад дургүйцдэг хэр нь өгнө, туслана гэж хэлээд л байдаг дээрх үйлдлүүдийг энэ тэргүүнд шийдвэрлэх нь үйлчилгээнд нэгээхэн ахиц гаргана хэмээн ХБИ үзэж байна.

Нийгмийн халамжийн шугамаар олгогдож буй тусгай хэрэгсэл нь ихэвчлэн БНХАУ-ынх байдаг бөгөөд эдэлгээ муутай, хэврэг буюу манай орны нөхцөлд тохиромжгүй, амархан эвдэрдэг, засвар тохиргоо авахдаа муу байдаг. ХБИ-дэд хамгийн хэрэгцээтэй байгаа тусламж дэмжлэг нь эн тэргүүнд мөнгөн тусламж бөгөөд түлшний туслалцааг ихээр хүссэнээс харахад улирлаас шалтгаалсан тусламж хэрэгтэй байдаг нь ажиглагдлаа.

Олон жил тэргэнцэртэй амьдарч байгаа иргэд цаг үеийн шаардлагаар төрөөс олгодог эд зүйлийн жагсаалтад живх, цооролтоос хамгаалах хэрэгсэл зэргийг оруулж олгохыг санал болгож, хүсч байв. Үүнээс дүгнэхэд ХБИ-дэд төрөөс үнэ төлбөргүй олгодог эд зүйлсийн жагсаалтыг тухайн ХБИ-ийн саналыг үндэслэн шинэчлэн тогтоох шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт нь түүхэн соёлтой гүн гүнзгий холбоотой байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй болно гэдэг нь “бурхны хүслээр” юм уу ямар нэгэн муу зүйл хийснээр “тахир дутуу” болдог гэсэн буруу ойлголт давамгайлдаг.

Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдуулан энэхүү буруу ойлголт улам даамжирснаар эдгээр бүлэг хүмүүс нийгмийн сөрөг хандлагатай байнга учирч байна. Түүнчлэн эдгээр хүмүүст үзүүлж буй нийгмийн үйлчилгээнд гомдол зонхилсоор байгаа юм. Үүнд тэргэнцэр, сонсголын хэрэгсэл, таяг болон бусад зайлшгүй олгогдох ёстой хэрэгслүүдийн чанар маш муу байдаг ба тэдний хэрэгцээ шаардлагад нийцдэггүй байна. Дүүргийн зарим нэг алба эдгээр хэрэгслүүдийг олгохгүй, зарим иргэд авдаггүй зэрэг нь эдгээрийн чанар муу байгаатай холбоотой.

Эдгээр хэрэгслүүдийг ихэвчлэн БНХАУ-аас оруулж ирдэг ба чанарын хувьд муу, хэрэглээний хувьд тайван хэрэглэх боломжгүй, богино настай байдаг. Иймэрхүү хэрэгслүүдийг хөгжилтэй орнуудад чанар сайтай үйлдвэрлэдэг ч, харамсалтай нь Монгол Улсын Засгийн газар мөнгөний эх үүсвэр гарган оруулж ирэх боломжгүй юм уу, оруулах шаардлагагүй гэдэг шалтгаанаар хүсдэггүй бололтой. Ихэнхи тохиолдолд эдгээр хэрэгслүүдийг оруулахад шаардагдах нэмэлт ажил, харилцаанаас үүдэлтэйгээр татгалзах нь олонтаа.

Япон, Америк, Европын Холбооноос ирж буй хуучин тэргэнцэрүүд нь Хятадаас оруулж ирж байгаа шинэ тэргэнцэрүүдээс хамаагүй илүү чанартай байдаг нь олон хүний яриагаар нотлогдоод байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй олон иргэд эдгээр орны тэргэнцэр, бусад эд зүйлийг авах хүсэлтэй байдаг. “Төмөр сан”, “Тусламжийн тэргэнцэр сан” ТББ-ууд гаднаас тэргэнцэр оруулж ирж байгаа ч ихэнх тохиолдолд Засгийн газраас дэмжлэг авахад хэцүү байдаг.

ЗӨВЛӨМЖ

Хууль эрх зүйн хүрээнд:

- ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах хууль эрх зүйн орчинд шаардагдах өөрчлөлтийг оруулж, хэрэгжүүлэх механизмийг бүрдүүлэх. Жишээлбэл, тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн халамж үйлчилгээний журамд “Нэн ядуу амьдралтай иргэнд дэмжлэг үзүүлнэ” гэж заасан нь хөгжлийн бэрхшээлтэй олон иргэнийг төрийн халамж хүртэхээс хөндийрүүлж байгаа учир “нэн ядуу” гэсэн заалтыг хасах хэрэгтэй байна.

Халамж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд:

- Халамж үйлчилгээний чиглэлээр ажиллаж байгаа ажилтан, ажилчдын ёс суртахууныг сайжруулан, харьцааны сургалтад хамруулж, хариуцлага тооцдог болох, энэ талаар гарч байгаа гомдлыг барагдуулж, заавар зөвлөгөө өгч асуудлыг шийдвэрлэж байх ХБИ, тэдний байгууллагын төлөөлөл оролцсон “Ёс зүйн хороо”-г бий болгон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам /НХХЯ/, ХХҮГ- т ажиллуулах,
- Дүүрэг бүрийн ХХҮХ, хороо, өрхийн эмнэлгүүд дээр тухайн эд зүйл авахад шаардагдах материалыг бүрдүүлэх дараалал, уг асуудлаар иргэдийг хүлээн авах ажилтны нэр, хаяг, ажиллах цагийн хуваарийг тодорхой бичиж тавих,
- Дүүрэг бүрийн ХХҮХ, хороо, өрхийн эмнэлгүүд дээр тэргэнцэртэй болон зорчих бэрхшээлтэй иргэд чөлөөтэй нэвтрэн орох налуу зам, шат, довжоог шаардагдах стандартын дагуу бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний байгууллагын төлөөлөл оролцсон комиссын шийдвэрийн дагуу ашиглалтад оруулах асуудлыг нэн даруй шийдвэрлэх,
- Тэргэнцэртэй иргэдийг тухайн байгууллагын асуудал шийдвэрлэх удирдах албан тушаалтан дээр саадгүй орох нөхцөлийг бүрдүүлэхэд хүндрэлтэй байвал тэдгээр албан тушаалтнуудыг хамгийн доод давхарт тэргэнцэртэй болон зорчих бэрхшээлтэй иргэд саадгүй нэвтрэн орох боломжтой газар байршуулан, саад багатай нэвтрэх орчинг гол хаалганы ойролцоо схемчлэн зурж, тэргэнцэртэй хүний харааны түвшинд байрлуулах,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үйл ажиллагаа явуулж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Төрийн бус байгууллагуудад чиглэлийнх нь дагуу гэрээний үндсэн дээр эрхтэн орлох, хөнгөвчлөх хэрэгслийг захиалах, олгох, ажлыг гүйцэтгүүлэн, бүх төрлийн татвар хураамжаас чөлөөлж, саадгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, хяналттай ажиллуулах асуудлыг Эрүүл мэндийн яам /ЭМЯ/, НХХЯ-аар шийдвэрлүүлэх,
- Хүн насан туршдаа ганц гутал өмсдөггүй шиг эд эрхтэн орлох, хөнгөвчлөх, туслах хэрэгслийг төрөөс үнэгүй олгохын хажуугаар хувь хүний биеийн өөрчлөлт, өсөлт хөгжилт, санал хүсэлтийг харгалзан сонголт арвинтай хэрэгслийн гадаад захиалга, худалдаа, засвар үйлчилгээг зорчих бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалдаг Төрийн бус байгууллагуудаар гэрээний дагуу гүйцэтгүүлдэг болох,
- Халамж үйлчилгээний журамд өнөөгийн цаг үеийн шаардлагаар өөрчлөлт оруулж, нуруу нугасны гэмтэл, бэртэлтэй хүмүүст зайлшгүй шаардлагатай байдаг хөнгөвчлөх эд зүйлийг нэмж оруулж, гэрээлэн захиалж, олгодог болох талаар судалгаа хийх,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд бүх төрлийн татвар хураамжаас бүрэн чөлөөлөгддөг, хөгжлийн бэрхшээлийн чиглэлийн дагуу эрхтэн орлох, хөнгөвчлөх эд зүйлсээр саадгүй хангагддаг болох.

Төмөр сан

Төмөр сан нь зорчих бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэдийн сурч, хөдөлмөрлөх боломжийг нэмэгдүүлж, тэдний амжиргааны нөхцөлийг сайжруулан нийгмийн бүхий л харилцаанд тэгш эрхтэй хамрагдан оролцох боломжийг дээшлүүлэн, бусад орны туршлага туслалцааг түшиглэн хөгжих зорилгоор тэргэнцэртэй иргэдийн өөрсдийн үүсгэл санаачилгаар байгуулагдсан олон нийтийн төрийн бус байгууллага /ТББ/ юм.

Мониторингийн багийн бүрэлдэхүүн

| | |
|---------------------|---|
| Төслийн удирдагч: | П.Төмөрбаатар |
| Төслийн зөвлөх: | Б.Энхтуяа |
| Төслийн ажилтан: | Х.Энэбиш, Д.Тунгалагтуяа, Ц.Цогтсайхан, Н.Энхцэцэг |
| Сайн дурын ажилтан: | Д.Даваасүрэн, Т.Номин, С.Эрдэнэчулуун, Х.Сэргэлэн |

Ном зүй

1. Ази, номхон далайн бүсийн тахир дутуу иргэдийн бүрэн оролцоог хангасан, саад тотгоргүй, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх талаарх үйл ажиллагааны “Бивакогийн мянганы хөтөлбөр”
2. НҮБ-ын Тахир дутуу хүмүүст тэгш боломж олгох “Стандарт дүрэм”
3. Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хууль
4. Тахир дутуу иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний тухай журам, ном товхимол ашигласан.

Товчилсон нэр

| | |
|-------|-------------------------------------|
| ХХҮХ | Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Хэлтэс |
| ХБИ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| НҮБ | Нэгдсэн Үндэстний байгууллага |
| НХХЯ | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |

Үгсийн тайлбар

Мэргэжил: тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар дадлын цогц;

Мэргэжил боловсрол: иргэний авъяас, сонирхол, хэрэгцээнд нийцүүлж албан ба албан бус хэлбэрээр эзэмшсэн мэргэжлийн ур чадварын төвшин, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшил;

Мэргэжлийн сургалт: иргэнд тодорхой мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа;

Хөгжлийн бэрхшээлтэй хүн: “Бие бялдар, оюун ухааны чадавх нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг өөрчлөлт, өвчин, тарилгын дараах хүндрэл, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон, хараа, сонсгол, хэл яриа, бие эрхтэн тахир дутуу, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг тахир дутуу хүн гэнэ.¹

¹ “Тахир дутуу хүний нийгмийн хагааллын тухай хууль”

Орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд МОНИТОРИНГ ХИЙХ НЬ

Төслийн зорилго:

Орон нутгийн шүүхийн үйл ажиллагааны хууль ёсны байдал, түүнд оршиж буй хүний эрхийг хохироож байгаа холбогдох дутагдлуудыг илрүүлж, шүүхийн байгууллагуудад нөлөөллийн үйл ажиллагааг хийх замаар уг дутагдлыг арилгах, бууруулах зорилготой.

Төслийн зорилт:

- Орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд дүгнэлт хийх,
- Орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд хүний эрхийг хохирооход нөлөөлж буй хүчин зүйлүүдийг олж тогтоон факт, баримтаар үзүүлэх,
- Гарсан факт, баримтуудыг үндэслэн үйл ажиллагааны доголдож буй хэсэг, үйл явцыг сайжруулах нөлөөллийн үйл ажиллагааг хийх,
- Орон нутгийн шүүхийн шатны үйл ажиллагаанд хийсэн мониторингийн үйл ажиллагааны үр дүнг олон нийт, шүүхийн байгууллагын ажилтнуудад мэдээлэх,
- Мониторингийн үйл ажиллагааны үр дүнг холбогдох иргэний нийгмийн байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглах зэрэг болно.

Мониторингийн үндэслэл

Монгол улсын шүүх нь хууль ёс, хүний эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн. Сүүлийн жилүүдэд Монголын нийгэмд олон нийтийн эрх ашгийг хамгаалах хэрэгцээ ихээхэн тулгамдаад байгаа бөгөөд уул уурхайн компаниудын үйл ажиллагааны улмаас нутгийн иргэдийн эрх зөрчигдөж байгаа асуудлыг ХЭХТ анхааран сонгож, нутгийн иргэдийн эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалан хэрэгжүүлэх үйл ажиллагааг эхлүүлээд байгаа билээ.

Бие даасан, хараат бус, шударга шүүхийн үйл ажиллагаанаас олон нийтийн эрх ашгийг шүүхээр хамгаалах үйл ажиллагааны хувь заяа хамаарч байдаг. Гэтэл орон нутгийн түвшний маргаантай асуудалд стратегийн өмгөөлөл хийх үед орон нутгийн шүүх хуулиа дээдлэж, хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэх нь анхаарал татсан асуудал болсон нь ажиглагдаж байна. Иймд шүүх хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа болж чадаж байгаа эсэхийг нягтлан шалгаж, алдаа дутагдлыг илрүүлэн засах хэрэгтэй бөгөөд ялангуяа орон нутгийн түвшний шүүхийн үйл ажиллагаанд мониторинг хийж, үйл ажиллагааг сайжруулах зайлшгүй хэрэгцээ байна.

Мониторингийн үр дүнд гарсан факт баримтуудыг олон нийт, шүүхийн байгууллагын ажилтнуудад таниулан нөлөөллийн үйл ажиллагааг хийж, орон нутгийн түвшний шүүхийн үйл ажиллагааг сайжруулах ач холбогдолтой тул энэ төслийн саналыг боловсруулан оруулж байна.

Мониторингийн хугацаа, хамарсан хүрээ байршил

Мониторингийн мэдээлэл цуглуулах болон үнэлгээний ажиллагаа нь 2006 оны 1 дүгээр сараас эхлэн 2006 оны 9 дүгээр сар хүртэлх хугацаанд үргэлжилж, Архангай аймгийн сум, сум дундын шүүх, аймгийн давж заалдах шатны шүүх, Захиргааны хэргийн шүүхийн шүүгч нар, шүүхийн мэдээлэл лавлагааны ажилтан, иргэдийн төлөөлөгчид, өмгөөлөгч, прокурор, шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлж байгаа болон тухайн орон нутагт оршин суугч иргэдээс нээлттэй, ганцаарчилсан ярилцлага хийх, анкет асуулга авах, шүүхийн холбогдох баримт бичгүүдэд анализ дүгнэлт хийх, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийн материалыг судлах, шүүх хуралд ажиглагчаар оролцох зэргээр мэдээлэл цуглуулж ажиллалаа.

Мониторингийн аргачлал

Үнэлгээний үе шатанд дараахи судалгааны аргуудаар мэдээлэл цуглуулав:

- Баримт бичигт анализ хийх: Архангай аймгийн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийн материалиудыг уншиж танилцах замаар нийт 61 хавтаст хэрэгтэй танилцсан. Үүнээс иргэний хэрэг 31, эрүүгийн хэрэг 21, захиргааны хэрэг 9-ийг тус тус уншиж, танилцсан.
- Ажиглалт: Орон нутаг дахь мониторингийн багийн гишүүд шүүх хуралдаануудад биеэр оролцон ажиглалт хийв.
- Ярилцлага: 7 шүүгч, 1 нарийн бичгийн дарга, 1 мэдээллийн ажилтан, Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч, 4 прокурор, 6 өмгөөлөгч нартай ганцаарчилсан ярилцлага хийсэн.
- Анкетаар мэдээлэл цуглуулах: Архангай аймгийн 31 иргэдээс анкетийн мэдээлэл цуглуулсан.

Төслийн баг орон нутгийн шүүхийн үйл ажиллагааг үнэлэхдээ дараах асуудлуудыг сонгон судалсан болно.

1. Шүүхийн хамт олон, материаллаг хангамж : ажлын ачаалал, ажилтнуудын чадавх, сургалт, дахин сургалтын асуудлууд, шүүгчийн компьютер, өрөө тасалгаа гэх мэт ажлын байрны хангамжийг үнэлэх,
2. Шүүх үйл ажиллагаанд баримтлах зарчмуудын хэрэгжилт: шүүгчийн хараат бус байдал, шүүхийн үйл ажиллагаан дахь шударга ёсны хэрэгжилт, түүнд нөлөөж буй сөрөг хүчин зүйлүүдийг гаргах, Шүүхийн үйл ажиллагааны зарчмууд нь:
 - Шүүгч гагцхүү хуульд захирагдан дотоод итгэлээрээ (мэргэжлийн ёс зүй-хэнээс ч хараат бус байх) асуудлыг шийднэ.
 - Шүүхийн үйл ажиллагааны мэтгэлцэх зарчим
 - Иргэдийн төлөөлөгчийг заавал оролцуулах зарчим
 - Гэм буруутайд тооцож үл болох зарчим
 - Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим
 - Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчим
3. Шүүхийн үйл ажиллагаанд хуулийг хэрхэн хэрэглэж буй байдал, ялангуяа иргэдийн зөрчигдсөн эрх, эрх чөлөөг хэрхэн сэргээн хамгаалж буй практикийг судлах,
4. Шүүхэд өргөдөл, гомдол хүлээн авах, бүртгэх, гомдол нэхэмжлэлд хариу өгөх үйл ажиллагаа, шүүхийн шийдвэрийг хуульд заасан хугацаанд нь хэргийн оролцогчдод хүргэх үйл ажиллагааны хэрэгжилт.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж, гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдана. Шүүгчийн хараат бус байдлыг Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар баталгаажуулна.

Шүүхийн тухай хууль. 4 дүгээр зүйл

Шүүхийн материаллаг хангамж:

Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

*Монгол улсын Үндсэн хуулийн
48 дугаар зүйлийн 3 дахь хэсэг*

Шүүхийн тухай Монгол Улсын хуульд зааснаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчмуудын нэг нь шүүхийн хараат бус, бие даасан байдлын зарчим юм.

Шүүх нь өөрийн гэсэн байргүй, аймгийн Засаг даргын тамгын газрын байранд /ашиглалтын түрээсээр/ үйл ажиллагаагаа явуулдаг, уг байрны шүүх байрлаж байгаа хэсгийг балансаас балансад авах талаар Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралтай анхны тохиролцоонд хүрсэн бөгөөд, өөрийн гэсэн байртай болох талаар Шүүхийн Ерөнхий Зөвлөлд санал хүргүүлээд байна. Шүүгч, ажилтнууд компьютер, техник хэрэгслээр бүрэн хангагдаж, дотоод сүлжээнд холбогдсоноор шүүхийн ажлыг хөнгөн шуурхай хийх боломж бүрдсэн байна.

Боловсон хүчний сургалт, мэдээлэл авах боломж:

Шүүхийн удирдлагаас шүүгчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар анхаарч байгаа боловч бодитой бодлого, үйл ажиллагаа байхгүй байна. Ярилцлагад оролцсон бүх шүүгчид мэдлэг боловсролоо дээшлүүлэх бололцоо муу, хуулийн өөрчлөлт, шинээр батлагдсан хууль тогтоомжуудын талаарх мэдээллийг цаг хоцорч авдаг тухай хэлж байсан. Тухайлбал, 2 жил ажиллаж байгаа шүүгч энэ хугацаанд зөвхөн 14 хоногийн сургалтад нэг удаа хамрагдсанаас өөр ямар ч сургалт, семинарт оролцоогүй байна.

Шүүгчдийн хувьд шаардлагатай байгаа сургалтуудыг, тухайлбал олон нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах, иргэн, эрүү, захиргааны эрх зүйн сэдвүүдээр зохион байгуулах хэрэгтэй байна.

Ажлын байр, ахуй хангамж, аюулгүй байдалтай холбоотой асуудлууд:

Шүүгчдийн орон байрны асуудал их хүндрэлтэй байна. Ялангуяа шинээр хуваарилагдаж очсон залуу шүүгчдэд энэ асуудал нилээд тулгамдсан шинжтэй байдаг байна. Мөн шүүгчийн амь насны баталгааг энд дурьдах хэрэгтэй.

Шүүгчдийг сүрдүүлэх, заналхийлэх явдал ч гардаг аж. Энэ байдал нь гадны нөлөөнд автах нэг том үндсэн шалтгаан гэж шүүгчид үздэг байна.

Аймгийн засаг даргын тамгын газрын байранд түрээсээр ажиллаж, аливаа мөнгө шаардлагатай үйл ажиллагаандаа аймгийн Засаг даргын дэмжлэгийг авдаг байдал нь нэг талаас шүүхийн бие даасан хараат бус байдлыг алдагдуулах шалтгаан болдог гэж дүгнэж болохоор байна. Учир нь шүүхийн удирдлагуудтай хийсэн ярицлагад аймгийн Засаг дарга, Тамгын газар шүүхэд ямар нэгэн хүсэлт, шаардлага тавих үед аль болох биелүүлэхийг хичээдэг тухайгаа өгүүлж байсан юм. Мөн өмгөөлөгчдийн бүлгээс шүүхийн үйл ажиллагааг үнэлэхдээ “Хэрвээ Засаг дарга, иргэн хоёр нэг хэрэгт орох бол шүүгч нар Засаг даргад үйлчлэх байдал гаргах магадлалтай” хэмээснийг анхаарахгүй орхиж болохгүй юм.

Шүүхийн хараат бус ажиллах эдийн засгийн баталгааг төрөөс хангах тухай Монгол улсын Үндсэн хуулийн заалт Архангай аймгийн шүүхийн хувьд хангалттай хэрэгжихгүй байгаа нь дээрх байдлаас тодорхой харагдаж байна.

Шүүхийн төсөв нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх шаардлагыг бүрэн хангасан байна.

Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

Аймгийн шүүхийн 2006 оны төсвөөс харахад ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, гэрэл цахилгаан, халаалт, цэвэр бохир ус, бичиг хэрэг, шуудан холбоо гэх мэт шүүхийн үйл ажиллагааг тасалчилгүй явуулах төдий ахуйн хэрэгцээг л дөнгөн данган хангахуйц хэмжээтэй байдгаас ном хэвлэл худалдан авах, шүүгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, семинар зохион байгуулах, хууль тогтоомж, шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлахад хүрэлцдэггүй байна. Иймээс сургалт семинар хийж ажилтнуудынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэх ажил орхигдсон дутагдал байна.

Эрх зүйн маргааны төлөв байдал, статистик:

Тус шүүх нь жилд дунджаар 300 шахам эрүүгийн, 800 гаруй иргэний, 150 шахам захиргааны зөрчилд арга хэмжээ авдаг. Тухайлбал: 2005 онд 1077, 2006 оны эхний 5 сарын байдлаар 356 нэхэмжлэл хүлээн авч бүртгэжээ. Дээрх нэхэмжлэлээс 35-ыг хүлээн авахаас татгалзаж 27-г буцаан 275-ыг хугацаанд нь шийдвэрлэсэн, 19 нэхэмжлэлийг шийдвэрлэх шатанд явж байна.

Тус аймгийн шүүгчид өөрсдийн ажлын ачааллыг хэвийн хэмээн үздэг бөгөөд эрх зүйн хэрэг маргааны ээдрээ төвөг бага, төрөл цөөн, ажиллахад хялбар байдаг тул өөрийгөө хөгжүүлэх цаг завтай нөхцөлд ажилладаг гэж дүгнэжээ.

Гэвч шүүхийн байгууллагын ажилтнууд мэдлэг, туршлагаа хөгжүүлэх боломж муу, шинээр батлагдаж байгаа хууль тогтоомж, өөрчлөлтүүдийг хурдан шуурхай авч чаддаггүй, хэвлэл хоцорч ирдэг зэрэг хүндрэлүүд байдаг аж.

Орон нутгийн иргэдийн шүүхэд хандах боломж:

*Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх, үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.
Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 10 дугаар бүлэг*

Хөдөө орон нутгийн иргэд шүүхэд нээлттэй байдлаар хандаж, эрх ашгаа хамгаалуулахад хүндрэл бэрхшээлтэй байдаг хэмээн шүүхийн байгууллагын ажилтнууд үздэг байна. Иргэд ч ихээхэн хүндрэл бэрхшээлтэй учирдагаа өгүүлсэн байна.

Шүүгчид иргэдэд учирч буй хүндрэл бэрхшээлүүдэд:

- иргэдийн эрх зүйн мэдлэгийн түвшин доогуур байдал,
- алслагдмал хол, зам, харилцаа, унаа муу байдлыг дурьдсан бол, өмгөөлөгчдийн бүлэг дээрх 2 шалтгаан дээр иргэдийн төлбөрийн чадваргүй байдлыг нэмжээ.

Хөдөөний хүн шүүхэд нэхэмжлэл гаргахдаа заавал аймгийн төв орж ирэх хэрэгтэй болдог. Гэтэл нотлох баримт дутуу бол эргээд л буцах хэрэгтэй болно. Тэгвэл хөдөө сумдад шуудан, унааны үйлчилгээ их хүндрэлтэй байдаг, мөн иргэдийн эрх зүйн мэдлэг муу байна. Хууль сурталчлах ажил бага байна. Бид хөдөө суманд хэрэг таслах үеэр л хуулийг таниулах ажлыг бага сага хийж байна шүү дээ...

/шүүгчийн ярианаас/

Хөдөөгийн иргэд шүүхэд нэхэмжлэл гаргахад асар бэрхшээлтэй байдаг. Тухайлбал, улсын тэмдэгтийн хураамжаа ч төлөх чадваргүй хүмүүс байдаг. Түүнээс гадна давж заалдах зардал, орон нутгийн алслагдмал байдал зэрэг нь шүүхийн шийдвэрийг давж заалдах боломжгүй болгож байна...

/өмгөөлөгчийн ярианаас /

Хэдийгээр шүүхээс шүүхийг олон нийтэд нээлттэй болгох менежментийг сайжруулах талаар тодорхой үйл ажиллагаануудыг хийж байгаа боловч иргэд шүүхэд хандахад хүндрэл бэрхшээлүүд байсаар л байна. Шүүхэд хандсан иргэдийн 41.9% (13 хүн) шүүхэд хандаж асуудлаа шийдвэрлүүлэхэд амар биш байсан гэж хариулсан бол 16.1% (5 хүн) амар байсан гэж хариулжээ. Иргэд шүүхэд хандахад учирч буй хамгийн гол хүндрэлүүд нь:

- шүүхийн байгууллагуудын ажилтнуудын дээрэнгүй харьцаа (30.7%),
- шүүх дээр учир байдлаа хэлэхэд сонсох хүн байдаггүй (30.7%)
- шүүхэд яаж хандахаа мэддэггүй (23.7%) зэрэг юм.

Нэхэмжлэл гаргахад хүндрэл ихээхэн учирдаг байна. Судалгаанд хамрагдагсдын 71.4% нь хүндрэлтэй гэж хариулсан бол 28.5% нь хүндрэлгүй

гэж хариулжээ. Нэхэмжлэл бичихэд хүндрэлтэй шалтгаануудад:

- яаж бичихээ мэддэггүй 47.8%
- шүүхэд итгэдэггүй 34.7%
- алслагдмал хол байдаг 30.4%
- шүүхээс айдаг 21.7%

зэрэг орсон байна. Үүнээс дүгнэхэд иргэдийн эрх зүйн мэдлэг тааруу байдал, шүүхэд итгэхгүй байгаа хандлагууд ноцтой юм. Тиймээс шүүх энэ хандлагуудыг арилгах, бууруулах талаар ажиллах нь нэн тулгамдсан асуудал болжээ.

Дүгнэлт

Архангай аймгийн шүүх иргэдэд үзүүлж буй шүүхийн үйлчилгээгээ хэвийн явуулдаг байна. Гэвч орон нутгийн шүүхийн хомс төсөв, орон байргүй байдал, мөн шүүгчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх үйл явц системтэй бус, мэдээллийг хурдан шуурхай авч чадахгүй байгаа байдал, мөн шүүгчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх үйл явц системтэй бус, мэдээллийг хурдан шуурхай авч чадахгүй байгаа байдал нь шүүхийн хамт олны чадавхийг бэхжүүлэхэд саад болж улмаар шүүхийн хараат бус байдлыг алдагдуулах нөхцлийг бий болгож олон нийтийн дунд шүүхийн нэр хүндийг унагаж байна.

Шүүгчдийн ажлын байр, утас, орон сууцны хангамж хангалтгүй, сурталтад хамрагдах бололцоо дэмжлэг байхгүй зэрэг хүндрэлүүдийг ноцтой хэмээн үзэж байна. Учир нь хуулийн нарийвчилсан асуудлаар шүүгчид мэргэжлээ дээшлүүлж чадахгүй байх, шүүгчдийн ахуйн асуудал ихтэй байдал нь тэдний хараат бус байдлыг алдагдуулах, нөлөөллүүдэд өртөх нөхцөл болж байгааг шүүхийн хамт олон гарган тавьж байна. Гэтэл эдгээр асуудлыг шийдэхэд шүүхийн удирдлагаас системтэй бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэх байдал дутмаг байна.

Шүүхийн төсөвт дээрх хүндрэл бэрхшээлүүдийг арилгах үйл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгө тусгагддаггүй бөгөөд шүүгчдийн орон байрны асуудал, мөн ямарваа нэг мөнгө шаардлагатай үед шүүхийн удирдлага аймгийн Засаг даргад хандан туслалцаа авдаг байдал ч эргэж харах нөхцөл мөн гэж шүүгчид үзэж байна.

Аймгийн шүүхийн үйл ажиллагаа

Энэ хэсэгт орон нутагт шүүх үйл ажиллагаанд баримтлах зарчмуудын хэрэгжилтийг үнэлэх зорилт тавьсан юм. Шүүгчийн хараат бус байдал, шүүхийн үйл ажиллагааны шударга ёсны байдлын хэрэгжилт, түүнд нөлөөлж буй сөрөг үйлдлүүдийг гаргаж, нөлөөллийн үйл ажиллагааг төлөвлөх, түүнд зориулсан зөвлөмж гаргах боломжтой болох юм.

2002 онд батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулинд «Үндсэн хуульд зааснаар Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ,...шүүх нь хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн» гэж заажээ.

Төслийн баг орон нутгийн шүүхээс шүүх засаглалыг хэрхэн хэрэгжүүлж байгаа байдал, шүүхийн үйл ажиллагаа хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа байх үүргээ хэрхэн биелүүлж байгааг үнэлэхдээ Шүүхийн тухай хуулиар баталгаажсан шүүхийн үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг үнэлэх замаар хийлээ.

Шүүгч гагцхүү хуульд захирагдан дотоод итгэлээрээ (мэргэжлийн ёс зүй-хэнээс ч хараат бус байх) асуудлыг шийдвэрлэх зарчим:

Монгол улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлд энэхүү зарчмын эрх зүйн үндсийг “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” хэмээн тодорхойлсон.

Шүүгчид энэхүү зарчмыг дээдлэн нотлох баримтад тулгуурлан, хуулиа барьж шийдвэр гаргахыг бүхий л талаар хичээдэг байна. Гэхдээ шүүгчид энэ зарчмыг алдагдуулж буй хүчин зүйлсийг нуугаагүй. Шүүгчид нэг өрөөнд хоёулаа суудаг, өрөөний дамждаг хаалга, орон нутагт байх танил тал, нутгархаг үзэл, эрх мэдэлтнүүдийн дарамт, цалин хангамж, ар гэрийн асуудлууд, шүүгчийн мэргэжлийн ухамсар дорой байдал зэрэг нь энэ зарчмын хэрэгжилтийг алдагдуулж байна.

Шүүгчид нэг өрөөнд сууж байна, түүнээс гадна иргэд эрх зүйн мэдлэг тааруу учраас шүүхийн ажилтнуудаас байнга юм асууж лавладаг, энэ нь шүүгчдийн ажлын ачааллыг ихэсгэж, нөгөө талаас хардлага сэрдлэг төрүүлдэг. Гэхдээ ард олны дунд шүүгчийн нэр хүнд уначихсан байгаа энэ цаг үед шүүгч бүр л энэ зарчмыг баримталж ажиллах хэрэгтэй гэж боддог.

Шүүгчийн цалин хангамж муу, хүүхдийн төлбөр гэх мэт ар гэрийн асуудлууд, утас салаа зэрэг зүйлүүд их нөлөөлдөг, гэхдээ тухайн шүүгчийн шунал, ёс суртахуунтай холбоотой...

/шүүгчидтэй хийсэн ярилцлагаас/

Прокурорууд энэ талаар хэлэхдээ зарим тохиолдолд хэргийг нотлох баримт харгалзахгүйгээр шийдвэрлэдэг хэмээн өгүүлж байсныг дурьдах хэрэгтэй. Учир нь нотлох баримтыг харгалзахгүйгээр шүүхийн шийдвэр гаргах боломжгүй юм. Тус шүүхийн хамт олон энэхүү улсын яллагчдын сөрөг сэтгэгдлийн учир шалтгааныг тодруулах, арилгах үйл ажиллагааг даруйхан хэрэгжүүлэх хэрэгтэй.

Орон нутгийн иргэд шүүгчдийг хахууль их авдаг гэж үздэг. Судалгаанд хамрагдагсдын 74.1% нь шүүгч нар хахууль авдаг гэж үзсэн бол 16.1%

нь л хахууль авдаггүй гэж хариулжээ. Шүүгч нарын хахууль авч байгаа нь хянах шалгах механизм байхгүй, шүүгчийн ёс суртахуун, цалин бага зэрэг шалтгаанаас болдог гэж үзжээ.

Шүүхийн үйл ажиллагааны мэтгэлцэх зарчим:

Шүүхийн үйл ажиллагаанд мэтгэлцэх зарчим хэрэгжих боломж бүрэн байна. Шүүгч нар оролцогч талууд адил, тэгш байдлаар санал бодол, нотлох баримтаа гаргаж илэрхийлэх бололцоог гарган ажилладаг. Хэдийгээр иргэдийн эрх зүйн мэдлэг харьцангуй нэмэгдэж байгаа ч мэтгэлцээн нь нэг талын харилцаа бус шүүхийн хуралдаанд оролцогч бүх талуудаас хамаардаг учир талуудын үр чадвар дээшлэхгүйгээр мэтгэлцэх зарчим хэрэгжихгүй.

Шүүгчид энэ зарчмыг бүрэн дүүрэн ашиглахад оролцогч талуудын чадвар харилцан адилгүй байна хэмээн үздэг байна. Учир нь иргэдийн эрх зүйн мэдлэгийн дорой байдал, прокурор, өмгөөлөгч нарын мэргэжлийн үр чадвараас хамааран энэ мэтгэлцэх боломжийг ашиглахгүй байна гэж дүгнэж болно.

Мэтгэлцээн өрнүүлэх боломжийг бүрэн хангадаг. Гэвч өмгөөлөгч, прокурор нар сайн ашиглахгүй байна. Тэд хэргийг сайн судлахгүй, ажиллахгүй байна. Жижүүрийн хэдэн үгтэй, түүнийгээ л хэлдэг. Шүүхийн зүгээс иргэд, өмгөөлөгч, прокурор нарт зориулсан үзүүлэх шүүх хурал ч зохион байгуулж байсан. Гэвч байдал дээрдэхгүй л байна....

Шүүгчийн ярианаас

Тэгвэл нөгөө талаас шүүгчдэд мэтгэлцэх бололцоо олгодог боловч өмгөөлөгч, нэхэмжлэгч, сэжигтэн, оролцогчийг загнаж зандрах, улсын яллагчид илүү боломж олгодог зэрэг зохисгүй байдал үзүүлдэг хэмээн өмгөөлөгч нар шүүмжилж байна.

Мэтгэлцэх зарчим хэрэгждэг, гэхдээ шүүх бүрэлдэхүүн прокурорын дүгнэлттэй урьдчилан танилцаад хэргийн талаар өөртөө урьдчилсан дүгнэлттэй болчихсон байдаг болохоор яаж ч мэтгэлцээд хэрэг болохгүй тохиолдол байдаг. Улсын яллагч мэтгэлцээнд ялагдаад байхад шүүгч түүний талд шийдвэр гаргах тохиолдол ч байна шүү дээ. Мөн шүүгч хүмүүсийг загнаж зандардаг, иймээс хүмүүс айж сандрах, үгээ дэс дараалалгүй ярих, буруу илэрхийлэх тохиолдол гардаг....

Өмгөөлөгчийн ярианаас

Иргэдийн төлөөлөгчид:

Шүүх хуралдаан дахь иргэдийн төлөөлөгчдийн оролцоо нь олон нийтийн хяналтын нэг хэлбэр юм. Тэгвэл иргэдийн төлөөлөгчдийн шүүх хуралдааны үйл явцад оролцох оролцоо доголдож байгааг үнэлгээний ярилцлагад оролцсон бүх талууд зөвшөөрч байна.

Шүүхийн тухай хуулиар иргэдийн төлөөлөгчдийг сонгон авах журмыг тогтоосон боловч сонгон авахдаа баримтлах шалгуурын талаар зохицуулаагүйгээс аймгийн шүүх иргэдийн төлөөлөгчдийг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар дамжуулан сонгон авдаг бөгөөд зөвхөн ажлын туршлага, холбоо барих боломж, зав чөлөөг л гол шалгуур болгодог байна. Одоогоор 50 гаруй иргэдийн төлөөлөгчийн бүртгэл байдаг.

Иргэдийн төлөөлөгчийг сонгогчдын нэрсийн жагсаалтыг үндэслэн шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон журмын дагуу сонгон авах ажлыг тухайн шүүхийн тамгын хэлтэс зохион байгуулж, шүүх хуралдаанд оролцуулна.

Шүүхийн тухай хуулийн 6 зүйлийн 2 дахь хэсэг

Иргэдийн төлөөлөгчид идэвхитэй, эрх зүйн мэдлэг өндөр, хавтаст хэрэгтэйгээ танилцаж хуралд оролцох ёстой. Шүүгч, прокурор, өмгөөлөгч нар тэдний оролцоог чухалчлан үзэж байна. Гэвч дараах дутагдлууд тэдний оролцоог доголдуулж байна.

Иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн мэдлэг сул байдаг бөгөөд гаргасан дүгнэлтээ бичгээр л өгдөг бөгөөд уншиж сонсох нь бага байдаг. Иргэдийн төлөөлөгчдийн дунд ажилтай, ажилгүй хүмүүс, тэтгэврийн хөгшид байдаг байна. Ажилтай хүмүүс нь ихэнхдээ завгүй байдаг тул тэтгэврийн хөгшид, ажилгүй хүмүүс шүүх хуралд сууж, нөгөө талаар өөрсдийн оролцоог ухамсарласан байдал нь хангалтгүй тул энэ байдал нь тэдний оролцоог ёс төдий гэж дүгнэхэд хүргэж байна.

Мөн иргэдийн төлөөлөгч оролцуулахгүй байх тохиолдол мэр сэр гарч, бүр нэг хэрэгт иргэдийн төлөөлөгчид оролцсон боловч дүгнэлт байхгүй байсан тохиолдол ч байв.

Иргэдийн төлөөлөгчид идэвхигүй байдаг. Заримдаа бүр олдохгүй, хавтаст хэрэгтэй танилцахгүй, хүн амь, хүчингийн хэрэгт л дуртай суух юм. Шүүх өөрөө хүнээ зөв сонгох, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар ажил хийх хэрэгтэй, яагаад хийхгүй байгаа учрыг мэдэхгүй байна.

/Прокурорын ярианаас/

Иргэдийн төлөөлөгчид бидний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар шүүхээс ажил хийхгүй байна. Урьд нь энэ талаар сургалт хийдэг байсан. Бидэнд эрх зүйн мэдлэг их хэрэгтэй шүү дээ.

/Иргэдийн төлөөлөгчийн ярианаас/

Иргэдийн төлөөлөгчид билгэдлийн төдий л сууж байдаг. Голдуу хийх ажилгүй завтай хүмүүс суудаг. Тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх хэрэгтэй.

/Өмгөөлөгчийн ярианаас/

Иргэдийн төлөөлөгчдийн оролцоо ерөнхийдөө сайн, гэхдээ тэдний зарим нь тун идэвхигүй оролцдог тул мэдлэгийг нь дээшлүүлж, үүрэг ролийг нь ойлгуулах хэрэгтэй байна.

/Шүүгчийн ярианаас/

Иргэдийн төлөөлөгчдийн оролцоог чанаржуулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар шүүхийн тамгын газраас тусгай, тогтмол сургалт, ярилцлагыг хийх хэрэгтэй юм.

Гэм буруутайд тооцож болохгүй зарчим:

Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд ямар нэгэн эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэдэг байхад энэхүү зарчмын агуулга оршино хэмээн шүүхийн тухай хуульд заажээ.

Шүүхийн шийдвэр гараагүй байхад хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй гэсэн зарчмыг бүх шүүгчид баримтлан ажилладаг хэмээн тус шүүхийн шүүгчид өгүүлж байна. Гэхдээ энэ зарчмыг алдагдуулах хамгийн их ажиглагдаж буй дутагдал нь шүүгчид шүүх хурал дээр яллагдагч сэжигтэнүүдэд тулгасан асуулт тавьж загнах байдал юм. Сэжигтэн, яллагдагчийг гэм буруутайг батлах шийдвэр гараагүй байхад загнах, тулгасан асуулт тавих нь зарчмын том алдаа гэж үзэж болно. Учир нь энэ байдал нь өрөөсгөл шийдвэр гаргахад нөлөөлөх нөхцөл болно.

Шүүгчид шүүх хурал дээр сэжигтнүүдээс тулгасан асуултууд асуудаг. “Чи хулгай хийсэн байна, түүнийгээ яриач” гэх мэт асуултуудыг их асуудаг. Мөн прокурорын дүгнэлтэд тулгуурлах байдал ажиглагддаг.

/Прокурорын ярианаас/

...шүүх хуралд орж ирэхдээ л сэжигтнүүдэд хэрэгтэн мэт ханддаг. Загнадаг, зандардаг, хийсэн хэргээ яриач гэж хэлдэг. Шүүгч прокурорын дүгнэлтийг уншаад урьдчилан дүгнэлт гаргачихсан хуралд орж ирэх бус, шүүхийн зөвлөлдөх танхимд шийдвэрээ гаргах ёстой.

/өмгөөлөгчийн ярианаас/

...энэ зарчмыг алдагдуулах байдал хаяа гаргадаг. Бид хуучин хандлагаа өөрчлөх ёстой, мөн хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтад зодож, тулгаж хэрэг хүлээлгэсэн гэх гомдол шүүх хурал дээр гардаг. Энэ бүгдийг бид нарийн сайн ялгаж ажиллах хэрэгтэй.

/шүүгчийн ярианаас/

Энэ байдлыг хуучин арга барилаас үлбаатай, одоо болтол арилж өгөхгүй байгаа хандлага хэмээн шүүгчид үзэж байна. Сэжигтэн, яллагдагч, хариуцагчийг шүүхийн шийдвэр гараагүй байхад гэмтэн ялтан лугаа харьцах нь бүү хэл шүүхийн шийдвэр гараад гэмтэн, ялтан болсон ч тухайн хүнтэй хүний ёсоор харьцах зарчмыг бэхжүүлэх хэрэгтэй гэсэн саналыг оролцогчид гаргаж байлаа. Үүний тулд шүүгчийн ёс зүйн сургалтуудыг зохион байгуулах, мэргэжлийн ярилцлага хийх, иргэдийн санал гомдлын мөрөөр ажиллах гэх мэт ажлуудыг зохион байгуулах шаардлагатай хэмээн үзэж байна.

Шүүх, хуулийн өмнө эрх тэгш байх зарчим:

Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуулиудад «Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага өмчийн хэлбэр, эрх хэмжээний ялгаваргүйгээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна» хэмээн энэхүү зарчмын эрх зүйн үндсийг тодорхойлсон байдаг.

Шүүхийн өмнө хүн бүр тэгш байж чадаж байна уу гэдэг асуудалд шүүхийн байгууллага анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Учир нь дээр дурьдсанаар олон нийтийн дунд шүүхийг хардах, шүүхэд итгэхгүй байх, шүүгчдийг хахууль авдаг гэх зэрэг сөрөг ойлголт маш их байгаа нь судалгааны дүнгээр гарсан. Хэдийгээр шүүх үйл ажиллагаагаа сайн хийж байгаа хэмээн өөрийгөө дүгнэж байгаа боловч олон нийтийн дундах сөрөг хандлага, үнэлгээг бууруулахгүйгээр шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүргэхэд хүндрэлтэй болох юм.

Олны дунд нэгэнт ийм сөрөг хандлага тархсан учраас “Овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ” гэдэг үгийг санах хэрэгтэй хэмээн шүүгчид үзэж байна. Учир нь олон нийтэд шүүх, шүүгчийн үйл ажиллагаа хаалттай, үнэн бодит ил тод байдлаар мэдээлэл олж авах боломж төдийлөн байхгүй, нөгөө талаас шүүгч нар гадны нөлөөнд автаж байгаа үйлдлийг илрүүлж чадахгүй байгаа, олон нийтийн дунд хардлага сэрдлэгийг бууруулах үйл ажиллагаа зохион байгуулж, явуулж чадахгүй зэргээс иргэдийн дунд шүүхийн байгууллагын нэр хүндийг өсгөж чадахгүй байна гэж шүүгчид дүгнэж байна.

Хуралдааныг нээлттэй явуулах зарчим:

Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ.

Монгол улсын Үндсэн хуулийн 54 дүгээр зүйл

Үндсэн хуулийн дээрх заалт нь Шүүхийн тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хууль зэрэг шүүхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон бүхий л баримт бичгүүдэд тусгалаа олон баталгаажсан байна.

Архангай аймгийн шүүхийн хувьд ямар нэгэн нууцын зэрэглэлгүй л бол бүх хуралдааныг нээлттэй явуулдаг. Ямар нэгэн байдлаар хуралдааныг шалтгаангүйгээр хаалттай явуулдаг байдал байхгүй байна. Гэхдээ шүүхийн удирдлага шүүхийн тухай шинэ хуулийг... шүүх сууж, иргэд ирж үйлчлүүлэх болсон... хэмээх хэтэрхий загварчилсан ойлголттой байна гэж болохоор байв. Учир нь шүүхийн систем шинээр бүрэлдэж байгаа шилжилтийн энэ үед шүүх өөрөө иргэдэд шинэ шүүх, хуулийг таниулах, сурталчлах, шүүхэд хандах мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийн дундах шүүхийн тухай хардлага

сэрдлэгийг бууруулах зорилготой олон талт ажлыг зохиох үүрэгтэй юм. Гэтэл энэ үйл ажиллагааны нэг чухал хэлбэр болох шүүх хуралдааныг сонирхож суух, ажиглах, мэдлэг, мэдээллээ дээшлүүлэх зорилгоор орон нутгийн иргэд шүүх хуралдаанд оролцдоггүй байна. Аймгийн шүүхээс олон нийтийн эрх зүйн ухамсар, боловсролыг дээшлүүлэх зорилгоор тодорхой онцгой хэргийн шүүн таслах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах үйл ажиллагааг ч зохион байгуулдаггүй байна. Гэхдээ сумын төвүүдэд шүүх хуралдааныг зохион байгуулбал хөдөөгийн иргэд, малчид идэвхитэй оролцдог аж. Харамсалтай нь нүүдлийн шүүх ажиллах бололцоо төсөв, шүүхийг ойлгож буй удирдлагын дээрх зарчмын улмаас ихээхэн хумигдаж байгаа тул хөдөөгийн иргэдийн оролцоо буурсан байна.

Шүүхийн үйл ажиллагаанд хүний эрх эрх чөлөө, олон нийтийн эрх ашгийг хэрхэн хамгаалж байгаа, түүндээ холбогдох хуулиудыг хэрхэн хэрэглэж буй практик

Шүүхийн үйл ажиллагаанд хүний эрх, ялангуяа олон нийтийн эрх ашгийг хэрхэн хамгаалж байгаа, түүнтэй холбогдох хууль тогтоомжуудыг хэрхэн зөв хэрэглэж байгаа практикийн 2 кейсийг ашиглалаа. Доор үзүүлсэн 2 кейс дээр шүүхийн шийдвэр иргэдийн эсрэг гарчээ. Тус аймгийн шүүх иргэдийн эрх, эрх чөлөө, нийтийн эрх ашгийг хуулиар хамгаалах зарчмаа баримтлан ажилладаг боловч энэ төрлийн үйл ажиллагаандаа анхаарч, дутагдлыг арилгах хэрэгтэй бөгөөд энэ зорилгоор доорхи 2 кейст хийсэн шинжилгээ, дүгнэлтүүдийг үнэлгээний тайланд оруулсан болно.

Ногооны зоорьний ногоо нарлуулах талбайн хэрэг

Товч тух: Иргэн “Х” 2001 онд ногооны 2 зоорь худалдаж авчээ. 2003 онд сумын Засаг дарга шийдвэр гаргаж, ногооны зоорины ногоо нарлуулах талбайг нэгэн худалдааны компаний захиралд эзэмшүүлэх шийдвэр гаргасан байна. Улмаар аймгийн Засаг дарга уг шийдвэрийг баталгаажуулжээ. Иргэн “Х” өмгөөлөгч авч өөрийн эрхээ сэргээлгэхээр захиргааны шүүхэд хандсан байна.

Аймгийн Захиргааны хэргийн 2005 оны 6 дугаар сард иргэн “Х”-ын нэхэмжлэлтэй хэргийг хянан шийдвэрлэжээ. Иргэний нэхэмжлэлийн утга нь тус иргэний ногооны зоорины ногоо нарлуулах талбайд барилга барих зөвшөөрлийг Засаг дарга өөр хүнд өгснийг эсэргүүцэж, Засаг даргын захирамжийг хүчингүй болгохыг хүссэн байна.

Иргэн “Х”-ийн өмгөөлөгч Засаг дарга тус иргэний ногооны зоорины талбайн ногоо нарлуулах талбайг өөр хүнд эзэмшүүлэхээр өгсөн нь илт хууль зөрчсөн гэдгийг нотлохдоо Газрын тухай хуульд ногооны зоорийг ногоо нарлуулах тодорхой хэмжээний талбайтай байхыг хуульчилсан байдаг, мөн иргэн “Х” тус газрыг худалдаж авсан зэргийг дурьдсан байна.

Иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлт нь Засаг даргын шийдвэрийг өөрчлөх боломжгүй, иргэн “Х”-ийг Засаг даргатай тохиролцохыг зөвлөжээ. Шүүх бүрэлдэхүүн уг иргэний газрын гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын захирамжийг хүчингүй болгохгүй иргэн “Х”-ийн эсрэг шийдвэр гаргасан байна.

Уг хэрэгт хуулийн өмнө тэгш байх зарчим алдагдсан гэж үзэх үндэслэл байна. Хэрэгт анализ хийсэн хуульчид иргэн “Х”-д шүүхийн шийдвэр тэгш бус ханджээ гэж дүгнэжээ. Учир нь Засаг даргын захирамж хууль бус байх магадлалтай байна. Иргэн “Х” Хууль зүй дотоодын хэргийн яаманд хүсэлт гаргаж, өөрийн өмчид хамаарах газрын тухай лавлагаа гаргуулж авсан бөгөөд Геодези зураг зүйн албанаас гаргасан дүгнэлтэд үндэслэн тус яам зоорьны ногоо нарлуулах талбай иргэн “Х”-д хамаарна гэж дүгнэсэн байна.

Иймээс 2005 оны 6 дугаар сарын 30-нд гаргасан шүүхийн шийдвэрийг иргэн “Х”-ийн өмчлөх эрх, шударга шүүхээр шүүлгэх эрхүүдийг бүдүүлгээр зөрчсөн гэж дүгнэж байна.

Архангай аймгийн Цэнхэр сумын Нарийн Хамрын хэрэг

Ариун суварга хөдөлгөөний гишүүд, дэмжигчид Архангай аймгийн сум дундын шүүхэд Цэнхэр сумын Нарийн хамар хэмээх газарт хууль бусаар алт олборлож байгаа гэх шалтгаанаар “Монгол газар” ХХК-ийг хариуцагчаар татсан байна.

Үндэслэл: 2005 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Архангай аймгийн сум дундын шүүхэд тус аймгийн Цэнхэр суманд хууль бусаар үйл ажиллагаа явуулж байгаа «Монгол газар» ХХК-ийн үйл ажиллагааг түр зогсоолгох нэхэмжлэл гаргасан. Монгол газар ХХК нь 2004 оны 12 дугаар сард Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Геологи уул уурхайн кадастрын албанаас Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг Нарийн хамрын гол гэдэг газарт ашигт малтмалын хайгуул хийх 1919Х, олборлолт хийх А8778 тоот лицензүүдийг тус тус авсан боловч сумын захиргаанаас газар болон ус ашиглах зөвшөөрөл өгөөгүй, мөн гэрээ хийгээгүй байхад үйл ажиллагаагаа эхлүүлснийг илрүүлсэн байна. Иймд шүүхэд нэхэмжлэл гаргаж дараах шаардлагыг тавьжээ.

1. Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу газар ашиглуулах тухай сумын Засаг даргын захирамж гараагүй, гэрээ байгуулаагүй учир газар ашиглах эрх үүсээгүй
2. Ус ашиглах эрх нь мөн үүсээгүй
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу БОЯ-ны зөвшөөрөл байхгүй.
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг орон нутгийн засаг захиргаанд өнөөдрийг хүртэл танилцуулаагүй байгаа учраас алт олборлох үйл ажиллагааг олон хууль зөрчиж үйлдэхээр завдаж, хүний эрхийн ноцтой зөрчил гаргасан. Иймд “Монгол газар” ХХК-ийн Нарийн хамар дахь үйл ажиллагааг зогсоож өгнө үү гэсэн нэхэмжлэлийг гаргасан.

Хэргийг шийдсэн байдал: Нэхэмжлэлийн дагуу иргэний хэрэг үүсгэж, 2005 оны 7 дугаар сарын 29-ний өдөр шүүх хуралдаан зарлагдсан боловч тухайн нэхэмжлэгч иргэд хуралдаанд хүрэлцэн ирээгүй гэдэг шалтгаанаар шүүх хуралдааныг хойшлуулах тухай шүүгчийн захирамж гарч, 2005 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулсан.

Өмгөөлөгч Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын /МХГ/ даргатай уулзсанаар “Монгол газар” ХХК нь тус байгууллагын албан ёсны дүгнэлтийг гаргуулаагүй байж үйл ажиллагаа эхэлснийг олж мэдсэн тул тус албаны даргыг шүүх хуралдаанд гэрчээр оролцуулахаар шийджээ.

Нэхэмжлэлийн үндэслэл шүүх хуралдаанаас өмнө хангагдсан байсан ч мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт гараагүй байсан нь шинэ үндэслэл болсон бөгөөд холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн МХГ-ын дүгнэлтийг гаргуулах хүртэл “Монгол газар”-ын үйл ажиллагааг зогсоох боломжтой гэж өмгөөлөгч үзсэн байна.

Учир нь тухайн үед үйлчилж байсан Ашигт малтмалын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар «...байгаль орчны холбогдох байгууллагаас бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд тухайн лиценз эзэмшигч нь хайгуул хийх болон ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа хийхийг хориглоно» хэмээн заасны дагуу нэхэмжлэлийн үндэслэлээ өөрчилсөн юм.

Архангай аймгийн шүүх уг хэргийг шийдвэрлэхдээ нутгийн иргэдээс гаргасан нэхэмжлэлийн үндэслэлийг үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш хангаж, газар, ус ашиглах гэрээг сумын Засаг даргатай байгуулсан учир тухайн компанийн үйл ажиллагааг зогсоох шаардлагагүй хэмээн үзсэн байна. Ингээд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргажээ.

Энэ хэргийн өмгөөлөгч нар үзэхдээ шүүгчид шийдвэр гаргахдаа уг компанийн үйл ажиллагаа хууль бусаар эхэлсэн тул эхнээсээ хууль бус үйл ажиллагаа, нөгөө талаар байгаль орчны холбогдох хуулиудыг алт олборлолт хийх тухай газарт нь холбогдуулж үзэж болох байсныг шүүгч нар хийгээгүй хэмээн дүгнэж байна.

Хамгийн чухал нь энэхүү компанийн үйл ажиллагааг хууль ёсны болгож баталгаажуулснаар байгаль орчны сүйтгэлээс болж хөдөөгийн иргэдэд учирах хохирлыг олж харалгүй шийдвэр гаргасан явдал юм.

Дээрх дутагдалтай байдлын талаар оролцогч талууд дараах санал бодолтой байна.

Шүүгчдийн бүлэг: Орон нутагт эрх зүйн маргааны төрөл цөөн, маргааны мөн чанар энгийн, хэргийн ихэнх хувийг ээдрээ багатай хэрэг эзэлдэг онцлогтой байна. Энэ байдал нь шүүгчийн мэргэжлийн мэдлэг, чадвар, туршлагад нөлөөлдөг хэмээн ихэнх шүүгчид дүгнэжээ. Иймээс шинэ соргог, шүүхийн практик төдийлөн нийтлэг бус, нарийн ээдрээтэй хэрэг дээр ажиллахад мэдлэг, туршлага дутах байдал гардаг хэмээн үзэж байна.

Энэ байдал нөлөөлөлгүй яхав. Маргаантай ээдрээтэй хэрэг дээр ажиллах тусам шүүгчийн мэдлэг, чадвар өсдөг. Ихэнхдээ зээл буцаан төлүүлэх, ажилласан жил тогтоох зэрэг асуудал дээр ажиллаж байна. Гэхдээ мэдээж шүүгчийн хичээл зүтгэлээс их хамаатай.

Прокурорын бүлэг: Шүүгчдийн мэдлэг, чадвар ерөнхийдөө сайн, гэхдээ мэдээж цөөн төрлийн хэрэгт дээр ажиллах нь “зэврэх” байдалд хүргэхийг анхаарах хэрэгтэй.

Өмгөөлөгчдийн бүлэг: Нөлөөлнө шүү, ялангуяа нийтийн эрх ашигтай холбоотой хэрэг их нөлөөтэй.

Нийтийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой Үндсэн хуулийн заалтууд, Монгол Улсын олон улсын гэрээ конвенциудыг харгалзан үзэх, хэрэглэх талаар ямар нэгэн алхам, оролдлогыг шүүхийн практикт хийгээгүй, тус хэргийн анализ, холбогдох хуулиудыг анхааран үзээгүй хэмээн үнэлгээний баг дүгнэж байна. Иймд орон нутгийн шүүхийн байгууллагын ажилтнуудад иргэдээс ирэх шинэ төрлийн нэхэмжлэл, түүний мөн чанар, ялангуяа олон нийтийн эрх ашгийг шүүхээр хамгаалах үйл ажиллагааны тухай мэдээлэл, богино хугацааны сургалтыг ойрын хугацаанд явуулах хэрэгтэй байна.

Олон нийтийн санал бодол: Шүүгчийн хараат бус байдал, шүүхийн үйл ажиллагааны шударга ёсны байдлыг алдагдуулж буй сөрөг хүчин зүйлс

Үнэлгээний тайлангийн энэ хэсэг шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг алдагдуулж буй сөрөг хүчин зүйлсийн талаарх олон нийтийн санал бодлыг гаргасан юм.

Архангай аймгийн 31 иргэнээс анкетаар мэдээлэл цуглуулж, боловсруулан шинжилгээ хийсэн болно. Судалгаанд хамрагдагсдын 54,2% нь дээд боловсролтой, 22,6% бүрэн дунд боловсролтой, 12,9% нь бүрэн бус дунд боловсролтой, 3,2% нь бага боловсролтой иргэд байв.

Хүснэгт 1. Санал асуулгад оролцогчдын тухай мэдээлэл

| Хүйс | | Шүүхэд хандсан эсэх | |
|-------|-------|---------------------|-----------|
| Эм | Эр | Хандсан | Хандаагүй |
| 67.7% | 32.3% | 48.4% | 51.6% |

Хөдөөгийн иргэд шүүхэд хандахад ихэд хүндрэлтэй байна. Шүүхэд хандахад амар байдаг уу гэсэн асуултад нийт 18 хүн хариулсан бөгөөд 13 хүн буюу 72,2% нь амар хялбар байгаагүй гэжээ. Шүүхэд хандахад хамгийн их хүндрэл учруулж байгаа хүчин зүйлүүд нь:

- Шүүхэд яаж хандахаа мэдэхгүй
- Шүүхийн ажилтнуудын дээрэнгүй харьцаа
- Шүүхэд учир байдлаа тайлбарлахад сонсох хүн байдаггүй зэрэг аж.

Шүүх шударга ажилладаг гэдэгт олон нийт итгэдэггүй хандлага, шүүхийн үйл ажиллагаанд итгэдэг хандлага хоёр бараг 50:50 хувьтай байгаа нь анхаарал татах нөхцөл юм. Нийт 16 хүн “Шүүхийн үйл ажиллагаа шударга явагддаг уу?” гэсэн асуултад хариулсан ба тэд өмнө нь шүүхээр хэрэг маргаанаа шийдүүлж байсан хүмүүс юм. Тэдний 9 нь шүүхийн үйл ажиллагаа шударга явагддаг, 7 нь шударга бус явагддаг гэж хариулсан байна.

Хүснэгт 2. Шүүхийн үйл ажиллагаа шударга бус болж байгаа учир

| | |
|------------------------------|-------|
| Шүүгч нар хахууль авдаг | 6 хүн |
| Шүүгч танил талдаа үйлчилдэг | 4 хүн |
| Иргэдийн эрх зүйн мэдлэг муу | 1 хүн |


Олон нийтийн дунд шүүгч нар хахууль авдаг гэж үзэх хандлага хүчтэй байна. Учир нь нийт 28 хүн энэ асуултад хариулсан бөгөөд үүний 82,1% нь шүүгч нар хахууль авдаг гэж хариулсан бол 17,9% нь хахууль авдаггүй гэж хариулсан байна. Шүүгчид хахууль авч байгаа гэж үзэх хандлага нь шүүгч нарыг хянах механизм сул /21 хариулт/, шүүгч нарын мэргэжлийн ёс зүйгүй байдал /9 хариулт/, шүүгч нарын цалин бага /3 хариулт/ зэргээс болдог гэж олон нийт үзжээ.

Шүүгч нарын гаргаж буй ёс зүйн хамгийн нийтлэг дутагдал нь зүй бус зан харьцаа гэж олон нийт үзэж байна. Дээрэнгүй ханддаг, загнадаг, хүний үгийг сонсдоггүй гэж боддог учраас олон нийт шүүгчийн зан харьцаа муу байна гэж дүгнэжээ. Иргэд өөрсдийгөө эрх зүйн мэдлэг муу, өмгөөлөгчид төлөх хөлсгүйн улмаас шүүхийн үйл ажиллагаанд хангалттай сайн оролцож чаддаггүй гэж үздэг аж. Тухайлбал, шүүхийн үйл ажиллагааны мэтгэлцээнд оролцоход дээрх шалтгаанууд хамгийн их саад болдог байна.

Нөгөөтэйгүүр, хэрвээ шүүгч мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргахад иргэд хаана хандаж хэлэхээ мэдэхгүй байгаа нь тэднийг шүүхэд итгэдэггүй, шүүгч нарын хахууль авдаг байдлыг хянах механизм сул байна гэж үзэх үндэс болжээ гэж дүгнэж болохоор байна. Судалгаанд хамрагдсан 28 хүн уг асуултад дараахь байдлаар хариулжээ. Үүнээс 78,5% нь (22 хүн) шүүгчийг алдаа гаргасан гэж үзвэл хаана хандахаа мэдэхгүй, 21,4% нь (4 хүн) хаана хандахаа мэднэ гэж дүгнэж байна.

Шүүхийн үйл ажиллагааны бие даасан хараат бус байдлыг хангаж байдаг үйл ажиллагааны зарчмуудын хэрэгжилтийн талаар олон нийт дээрх байдлаар тааруу санал бодолтой байгаагаас тус шүүхийн үйл ажиллагааг сайн ч биш, муу ч биш, дунд зэргийн л байна гэж дүгнэжээ.

Диаграм 1. Шүүхийг үнэлсэн олон нийтийн үнэлгээ



Дээрх дүнгээс харахад орон нутгийн иргэд шүүхийг шударга сайн ажилладаггүй, шүүгчид нь хахууль авдаг, хахууль авсан шүүгчээ хянах, хариуцлага тооцох механизм байдаггүй, шүүгчдийн биеэ авч явах байдал нь маш их дээрэнгүй хэмээн үзэх хандлагатай гарч байгааг анхаарахаас өөр аргагүй юм. Мөн орон нутгийн иргэдийн шүүхэд хандах мэдлэг, төлбөрийн чадвар дорой байгааг анхаарах хэрэгтэй болжээ. Шүүгчдийн бүлэг шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулж буй дараах хүчин зүйлс байгааг гаргасан байна.

- цалин хөлс, ахуй хангамж муу
- ажлын байрны тохь тух
- дээд албан тушаалтны нөлөө
- хамгийн гол нь шүүгчийг сонгон шалгаруулах шалгаруулалт учир дутагдалтай, өөрөөр хэлбэл шударга хүнийг сонгон гаргаж чадахгүй байгаа байдал хэмээн дүгнэсэн байна.

Шүүгч хүний цалин хөлс, ажлын нөхцөл бүх зүйлийг сайжруулж болно. Гэхдээ хамгийн гол нь шударга, шүүгчийн ёс зүйг бүрэн ухамсарлаагүй хүн ямар ч сайхан нөхцөлд ажлаа хийлээ гээд гадны нөлөөнд автахгүй байж чадахгүй. Шуналтай хүний шунал хязгааргүй юм. Тиймээс хамгийн гол анхаарах зүйл бол шүүгч хүний шударгаар ажиллах нөхцлийг л бий болгох ёстой...

Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

Хүснэгт 3. Олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлэхийн тулд:

| | |
|--|----|
| Шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох | 18 |
| Шударга шүүгчийг ажиллуулах | 16 |
| Шүүгчийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх | 12 |
| Олон нийтийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэх | 11 |
| Шүүгчийн цалин хангамжийг нэмэгдүүлэх | 8 |

гэх мэт үйл ажиллагаануудыг хийх хэрэгтэй гэж хариулсан байна.

Шүүгчийг сонгон томилох процесс, шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг хангаж байдаг үйл ажиллагаандаа баримтлах зарчмуудыг хянах, шалгах, дүгнэх механизм, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх системтэй бодлого, олон нийттэй харилцах харилцааг шинэчлэх зэргийг шүүгчийн шударгаар ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай арга хэмжээ гэж дүгнэж байна.

Өргөдөл гомдол хүлээн авах, бүртгэх, хариу өгөх ажиллагаа, шүүхийн шийдвэрийг иргэдэд хүргэх нь

Өргөдөл гомдол хүлээн авах, тэдгээрийг бүртгэх, түүнд хариу өгөх, шүүхийн шийдвэрийг хуульд заасан хугацааны дотор хэргийн оролцогчдод гардуулж өгөх ажиллагаа маш чухал юм. Тус шүүх нь өргөдөл гомдол хүлээн авах, бүртгэх ажлын 4 өдөртэй, хариулах үйл ажиллагааг аймгийн шуудангаар илгээн бүртгэл хөтөлдөг зэрэг дэвшилттэй зүйлүүд байна.

Гэвч аймгийн шуудангаар дамжуулахад хугацаа их алддаг, дунджаар 3 долоо хоногийн хугацаа шаарддаг байдал, шуудангаар илгээсэн хариу, шүүхийн шийдвэр жинхэнэ эзэндээ очиж байгаад хяналт тавьдаггүй зэрэг дутагдлууд байна.

Дүгнэлт

Архангай аймгийн шүүх иргэдэд үзүүлж буй шүүхийн үйлчилгээгээ хэвийн явуулдаг байна. Гэвч орон нутгийн шүүхийн хомс төсөв, орон байргүй байдал, шүүгчдийн нийгмийн хангамж сулхан байгаа, мөн шүүгчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх үйл явц системтэй бус, мэдээллийг хурдан шуурхай авч чадахгүй байгаа байдал нь шүүхийн хамт олны чадавхийг бэхжүүлэхэд саад болж улмаар шүүхийн хараат бус байдлыг алдагдуулах нөхцлийг бий болгож олон нийтийн дунд шүүхийн нэр хүндийг унагаж байгаа юм.

Шүүгчдийн ажлын байр, утас, орон сууцны хангамж хангалтгүй, сурталтад хамрагдах бололцоо дэмжлэг байхгүй зэрэг хүндрэлүүдийг ноцтой хэмээн үзэж байна. Учир нь хуулийн нарийвчилсан асуудлаар шүүгчид мэргэжлээ дээшлүүлж чадахгүй байх, шүүгчдийн ахуйн асуудал ихтэй байдал нь тэдний хараат бус байдлыг алдагдуулах нөлөөллүүдэд өртөх нөхцөл болж байгааг шүүхийн хамт олон гарган тавьж байгаа юм. Гэтэл эдгээр асуудлыг шийдэхэд шүүхийн удирдлагаас системтэй бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэх байдал дутмаг байна.

Шүүхийн төсөвт дээрх хүндрэл бэрхшээлүүдийг арилгах үйл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгө тусгагддаггүй бөгөөд шүүгчдийн орон байрны асуудал, мөн ямарваа нэг мөнгө шаардлагатай үед шүүхийн удирдлага аймгийн Засаг даргад хандан туслалцаа авдаг байдал ч эргэж харах нөхцөл мөн гэж шүүгчид үзэж байна.

ЗӨВЛӨМЖ

Шүүхийн хамт олон, материаллаг хангамж

Тус шүүх материаллаг хангамжийн улмаас гадны нөлөөнд орж болохоор байгааг доорх хэд хэдэн нөхцөл байдал харуулж байна. Үүнд:

- шүүгчдийн цалин, ажлын байр, ахуйн хангамжийн дутагдалтай байдал
- шүүгчдийн мэдлэгийг системтэй нэмэгдүүлэх сургалтын бодлого системтэй бус, мэдээллийг хоцорч авдаг байдал
- орон нутгийн иргэд шүүхийн үйлчилгээ авахад олон хүндрэл, бэрхшээлтэй учирдаг байдал

Дээрх хүндрэлтэй байдлуудыг багасгаж, арилгахын тулд дараахь үйл ажиллагааг хийхийг санал болгож байна.

- Шүүгчдийн хэлэлцүүлэг: Шүүгчдийн дунд шүүгчийн мэргэжлийн ёс зүй, шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг алдагдуулж буй хүчин зүйлсийн талаар ялангуяа, удирдах албан тушаалтны нөлөөний талаар чөлөөт ярилцлага зохион байгуулж, санал зөвлөгөө боловсруулах, тэдгээрийг шүүхийн үйл ажиллагааны дотоод механизмд тусгах
- Сургалтын шинэ сэдэв: Шүүгчдийн дунд явуулдаг 14 хоног тутмын хичээлүүдийг хүний эрх, эрх чөлөө, олон нийтийн эрх ашиг зэрэг сэдвүүдээр 1-2 сарын турш зохион байгуулах
- Олон нийттэй харилцах: Олон нийтэд шүүхийн үйл ажиллагаа, тэдний эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх зорилгоор одоо явуулж байгаа үйл ажиллагаануудыг чанаржуулах, иргэдэд ойртуулах, шинэ хэлбэрийн үйл ажиллагааг зохион байгуулах, ялангуяа орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглах, зөвхөн статистик мэдээллээр хязгаарлахгүйгээр иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх, шүүхийн үйлчилгээг хэрхэн авах тухай мэдлэг мэдээллийг агуулсан, шүүх, шүүгчийн бие даасан хараат бус байдал, түүнд олон нийтийн хяналт оролцоо хэрхэн байж болох тухай шүүхийн хамт олны санаа бодол зэргийг тусгасан өгүүлэл, мэдээллийг гаргах гэх мэт.

Шүүхийн үйл ажиллагаа:

Шүүгч гагцхүү хуульд захирагдан дотоод итгэлээрээ (мэргэжлийн ёс зүй-хэнээс ч хараат бус байх) асуудлыг шийднэ.

- Шүүхийн үйл ажиллагааны мэтгэлцэх зарчим
- Иргэдийн төлөөлөгчийг заавал оролцуулах зарчим
- Гэм буруутайд тооцож үл болох зарчим
- Хууль шүүхийн өмнө хүн бүр тэгш байх зарчим
- Хуралдааныг нээлттэй явуулах зарчим

Дээрх зарчмууд нь шүүхийн үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангаж байдаг үндсэн элементүүд бөгөөд эдгээрийг шүүхийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллах нь нэн чухал. Гэтэл эдгээрийг алдагдуулах дараах хүчин зүйлс байна. Үүнд:

- Шүүгчийн мэдлэг, чадвар, ёс зүйн доголдол
- Олон нийтийн шүүхэд үл итгэх байдал зэрэг шүүхийн талаарх сөрөг хандлагууд
- Иргэдийн төлөөлөгчдийг сонгох, тэдний зохистой оролцоог хангах, хууль шүүхийн өмнө хүн бүр тэгш байх, хуралдааныг нээлттэй явуулах зарчмуудыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхэд шүүхийн байгууллагын санаачлага сул
- Шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийтийн хүчтэй сөрөг үнэлгээ, мөн иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрын дорой байдал зэрэг юм.

Дээрх хүчин зүйлсийн нөлөөллийг бууруулахын тулд дараахь санал зөвлөмжийг гаргаж байна.

- Шүүгчдийн дунд шүүгчийн ёс зүйн талаар хэлэлцүүлэг зохион байгуулах,
- Олон нийтээс шүүгчдийн зан харьцаа, ёс суртахуун, үйл ажиллагааны талаар нээлттэй мэдээлэл авдаг механизмыг бий болгох,
- Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтуудыг хийх,
- Шүүгчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаануудыг чанаржуулах,
- Иргэдэд хуулийг сурталчлах, мэдүүлэх, таниулах, шүүхийн үйл ажиллагааг чанаржуулах, тогтмолжуулах, үүнд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах

Шүүхийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө, олон нийтийн эрх ашгийг хэрхэн хамгаалж байгаа, түүндээ холбогдох хуулиудыг хэрхэн хэрэглэж буй практик

2 кейст хийсэн анализын үр дүнд дараахь дүгнэлтүүдийг гаргасан.

- Шүүхийн шийдвэрүүд нь аль нэг талд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байдлаар гарах ёстой. Гэтэл 2 шийдвэрт хоёуланд нь иргэд ихэд эргэлзээтэй байгаа бөгөөд эдгээр шийдвэрүүд нь хууль шүүхийн өмнө тэгш байх зарчим болон шударга шүүхээр хэргээ шүүлгэх эрхийг зөрчсөн, олон нийтийн эрх ашгийг хангаж чадаагүй хэмээн дүгнэж байна. Учир нь уг хэргүүдийг шийдвэрлэхэд гадны нөлөө орсон, шүүгчийн мэдлэг чадвар дутагдсан хэмээн үзэж байгаа юм. Энэ байдал иргэдийн шүүхэд итгэхгүй байх хандлагыг нэмэгдүүлж, улмаар өөр байгууллага, албан тушаалтнаар үнэнийг олуулах оролдлого хийхэд хүргэж байгааг анхаарах хэрэгтэй болжээ.

- Хүний эрх, эрх чөлөө олон нийтийн эрх ашгийг ханган хамгаалахад шүүхийн үүрэг ямар байх, хэрхэн хамгаалах талаар сургалтыг шүүгчдэд зохион байгуулах

Олон нийтийн санал бодол: Шүүгчийн хараат бус байдал, шүүхийн үйл ажиллагааны шударга ёсны байдлыг алдагдуулж буй сөрөг хүчин зүйлүүд

Энэхүү үнэлгээ судалгаагаар олон нийтийн дунд шүүх, шүүгчдийн талаарх сөрөг үнэлгээ хүчтэй байгаа нь гарсан. Иймээс ч шүүхийн үйл ажиллагааг “дунд” байна гэж үнэлжээ. Иймээс олон нийтийн дунд байгаа сөрөг үнэлгээ, хандлагыг бууруулахын тулд дараах зүйлсийг хийх хэрэгтэй байна:

- Шүүхийн үйл ажиллагааг олон нийтийн дунд нээлттэй болгох: шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гаргах ажиллагааг тогтмолжуулах,
- Мэдээллийн албанд мэдээлэл, зөвлөгөө өгдөг үйл ажиллагааг чанаржуулж, тогтмолжуулах,
- Шүүхийн Тамгын газраас шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, гарсан санал зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах,
- Шүүхийн байгууллагаас иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд хууль таниулах, мэдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах, хэрэгжүүлэх,
- Олон нийтээс шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, ёс суртахууны талаар мэдээлэл авдаг механизмыг бий болгох.

Өргөдөл, гомдол хүлээн авах, бүртгэх, хариулах үйл ажиллагаа, шүүхийн шийдвэрийг иргэдэд хүргэх

- Шүүхийн шийдвэрийг иргэдийн гарт хүргэж байгаа үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах
- Шүүхийн мэдээллийн албанд иргэдийн асуулт, лавламжид хариулах, зөвлөх үйл ажиллагааг нэмэгдүүлэх

Хүний эрх хөгжил төв

Хүний эрх хөгжил төв нь 1998 онд байгуулагдсан. Хүний эрхийн идэвхтэнүүд, хуульчдын санаачилгаар байгуулагдсан нам бус, ашгийн бус, Монгол улсын төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу бүртгэгдсэн байгууллага юм. Манай байгууллага нь хүний эрхийг дэмжих, хамгаалах, нийгэмд шударга ёсыг хэвшүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгын хүрээнд хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх, хүний эрхийн стратегийн өмгөөлөл болон олон улсын хүний эрхийн нөлөөллийн механизм зэргийг үр ашигтай дэмжин хэрэглэх, эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүд, ялангуяа ядуу иргэдийн эрхийг хамгаалах, үүний дотор зохистой орон байрны эрх, хүнсний болон газрын эрхүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.

Мониторингийн багийн бүрэлдэхүүн

Төслийн удирдагч : Г.Уранцоож, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн

Гишүүд
Ч.Дэлгэрмаа, судлаач
Д.Цэнд-Аюуш, хуульч
Д.Эрдэнэчимэг, хуульч
Ц.Самдан
Үүрцайх
Даваа

Ном зүй

1. Монгол улсын Үндсэн хууль 1992 он
2. Шүүхийн тухай Монгол улсын хууль 2002 он
3. Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002 он
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
5. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
6. What is Monitoring, Human Rights Monitoring and Documentation Series by Manuel Guzman, Bert Verstappen, HURIDOCS, Switzerland 2003.

